

ХАРРИ ПОТТЕР НУУЦ ӨРӨӨ

J. K. ROWLING



Харри Поттер ба Нууц өрөө

Зохиолч: J. K. Rowling
<http://www.jkrowling.com/>

Орчуулагч: Д.Даваа

Эмхэтгэл, хөрвүүлэлт: Б.Болдхүү

Имэйл: bxbenny@gmail.com

Блог: <http://www.boldkhuu.com>

Facebook: <http://facebook.com/bxbenny>

Twitter: <http://twitter.com/bxbenny>

Эхийг Asuult Forum-аас авав.

ГАРЧИГ

БҮЛЭГ 1: ТӨРСӨН ӨДРӨӨС МУУ ЮМ АЛГА	4
БҮЛЭГ 2: ДОББИ АЮУЛЫН ТУХАЙ АНХААРУУЛАВ	10
БҮЛЭГ 3: «ҮҮР»	19
БҮЛЭГ 4: «ФЛОРИШ БЛОТТС» ДЭЛГҮҮР	32
БҮЛЭГ 5: ШАЖИГНУУР УД.....	49
БҮЛЭГ 6: АЛТАН ХОНГИОТ ТУГ ҮС	64
БҮЛЭГ 7: ЭРЛИЙЗ БА НУУЦЛАГ ДУУ	77
БҮЛЭГ 8: ҮХЛИЙН ОЙН БАЯР	90
БҮЛЭГ 9: ХАНАН ДЭЭРХ БИЧИГ.....	104
БҮЛЭГ 10: ГАЛЗУУРСАН БӨМБӨГ	118
БҮЛЭГ 11: ХАЛЗ ТУЛААНЫ КЛУБ	132
БҮЛЭГ 12: ХУВИРГАХ УУСМАЛ.....	147
БҮЛЭГ 13: ШИДЭТ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ.....	163
БҮЛЭГ 14: КОРНЕЛИУС ФАЖ.....	179
БҮЛЭГ 15: АРАГОГ ААЛЗ.....	191
БҮЛЭГ 16: НУУЦ ӨРӨӨ	203
БҮЛЭГ 17: СЛИЗЕРИНИЙ ҮЕ ЗАЛГАМЖЛАГЧ.....	220
БҮЛЭГ 18: ДОББИЙН ХҮРТСЭН ШАГНАЛ.....	235

БҮЛЭГ 1: ТӨРСӨН ӨДРӨӨС МУУ ЮМ АЛГА

Улаан модон гудамжны дөрөвдүгээр байшинд өглөөний цайны үеэр бас хэрүүл шуугиан дэгджээ, Өглөө эрт зээгийнхээ өрөөнөөс гарах уульний чанга гуугчих чимээнээр ноён Дурслы сэрсэн аж.

- Долоо хоногт гурван удаа! Түүнийгээ захирч чадахгүй юм бол хурдхан гаргаж хая гэж ширээний голд суух үедээ зандран хэлэв,

- Ууль торонд байхдаа уйдаа юмаа. Дураараа байдаг шувуу шүү дээ. Үгүй ядахдаа шөнө гаргаж байхгүй бол гэж Харри дандаа тайлбарладаг байлаа.

- Тэгвэл би хувиа бодсон хэрэг болж байна уу? Ууль шөнийн цагаар чухам яадгийг мэдэхгүй гэж бодоо юу?

Вернон ах нь эхнэрээ харснаа өндөг наалдсан сахлаа арчив. Харри бас л эсэргүүцэх санаатай амаа нээсэн авч үеэл Дадли нь:

- Гахайн утсан мах аль! гэлээ.

- Үр минь, хайруулын тавагнаас авчих. Тэнд зөндөө бий. Одоохондоо олдож байгаа дээр нь сайн идэж ав. Сургуулийн хоолыг хоол гэх арга алга! гэж Петунья эгч хэлээд уярсандаа нулимс мэлтрүүлж байв.

- Петунья, дэмий юм яриад л. Би энэ сайхан сургуульд огт өлсөж үзээгүй юм даг. Хүүгээ ч цатгалан байгаа гэж бодож байна хэмээн Вернон ах дургүйцэн хэллээ.

Дадли хоол хүнсээр дутагдаагүй нь хартал илт. Харвин нь сандал шүргэхээр бүдүүн болчихсон юм чинь.

- Надад хайруулын таваг аваад аль! гэж Харрид тушаав.

- Шидэт үгээ мартчихжээ дээ гэж Харри түүнд санууллаа,

Энэхүү жирийн үг тэдний гэр бүлийнхэнд бух уурлуулдаг улаан даавуу шиг нөлөөлжээ. Дадли дуу алдаад сандал дээрээсээ түжигнэн унав. Хатагтай Дурслы хашгирах гэснээ болиод алгаараа амаа дарлаа. Харин ноён Дурслы сандлаасаа үсрэн босоход санчигны нь хөх судас гүрэлзэж харагдана.

- Би түүнийг «ажаамуу» гэдэг эелдэг үгийг мартчихжээ гэж л хэлэх гэсэн юм хэмээн Харри өөрийгөө яаран зөвтгөв.

- Манай гэрт «ш» үсгээр эхэлсэн ямар ч үг хэлж болохгүй гэдгийг чамд би хичнээн удаа хэлэх хэрэгтэй болж байна. Бас хүүг маань сургах санаатай шүү! гэж Вернон ах шүлсээ үсчүүлэн, ширээ шаан хорсолтой хэллээ.

- Би ердөө л ...

- Би энэ дээвэр дор байхдаа чиний тэр заваан юмыг чинь тэвчихгүй!

Харри нагац ахынхаа баргар хүрэн царай, шалан дээрээс хүүгээ босгох санаатай амьсгаадан ноцолдож Петунья эгчийнхээ цонхигор царай харлаа. Тэгээд:

- За ... за гэж толгой дохив.

Вернон ах сандалдаа суугаад уурласан хирс шиг амьсгаадан байхдаа жижигхэн нүдээрээ Харриг нэвт өрөмдөхийг хүсэх мэт харагдана. Үнэндээ бол Харри бусадтай адилгүй ер бусын хүүхэд байлаа. Харри Поттер бол ид шидтэн шүү дээ. Тэрбээр шидтэнгүүдийн хэлээр «бодон» гэгдэх ид шидтэнгүүдийн «Хогвартс» сургуулийн нэгдүгээр дамжааг дүүргээд, амралтаараа гэртээ ирээд байгаа нь энэ. Түүнийг ирэхэд Дурслийхэн баярлаагүй хэдий ч энэ гэрт байхдаа Харрийн үзсэн зүйлтэй харьцуулахад юу ч биш байхгүй юу.

Харри сургууль, шилтгээн, нууц хонгил, хий үзэгдэл, хичээл ном, багш нараа (гэхдээ шидэт уусмалын хичээл заадаг Снеггийг биш шүү) бас их танхимд нийтээрээ иддэг хоол ундаа санаж байлаа. Шилтгээний хамгийн дээр байдаг унтлагын дугуй өрөөн дахь дөрвөн хөлтэй ор нь хичнээн сайхан гээч. Уульнууд шуудан зөөгөөд л бас Хориотой ойн цоорхойд сайхан сэтгэлтэй ойн сахиул Хагрид суудаг юм. Ялангуяа шидтэнгүүдийн тоглох дуртай квиддичээ бүр ч их үгүйлж байв. Өндөр модон дээрх зургаан цагариг хөөрөгч дөрвөн бөмбөг шүүр унасан арван дөрвөн тоглогч.

Вернон ах нь зээгээ гэртээ авчраад хамгийн түрүүнд сурах бичиг, шидэт саваа, жанч, шинэ загварын «Нисдэг лус-2000» шүүр зэрэг шидэт зүйлүүдийг нь хураан авчээ. Энэ бүхнийг шатны хонгилд хийгээд цоожилчихсон аж. Зуны даалгавраа хийх эсэх нь Дурслийханд огт хамаагүй хэрэг. Гэтэл Харрийг бэлтгэл сургуулиа хийхгүй бол тэнхимийн шигшээгээс хөөх болно. Судсанд нь ид шидтэний дусал ч цус байхгүй жирийн хүмүүсийг шидтэнгүүд магл гэдэг нь тэдний хэлээр «эгэл хүмүүс» гэсэн үг юм. Бүгд биш ч гэлээ эгэл хүмүүсийн хувьд гэртээ шидтэн байлгах нь шившигт тооцогдоно. Ид шидийн ертөнцтэй ямар ч холбоогүй байхын тулд Вернон ах маань Хэдваг уулийг хүртэл цоожтой байлгана.

Харри хүү Дурслийн гэр бүлд онцгой содон байлаа. Вернон ах нь болохоор өтгөн хар сахалтай хүзүү гэхээр юмгүй намбатай эр. Харин Петунья эгч нь морь шиг царайтай туранхай цонхигор бол улаан хацартай, цайвар цагаан царайтай Дадли болохоор торойтой тун ч төстэй.

Харри бол жижигхэн туранхай, дугуй шилнийхээ цаанаас орчлон хорвоог гялалзсан ногоон нүдээрээ харна. Хөө шиг хар үс нь ямагт арзайж, духан дээрх цахилгаан шиг нарийхан сорви нь арван нэгэн жилийн тэртээ Харрийг Дурслийн гэрийн үүднээс олж авахад тохиолдсон эмгэнэлт явдлын гэрч болон хоцорчээ.

Тэгэхэд ердөө л ой хүрч байсан юм чинь үхлээс яаж мултарснаа огт санахгүй байх нь мэдээж.

Одоо болтол нэрээрээ бусад шидтэнгүүдийг сүрдүүлдэг агуу их хар шидтэн лорд Волдеморт Харрийн гэр бүлийнхэнд хараал хийсэн билээ. Эцэг эх хоёр нь үрэгдсэн ч

хараал жатга хүүд нөлөөлөөгүй юм. Духан дээрх тахир сорви л өнгөрсөн явдлыг сануулна. Хамгийн хачирхалтай нь энэ явдлын дараа харгис Волдемортын ид

шидийн хүч нь яагаад ч юм барагдчихжээ. Ингээд л Харри маань цорын ганц хамаатан болох ээжийнхээ эгч түүний нөхөр хоёрын гэрийн үүдэнд хүргэгдсэн юм даа. Тэдэнтэй хамт арван жил амьдрахдаа, эргэн тойронд нь заримдаа хачирхалтай зүйл болж байгааг огт ойлгодоггүй байв. Эцэг эхээ машины осолд амь үрэгдсэний дараа энэ сорви духан дээр чинь үлдсэн гэж нагац ахыгаа ярихад хэзээ ч эргэлзэж байсангүй.

Тэгтэл жилийн өмнө үнэнийг өгүүлсэн захидал «Хогвартс»-аас авсан билээ. Тэнд суралцахаар явж байхдаа гэнэтхэн алдартай хүн бүр сорвиор нь таньж байна гэдгийг мэдсэн юм.

Харин одоо зуны амралт болж ахиад л энэ гэрт шаварт хутгалдсан золбин нохой шиг аашлуулан сууж байна.

Өнөөдөр төрсөн өдөр нь ч гэлээ хэн ч энэ тухай санасангүй. Тэд бялуу ч өгдөггүй юм чинь бэлэг сэлт горьдох хэрэггүй. Гэхдээ бүр мартана гэдэг ... Вернон ах учир битүүлэг ханиалган Харрийн гуниг бодлыг тасалдууллаа. Вернон ах нь:

- Өнөөдөр бидний хувьд чухал өдөр шүү дээ ... гэжээ. Харри санамсаргүй байснаа гайхлаа.

Тэгтэл:

- ... Яагаад гэвэл амьдралдаа хамгийн том гэрээ хийнэ гэж ноён Дурсль үргэлжлүүлжээ.

Харри ахиад л талхаа зажилж байв. Энэ гэрээ гэдэг нь түүнийг бүр залхааж гүйцжээ. Сүүлийн хоёр долоо хоног зөвхөн үүний тухай л ярьцгаасан юм. Өнөө орой барилгын пүүсийн баян эзэнд зориулж зоог барих ажээ. Өрөм хийдэг хувийн үйлдвэрийн эзэн Вернон ах түүнтэй ашигтай гэрээ хийх санаатай байгаа юм. Зочин эхнэртэйгээ хамт ирнэ.

- Өнөө орой яах ёстойгоо дахин нэг давтал гэмгүй байхаа. За, яг найм гэхэд бүгд байраа эзэлсэн байх ёстой. Тэгээд Петунья чи ... гэж Вернон ахыг хэлэхэд:

- Зочны өрөөнд. Миний үүрэг бол эрхэм зочдыг хүндэтгэн мэндлэх ёстой гэж Петунья эгч дэмжлээ.

- Сайн байна. Харин Дадлик?

- Би зочдод үүд нээж өгнө. Ноён Мейсон, хатагтай Мейсон та бүхэн хувцасаа өгнө үү! гэж хэлнэ гээд бүдүүн хүү инээмсэглэв.

- Ай даа! Тэд чамайг шууд л хайрлах болно! гэж Петунья эгч уулга алдлаа.

- Сайна байна. Дадлик гэж ноён Дурсль хүүгээ магтаад Харри руу хандан:
 - Чи яах ёстой билээ? гэв.
 - Өрөөнд огт байхгүй юм шиг чимээгүй сууна гэж Харри нэгэн хэмээр дуржигнууллаа.
 - Нэг ч авиа гаргаж болохгүй шүү! Дараа нь би тэднийг зочдын өрөөнд дагуулж ороод Петуньяд танилцуулна. Тэгээд уух юм өгнө. Найм арван тав гэхэд ...
 - Би зочдыг хоолонд урина гэж Петунья эгч албархуу хэлэв.
 - Тэгээд Дадлик ...
 - Та бүхэн хоолны өрөөнд орцгооно уу гэж байхгүй хүмүүсийн зүг тарган булцгар гараа сунган хэлснээ эцэг, эхээ бардамхан хараад:
 - За ямар байна? гэлээ.
 - Бяцхан үр минь, ёстой эр хүн! гэж нагац эгч нулимс гүйлгэнүүлэн бахархана.
 - Харин чи? гэж Вернон ахыг ширүүн харан асуухад:
 - Өрөөнд огт байхгүй юм шиг чимээгүй сууна гэж Харри давтлаа.
 - Зүйтэй. Хоолны үеэр зочиддоо хүн бүр аятайхан үг хэлэх болно. Петунья юу бодож олсон бэ?
 - Ноён Мейсон таныг гольф сайн тоглодог гэж Вернон маань ярьсан шүү!
Хатагтай Мейсон та энэ гайхамшигтай пальтог хаанаас худалдаж авснаа хэлж болохсон болов уу?
 - Маш сайн! Харин Дадлик?
 - Өнгөрөгч долоо хоногт бид хичээл дээрээ «Миний шүтээн» гэдэг сэдвээр зохион бичлэг хийсэн юм. Би ноён Мейсон таны тухай бичсэн.
- Энэ ч арай дэндлээ.
- Петунья эгч хэт догдолсондоо болоод хүүгээ цээжиндээ наан уйлахад Харри ширээн доогуур оров. Чимээгүй ч гэсэн инээж байгааг нь харчихвал балрана биз дээ.
- Харри чи?
 - Харри ширээн доороос гарч инээхгүй байхыг хичээн:
 - Өрөөндөө огт байхгүй юм шиг чимээгүй сууна гэж давтлаа.
 - Яг зүйтэй. Мейсоныхонд би чиний тухай юу ч яриагүй шүү. Тэд үүнийг мэдэх шаардлагагүй ... Хоолны дараа Петунья тэднийг цай уулгахаар зочны өрөөнд урих үеэр би өрөмнийхөө тухай санаандгүй мэт ярина. Оройн мэдээ эхлэхээс өмнө

гэрээнд гарын үсэг зурах юм. Тэгээд л маргааш өглөө дэлгүүрээр явна даа. Майоркад амрахын тулд юм авах хэрэгтэй байна!

- Одоо Дадли бид хоёр явж хувцас худалдаж авна. Петунья чи бүх юмыг сайхан янзалчих. Харри минь, түүний хөлд орооцолдон бүү саад болоод байгаарай.

Харри цэцэрлэгт очлоо. Нарлаг сайхан өдөр байв. Тэрбээр ногоон дээгүүр явснаа сандал дээр сууж: «Төрсөн өдрийн мэнд хүргэе, төрсөн өдрийн мэнд хүргэе ...» гэж гунигтайхан аялав. Ил захидал ч үгүй бэлэг ч үгүй үдэш болоход бүр ч хэцүү.

Ийш тийш хааш яашхан харж байснаа таримал бургасан хашаан дээр харц нь тогтлоо. Түүний сэтгэл санаа хэзээ ч ийм гунигтай, ганцаардмал байсангүй. Дэргэд

нь Рон Уизли, Гермiona Грэйнджер гээд түүний сайн андууд алга. Тэд түүнийг бүр мартжээ. Бүхэл зуны туршид ганц ч захиа ирсэнгүй! Зургадугаар сард уг нь Рон түүнийг урьж байсан шүү дээ.

Харри торыг шившлэгээр нээж анд нар лугаа Хэдвиггаар захиа илгээх гэж хичнээн удаа хүссэн гээч. Гэхдээ ингэвэл хэрэг мандах байлгүй. Насанд хүрээгүй шидтэнгүүд сургуулиас гадуур ид шид үзүүлэх хатуу хориотой. Үнэндээ Вернон ах хоригийн тухай юу ч мэдэхгүй л дээ. Хэрэв мэддэгсэн бол зээ дүүгээ аль эрт шүүр, шидэт саваатай нь хамт хонгилд цоожлох байсан байлгүй. Хэрэв тэднийг шивхний цох ч юм уу, өөр ямар нэгэн амьтан болгон хувиргачихвал тэд ямар их айх бол доо. Эхний хоёр долоо хоногт Харри зугаатай юм бодож олжээ. Дадлид дургүй нь хүрэхээрээ нэг юм хэлээд л салхи шиг хийсгэчихдэг байв. Андаас нь захидал ирэхгүй болохоор шидэт ертөнц зэрэглээ болон хувирч үеэлээ даажигнан тоглохоос ч дургүй хүрнэ. Гэтэл тэд өнөөдөр төрсөн өдрийг нь ч санахгүй байдаг. Сургуулийнхаа хэнээс ч хамаагүй ямар ч хамаагүй сураг дуулах юм сан. Эвлэршгүй байдаг Драко Малфой байсан ч хамаа алга. Хогвартс зүүд биш байсан гэдгийг л итгүүлж байвал болоо.

Сургуульд ч янз бүрийн л явдал гардаг байлаа. Гуравдугаар улирлын сүүлчээр Харри Волдеморттой улаан нүүрээрээ тулгарсан билээ. Хэдийгээр хар лорд маань өнгөрсөн үеэ бодвол сүүдэр төдий байсан ч тийм муухай амьтантай хэн тааралдая гэж бодох вэ дээ. Юутай ч атугай хар шидийн заль, овсгоог хэн ч гүйцэхгүй юм даг. Хүчин чадлаа эргүүлж олохын тулд тэр хэний ч өмнө сөхрөхгүй нь лавтай. Үнэндээ бол Харри хоёрдахь удаагаа амь гарсан хэрэг. Түүний амь нас дээсэн дөрөөн дээр байсан шүү. Тэр өдрөөс хойш нэг бус долоо хоног өнгөрсөн ч шөнө сэрэхэд нь хүйтэн хөлс цувчихсан байна. Ахиад л аймшигт царай ухаангүй нүд зүүдлэгдэнэ. Үнэхээр аймаар. Одоо Волдеморт хаана байдаг бол?

Харри гэнэтхэн биеэ хөвчлөв. Бутан дундаас хэн нэг хүн түүнийг ажиглаад ч байх шиг. Харрийг сандлаас үсрэн босоход өтгөн навчин дунд хоёр том ногоон нүд жирсхийн үзэгджээ.

- Өнөөдөр ямар өдөр гэдгийг би мэднээ гэх Дадлийн тохуутай дуу сонсогдов.

Тэр дөхөж ирлээ.

Том нүд анивчсанаа алга болчихжээ.

- Юу гэнээ? хэмээн Харри бургасан хашаанаас нүд салгалгүй асуув.
- Өнөөдөр ямар өдөр гэдгийг би мэднэ гэж Дадли ойртон ирээд давтан хэллээ.
- Агуу их амжилт! Чи долоо хоногийн бүх гаригийг цээжилчихсэн байна шүү ээ.
- Өнөөдөр чиний төрсөн өдөр. Баяр хүргэсэн ил захиадал чинь хаана байна?

Танай тэр муухай сургуульд чиний анд гэж байдаггүй юм уу? гэж Дадли хэлээд шоолон инээлээ.

- Сургуулийн тухай ярьсныг чинь ээж чинь л бүү сонсоосой доо гэж Харри хөндий байдалтай хэлэв.

Дадли бүдүүн гэдсэндээ тогтохгүй шувтрах өмдөө татна.

- Чи яагаад бут руу ингэтлээ ширтээд байгаа юм бэ? гэж Дадли сэжиглэнгүй асуув.
- Шившлэг хийж байгаа юм. Тэгвэл сайн шатна даа. Дадлийн торойнх лугаа хацар нь цайж буцан гүйх зуураа ээрч:
- Чи ... чи ... тэгэх ёсгүй. Чамайг ид шид үзүүлэх юм бол гэрээсээ хөөнө гэж аав хэлсэн. Харин ... чи хаачих вэ дээ? Чамд найз нөхөд байхгүй юм чинь! гэлээ.
- Жокер-покер, фокус-покус, фигли-мигли гэж Харри сүрдүүлэн дуржигнууллаа.
- Ээж ээ! Ээж ээ! Энэ чинь ... юу яагаад байна! гэж орилсоор Дадли гэрлүүгээ гүйжээ.

Харри үүнийхээ төлөө хатуу шан хүртжээ. Энэ үг юу ч биш, хүүг нь яагаа ч үгүй, бас хашаа ч зүгээр гэдгийг Петунья эгч шууд л мэджээ. Гэхдээ зээгээ айлгахаар хайруулын тавгаа далайхад нь Харри бултаж амжсан ч түүнийг бишгүй их ажлаар даржээ.

- Үүнийгээ дуусгахгүй юм бол үдийн хоол иднэж гэж бүү бодоорой гэж эгч нь хэлээд ажил төрөл рүүгээ орлоо.

Дадлийг гуравдахь зайрмагаа идэж байхад Харри алчуур аван цонх машин угааж дараа нь зүлэг тайрч тэгшлэн цэцгийн мандлыг бордож янзлаад сарнайн бутыг услаж байв. Нар энэрэлгүй шарж ядарсан хүүгийн ам цангана. Одоо бас сандал будах ёстой.

Уул нь Дадлийг тоох хэрэг байхгүй л дээ. Гэхдээ түүний үгэнд гомдохгүй байж болно гэж үү? Үнэхээр сургуульдаа анд найзгүй хэрэг үү?

«Нөгөө алдарт Харри Поттер маань цэцгийн мандлыг шивхээр бордож байгааг тэд харсан ч болоосой» гэж гашуудан бодлоо. Ууц нь хөшиж нүүрэнд нь хөлс бурзайна.

Долоо хагаст эгч нь түүнийг арайхийн дуудлаа.

- Явж хоолоод! Дэвссэн сонин дээгүүр яваарай!
Тэгэхгүй бол балиартуулчихна шүү.

Харри гал зуухны гял цал болсон, сэрүүн өрөөнд орлоо. Хөргөгч дээр баярын бялуу харагдана. Цохисон цөцгий нил цэцэг шиг чихрээр чимэглэсэн ажээ. Халуун зууханд зочдод зориулан шарж буй гахайн гуя хорхой хүргэнэ шаржигнана. Петунья эгч нь түүнд хоёр зүсэм талх, хэрчим бяслалтай хамт тавган дээр тавиад өгчээ. Тэрбээр оройн гоёлд зориулан хул шаргал даашинз өмсчээ.

- Алив хурдлаарай. Зочид одоохон ирнэ! гэж яаруулна.

Харри гараа угаагаад зүдэгхэн хоолоо идэхээр яравчлав. Сүүлийн зүсэм талхаа идэж амжаагүй байтал эгч нь түүнийг ширээнээс хөөн:

- Өрөөндөө оч! гэж занган тушаажээ.

Зочны өрөөний дэргэдүүр өнгөрөхдөө Вернон ахыгаа бас Дадлийг харав.

Тэр хоёр шинэхэн хувцсаа өмсөөд эрвээхэй зангиа зүүжээ. Тэгээд дээш гарснаа сүүлчийн удаа үүдний өрөөг эргэн харлаа.

- Сайн бодоорой нэг л авиа гаргах юм бол дэмий шүү гэж Харрид чухам л үүнийг сануулах санаатай зочны өрөөнөөс гарч ирсэн нагац ах нь хэлжээ.

Харри өлмий дээрээ гэтсээр өрөөндөө ороод дотроос нь түгжин чимээгүй суулаа. Харин түүний орон дээр бас нэг хүн сууж байв.

БҮЛЭГ 2: ДОББИ АЮУЛЫН ТУХАЙ АНХААРУУЛАВ

Харри гайхсандаа арай л хашгирчихсангүй тэслээ. Орон дээр нь сарьсан багваахай шиг дэлдэн чихтэй, одон бөмбөг шиг бүлтгэр ногоон нүдтэй одой хүн суугаад харж

байв. Харри түүнийг шууд танилаа. Энэ хүн л өглөө түүнийг таримал бургасан хашааны цаанаас харж байсан юм,

Одой хүн түүнийг нүд салгахгүй ширтэхэд Харри ч бас түүнийг харсаар.

- Ноён Мейсон, хатагтай Мейсон та бүхэн хувцасаа өгөх ажаамуу? хэмээн

Дадлийн хүндэтгэлтэй өгүүлэх нь дороос сонсдоно.

Одой хүн орон дээрээс үсрэн бууж урт нарийхан хамрынхаа үзүүрийг хивсэнд хүртэл тонгойн бөхөлзөв. Тэрбээр хөл гараа гаргах цоорхойтой хуучин дэрний уут углажээ.

- Сайн байна уу гэж Харри түгдчин хэлэв.

- Харри Поттер! Добби тантай танилцах гэж аль эртнээс хүссэн юм ... Энэ бол их завшаан гэж урилгагүй зочин маань жингэнэсэн дуугаар хэлэв (Зочны өрөөнд байгаа Вернон ах бараг сонссон байлгүй дээ).

- Баярлалаа гэж Харри хэлэв.

Харри хана даган явж бичгийн ширээнд хүрснээ Хэдвиг уулийн унтаж байгаа том торны дэргэдэх сандал дээр суулаа. Танихгүй хүнийг юун хүн гэдгийг асуумаар байсан ч онцгүй гэж үзээд зөвхөн нэрийг нь асуулаа.

- Добби, ноёнтон минь. Зүгээр л Добби. Добби гэрийн үйлчлэгч, хүсвэл сахиул ч гэж болно.

- Үнэхээр үү? Өнөөдөр ... гэрийн үйлчлэгчтэй танилцаад байхаар өдөр ч биш л дээ. Гэхдээ бүү гомдоорой гэж хэлэхдээ Харри өөр үед сэн бол үнэхээр гайхах байсан хэдий ч энэ удаа үүнтэй мантай.

Дор Петунья эгчийн өндөр дуугаар хуурамч инээх нь дуулдана. Добби үйлчлэгч толгойгоо унжуулжээ.

- Тантай танилцахад таагүй байна гэж бүү бодоорой. Гэхдээ би ... та надад ... яаж гэж ирснээ тайлбарлаж өгөхгүй юу гэж Харри түүнийг яаран тайгаруулав.

- Тийм ээ, ноёнтоон. Тэгэлгүй яахав. Добби ирэхдээ ... үүнийг хэлэхэд хэцүү л дээ ... Добби яаж эхлэхээ мэдэхгүй байна ...

- Суугаач гэж хэлээд Харри ороо заалаа.

Тэгтэл үйлчлэгч гэнэтхэн чангаар уйлахад Харри бүр айжээ.

- Суу гэнэ шүү! Хэзээ ч ... хэзээ ч ... гэж тэрбээр чанга хэллээ. Дор хүмүүс ярилцахаа больсон бололтой.

- Уучлаарай. Би таныг гомдоох гээгүй юм шүү гэж Харри шивнэв.

- Юутай гомдолтой! Нэг ч шидтэн Доббитой эн тэнцүү зиндаанд ярьж, хэзээ ч суухыг урьж байгаагүй юм даа ... гэж үйлчлэгч санаа алдав.

- Хүүе, та чимээгүй бай гэж Харри гуйгаад царайгаа аль болохоор төв түвшин байлгахыг хичээн түүнийг ор луугаа түлхлээ.

Үйлчлэгч орон дээр авиран гарч аятайхан суугаад мэгшиж байгаа нь том үнгэгдсэн хүүхэлдэй шиг харагдана. Тэгээд нулимсаа арчсанаа маргад адил гялалзах том нүдээрээ Харрийг гайхан харлаа.

- Хүмүүжил сайтай шидтэн танд цөөн тааралдсан юм байлгүй дээ гэж Харри түүнийг тайвшруулах санаатай хэлэв.

Добби толгой дохино. Тэгснээ гэнэтхэн цонхны тавцан дээр үсрэн гараад толгойгоороо цонхны жаазыг мөргөн:

- Муухай Добби! үзлийн муухай Добби! гэж хашгирч гарав.

- Үгүй ээ, болохгүй. Та чинь яаж байнаа? гэж Харри шивнэн хэллээ.

Харри сандлаасаа үсрэн босоод гэрийн үйлчлэгчийг ахиад л орон дээрээ суулгав. Тэгтэл гайтай юм шиг Хэдваг сэрчихээд чанга дуугаар гууглан даль жигүүрээрээ торны ханыг галзуурсан мэт балбаж гарчээ.

- Добби өөрийгөө шийтгэх ёстой, ноёнтоон. Добби гэр бүлийнхээ тухай муу юм ярьсаан, ноёнтон минь ... гэж толгойгоо цохьсондоо нүд нь яльгүй сөлийсөн үйлчлэгч маань хэллээ.

- Гэр бүлийнхээ тухай гэнээ?

- Эздийнхээ тухай, ноёнтоон ... Добби гэрийн үйлчлэгч болохоор эцсээ хүртэл нэг л байшинд байж нэг л гэр бүлд үйлчлэх тавилантай ...

- Одоо тэд таныг хаана байгааг мэдэх үү? гэж Харри сониучирхав.

- Үгүй ээ, ноёнтоон. Яалаа гэж! Үүний төлөө Доббийг хатуу шийтгэх болно, Маш хатуу шүү, ноёнтоон! Чихийг маань пийшингийн хаалганд хавчуулдаг юм. Хэрэв тэд энэ тухай хэзээ нэгэн цагт мэдэх аваас ... гэж үйлчлэгч уулга алдлаа,

- Өөрөө өөрийгөө шийтгэсэн гэдгийг чинь тэд мэдэхгүй гэж үү?

- Добби үүнд эргэлзэж байна, ноёнтоон. Добби өөрийгөө дандаа шийтгэдэг юм.

Эзэд тэгж зарлигддаг байхгүй юу. Шийтгэл давхардах нь илүүдэхгүй гэгцээдэг юм ...

- Та яагаад тэднийг хаячихдаггүй юм бэ? Яагаад оргодоггүй юм?

Эзэн чөлөөлсөн цагт л Добби үйлчлэгч чөлөөлөгдөж магадгүй. Гэхдээ энэ гэр бүл хэзээ ч чөлөөлөхгүй л дээ ... Добби үхэн үхэтлээ тэднийд зүтгэх болно.

- Надаас дор заяатай амьтан байхгүй гэж боддог байлаа. Энд уг нь ахиад ганцхан сар л болох юм! Маглууд танай эздийг бодвол сахиулсан тэнгэр юм

байна. Танд хэн нэг нь туслаж болдоггүй юм уу? Үгүйдээ би туслаж болох уу?

Харри ингэж хэлэнгүүтээ зогслоо. Учир нь Добби талархан чангаар дуу алджээ.

- Чимээгүй байгаарай. Хэрэв Дурслийнхан ямар нэг юм сонсвол, хэрэв тэд гэрт нь үйлчлэгч байна гэж мэдвэл ... гэж Харри цөхрөн шивнэв.

- Доббид туслаж болох уу гэж Харри Поттер хэллээ ... Добби таны алдар хүндийг олонтаа сонссон авч таны сайхан сэтгэлийг үзээгүй билээ.

Харрийн хацар нүүр халуу оргин:

- Миний алдар хүндийн тухай яриа бол дэмий зүйл. Би Хогвартсын хамгийн сайн сурагч ч биш. Гермiona л хамгийн сайн сурдаг юм. Түүнд ... гэснээ харри яриагаа үргэлжлүүлж чадсангүй. Гермiona гэнэтхэн санагдахад зүрх нь догдолжээ.

- Харри Поттер бол даруухан эелдэг. Харри Поттер Хэцүү нэртийг дийлснээрээ түрээ барьдаггүй гэж Добби бишрэн хэлэхдээ бүлтгэр нүд нь гялалзана.

- Волдемортгыг хэлж байна уу? гэж Харри асуулаа. Добби дэлдгэр чихээ алгаараа таглаад:

- Энэ нэрийг бүү хэл, ноёнтоон. Дурдахгүй байхыг хүсье! гэв.

- Өршөөгөөрэй. Олон хүнд энэ нэр таалагддаггүйг би мэднээ. Миний анд Рон

... гэж харри яаран уучлал гуйлаа.

Тэгээд чимээгүй болчихлоо. Энэ нэрийг санахад хэцүү байжээ. Добби урагш тэмүүлж, нүд нь машины гэрлээс ч хурц гялалзана.

- Харри Поттер хар Лордтой дахин тааралдсан гэдгийг Добби сонссоон. Ердөө хэдхэн долоо хоногийн өмнө ... Харри Поттер ахиад л амьд үлдсэн гэж сөөнгөдүү дуугаар хэлэв.

Харри толгойгоо дохилоо. Доббийн бүлтгэр нүдэнд нулимс мэлтэрчээ.

- Ай даа, ноёнтон минь. Харри Поттер бол ач тустай, зоригтой! Тэр маш олон ялалт байгуулсан! Харин Добби түүнийг хамгаалж аюулын тухай анхааруулах гэж ирсэн юм. Дараа нь чихээ пийшингийн аманд хавчуулах л байлгүй ... гэж хэлээд бохир дэрний уутныхаа булангаар нүүрээ арчлаа. Тэгснээ:

Өрөөнд нам гүм болж Вернон ахын яриа хутга сэрээ харших дуу дороос сонсдоно.

- Я-я-яагаад? Би сургуульдаа явах ёстой. Хичээлийн шинэ жил есдүгээр сарын нэгэнд эхлэнэ. Энд тэсэх арга алга гэдгийг та мэдэхгүй л дээ. Би энд чинь гадны хүн.

Би танай ертөнцөд л байх л ёстой. Ид шидтэний сургуульд гэж Харри өөрийн эрхгүй ээрэн хэлжээ.

- Үгүй ээ, үгүй! Харри Поттер түүнд аюулгүй газарт байх ёстой. Харьцуулахын аргагүй агуу их Харри Поттер бол бүх нийтийн бахархал. Хогвартсад Харри Поттерыг аймшигтай явдал хүлээж байна! гэж Добби далбагар чихээ дэлдэгнүүлэн толгой сэгсэрлээ.

- Ямар аюул? гэж Харри улам их гайхжээ.

- Нууцаар үгсэж байна. Ид шидтэний сургуульд энэ жил аймаар юм их болно.

Добби энэ тухай аль эрт бүр хэдэн сарын өмнө мэдсэн шүү, ноёнтоон Харри

Поттер өөрийгөө аюул оруулах эрхгүй. Тэр бүгдэд их хэрэгтэй, ноёнтоон!

- Бас ямар аймаар юм байдаг билээ? Хэн сэдэж байгаа юм бол? гэж Харри шуудхан асуулаа.

Добби хачирхалтай дорой дуу гаргаснаа ахиад л толгойгоороо хана мөргөж эхлэв.

- Болтугай, болтугай. Таныг юм хэлж чадахгүй гэж би мэдэж байна. Гэхдээ та надад яагаад анхааруулж байгаа юм бэ? гэж хэлээд Харри түүнийг болиулах санаатай гараас нь зуурч байснаа гэнэтхэн ухаарч:

- Байзаарай! Энэ чинь нөгөө Вол ... уучлаарай, Хэцүү нэрттэй холбоотой юм уу? Хэрэв чадмааргүй бол бүү хариулаарай. Толгойгоо дохих юм уу, сэгсэрч болно шүү дээ гэж хэлэхдээ Доббийн дух хананд ойрхон байхыг анзаарлаа.

Добби толгойгоо алгуурхан сэгсрэв.

- Үгүй ээ, ноёнтоон. Энэ бол Хэцүү нэрт биш гэж үе үеэр нь таслан хэлсэн авч нүд нь улам бүлтийжээ.

Добби түүнд ямар нэг юм сануулах гээд байгааг Харри мэдлээ. Тэгээд таахыг оролдож:

- Тэр бас тийм муухай ах дүүтэй юм уу? гэв.

Добби толгойгоо улам хүчтэй сэгсэрч, нүд нь аяганаасаа бүлтрэн гарах дөхжээ.

- За яахав. Хогвартсад байхад хэн надад аюул учруулах гээд байгааг төсөөлж чадахгүй юм. Тэнд Дамблдор байгаа. Та Дамблдорыг мэднэ биз дээ? Добби толгой дохин:

- Мэдэлгүй яахав. Альбус Дамблдор бол Хогвартсын түүхэнд хамгийн агуу захирал Добби үүнийг мэднээ. Тэр ч байтугай Хэцүү нэртийг ид байхад нь ч Дамблдор түүнээс дутахааргүй хүч чадалтай байсныг Добби соссон юм. Гэхдээ ноёнтон минь, Дамблдорын хүчрэхээргүй дайснууд бий шүү ... Тэднийг нэг ч шидтэн хүндэлдэггүй юм ... гэж Добби шивнэн хэллээ.

Харрийг нүдээ цавчиж амжаагүй байтал Добби орноос үсрэн буугаад ширээний дэнлүүг шүүрэн авч өөрөө өөрийгөө шийтгэн хашгирч толгой дундуураа балбаж гарлаа.

Дор байсан эзэд, зочид цөм чимээгүй болжээ. Вернон ахыгаа хонгилоор явахыг сонссон Харрийн зүрх түгшин булиглав.

- Дүрсгүй Дадли ахиад л зурагтаа унтраалгүй орхичихож! гэж ах нь үглэнэ.
- Хурдхан шүүгээнд ор! гэж Харри шивнэн хэлээд Доббийг шүүрэн авч шүүгээ рүү түлхээд хаалгыг нь хаамагцаа ганцхан үсрэн орон дээрээ суучихлаа. Яг энэ агшинд үүдний бариул эргэв.
- Чөтгөр ав ... юу болоод байна? гэж Вернон ах шүднийхээ завсраар сийгүүлэн хэлээд уурлаж минчийсэн царай гаргах ойртож ирээд:
- Намайг «японууд гольф яаж тоглодог вэ» гэдэг сайхан шогоо ярьж байтал чи тасалдуулчихлаа. Ахиад чимээ гаргах юм бол энэ дэлхий дээр төрсөндөө харамсах болно шүү! гэв.

Ингэж хэлээд хүнд алхалсаар Харрийн өрөөнөөс явлаа,

Харри айсандаа чичирсээр өлмий дээрээ гэтэн шүүгээ рүү очоод Доббийг гаргалаа.

- Энд намайг ямар байгааг хараа биз дээ? Яагаад Хогвартс руу буцах хэрэгтэй гэдгийг ойлгов уу? Энэ бол надад ... үгүйдээ гэхэд анд найз нар минь байгаа цорын ганц газар ...
- Харри Поттерт нэг ч захидал бичдэггүй анд найз нар уу?
- Тэд зүгээр л ... Алив, байзаарай. Миний найзууд захидал бичээгүй гэдгийг чи яаж мэддэг юм бэ? гэж Харри асуулаа.
- Харри Поттер Доббид уурлах ёсгүй шүү. Добби сайн санаж л тэгсэн хэрэг ... гэж үйлчлэгч хөл дээрээ дайвалзан хэллээ.
- Чи миний захидлуудыг хулгайлсан юмуу?
- Захидал цөмөөрөө энд байгаа гэж хэлээд Добби ямар ч атугай Харригаас үсрэн холдсоноо цүндгэр өврөөсөө баахан захиа гаргаж ирэв.

Харри Гермionaгийн нямбай Ронын хайнга тэр ч байтугай Хагрид л бичсэн бололтой муруй саруй бичгийг ялган танилаа.

Добби буланд зогсоод Харрийг айсан байдалтай харна.

- Добби найдсан юм ... нөхөд нь түүнийг мартсан гэж Харри Поттер бодог гэсэндээ ... Харри Поттер сургуульдаа буцаж очихыг хүсэхгүй байх гэсэн дээ

...

Гэвч Харри сонссонгүй. Тэрбээр захидлыг авахаар гараа сунган Добби руу дайртал цаадах нь эвтэйхэн бултаад:

- Хэрэв Хогвартс руу буцаж очихгүй гэж Доббид ам өгөх юм бол Харри Поттер захидлуудыг авах болно, ноёнтоон. Ноёнтоон та өөрийгөө тийм аюулд оруулах ёсгүй шүү! Ахиад сургуульдаа явахгүй гэж Доббид амла гэв.

- Яагаад ч үгүй! Найз нарын маань захидлыг одоохон өг! гэж Харри дуржигнууллаа.

- Та мэдэж ав, ноёнтоон. Добби сүүлчийн аргаа хэрэглэхээс дээ. Өөр арга алга гэж үйлчлэгч гунигтайяа хэлэв.

Тэгээд Харрийг ухаарч амжаагүй байтал Добби өрөөнөөс үсрэн гарч хаалга түлхээд шатаар өнхрөн одлоо.

Харрийн хоолой аргаж зүрх нь хэнхдэгнээсээ үсрэн гарах шахна. Тэрбээр чимээ гаргахгүйг хичээн үйлчлэгчийн араас ухасхийлээ. Шатны сүүлчийн зургаан гишгүүрийг алгасан харайснаа үүдний өрөөний хивсэн дээр муур шиг зөөлхөн чимээгүй буужээ. Добби хааччих ваа? гэж эргэн тойрноо харлаа.

- Ноён Мейсон та нөгөө америкийн сантехникчидийн тухай инээдтэй явдлаа Петуньяд ярьж өгөхгүй юу. Тэр сонирхоно гэж жигтэйхэн гэх Вернон ахын дуу гал зуухнаас сонсдоно.

Харри гал зуух руу гүйн орсноо гайхан зогслоо.

Нагац эгчийн гараа гаргаж хийсэн цөцгий нил цэцгийн чимэг бүхий өнөөх сайхан бялуу агаарт хөвөн хөөрнө. Өрөөний дээд булан Добби атийчихсан сууж байлаа.

- Болохгүй ээ. Тэд намайг ална шүү ... гэж Харри хэллээ.

- Харри Поттер сургуульдаа буцаж очихгүй гэж амлах ёстой.

- Добби минь, гуйя ...

- Үгүй ээ.

Добби түүнийг их л гайхаж харснаа:

- Тэгвэл Добби ингэхээс өөр аргагүй. Таны тулд ноёнтоон гэв.

Ингэж хэлмэгц бялуу их чимээ гарган шалан дээр уналаа. Цөцгий үсэрч цонх ханыг будав. Харин Добби ташуур шиг тас няс хийсэн дуу гаргаад огт байгаагүй юм шиг алга болчихлоо.

Гал зуухны өрөөнд чимээ гарч Вернон ах нь орж ирээд хөлөөсөө толгой хүртэл бялуугаар будагдсан Харрийг харлаа.

Вернон ах нь байдлыг аятайхан болгож ойлгуулах санаатай:

- Манай үеэл дүү л байна ... Энэ жаахан тийм юм аа ... Танихгүй хүнээс их айдаг юм ... Тэгээд л дээр байлгасан хэрэг ... гэж хэлээд Мейсоныхныг буцааж оруулав,

Тэрбээр буцаж ирээд Харрийн гарт шал угаах мод бариулаад зочдыг явсны дараа нэвширтэл балбана гэж заналхийллээ. Петунья эгч нь зайрмаг авахаар хөргөгч руу очиж Харри гал зуухыг цэвэрлэж эхлэлээ.

Вернон ах энэ орой амьдралдаа хамгийн том гэрээ хийж магадгүй байсан ч ахиад л нэг будлиан гарчээ.

Петунья эгчийг зочиддоо гаатай шоколад бүхий хайрцаг өргөн барьж байх үед гэнэтхэн өрөөний цонх нээгдэн асар том ууль далавчаа саржигнуулсаар нисэж ирээд хатагтай Мейсоны толгой дээр захидал унагааснаа харанхуй цэцэрлэг рүү нисэж

одлоо. Хатагтай Мейсон үхлийн тухай мэдээлэгч ирландийн хий үзэгдлээс ч дутахааргүй муухай хашгиран гэрээс гарч гүйлээ. Ноён Мейсон тэндээ үлдээд, эхнэрийгээ ямар ч шувуунаас хамаагүй айдаг, иймэрхүү наргианыг ойлгохгүй гэж тайлбарлаж байлаа.

Харри шал угаадаг модоо барьсан хэвээр гал зуухандаа зогсож байв. Вернон ах нь жижигхэн нүдээ шулмас шиг гялалзуулсаар дөхөж ирээд:

- Унш! Чанга унш! гэж уулийн авчирсан захидлыг Харрийн хамрын өмнүүр даллан хашгирав.

Харри захидлыг авлаа. Тэгээд уншихад:

«Эрхэм ноён Поттер!

Таны оршин суугаа газарт өнөө оройн хорин нэгэн цаг арван хоёр минутад

Левитацын шившлэг хэрэглэсэн тухай мэдээлэл бид хүлээн авлаа.

Насанд хүрээгүй шидтэнгүүд сургуулиас гадуур ид шидийн арга хэрэглэх хориотой гэдгийг та мэднэ. Хэрэв энэ явдал дахин нэг удаа давтагдвал насанд хүрээгүйчүүдийг ид шид хэрэглэхийг хязгаарлах тухай Зарлигийн дагуу (1875 он, зүйл С) дээр дурдсан сургуулиас хөөх болно.

Мөн ид шид үзүүлж үл чадах иргэдийн (эгэлчүүдийг) анхаарлыг татахуйц ид шидийн ямар ч үйлдэл Илбэчин, ид шидтэний олон улсын холбооны нууцлалын журмын дагуу хуулийг ноцтой зөрчсөнд тоогцогдох болно гэдгийг анхааруулъя.

Амралтаа сайхан өнгөрүүлээрэй! Хүндэтгэн ёсолсон, Муфалда Хмелкирк

Ид шидтэний яамны ид шидийг хэтрүүлэхтэй тэмцэх хэлтэс» гэжээ. Харрийг уншиж дуусахад хоолойд нь бөөн юм тээглэв.

- Сургуулиас гадуур ид шид үзүүлэх хориотой гэж чи бидэнд яагаад хэлээгүй юм бэ? Зүгээр л мартчихаж ... огт санасангүй гэх биз ... хэмээн Вернон ах нь довтолоно. Нүдэнд нь уур хилэнгийн оч бадрах шиг Харрид санагджээ.

Вернон ах нь түүн рүү яг л амаа ангайсан аварга том бух нохой шиг харснаа:

- Харин чамд дуулгах таатай мэдээ байна. Өнөөдрөөс эхлээд чи цоожтой байх болно ... Нөгөө сургуульдаа дахин хэзээ ч очихгүй шүү ... хэзээ ч. Илбэ жилбэ үзүүлэх аваас тэртэй тэргүй чамайг хөөх юм чинь! гэлээ.

Тэгээд солиотой юм шиг инээсээр Харрийг дээш чирэн өрөөнд нь оруулав.

Вернон ах дэмий ярьдаг хүн биш ээ. Маргааш өглөө мужаан дуудаж авчраад багахан хөлсөөр Харрийн өрөөний цонхонд модон тор хийлгэв. Тэгээд өөрийнхөө гараар үүдэнд муур орох төдий онгорхой нүх гаргажээ. Хоригдон буй хүүд өдөрт гурван удаа яльгүй идэж уух юм өгөхийн зэрэгцээ өглөө орой хоёр жорлонд оруулна. Үлдсэн бүх л хугацааг Харри Поттер цоожтой өрөөнд сууж өнгөрүүлэх боллоо.

Иймэрхүү байдлаар гурван өдөр өнгөрлөө. Дурслийхан өршөөн нигүүлсэж, энэрэн хайрлах сэтгэл гаргасангүй. Харри орон дээрээ суугаад торлосон цонхоор нар алгуурхан жаргахыг харж байв. Одоо яах ч юм билээ дээ? Цөхөрсөндөө зүрх нь шимширч, чухам яахаа ч мэдэхгүй байлаа.

Ид шид хэрэглээд хорионоос гарчихвал Хогвартсаас хөөгдөх юм инь ямар нэмэр байх билээ. Тэгээд ч Улаан модон гудамжинд сайн сайхан юм болно гэж бодолтгүй. Нэгэнт л шөнө сарьсан багваахай болоод хувиргахгүй юм хойно шөнө тайван унтаж болно гэдгээ Дурслийхан мэдэж байлаа. Одоо Харрид тэдний эсрэг хэрэглэх зэвсэг байхгүй.

Хогвартсад учирч болох ямар нэг аюулаас Добби түүнийг аварсан ч байж болох л юм. Гэтэл түүнийг энд өлсөж үхэх аюул хүлээж байдаг.

Муур орохоор зайтай нөгөө нүх онгойж Петунья эгчийн гар тавагтай шөл оруулж өглөө. Харри өлссөндөө дотор нь харанхуйлж байсан болохоор орноосоо үсрэн босоод тавагтай шөл руу ухасхийв. Шөл хэдийгээр цэв хүйтэн байсан ч хэдхэн агшны дотор хагасыг нь идчихээд, ногооны үлдэгдэлтэй шөлийг нь торонд суугаа Хэдваг уулийн идүүрт хийж өглөө. Ууль өд сөдөө өрвийлгөн Харрийг ажиглангүй харна.

- Хошуугаа унжуулах хэрэггүй ээ. Байгаа нь л энэ гэж Харри уруу царайлан хэлэв.

Хоосон тавгаа муурны нүхний ойролцоо шалан дээр тавиад ахиад л орондоо орж хэвтлээ. Улам их өлсөж байв.

Үлдсэн дөрвөн долоо хоногийг арай үхчихэлгүй өнгөрөөе гэж бодъё л доо. Хэрэв түүнийг есдүгээр сарын нэгэнд ирэхгүй бол Хогвартсынхан үгүйлэх болов уу? Хэн

нэгнийг түүний хойноос явуулах болов уу? Дурслийхныг ятгаж түүнийг суллуулж дөнгөх болов уу?

Өрөөнд харанхуй боллоо. Зовж зүдэрч өлссөндөө ходоод нь хоржигнох Харри баахан асуултанд дарагдсаар түгшүүрт нойронд автлаа.

Түүнийг амьтны хүрээлэнд бэлэглэсэн байна гэж зүүдэлжээ. Тэрбээр «Насанд хүрээгүй шидтэн» гэсэн пайз бүхий торонд суух юм. Хүмүүс түүнийг сараалжин торны цаанаас харахад өлсөж сульдсан тэр өөрөө сүрлэн хэвтэр дээр хэвтэнэ. Олон хүний дунд Доббийн чих нүд харагдахад нь туслахыг гуйн хашгиртал Добби ердөө л:

- Харри Поттер та энд байвал аюулгүй шүү, ноёнтоон гэх юм.

Тэгтэл Дурслы, Дадли нар ирээд сараалжин торны төмрийг саваагаар цохиж гарлаа. Харрийн толгой хагарах шахан өвдөнө.

- Болиоч дээ, надад бүү саад бол ... Би унтмаар байна ... гэж гуйна.

Харри нүдээ нээлээ. Өрөөг сарны гэрэл гийгүүлнэ. Гэтэл үнэхээр хэн нэгэн хүн торны цаанаас харж байв. Сэвхтэй шаргал үстэй урт хамартай юм.

Мэдээж энэ бол түүний дотны анд Рон Уизли байлаа.

БҮЛЭГ 3: «ҮҮР»

- Рон! гэж Харри уруулаа дөнгөж хөдөлгөн хэлэв.

Цонх руу арайхийн мөлхөж очоод ярихад арай амар гэж бодоод нээлээ.

- Рон чи яаж энд ирэв ээ? Чи яагаад ...

Тэгтэл Рон цонхны дэргэд агаарт дүүжигнэх хуучивтар цэнхэр машинд суугаад түүнийг харж байгааг ажиглалаа. Харри гайхсандаа амаа ангайжээ. Түүнийг ингэхэд урд нь сууж буй ихэр Фред, Жорж хоёр ихэр баясан хөөрөв.

- Сайн уу, Харри! гэж тэд нэгэн зэрэг хэллээ.
- Юу болж байнаа? Чи яагаад хариу захиа бичихгүй байсан юм бэ? Би чамайг бараг арван удаа урьсан шүү дээ. Харин өчигдөр аав ирээд, чамайг маглуудын нүдэн дээр илбэ жилбэ үзүүлсэн тэгээд сануулга авсан гэж ярьсан юм. .. гэж Рон хэллээ.
- Би тэгээгүй ээ. Аав чинь яаж мэдсэн юм бол?
- Аав Ид шидтэний яаманд ажилладаг юм. Сургуулиас гадуур ид шид хэрэглэж болохгүй гэдгийг чи мэднэ шүү дээ.
- Чи надад үүнийг хэлэх хэрэг байна уу? гэж хэлээд Харри түүний хөөрөн буй машиныг асуусан янзтай харав.
- Энэ огт хамаагүй ээ. Бид үүнийг түр зуур авсан юм. Аавын машин байхгүй юу. Бид ямар ч ид шид хэрэглээгүй. Амьдарч байгаа эгэл хүмүүсийнхээ нүдэн дээр ид шид үзүүлнэ гэдэг чинь өөр хэрэг шүү дээ.
- Би тэгээгүй гэж чамд хэлээд байна шүү ... Тайлбарлавал бишгүй удна.

Дурслийхан намайг хорьчихоод ахин Хогвартс руу явуулахгүй гэснийг чи сургуульдаа очоод ярьж чадахгүй биз. Хэзээ ч явуулахгүй гэсэн! Харин би ид шид хэрэглэхгүйгээр эндээс гарч чадахгүй. Тэгвэл өнөө яаман дээр чинь намайг гурван өдрийн дотор бүхэл бүтэн хоёр зөрчил гаргасан гэлцэх байлгүй.

- Тайвшир даа, учир нь олдож л таарна. Бид чамайг авах гэж ирсэн юм.
- Амралтынхаа сүүлчийн сарыг чи манайд өнгөрүүлнэ гэж Рон хэлэв.
- Та нар ч бас ид шид хэрэглэх эрхгүй шүү дээ ...
 - Бид хэрэглэхгүй ээ. Хэнийг авчирсныг чи харахгүй байна уу? гэж Рон хэлээд ах нараа заалаа.
 - Энэ уяаг торонд бэхлэ гэж хэлээд Фред олсны үзүүрийг түүнд өгөв.
 - Хэрэв Дурслийхан сэрвэл намайг баллана шүү гэж уяаг сараалжин торны хөндлөвчинд зангидах зуураа Харри шивнэлээ.
 - Одоо хажуу тийшээ холд. Айж чичрэхийн хэрэггүй гээд Фред сайтар хаазлав.

Харри шувууныхаа тор руу очлоо. Хэдвиг ууль эзнийхээ түгшиж байгааг мэдсэн мэт огт хөдөлгөөнгүй сууна.

Машин урагш ухасхийж хөдөлгүүр нь улам хүчтэй дүнгэнэхэд тор өөрийн эрхгүй шажигнан цонхны жаазнаас мултарлаа. Машиныг дээш хөөрөхөд Харри цонхоор сараалжин тороо харав. Тэр нь газраас алд дэлэм хэртэй дээр дүүжигнэн санжиганан. Рон амьсгаадсаар торыг машинд оруулав. Харри хөдөлгөөнгүй болон чагнахад Вернон ах, Петунья эгчийн нь унтлагын өрөөнөөс чимээ гарахгүй ажээ.

Сараалжин торыг машиндаа арайхийж оруулаад Фред ухарсаар цонхонд аль болохоор ойртож ирэв.

- Үсэр гэж Рон тушаалаа.

- Би хичээлийнхээ хэрэгслийг яах юм бэ? Шидэт саваа, шүүрээ ...

- Хаана байгаа юм?

- Шатны хонгилд. Хаалга нь цоожтой байгаа.

- Энэ юу ч биш ээ. Харри минь цонхноос холд гэж урд суудлаас Фред хэлэв. Ах дүү нар болгоомжтой мөлхөн өрөөнд орлоо.

«Би өөрөө л юмныхаа хойноос явдаг байж дээ» гэж бодсон Харри маань Жоржыг халааснаасаа сүлбээр гаргаж ирсээд цоожинд шургуулахыг харж байлаа.

- Маглуудын ийм илбэ сурах нь шал дэмий гэж ихэнх шидтэнгүүд боддог юм.

Харин бид тэгж боддоггүй. Тэднээс бас сурах юм бий шүү. Үнэндээ бол тэд цахилгаан шиг хурдан хийж чаддаггүй юм л даа гэж Фред өгүүлэв.

Тэгтэл цоож торхийн дуугарч үүд нээгдлээ.

- Бид чемоданыг чинь авчрахаар доош буулаа. Харин чи өрөөндөө байгаа хэрэгтэй юмнуудаа цуглуулаад Ронд өг гэж Жорж шивнэв.

- Болгоомжлоорой. Сүүлчийн гишгүүр шажигнадаг юм шүү гэж Харри мөн л шивнэн санууллаа.

Ингээд ихэр хоёр харанхуй шат руу алга боллоо.

Харри эд хогшлоо цуглуулан өрөө дотуураа гүйж цонхоор Ронд өгнө. Тэгээд чемоданаа авахад туслахаар доош яарлаа. Унтлагын өрөөнөө Вернон ахын ханиалгах сонсогдоно.

Тэд чемодан бас бус юмаа эхлээд үүд дараа нь цонх хүртэл чирсээр авчирлаа. Фред машинд суугаад Роны хамт татаж Харри Жорж хоёр өрөөн дотроосоо түлхэж байна.

Чемодан сөөм сөөмөөр ахисаар машинд орох дөхжээ. Вернон ах ахиад ханиалгалаа.

- Амжина аа. Нэг, хоёр түлхээд! гэж Фред тушаалаа.

Харри, Жорж хоёр чемоданыг мөрлөн түлхтэл цонхоор сугаран гарч арын суудал дээр уналаа.

- Одоо боллоо. Хурдан ороод ир! гэж Жорж шивнэв. Харри цонхны тавцан дээр үсрэн гартал:

- Ахиад л нөгөө золигийн ууль! гэж хашгирах Вернон ахын дууг таслан чангаар гууглах дуу ард нь гарлаа.

- Би Хэдвиэг мартчихжээ гэж Харри сандран шивнэлээ.

Тэгээд тавцан дээрээс үсрэн буутал шатны гэрэл мэлсхийн асав. Харри тортой уулиа шүүрэн авч цонхны зүг ухасхийн Жоржын гарт бариулчихаад, хайрцагнаасаа бас нэг юм авах санаатай эргэлээ. Энэ үед хаалга цоожтой гэж бодоод Вернон ах хаалга балбатал аяндаа нээгдчихлээ. Вернон ах үүдний тэнд хэсэг зуур алмайран зогссоноо улангассан бух шиг орилоод цонх руу ухасхийснээ Харрийн хөлөөс зуурч амжлаа.

Ах дүү нар Харрийн гараас барин байдаг чадлаараа машин руугаа чангаана.

- Петунья! Тэр зугтааж байна! Харри оргож байна! гэж Вернон ах хашгирлаа. Ах дүү нар ахиад угз татгал Харрийн хөл Вернон ахын гараас алдуурчээ. Харри

машинд ороод хаалгыг тасхийгэл хаалаа.

- Фред минь, гишгээд бай! гэж Рон хашгирахад машин бүх хурдаараа дээш хөөрч сарыг чиглэн нислээ.

Харри чөлөөтэй болсон гэдгээ ч сайн ухаарч чадахгүй байв! Машины цонхыг нээхэд шөнийн агаар үсийг нь хийсгэнэ. Доошоо харахуй Улаан модон гудамжны байшингууд харьцангуй жижигхэн болчихжээ. Вернон ах, Петунья эгч, Дадли нар Харрийн өрөөний цонхны дэргэд зогсож харагдана.

- Дараа зун уулзацгаая! гэж Харри тэдэнд гараа даллан хэллээ.

Ах дүү Уизли нар инээлдэж ямар нэг юм чанга хашгирцгаан. Аврагдсан нөхөр маань арын түшлэг налж суугаад олон өдрийн туршид анх удаа нүүр дүүрэн инээмсэглэлээ.

- Хэдвиэг гарга. Яахав араас л ниснэ биз. Олон хоног хоригдож байсан юм чинь! гэж Рон хэллээ.

Жорж сүлбээрээ Ронд өгөхөд хормын дараа баясаж хөөрсөн Хэдвиэг хий үзэгдэл адил нисэн гараад машины дэргэд чимээгүйхэн элин хальж явлаа.

- За юу болсон бэ? Хурдхан яриарай гэж Рон тэсэлгүй шаардана.

Харри тэдэнд Доббийн ирсэн тухай түүний анхааруулж хэлсэн зүйлийн тухай хатагтай Дурслийн бялуу хэрхсэн тухай цөмийг ярьж өглөө.

- Хачин юм даа гэж Фред уянгалуулна.

- Худал юм шиг санагдана. Ийм муухай юм хэн сэдэж байгааг тэр хэлээгүй юу? гэж Жорж асуулаа.

- Түүнийг хэлж болохгүй юм шиг надад санагдсан. Хэлэх гэснээ л толгойгоороо хана балбаад унадаг юм гэж Харри тайлбарлахыг оролдоно.

Фред Жорж хоёр бие биеэ харлаа.

- Бүгдийг зохиосон гэж та нар бодож байна уу? гэж Харри асуув.

- Гэрийн үйлчлэгчид ид шид үзүүлж чаддаг ч гэлээ эзнийхээ зөвшөөрөлгүйгээр тэгж зүрхлэдэггүй юм. Юутай ч атугай чамайг сургуулиас гаргахын тулд Доббийг хэн нэгэн хүн чам руу явуулжээ. Хогвартсад чиний өстөн бий юу? гэж Фред хэллээ.

- Бий гэж Рон, Харри хоёр юу ч бодолгүй нэгэн дуугаар хариулав.

- Драко Малфой. Тэр намайг үзэн яддаг юм гэж Харри тайлбарлалаа.

- Драко Малфой гэнээ? Люциус Малфойн хүү юу? гэж Жорж эргэж харан тодруулж асуув.

- Тийм байхаа. Малфой гэдэг чинь ховор нэр. Энэ тийм чухал юм уу? гэж

Харри хэллээ.

- Түүний тухай аавын ярьж байхыг соссон юм. Тэр чинь Хэцүү нэртийн хамтран зүтгэгч. Гол хүмүүсийн нэг нь гэж Жорж ярив.

- Харин Хэцүү нэртийг алга болоход Люциус Малфой өөрийгөө түүнтэй ямар ч холбоогүй гэж бүх хүнийг ятгаж байжээ. Энэ нь худлаа байхгүй юу. Түүний хамгийн дотны туслагч гэж аав ярьсан хэмээн Фред бараг бүтэн эргэж хараад хэллээ.

Харри Малфойн гэр бүлийн тухай иймэрхүү яриа нэг ч удаа сонсоогүй болохоороо найз нарынхаа үгэнд огт гайхсангүй. Гэхдээ л Драког бдвол Дадли хавьгүй элэгсэг дуулгавартай хүүхэд билээ.

- Малфойнх хувийн үйлчлэгчтэй эсэхийг мэдэхгүй юм даа ... гэж хэлээд Харри мөрөө хавчив.

- Доббийн эзэн хэн ч байлаа гэсэн маш баян эртний шидтэний удам байгаа байлгүй гэж Фред хэллээ.

- Магадгүй л юм ... Ээж үйлчлэгч байхгүй гэж гомдоллоод л байдаг юм.

Манайх өнөр өтгөн болохоороо угаах индүүдэх хэрэг их гарна. Тэгтэл ид шид тус болдоггүй. Манайд нэг зөнөг ороолон л дээвэр дээр амьдардаг юм. Бас цэцэрлэг дүүрэн анахай бий. Үйлчлэгч нар зөвхөн дээр үеийн ордон, шилтгээнд л байдаг шүү

дээ. Тэднийг өв залгамжлан дамжуулдаг юм билээ. Манайд үйлчлэгч байхгүй гэж Жорж ярив.

Харри дуугүйхэн ниснэ. Бодоод үзэхэд Дракогийн бүх юм сайхан байдаг юм чинь гэр орныхон нь үнэхээр шидэт алтанд умбан байдаг хэрэг. Тэрбээр Драког том өргөөн дотуураа ихэмсэг алхаж яваагаар төсөөлөн бодлоо. Үнэнч үйлчлэгчээ Харри руу явуулж ямар ч үнээр хамаагүй түүнийг сургуульд явуулахгүй байх талаар ятга гэж хэлсэн байж бүрэн болох юм. Драко Малфой ингэж чаднаа. Тэгэхээр Дobbид дэмий итгэн хэлсэн үгийг нь үнэн гэж бодсон хэрэг болж таарлаа.

- Ямар ч байлаа гэсэн бид чамайг авахаар ирсэндээ баяртай байна. Намайг ямар их санаа зовсон гээч! Бичээд л байдаг бичээд л байдаг хариу байдаггүй. Эхлээд л би Сумыг буруутай гэж бодлоо ... хэмээн Рон ярина.

- Юун Сум бэ?

- Манай шуудан зөөгч ууль. Бүр хөгширчихсэн юм. Захиа аваад нисэж байснаа замд гэнэтхэн уначихна шүү дээ. Би Гермесийг гуйгаад ...

- Юуг тэр вэ?

- Персийн уулийг. Персийг ахлагч болоход аав ээж хоёр түүнд бэлэглэсэн юм гэж Фред урд суудлаас хэллээ.

- Харин Перси надад хэрэгтэй гэж хэлээд уулиа өгөөгүй юм.

- Ер нь Перси энэ зун их хачин байгаа. Өөрийгөө түгжиж аваад л хэдэн цагаар захиа бичээд суучихна. Ахлагчийн тэмдгийг гялалзуулах гээд байгаа юм байлгүй. Хөөе Фред чи хэт баруун тийш яваад байна гэж Жорж хэлээд удирдлагын самбар дээрх луужинг заалаа.

Фред яаран жолоогоо зүүн тийш эргүүлэв.

- Машинаа авсан гэж аав чинь мэдсэн үү? гэж Харри асуухдаа ямар хариу сонсохоо бараг тааварлаж байлаа.

- Үгүй ээ. Аав өнөө шөнө ажиллаж байгаа. Ээжийг сэрэхээс өмнө машинаа гараашт хийж амжих болов уу гэж бодож байна. Биднийг машин авсан гэж ээж мэдээгүй л байгаасай гэж Рон хэлэв.

- Аав чинь Шидтэнгүүдийн яаманд юу хийдэг юм бэ?

- «Маглуудын бүтээлийг хууль бусаар ашиглахтай тэмцэх» гэдэг хамгийн уйтгартай хэлтэст ажилладаг юм.

- Ямар юм ашиглах гэнээ?

- Одоохон тайлбарлая. Жишээ нь, чамд эгэлчүүдийн хийсэн нэг юм байна гэж бодъё. Тэгээд чи түүнийг ид шидээр хувиргасныхаа дараа өөр дэлгүүрт ч юм уу айлд

өглөө гэж бод. Ноднин жил үхсэн нэг хөгшин шулмаст цайны шаазангийн цуглуулга байсан юм. Түүнийгээ дуудлага худалдаан дээр нэг эгэл авгайд зарчихаж л дээ. Тэр авгай нөхдөө цай уулгахаар урьжээ. Тэнд юу болсон гэж санана. Аав маань энэ хэрэг дээр хэдэн долоо хоног ажилласан шүү.

- Арай тодорхой ярьж болохгүй юу?

- Бололгүй яахав. Цуглуулын гүц нь галзуурчээ. Гүц ойр тойрныхоо хүмүүсийг халуун цайгаар шүршиж, ёстонгийн хямсаа нь нэг зочны хамрыг чимхэж тэр хүн нь бүр эмнэлэгт очсон юм. Аав маань бүр аргаа барсан даа. Хэлтэстээ тэд хоёулханаа. Перкин Уорбек гэдэг шидтэнтэй хамт ажилладаг юм. Тэр хоёр ч тарчилсан шүү. Бүр мартуулах шившлэг хэрэглэсэн гээд л бодчих.

- Аавын чинь машин яах вэ?

- Энэ огт хэрэггүй эд! Эгэл хүмүүсийн хийсэн элдэв дээдийн юм бишгүй бий.

Манайд гэхэд л саравч дүүрэн! Авчраад л, хэсэг хэсэг болгоод шившлэг уншин ахин бүрдүүлдэг юм. Эрж хайх хэрэг гарвал өөрийгөө л баривчлах болно байх даа. Ээж загнаад ч нэмэр болдоггүй юм.

- Энэ бидний зам байна. Ахиад арван хором явбал гэртээ очно. Одоо үүр цайж байгаа юм чинь бид амжих байх аа гэж Жорж харанхуйн зүг цонхоор харан хэллээ.

Тэнгэрийн хаяа дорно зүгт яльгүй ягаарчээ.

Фред доошилж эхлэв. Харри дороо харагдах талбайн зурвас, моддын орой ялгахтай боллоо.

- Бид Оттерн-Сент Кэчпоул тосгоны дээр явж байна гэж Жорж мэдэгдэв.

Газар хурдан ойртсоор байлаа. Моддын орой дундуур нарны гэрэл нэвт тусаж харагдана.

- Доошилцгооё! гэж Фред хэллээ.

Машин яльгүй донсолсноо дугуйгаараа газар шүргэв. Тэд хазайсан гарааш бүхий арын жижиг хашаанд газардахад Харри анх удаа Роны байшинг харлаа.

Эхлээд гахайн жижигхэн байр байснаа сүүл сүүлдээ дээд хажуу талаас нь нэмж барьсаар хэдэн давхар болгож барьсан юм шиг санагдах авч ид шидийн хүчээр тогтоосон мэт бөх бат харагдана. («Тийм байж ч магадгүй» гэж Харри боджээ) Улаан вааран дээвэр дээр таван яндан ёрдойно. Орох хаалганы дээд талд «Үүр» гэсэн хаяг өлгөөтэй байлаа. Довжооны хажуугийн зэвтэй том савны дэргэд янз бүрийн өнгө, хэлбэртэй гутал овоолжээ. Хашаанд тарган тахианууд юу ч юм тоншин явцгаана.

Тэд бүгдээрээ машинаас гарлаа.

Бурхан өршөөлөө гэж Рон даруухан хэлэв.

- Сайхан юм аа! гэж бөглүүхэн Улаан модон гудамжаа санасан Харри бахархан дуу алдлаа.

- Одоо дээшээ гарцгаая. Бүгд ор орондоо. Тун чимээгүй явцгаана шүү! Ээж өглөөний цайнд дуудна. Рон чи доош гүйгээд: «Ээж ээ, шөнө хэн ирснийг хараач!» гэж баярлан хашгираарай. Ээж баярласандаа болоод бидний машин авч явсныг мэдэхгүй гэж Фред заавардлаа.

- За тэгье. Харри явцгаая. Би чамд ... гэж Рон хэлснээ дорхноо чимээгүй болж, царай нь цонхийн цайв.

«Үүр»-ний цонх гэрэлтэж довжооны тэндээс тахиануудыг хөөсөөр хатагтай Уизли дөхөж ирлээ. Энэ бол эелдэг царайтай жижигхэн булцгар эмэгтэй байсан ч одоо бар шиг харагдана.

Фред уулга алдлаа.

- Бурхан минь гэж Жорж өөрийн эрхгүй дуугарав.

Хатагтай Уизли тэдний зүг дөхөж ирээд ташаа тулан зогсож тэдний гэмшингүй царайг ээлж дараалан харлаа. Цэцэгтэй хормогч өмссөн агаад халааснаас нь шидэт саваа цухуйна.

- За яав? гэж ширүүн асуулаа.

- Өглөөний мэнд, ээжээ гэж Жорж аль болохоор хөгжилтэй сэтгэл хангалуун харагдахаар хэлэв.

- Намайг яаж сандарсныг та нар ойлгохгүй байна уу? гэж хатагтай Уизли уурсан өгүүллээ.

- Уучлаарай ээжээ, гэхдээ бид ...

Тэр гурав ээжээсээ бараг толгой хэр өндөр ч түүний уурлахаас их л айх ажээ.

- Ор дэвсгэр хоосон байдаг! Ямар ч зурвас алга! Машин байдаггүй! Замын осолд орох нь их байна шүү дээ! Би санаа зовоод эгээ л галзуурчихсангүй! Өөрсдөөсөө өөр хэнийг ч боддоггүй амьтад! Би амьд явах хугацаандаа ийм зүйл үзсэнгүй! Одоохон эцэг чинь ирнэ. Билл, Чарли, Перси гээд ах нар чинь хэзээ ч ингэж байгаагүй юм ...

- ... Тэд огт өөр гэж Фред яриаг дуусгалаа.

- Персийг жаахан ч гэлээ дуурайвал зүгээрсэндээ! гэж хатагтай Уизли Фредийн цээж рүү хуруугаараа чичин өгүүлээд:

- Та нар үрэгдэж, хүн амьтанд харагдаж болох байлаа шүү дээ. Үүнээс болоод аав чинь ажлаасаа халагдвал яана ... гэлээ.

Уур хилэнд эцэс төгсгөл байхгүй мэт санагдана. Тэгснээ айсандаа болоод агийн зогсох Харрийг олж хараад:

- Хүндэт Харри тавтай морилоорой. Орцгоо, одоо цайгаа ууцгаая гэж эелдэгээр инээмсэглэн хэлээд эзэгтэй гэр лүүгээ яарлаа.

Хөөрхий Харри Роныг асуусан байртай харахад цаадах нь дэмжсэн маягтай толгой дохив. Харри хатагтай Уизлийн араас явлаа.

Гал зуухны өрөө жижигхэн давчуу ажээ. Голд нь сандал тойруулж тавьсан модон ширээ байна. Харри наад талын сандлын ирмэг дээр суугаад эргэн тойрноо харав. Тэрбээр шидтэний гэрт байж үзээгүй билээ.

Эсрэг талын хананд нэг зүүтэй цаг дүүжлээстэй байна. Цаган дээр тооны оронд:

«Цайны цаг», «Тахиа хооллох цаг», «Хоцролт» гэх мэт бичгүүд байх ажээ. Зуухны тавиур дээр баахан ном овоолж «Бяслаг хийх шид», «Жигнэхэд хэрэгтэй тарни»,

«Ганцхан агшинд найранд бэлдэхүй. Ид шидийн гайхамшиг!» гэсэн гарчиг бүхий номууд байх юм. Угаагуурын ардах хананд өлгөөтэй хуучин радио гэнэтхэн ярьж гарлаа. Харри бүр буруу сонслоо гэж боджээ. Нэвтрүүлэгч:

«Шидтэнгүүдийн цаг. Одоо нэрт дуучин, ууган Селестина Уорлок дуулна» гэж зарлалаа.

Хатагтай Уизли пийшингийн дэргэд зогсоод өглөөний зоог бэлтгэн зайдас шарах зуураа гэмшсэн хүүхдүүдээ ширүүн харцаар харж:

- Юу бодсоныг чинь би ойлгохгүй юм ... Үнэхээр итгэх арга алга ... Харин Харри чи ямар ч буруугүй шүү гэж хэлээд түүний тавганд найман зайдас хийж өглөө. Тэснээ:

- Артур бид хоёр чиний төлөө санаа зовж байсан юм. Яг өчигдөр бид хэрэв баасан гарагт хариу захидал ирэхгүй бол чиний хойноос явья гэж шийдэж байлаа. Гэхдээ чи бодоод үз л дээ. Нутгийн хагасыг нууц машинаар туулна гэдэг чинь! Хэн нэг хүн харсан байлгүй дээ! гэж хэлээд хатагтай Уизли өндгөн жаврай гурвыг нэмж хийлээ.

Дараа нь бохирдсон сав суулгыг шидэт саваагаараа дохитол сав суулга хоорондоо харшилдан угаагдаж эхлэлээ.

- Үүл доогуур байсан ... гэж Фредийг хэлтэл:

- Юм идэхдээ ярьж болохгүй хэмээн хатагтай Уизли хүүдээ журам сахихыг анхааруулав.

- Тэд Харрийг өлсгөн зовоосон байжээ! гэж Жорж яриаг өөрчлөх санаатай хэлтэл:

Журам чамд ч хамаатай гэж ээж нь хэллээ. Гэхдээ Харрид талх өгөхөөр тос түрхэж байхдаа тийм ч ууртай биш харагдаж байв.

Гэтэл гал зууханд унтлагын урт цамц өмссөн, шаргал үстэй охин гэнэтхэн орж ирээд байдлыг өөрчиллөө. Охин аяархан дуу алдаад гал зуухнаас гарч гүйв.

- Энэ миний дүү охин Жинни. Чиний тухай зунжингаа ярьсан юм гэж Рон Харрид шивнэн хэллээ.

- Тиймээ, ярьдаг байлаа. Одоо гарын үсгийг чинь авна гэж Фред инээмсэглэн хошигнож хэлэв. Тэгээд ээжтэйгээ харц тулгармагц ахиад л таваг руугаа тонгойжээ. Ахиад хэн ч дуугарсангүй. Тавгаа хоосортол дуугүй байлаа. Таваг ч хурдан хоосорчээ.

- Би их ядарчээ. Явж унтаж байз ... гэж эвшээн хэлээд Жорж хутга сэрээгээ тавган дээр тавилаа.

- Үгүй ээ, явахгүй. Өөрийнхөө тэнэгээс болоод шөнөжин унтаагүй юм чинь.

Цэцэрлэг рүү оч. Тэндээс анахайнуудыг гаргах цаг болжээ. Ахиад л цэцэрлэгээр дүүрчихэж гэж ээж нь хэллээ.

- Ээж ээ ...

- Фред Рон та хоёр тийшээ яв. Харин хүү минь чи дээш явж амар даа. Би эднийг энэ муу машинаар чамайг авчир гэж явуулаагүй л дээ гэж Харрид хандан хэлэв.

- Би Ронтой хамт явж болох уу? Анахай яаж хөөдгийг хармаар байна. Би хэзээ ч үзээгүй гэж нойр хүрэхтэй мантай байсан Харри яаран хэллээ.

- Чи сайн хүү шүү, Харри минь. Гэхдээ анахай хөөнө гэдэг чинь уйтгартай ажил шүү дээ. Энэ тухай Туг үс юу гэснийг харъя л даа гэж хэлээд хатагтай Уизли тавиур дээрээс зузаан боть авлаа.

- Бид тэднийг яаж зайлуулахаа мэднэ гэж Жорж эсэргүүцэв.

Харри номын хавтсыг харлаа. Түүн дээр сайхан алтан үсгээр: «Алтан хонгиот Туг үс. Гэрийн хортон. Лавлах» гэж бичжээ. Мөн тэнд зохиогчийн том зураг харагдана. Цайвар туг үс бүхий эелдэг царай тод цэнхэр нүдтэй юм. Шидэт номын заншлаар нүүр царай нь гэрэлтэж, нүдээ ирмэж байлаа.

Тун сайхан байна! Энэ хүн өөрийнхөө мэдэх ёстой гэрийн хортонг сайн мэддэг юм. Их сайхан ном доо ... гэж хатагтай Уизли уулга алдана.

- Ээж түүнийг хүндэтгэдэг юм гэж Фред чанга хэллээ.

- Бүү тэнэглээд байгаач. Та нар цэцэрлэгийг анахайгүй болгох аргыг Туг үсээс илүү мэддэг юм бол явж ажлаа хийцгээ. Нэг л анахай үлдсэн байх юм бол сайхан мэдээрэй гэж хэлэхдээ хатагтай Уизлийн царай яльгүй улайсан байлаа.

Ах дүү нар эвшээлгэн үглэсээр цэцэрлэг рүү явахад Харри араас нь дагалаа. Цэцэрлэг том бөгөөд Харрийн бодлоор бол байх ёстойгоосоо эмх замбараагүй ажээ. Зэрлэг өвс хэт их ургасан, зүлгийг нь тайраагүй гээд Дурслийханд л лав таалагдахгүй нь мэдээж. Гэхдээ хөгшин моддын бахим муруй мөчрүүд чулуун хашааг чимэглэж, мандал дээр Харрийн мэдэхгүй цэцгүүд алаглаж, ногоон замаг ургасан жижигхэн цөөрөмд мэлхий бужигнаж байв.

Тэд зүлэг дундуур явсаар цэцгийн мандал руу ирцгээлээ.

- Маглуудад бас анахай байдаг юм гэж Харри Ронд хэлэв.

- Тэр чинь анахай гэж үү? Санта-Клаустай адилхан жижигхэн бүдүүн, гартаа загасны уургатай ... гэж Рон цээний бутанд толгойгоо шургуулангаа хэллээ.

Бут хөдөлж цөхрөнгөө баран эсэргүүцэх чимээ гарахад Рон гартаа нэг юм барьсаар дээш босоод:

- Жинхэнэ анахай чинь энэ дээ гэж баясгалантай хэлэв.

- Намайг эргүүл! Эргүүл! гэж нөгөөх хүнтэй адил юм нь дуржигнуулна.

Юутай ч атугай энэ анахай Санта-Клаустай адилгүй юм. Арьсаар оёж хийсэн юм шиг жижигхэн том булцуу бүхий халзан толгойтой томоохон төмс шиг ажээ. Рон түүнийг сунгасан гартаа барьж байхад цаадах нь цахиур шиг хатуу тавхайгаараа тангарах гэж оролдоно. Рон түүнийг тавхайнаас нь самбаа гарган барьж аваад толгойг нь доош харуулаа.

- Яг л ингэх хэрэгтэй шүү гэж хэлээд Рон анахайг дээш өргөснөө бугуйл шиг даллан эргүүлж эхэллээ. («Намайг эргүүл!» гэсэн шүү дээ). Тэгэхдээ Рон:

- Үүнд муу юм болохгүй ээ. Толгой нь эргээд үүрэндээ эргээд очих замаа олохоо больчихдог юм гэж байв.

Ингэж хэлээд Рон түүний хөлийг тавьтал анахай таван метр хэртэй ниссэнээ хашааны хаа нэгтээ алга боллоо.

- Ойр байна! Би тэр хожуул хүртэл шидэж чадна гэж мөрийцье хэмээн Фред хэлэв.

Харри хөөрхий анахайнуудыг төдхөн өрөвдөхөө больжээ. Анхныхаа анахайг тэрбээр эргүүлж дүүгүүрдэлгүй шууд л хашаа давуулж хаяхаар шийджээ. Гэтэл нөгөөх нь шинээр ирсэн цэвэрлэгчийн сул талыг ашиглан сахлын хутга шиг хурц шүдээрээ Харрийн хурууг хазаад зуурчихлаа. Түүнийг салгах тун ч амаргүй байв.

- Сүрхий анахай юм. Арван метр ч нисэж болохоор байлаа гэж ах нарын нэг нь хэллээ.

Төдхөн агаарт нисэх анахайнууд үүл шиг бужигнах болов.

- Манай анахайнууд тэнэг ээ. Цэвэрлэгээ эхэллээ гэж дуулмагцаа л дээшээ гараад ирдэг юм. Үүр лүүгээ шургаж мэдэхгүй шүү гэж хэлээд Жорж шууд тавыг шүүрэн авлаа.

Тэгээд талбайгаас хөөгдсөн хорьж гаруй анахай бөөгнөрч байснаа мөрөө унжуулан цуварсаар явж одов.

- Тэд эргээд ирнээ. Манайх тэдэнд аятайхан санагддаг юм. Аав тэднийг хөгжилтэй гээд элэгсэг ханддаг гэж хэлээд Рон талбайн нөгөө талд байгаа таримал бургасан хашааны цаагуур ар араасаа далд орох анахайнуудыг харж байв.

Орох хаалга дуугарах сонсогдлоо.

- Энэ аав байна. Ажлаасаа иржээ хэмээн Жорж дуу алдав. Хөвгүүд анахайгаа мартаад цэцэрлэг дээгүүр гэр лүүгээ гүйлдлээ.

Ноён Уизли нүдний шилээ аваад гал зуухны буйдан сандал дээр нүдээ анивчин ядрангуй суух ажээ. Тэрбээр туранхайдуу их халзан ч гэлээ үлдсэн цөөн хэдэн үс нь шав шаргал харагдана. Байнга явсаар байгаад тоос шороонд дарагдаж үнгэгдсэн ногоон жанч нөмөрчээ.

- Хэцүүхэн шөнө байлаа. Есөн дуудлага. Ес шүү! Өвгөн Наземникус Флетчер буцаад явахын ороонд харин намайгаа хараах санаатай ... гэж аядуухан хэлээд данх руу гараа сунгав. Хүүхдүүд түүнийг тойрон суулаа.

Ноён Уизли цайнаасаа сайн балгаж аваад санаа алдав.

- Сонирхолтой юм болсон уу, аав аа? гэж Фред сониучирхана.

- Ердөө л хэдэн хайлдаг түлхүүр бас хаздаг тогоо. Өөр нэг тусгүй зүйл байсаан.

Гэхдээ тэр манай чиглэлийнх биш. Бас туйлын хачирхалтай зурамнууд гарч

ирсэн. Зурамнууд Цөөрмийн үхлийг байцаалгахаар дуудуулаад. Бурханы авралаар зурамнуудыг Ид шидийн туршилтын хорооны мэдэлд ... гэж ноён Уизли эвшээлгэн хариулав.

- Хайлдаг түлхүүрт цагаа барах гэж хэн дурладаг байнаа? гэж Жорж асуулаа.

- Эгэл хүмүүсийг уурлуулах дуртай сонирхогчид байдаг юм. Тийм түлхүүрийг эгэл хүнд зарна. Тэгтэл түлхүүр нь алга болчихно. Нөгөө хүн эрээд л байна эрээд л байна түлхүүр нь ор сураггүй. Буруутгах хүн байдаггүй. Маглууд алдсан гэдгээ хэлэхгүй хайлдаг түлхүүр байдаг гэж мэдэхийг хүсэхгүй. Хаячихлаа гээд л байх нь тэр. Ид шид хамар дор нь болж байсан ч тэд тоогоогүй дүр үзүүлэн тэсэж байдаг юм.

Манайхан юу эсийг шившлэгээр өөрчилдөг гээч. Та нарын санаанд ч багтахгүй гэж ноён Уизли санаа алдан өгүүлэв.

- Жишээ нь манай машин?!

Хатагтай Уизли гартаа илд шиг урт шилээгүүр барьсаар орж ирэв. Ноён Уизли нүдээ бүлтийлгэн гэмшсэн царайлсаар эхнэрээ харлаа.

- Я-ямар машин гэж, хайрт Молли минь?

- Машин л байхгүй юу, Артур аа. Эвдэрхий сэг авчраад бүтэц зохион байгуулалтыг нь үзнэ гээд нэгд нэгэнгүй задалдаг шидтэн байна гэж бодоод үз. Тэгсэн мөртөө шившлэг хэрэглээд нисдэг болгочихож байгаа юм. Тэгээд л энэ машинаараа хаашаа ч хамаагүй ниснэ шүү дээ гэж хэлэхдээ хатагтай Уизлийн нүд гялалзана.

Ноён Уизли нүдээ цавчилснаа тайлбарлах санаатай:

- Хайрт минь, энэ шидтэн бол хуулийг огтхон ч зөрчөөгүй гэдгийг чи одоо ойлгох болно. Гэхдээ ... эхнэртээ үнэнийг хэлсэн бол дээр л дээ ... Хуульд тийм үг байдаг юм аа ... Хэрэв шидтэн нисэх зорилготой байгаагүй бол машин нь нисдэг болсон ч гэлээ ...

- Артур чи өөрөө энэ хуулийг боловсруулсан юм чинь ийм үг зориуд оруулсан хэрэг! Эгэл хүмүүсийн хийсэн элдэв юмтай саравчиндаа ноцолдож байх гэж л тэр. Тэгвэл үүний чинь гэрч болгож өнөөдөр Харри нисэх зориулалтгүй машинаар чинь манайд хүрээд ирчихэж! гэж хатагтай Уизли хангиналаа.

- Харри гэнээ? Ямар Харри? гэж ноён Уизли юу ч ойлгохгүй асуув.

Тэгээд гал зуухыг тойруулан харснаа Харрийг олж үзээд гайхсандаа огло хайрайжээ.

- Бурхан минь! Энэ чинь Харри Поттер байна шүү дээ. Чамтай уулзсандаа баяртай байна! Рон чиний тухай бидэнд бишгүй ярьдаг юм ...

- Урьд шөнө хүүхдүүд чинь энэ машинаар Улаан модон гудамж рүү нисэж очоод найзыгаа авчирчээ. Үүнийг юу гэх вэ? гэж хатагтай Уизли ширүүхэн асуулаа.

- Та нар үнэхээр тийшээ ниссэн юм уу? Тэгээд амжилттай юу? гэж ноён Уизли үнэн сэтгэлээсээ бахархан асууснаа хатагтай Уизлийн нүд ширүүн болохыг анзааран түгдэрч:

- Хүүхдүүд минь, энэ чинь тун тусгүй хэрэг шүү ... гэлээ. Хатагтай Уизли яг л том мэлхий шиг пэндийж эхлэлээ.

- Бидэнд энд хийх юм байхгүй. Явж би чамд өрөөгөө үзүүлье гэж Рон Харрид хэлэв.

Тэд гал зуухнаас хурдан гарч нарийн хонгилоор явснаа дээш гардаг налуу шат руу очлоо. Гуравдугаар давхарын өрөөний үүд нээлттэй ажээ. Харрид хэн нэгний том нүд харагдсанаа хаалга чанга хаагдлаа.

- Энэ бол Жинни. Тэр их гэрэвшингүй болохоороо зовдог байх. Ер нь түүний өрөөний хаалга дандаа нээлттэй байдаг юм гэж Рон тайлбарлав.

Ахиад хоёр давхар өгсөөд: «Рональдын өрөө» гэсэн хаягтай үүдний дэргэд зогсож байлаа.

Роныг үүд нээхэд бараг толгой шүргэхээр намхан адартай жижигхэн өрөөнд Харри орлоо. Галтай зууханд орчих шиг санагдсан учир Харри хэсэг зуур нүдээ аньжээ. Бүтээлэг хана, тэр ч байтугай адар хүртэл гал шаргал өнгөөр туяарна. Харри сайтар харснаа учрыг оллоо. Туурганы хуучин цаасан дээр нэг гартаа шүүр барьж нөгөө гараа даллан мэндчилж буй долоон шидтэн бүхий зурагт хуудсыг зай завсаргүй наажээ.

- Чиний хүндэлдэг баг уу? гэж Харри асуув.

- «Педдлийн их буунууд» гэж Рон хариулаад том хар «П» үсэг, их бууны харван яваа сум дүрсэлсэн шаргал бүтээлгийг заагаад:

- Дээд зэрэглэлийн есдүгээр байр гэж тодрууллаа.

Өрөөний буланд сурах бичгийг хамаагүй өрсөн байх агаад дэргэд нь цуврал зураг

«Патрик Пигс, Солиотой хүн» цуврал бараг бүгдээрээ байв. Цонхны тавцан дээр мэлхийний түрс дүүрэн шилэн цөөрмөг наранд гялалзан, дээр нь шидэт саваа харагдана. Түүний хажууд тарган бор Короста харх наранд зүүрмэглэн хэвтэх ажээ.

Харри өөрөө сугаран гардаг багц хөзөр дээгүүр алхан гараад жижигхэн цонхоор харлаа. Тээр дор таримал ногоон хашааны дэргэд талын тэртээгээс Уизлийн цэцэрлэг рүү ар араасаа цувран ирэх анахайнууд бөөгнөрөлдөн харагдана. Рон руу эргэж харахад цаадах нь сэтгэл хөдөлсөн бололтой:

- Өрөө маань бага даа. Дурслийнд чиний байдаг өрөөтэй адилгүй. Бүхээгний дор ороолон бий. Тэр чинь дээвэр дээр суугаад гууглах юм уу усны хоолойг балбадаг юм гэлээ.

- Энэ бол дэлхий дээрх хамгийн сайхан байшин гэж би бодож байна гэж Харри хэлээд нүүр дүүрэн инээлээ. Роны чих улайжээ.

БҮЛЭГ 4: «ФЛОРИШ БЛОТТС» ДЭЛГҮҮР

«Үүр»-ний бүх юм Улаан модон гудамжныхаас өөр ажээ. Дурслийн гэр бүлийнхэн амар тайван эмх журамтай байхыг эрхэмлэдэг юм. Харин Уизлийн байшин эмх замбараагүй байлаа. Тэнд байнга юм унах доргих шуугих чимээ гарна. Ханын

зуухны дээр өлгөөтэй байгаа толинд Харри анх удаа харахдаа эгээтэй л муурч унаагүй билээ. Толь гэнэтхэн: «Салан амьтан минь, одоохон цамцаа өмдөндөө шургуул!» гэжээ. Дээвэр дээр энэ гэрийн амьдрал хэтэрхий нам гүм нэгэн хэвийн байна даа гэж бодож суудаг нэгэн ороолон байна. Тэрбээр усны хоолойг цохин хөгжимдөж гууглан дуулах нь бий. Ихэр хоёрын өрөөнд байнга ямар нэг юм дэлбэрнэ,

Гэхдээ ярьдаг толь, гуугладаг хий үзэгдлээс илүүтэйгээр тэдний гэр бүлийнхэн Харрид хэрхэн ханддаг нь гайхшруулдаг байв. Хатагтай Уизли өглөө бүр түүнд хос шинэ оймс өгч, хоол идэх болгонд жаахан юм нэмнэ. Ноён Уизли оройн хоол идэхдээ Харрийг дэргэдээ суулгаж эгэл хүмүүсийн амьдралын тухай асуултаар дарж гарна. Түүнийг цахилгаан хэрэгсэл, шуудангийн албаны ажил гойд догдлуулдаг байв.

- Үгүй ер! Ямар их юм хийдэг улс вэ! Харин тэд ид шидгүйгээр өөр юу ч хийх юм билээ! гэж Харригаас ярьдаг утасны тухай дуулаад гайхжээ.

«Үүр»-нд ирснээсээ долоо хоногийн дараа Хогвартсаас захидал авлаа. Цэлмэг нартай өглөө байв. Ноён Уизлийг эхнэр охинтойгоо өглөөний цайгаа ууж байхад Рон Харри хоёр бууж иржээ. Тэднийг хармагцаа Жинни будаатай тавгаа ширээн дээрээс санамсаргүй унагаачихав. Ер нь Харрийг харахаараа юмаа алдчихдаг юм. Тэгээд агшин зуур тавгаа авахаар ширээн доогуур шургаснаа хавч шиг улайчихсан гарч ирлээ. Харри юу ч мэдээгүй дүр эсгэн сандал дээрээ суугаад шарсан талх дүүрэн хийсэн тавгийг хатагтай Уизлийн гараас авав.

- Хөвгүүд ээ, сургуулиас чинь захидал ирж гэж хэлээд ноён Уизли Харри, Рон хоёрт нэг нэг дугтуй гардууллаа. Шар өнгийн цаасан дээр ногоон бэхээр хаягласан дугтуй нь адилхан юм. Ноён Уизли:

- Дамблдор чамайг манайд байгааг мэдсэн юм байна. Энэ хүнээс юу ч нуухын аргагүй гэв.

Хаалга нээгдэж хүрэм өмссөн Фред Жорж хоёр гал зууханд орж ирлээ.

- Ашгүй ирэв үү май гэж ноён Уизли ихэр хоёрт мөн л адилхан дугтуй өглөө. Гал зууханд таван хором хэртэй чимээгүй байв. Харри болон ах дүү нар захидлаа уншицгаажээ. Харрийн захидалд урьдынх шигээ есдүгээр сарын нэгэнд Кингс-Кросс буудал дээрээс Лондон-Хогвартс гэсэн буухиа галт тэргэнд суух ёстойг дурдсан байв. Захидалд хоёрдугаар дамжаанд хэрэглэгдэх сурах бичгүүдийг жагсаажээ. Үүнд:

Ид шидийн сурах бичиг, 2-р дамжаа. Миранда Гуссокл

Цус сорогчидтой тулгарсан нь. Алтан хонгиот Туг үс

Замд тааралдах сүнс. Алтан хонгиот Туг үс

Хөгшин шулмастай өнгөрүүлсэн амралт. Алтан хонгиот Туг үс

Хий үзэгдлийг ялсан нь. Алтан хонгиот Туг үс Савдгийн жимээр. Алтан хонгиот Туг үс Ороолонтой орооцлолдсон нь. Алтан хонгиот Туг үс Иоркширийн алмас. Алтан хонгиот Туг үс

Фред захидлаа хойш тавиад Харрийн номын жагсаалтыг харснаа:

- Чамд Туг үсийн бүх ном хэрэгтэй юм байна. Хар урлагаас хамгаалах хичээлийн шинэ багш. Шулмас байна гэж мөрийцье! гэв.

Тэгснээ ээжтэйгээ харц тулгараад чимээгүй болж талхандаа жимсний чанамал түрхэж байлаа.

- Туг үсийн цогц ном ч үнэтэй дээ. Хаанаас тийм их мөнгө олох вэ? гэж Жорж эцэг эхээ хяламхийн харж хэллээ.,

- Хэмнэхээс л өөр аргагүй. Жинний дүрэмт хувцасыг хямдарсан барааны дэлгүүрээс авч болох юм гэж хатагтай Уизли итгэлгүйхэн хэлсэн ч санаа зовсон байдал илэрхий.

- Жинни чи энэ жил сургуульд орох юм уу? гэж Харри асуув.

Жинни ахиад л догдлон шаргал үс нь улам тодрох шиг болоод бас л гэнэтхэн тосон дээр тохойлчихов. Аз болоход Харригаас өөр хэн ч үүнийг анзаарсангүй. Энэ агшинд Перси гал зууханд орж ирлээ. Тэрбээр хувцасаа өмссөн агаад энгэрт нь ахлагчийн тэмдэг гялалзана.

- Бүгд сайн уу. Өнөөдөр сайхан өдөр байна гэж Перси товчхон хэлэв.

Тэгээд үлдсэн цорын ганц сул сандал дээр сууснаа нэг юм гартаа барин хатгуулсан юм шиг үсрэн болслоо.

«Тоос арчдаг өдөн сойз байсан байлгүй» гэж Харрийг бодсон ч өд амьсгалж байхыг

Харри ажигласан аж.

- Сум байна! Арайхийж иржээ! Энэ Гермионагийн хариу захиа байна. Би түүнд Харрийг Дурслийхнаас аврахаар явлаа гэж бичсэн юм хэмээн Рон хэлээд үнгэгдсэн шувууг Персийн гараас авч жигүүр доороос нь захидлыг гаргаж ирлээ.

Рон уулийг хашаанд гаргаад хөндөл модон дээр суулгав. Гэтэл унаад болохгүй байхаар нь угаадасны дэргэдэх самбар дээр аятайхан тавилаа.

- Хөөрхий амьтан гэж Рон санаа алдан хэлээд дугтуйг задлан захиаг уншлаа. Захианд: «Сайн байна уу, Рон! Хэрэв Харри танайд байгаа бол мэнд дамжуулаарай.

Та нарыг сайн сайхан байгаа гэж бодож байна. Бас хориотой ямар ч зүйл хийгээгүй гэдэгт итгэнэ. Чи ч гэсэн тэр ч гэсэн үүнээс болж эвгүй байдал орж магадгүй шүү.

Би Харрид их санаа зовж байна. Надад дэлгэрэнгүй бичиж туслаарай. Захиагаа өөр уулиар явуулбал дээр юм. Сумыг ахин нисэж чадахгүй болов уу гэж айж байна. Би хичээлээ их давтаж байгаа. Ирэх лхагва гаригт бид хоёрдугаар дамжаанд үзэх шинэ сурах бичгээ авахаар явна. Бид Тахир гудамжинд уулзаж болохгүй гэж үү? Ажил төрөл ямар байгаагаа бичээрэй.

Хайрлан хүндэтгэсэн Гермiona» гэжээ. Рон унших зуураа амралт болж байхад юу давтдаг байна? гэж гайхшрав. Тэгтэл

хатагтай Уизли:

- Сайхан санаа байна. Бид ч бас бүх юмаа худалдан авахаар маргааш явж болно шүү дээ. Харин өнөөдөр та нар юу хийх билээ? гэж ширээ арчингаа асуулаа.

Харри Рон хоёр Фред Жорж хоёртой квиддич тоглохоор зэхэж байжээ. Толгодын орой дээр Уизлийн гэр бүлийн мэдлийн хэсэгхэн талбай байдаг юм. Тэр талбайг нуун эргэн тойронд нь мод хүрээлжээ. Тэд маглуудад харагдахгүйн тулд талбай дээгүүр нэг их өндөр биш нисэж бэлтгэл сургуулиа хийдэг байв. Бөмбөгөөр бус алимаар тоглоно. Алим тосгон руу нисчихвэл хэн ч сэжиглэхгүй шүү дээ. Алим л бол алим байгаа биз! Харрийн хурдан «Нисдэг лус-2000» шүүрээр ээлжлэн сургуулилна. Роны хуучин «Солир» эрвээхэйнээс хурдан нисэхгүй ажээ.

Таван хормын дараа хөвгүүд мөрөн дээрээ шүүр тавьчихсан толгод руу өгсөж явлаа. Персийг хамт явъя гэж дуудсан ч тэр урьдын адил завгүй байлаа. Харри түүнийг зөвхөн хоол идэх үед нь л харна. Үлдсэн бүх хугацаанд тэр өрөөнөөсөө огт гарахгүй.

- Юу бодоод байгааг нь мэдэх юм сан. Сүүлийн үед тэр их өөрчлөгдсөн шүү.

Харри чамайг ирэхээс нэг өдрийн өмнө шалгалтынхаа дүнг хүлээж авсан юм. Арван хоёр С.И.Ш! Гэтэл тэр огт тоогоогүй гэж Фред хөмсөг зангидан хэллээ.

- С.И.Ш гэдэг бол «супер ид шид» гэсэн үг, Билл ч бас тийм сурч байсан.

Эргэж ч харахын зуургүй гэр бүлд маань ахиад нэг толгойтой хүү нэмэгдлээ. Хүмүүсийг харахаас ичих юм гэж Жорж Харрийн гайхан байхыг хараад тайлбарлаж өгөв.

Билл бол Уизлийн хүүхдүүдийн ууган нь юм. Тэрбээр Хогвартсыг төгсөөд одоо

«Гринготтс» банкны Египет дахь салбарт ажиллаж байгаа юм. Нөгөө нэг ах нь сургуулиа төгсөөд Румынд луу судалж байгаа билээ. Харри тэр хоёрыг хэзээ ч хараагүй аж.

- Аав ээж хоёр тэр их юм авах мөнгө хаанаас олохыг мэдэхгүй юм даа. Хүн бүрт Туг үсийн таван ном хэрэгтэй. Бас Жинни нэгдүгээр ангид орно. Түүнд жанч шидэт саваа гээд олон юм хэрэг болно гэж Жорж бодлогоширон хэллээ.

Харри эвгүйрхэн дуугүй байв. Эцэг эхийн үлдээсэн мөнгө Лондоны «Гринготтс»-ын дансанд хадгалагдаж байгаа. Үнэндээ энэ мөнгийг зөвхөн шидэт ертөнцөд л үрж

болно. Сикль, галлеон, кнатаар маглуудын дэлгүүрт үйлчлэхгүй юм чинь. Энэ мөнгөний тухай Харри Дурслийханд огт дурсаагүй билээ. Шидэт алтнаас болоод шидтэнгүүдийг үзэн ядах нь нэмэгдэнэ гэж байсан хэрэг.

Лхагва гарагын өглөө хатагтай Уизли хүүхдүүдээ сэрээлээ. Хүүхдүүд өөртөө оногдсон махан хачиртай талхаа идэж дуусмагц хүрмээ өмсөцгөөв. Хатагтай Уизли ханан зуухны тавиур дээрээс цэцгийн сав аваад доторхыг нь харлаа.

- Бараг юу ч үлдсэнгүй ээ, Артур минь. Өнөөдөр авах юмаа мартчих вий дээ ...

Харри чи зочин юм чинь түрүүлж яв гэж санаа алдан хэллээ. Тэгээд хатагтай Уизли түүнд цэцгийн саваа сарвайжээ.

Харри эхлээд савыг дараа нь гэрийхнийг хайхрамжгүй харахад тэд түүнээс нэг юм хүлээгээд байлаа.

- Би ... би яах ёстой вэ? гэж ээрэн асуув.

- Тэр «нисдэг дарь» хэрэглэн нисэж хэзээ ч үзээгүй юм. Уучлаарай Харри, би энэ тухай мартчихжээ гэж Рон хэллээ.

- Хэзээ ч үзээгүй гэж үү? Чи өнгөрсөн жил сургуулийнхаа хэрэгслийг яаж худалд авсан юм бэ? Тахир гудамжинд юугаар очив оо? гэж ноён Уизли гайхан асуув.

- Метроогоор явсан

- Үнэхээр үү? Тэнд гайхамшигтай шат байдаг гэж би дуулсаан! Чухамдаа яаж ... гэж ноён Уизли гайхаж бахархсанаа нуулгүй хэлтэл:

- Одоо хэрэггүй ээ, Артур. «Нисдэг дарь» хамаагүй хурдан. Харин чи хэзээ ч хэрэглэж үзээгүй юм бол ... хэмээн метроны бүтцийн тухай хичээл сонсохыг хүсээгүй хатагтай Уизли хэллээ.

- За, зүгээр дээ ээж ээ. Бүү сандар. Бидний эхлээд явахыг Харри ч хараарай гэж Жорж өгүүлэв.

Фред савнаас чимх дарь аваад ханан зуух руу очиж гал руу хийлээ. Гал дүрсхийснээ шуугин асаж маргад ногоон дөл хүнээс өндөрт цоролзон Фредийг авч одлоо.

- Тахир гудамж гэж хашгираад Фред алга болов.

- Тод хэлэх хэрэгтэй. Бас ханан зуухны сараалжийг андуурч болохгүй гэж хатагтай Уизли Харрид зөвлөлөө.

- Юу андуурч болохгүй гэнээ? гэж Харри сэтгэл зовнин асуув.

Энэ үед Жорж саванд гараа шугругуулж гал дөл ахиад л бадарч ихрийн өрөөсөн ханан зуухны яндангаар алга боллоо.

Бидний дээр доор шидэт ханан зуух, гудамж руу гаргах хаалга олон байгаа. Тийм болохоор төөрчихгүйн тулд тодорхой хэлэх ёстой гэж хатагтай Уизли тайлбарлаж өгөв.

- Зүгээр ээ, Молли тэр чадна гэж хэлээд ноён Уизли жаахан дарь авч зуух руу явлаа.
- Хэрэв хүү төөрчихвөл яанаа? Ах эгчид нь юу гэж хэлэх вэ?
- Тэд нэг их гашуудаад байхгүй ээ. Намайг янданд тээглэчихлээ гэхэд Дадли хагартлаа инээх байлгүй гэж Харри хэлэв.
- За яахав. Артурын араас яваарай. Зуух руу ормогцоо хаашаа нисэхээ шуудхан хэлээрэй гэж хатагтай Уизли хэллээ.
- Тэгээд л болно гэж Рон хэлэв.
- Нүдээ сайн анихгүй бол яндан их хөөтэй шүү.
- Айх хэрэггүй ээ, тайван зогс. Нөгөөдүүлээ хараад гараарай. Тэгэхгүй бол өөр зуухаар гаргачихаж магадгүй.

Харри энэ бүх сургамж зааврыг тогтоож авахаар мэрийх зуураа чимх дарь аваад ханан зуух руу очлоо. Тэгээд санаа алдан гал руу орлоо. Гал дөл түүн сэвшээ салхи шиг санагдана. Тэрбээр гайхсандаа амаа ангайхад аманд нь үнс орж ханиалгалаа.

- Та-тахир гудамж хэмээн Харри түгдчин хэлэв.

Гэтэл галт шуурга түүнийг ээрүүл мэт эргэлдүүлэн дээш авч одлоо. Гал дөлний шуугих чимээ чихний хэнгэрэг балбан дүлийрүүлэх шахна.

Харри нүдээ анихаас айж байв. Өөрийнхөө зуухны сараалжийг мэдэлгүй дэргэдүүр нь нисээд өнгөрчихөж магадгүй шүү дээ. Ээрүүл мэт эргэлдсэнээсээ болоод хоолойд нь юм тээглэн дотор муухайрна. Ай-яа! Нэг юм тохойг нь өвдтөл цохиход Харри улам атийлаа. Хуй салхи түүнийг эргүүлсээр, хүйтэн урсгал хацарт нь мэдрэгдэнэ. Харри галтай ханан зуухнууд ар араасаа хэрхэн өнгөрөхийг нүдний шилнийхээ цаанаас сэмхэн харж байв.

Түүний идсэн хачиртай талх буцаж гарчих гээд байлаа. Харри нүдээ анив.

«Бурхан минь, энэ бүхэн хэзээ дуусах болоо» гэж бодтол зуухнаас гараад ямар нэг өрөөний хүйтэн шалан дээр буулаа. Буухдаа нүднийхээ шилийг цохисон тул өрөвдөлтэйгээ жингэнэж байв. Харри цав гарсан шилээ нүүр лүүгээ шахаж наагаад гуйвсаар хөл дээрээ бослоо. Толгой нь эргэж, хамаг юм нь хөө болчихсон агаад өрөөнд Фред Жорж аль нь байсангүй.

- Би хаана байна? гэж Харри шивнээд бүдэг гэрэлтэй, том өрөөг тойруулан харлаа.

Энэ бол шидэт мухлаг гэдэгт эргэлзэх юм алга. Гэтэл сургуулийн ямар ч хэрэгсэл байхгүй юм. Үзэсгэлэнгийн шилэн хоргонд цус болж хатсан гар, багц хөзөр, гөлийтөл ширтэх болох нүд харагдана. Хананд янз бүрийн аймаар баг зүүжээ. Харин лангуун дээр бүр аймаар. Төрөл бүрийн хэмжээ бүхий хүний араг яс эгнүүлэн тавьсан байв. Адараас тамлахад зориулсан зэвтэй, хурц зэвсэг хэрэгслүүд дүүжлээстэй. Хамгийн таагүй зүйл бол тоостой цонхоор харагдах харанхуй нарийхан гудамж байв. Ямар ч гэсэн Тахир гудамж биш ээ.

Эндээс хаашаа ч хамаагүй гарах л хэрэгтэй. Хэдий чинээ хурдан бол төдий чинээ сайн. Цохиулсан хамар нь өвдсөөр авч энэ бол юу ч биш ээ. Харри үүд рүү ухасхийсэн авч замдаа зогсчихлоо. Хоёр хүн дэлгүүр рүү ирж явлаа. Бүх юм нь хөө

болчихсон хамар дээрээ эвдэрхий шил тохсон байдалтайгаар таарахад тун онцгүй санагдах хүн нэг нь байлаа. Энэ бол нөгөө муухай Драко Малфой өөрийн биеэр явж байв.

Харри зүүн талдаа том хар шүүгээ байхыг хармагцаа түргэн зуур тийшээ шурдхийн оров. Яльгүй завсар гаргаж үүдийг нь хаатал хонх дуугарлаа. Хаалга онгойж Драког мухлагт орж ирэхэд араас нь ... түүний эцэг орж ирэв. Бас л шонхор хамартай цайвар царайтай хүйтэн бор нүдтэй юм. Дракотой тун ч адилхан аж!

- Юунд ч бүү гар хүрээрэй! гэж ноён Малфой болор нүд рүү гараа сунгах хүүдээ тушаалаа.

- Та надад бэлэг авч өгнө гэсэн шүү дээ.

- Би чамд хурдан шүүр авч өгөхөөр амалсан.

- Би түүгээр чинь яах юм? Би өөрийнхөө багт тоглодог биш. Ноднин Харри Поттер өөртөө «Нисдэг лус-2000» шүүр худалдаж авсан юм. Тэгээд тусгай зөвшөөрөл Дамблдороос аваад өөрийхөө Гриффондор багийн бүрэлдэхүүнд тоглох болсон билээ. Алдартай юм чинь аргагүй шүү дээ! Духан дээрх тэнэг соривноос нь болоод л тэгдэг юм. Бүгд л түүнийг ухаантай гэлцэнэ. Ай, Поттер сайн хүү! Ай, ямар хэцүү сорви бэ! Яасан сайхан шүүр вэ! гээд л байх нь тэр гэж Драко ууртай хэлээд тавиур дээрх гавлын яснуудыг харж байв.

- Үглээд л байх юм. Үүнийг чи надад лав зуун удаа ярьсан байх аа. Харри Поттертой муудалцаж болохгүй гэдгийг чамд анхааруулъя. Хүмүүс түүнийг баатар гэж үзэж байгаа. Түүнээс л болоод Хар лорд үгүй болсон гэж ноён Малфой уурслаа.

Тослог үсээ арагш толийтол самнасан үстэй, өндөр хүн лангууны ард ирлээ.

- А-а, ноён Горбин ...

- Ноён Малфой та тавтай морилоорой! Тантай болон таны хүүтэй уулзахдаа ямагт баярлах болно. Юу авмаар байна? Надад ч бас үзүүлэх юм бий шүү. Саяхан бараа авсан, үнэ нь боломжийн! гэж лангуун эзэн нарийхан дуугаар хэллээ.

- Өнөөдөр юм авахгүй ээ, ноён Горбин минь, харин худалдана гэж эцэг Малфой албархуу дуугарав.

- Худалдана гэнээ? гээд Горбин инээмсэглэхээ болилоо.

- Яамнаас ээлжийн шалгалт хийх болсныг та дуулсан байлгүй. Харин гэрт маань ... юухан хээхэн бий. Хэрэв манайд ирэх л юм бол эвгүй байдалд орох юм.

Ноён Малфой ингэж хэлээд цүнхнээсээ хуйлаастай цаас гарган худалдагчийн нүдний өмнө барьж харуулав.

- Яам таны тав тухыг алдуулж чадна гэж үү? хэмээн Горбин хэлээд хамар дээрх шилээ заслаа.

Малфой муухан инээмсэглээд:

- Яам биднийг ухаж төнхөөд эхэлчихсэн. Маглуудыг хамгаалах шинэ хууль гаргана гэж цуураад л байна. Үүний ард эгэлчүүдэд хайртай чалчаа Уизлийг байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Ямар нэг хор ... гэж хэлэхэд:

- Тийм ээ, тийм ноёнтоон. Би бодъё ... гэж Горбин толгой дохилоо.

- Ааваа та надад үүнийг өгөхгүй юм уу? гээд Малфой хатсан гар хэвтэж байгаа лангууг заан мухлагийн эзний үгийг таслан хэлэв.

- Алдрын гар! Энэ гарыг аваад ассан лаа бариулах аваас танаас өөр хэн ч түүний гэрлийг хардаггүй юм даа. Хулгайч дээрэмчдийн сайн анд! Ноёнтон таны хүү ч сайн мэдэж байна шүү! гэж Горбин хэллээ.

- Хүү маань хулгайч дээрэмчдээс арай өөр зүйл сонирхоно гэж найдаж байна хэмээн ноён Малфой хүйтнээр сийгүүлэн хэлэв.

- Би таныг гомдоох гэж бодоогүй юм. Зүгээр л үгийн далимд хэлчихсэн юм гэж Горбин санаа зовон өгүүлжээ.

- Энэ маань бас тийм ч сайн сурахгүй байна. Гэхдээ ч толгойгүй гэсэн үг биш л дээ гэж Малфой улам ч хүйтнээр хэлэв.

- Үүнд би буруугүй ээ. Багш бүхэн хайртай шавьтай. Үгүй дээ гэхэд Гермоиона Грэйнджерийг аваад үзье л дээ гэж Драко толгой хаялана.

- Чи ичихгүй байна уу? Зүгээр л нэг эгэл хүүхэд бүх юмаа чамаас илүү сурсан байхад! гэж эцэг нь түүнийг айлгав.

Драко Малфой мухарджээ.

«Ай даа! Ааг омгийг чинь дарж болдог л юм байна!» гэж Харри бодлоо.

- Дандаа л ийм шүү дээ. Ид шидтэний цус хаа сайгүй л доогуур үнэлэгдэх юм гэж Горбины хариугүй дуу сонсогдоно.

- Тэгдэг л юм байгаа биз. Харин манай гэр бүлд энэ огт хамаагүй гэж эцэг

Малфой хамраа сарталзуулан хэлэв.

- Тэгэлгүй яахав, ноёнтоон гэж Горбин доош тонгойн бөхөлзлөө.

- За тэгвэл ажил руугаа буцаж орьё. Өнөөдөр олон чухал ажилтай болохоороо би их яарч байна.

Эзэн, зочин хоёр наймаагаа хэлэлцэж эхлэхэд Драко лангуу даган явж байлаа. Нэг бус хэрэгтэнг дүүжилсэн дүүжлүүрийг сонирхоно. Бадмаараг сондор бүхий лангууны дэргэд зогслоо.

- «Энэ сондор арван есөн эгэл хүний амийг авсан гэдэг хууч яриа бий.

Болгоомжил. Хүрч болохгүй, хараалтай» гэж шоолонгуй инээж уншив.

Дракогийн алхах чимээ Харрийн сууж буй шүүгээнд дөхсөөр. Одоо ирээд онгойлгож үзэх байлгүй. Харри зүрх түгшлээ.

- Наймаа тохирлоо! Драко, хурдхан явцгаая! гэх ноён Малфойн сэтгэл хангалуун дуу лангууны цаанаас гарав.

Драко тэндээс яаран одлоо. Харри ханцуйгаараа духаа арчив.

- Баяртай, ноён Горбин. Маргааш таныг гэртээ хүлээж байя. Сайн сайхныг хүсье.

Үүд чимээтэй хаагдахад Горбины хүлцэнгүй байдал агшин зуур алга боллоо.

- Та бас тэгнэ вий. Олны үг ортой гэдэгчлэн гэртээ нуусан зүйлийн тэн хагас нь жагсаалтад алга байна.

Горбин ийнхүү сэтгэл зундуур үглэсээр лангууны цаадах өрөө рүү алга боллоо. Харри хэдэн хором хүлээснээ (Горбин гэнэтхэн буцаад ирвэл яана) шүүгээнээс гарч лангууны дэргэдүүр өнгөрөн мухлагаас гарлаа. Хамар дээрх эвдэрхий шилээ засаад эргэн тойрноо харвал харанхуй гудамж, янз бүрийн аймаар зүйл зарах шахалдсан мухлагууд байна. «Горбин, Бэрксс» бол хамгийн том мухлаг бөгөөд нөгөө талд нь хатаамал толгой дүүрэн чихсэн ёрын лангуу байх юм! Хоёр хаалганы цаана аварга том хар аалз дүүрэн бужигнах том тор харагдана.

Хоёр мухлагийн хоорондох харанхуй завсраар явах үед нь өрөвдөлтэй царайны хоёр илбэчин ямар нэг юм сэжигтэй шивнэлдэн түүнийг дагах ажээ. Харри доош унах

шилээ ахин янзлаад цааш явлаа. Яасан муухай юм бэ! Гэхдээ Харри эндээс бүрэн бүтэн гарна гэдэгтээ итгэлтэй байв.

Хортой лааны мухлаг дээр муруй хазгай өлгөсөн модон самбарт: «Догшин гудамж» гэсэн бичиг харагдана. Харрид энэ тус болсонгүй. Ийм гудамжны тухай хэзээ ч дуулаагүй юм чинь. Тэрбээр ханан зууханд ормогцоо үнсэнд хахаж цацаад очих газраа буруу хэлчхсэн юм байлгүй дээ.

«Яавал дээр вэ?» гэж Харри тайван байхыг хичээн бодлоо.

- Хүү минь, чи төөрөөгүй биз? гэсэн дуу гарч түүнийг хэвийн байдалд нь оруулав.

Харри цочин дээш харлаа. Өндөгний хальс шиг баахан юм овоолсон тавиур гартаа барьсан хөгшин шулам өмнө нь зогсож байлаа. Энэ чинь хүний хумс байна шүү дээ! Эмгэн харласан шүдээ ярзайлган түүнийг ширтэх ажээ.

- Үгүй ээ, баярлалаа! Би ... би ... зүгээр л ... гэж Харри түгдчив.

- Харри! Чи энд юу хийж байгаа юм бэ?

Харри, шулмас хоёр санамсаргүй байсандаа болоод овсхийн цочлоо. Эмгэн тавиуртай хумсаа асгачихлаа.

Энэ бол Хагрид байв. Өтгөн хөмсөг бүхий жижиг хоёр нүд нь хар цох лугаа гялалзана.

- Хагрид аа! Би төөрчихжээ ... «Нисдэг дарь» хэрэглэснээс болоод ... гэж Харри баясан дуу алдлаа.

Хагрид шулмасын барьж байсан тавиурыг унагаагаад Харрийг шүүрэн хөгшин зөнөгөөс холдуулав. Тэд тахир харанхуй гудамжаар явцгаана. Тэдний ард гомдсон хөгшний орилох дуу сонсогдсоор байлаа. Тэгтэл нарны туяа цацарч эхлэн төдхөн гэрэл гэгээтэй болов. Урд нь цасан цагаан гантигаар брьсан аварга байшин сүндэрлэнэ. Энэ бол «Гринготтс» банк! Хагрид түүнийг шууд л тахир гудамжинд аваачив.

- Фү, яасан заваан юм бэ! гэж гэрэлд гарсан Харрийн бохир байдлыг харсан Хагрид үглэснээ зуухны хөөг нь гүвж гарлаа. Гүвэхдээ харин түүнийг эмийн сангийн үүдний дэргэд байгаа лууны хомоол бүхий торхонд эгээтэй л унагачихсангүй.

- Догшин гудамжаар тэнэх хэрэггүй ээ ... Муухай газар. Аюултай! Чамайг энд байхыг чинь хүн харвал яана?

- Би үүнийг шууд л мэдсэн. Би төөрсөн юм байхгүй юу даа! Харин чи тэнд юу хийж явсан юм бэ?

- Би ... ургамал иддэг нялцгай биетэнд өгөх хор хайж явсан юм. Энэ муухай шимэгч манай бүх байцааг устгаж дуусах нь. Чи энд ганцаараа байгаа юм уу?

- Би Уизлийнханд байгаа. Бид өнөөдөр сурах бичиг авахаар ирсэн боловч би төөрчихжээ. Тэднийгээ хурдхан олж авбал зүгээр сэн гэж Харри тайлбарлав.

Тэд гудамжаар цааш явлаа. Үнэндээ бол Хагрид явж, Харри гүйцэж ядан дэргэд нь гүйнэ. Тэрбээр андыгаа аварга гутлаараа нэг алхах зуур гурав дөрөв алхах бүлгээ.

- Чи яагаад хариу захидал бичихгүй байсан юм бэ? гэж Хагрид асуув.

Харри түүнд Дурслийхны тухай, Доббийн тухай бас ноён Уизлийн Фордоор тэднийхээс оргосон тухайгаа бүгдийг ярьж өглөө.

- Энэ гайтай маглуудыг! Мэдсэн бол ... хэмээн Хагрид уурсангуй дуугарав.

- Харри! Харри! гэж хэн нэг хүн чанга дуудлаа.

Банкны үүдний дээд гишгүүр дээр Гермиона Грэйнджер зогсож байв. Тэрбээр хуучин андуудаа хармагц уулзахаар ирлээ. Түүний өтгөн хүрэн үс салхинд хийснэ.

- Харри! Чи нүднийхээ шилийг яачихаа вэ? Сайн байна уу: Хагрид, Тантай дахин уулзсандаа баяртай байна! Харри чи «Гринготте» руу явж байгаа юм уу?

- Сайн уу, Гермиона. Банк руу явж байгаа минь чи таачихлаа. Гэхдээ би эхлээд

Уизлийнхныг олох хэрэгтэй байна.

- Тэгвэл удаан хүлээх хэрэг гарахгүй ээ гэж ойн сахиул сахлаа хөдөлгөн инээмсэглэн хэлэв.

Гэтэл яг л хэлсэн ёсоор нь болж тэднийхэн банк руу яаран ирж харагдана.

- Харри! Чамайг нэг сараалжнаас доогуур орчихлоо гэж бид бодсон юм. Молли сандарсандаа эгээ л ухаан алдчихсангүй. Тэр одоо ирнэ гэж ноён Уизли гар даллан хашгиран хэлээд нялалзсан халзан духаа арчлаа.

- Чи ямар зуухаар гарсан бэ? гэж Рон асуув.

- Мэдэхгүй.

- Наад хүү чинь Догшин гудамжинд очсон байна гэж Хагрид өтгөн хөмсгөө зангидан хэлэв.

- Үгүй ер өө! гэж ихрүүд дуу алдлаа.

- Биднийг тийшээ очихыг хатуу хориглодог юм ... гэж Рон илэн далангүй атаархсан байдалтай хэлэв.

- Мэдэхгүй биш дээ! Тэнд удаж төдөлгүй үхэж болох газар гэж Хагрид ярилаа.

- Харри! Хүү минь! Олдож дээ! гэж хатагтай Уизли уулга алдан нэг гартаа цүнхээ савчуулан нөгөө гартаа Жиннийг хөтөлсөөр яаран гүйж ирлээ. Тэгснээ:

- Харри! Хонгор минь! Ингэвэл үрэгдэж ч болно шүү дээ! гэлээ.

Хатагтай Уизли ирснээ агшин зуур цүнхнээсээ хувцасны сойз гаргаж ирээд Харрийн жанчинд наалдсан хөөг цэвэрлэж эхлэв. Харин ноён Уизли Харрийн хамар дээрээс шилийг нь аваад шидэт саваагаа хүргэтэл тэр дорхноо шинэ юм шиг болчихлоо!

- Би явах боллоо. Сургууль дээрээ уулзацгаая гэж Хагрид хэлээд огт тайвширч чадахгүй байгаа хатагтай Уизлийн гарыг атгахад:

- Догшин гудамж! Чи түүнийг олоогүй бол яанаа! гэж хатагтай Уизли үглэж байв.

Ойн сахиул нөгөө тийш явахад хүмүүсийн дундаас толгой нь тэр дээр харагдана. Тэд цөмөөрөө банк руу зүглэв.

- Намайг «Горбин, Бэрксс» гэдэг мухлагт хэнийг харсан гэж бодноо? гэж Рон Гермиона хоёроос асууснаа:

- Малфой түүний эцэг хоёрыг! гэж өөрөө хариуллаа.

- Люциус Малфой тэндээс ямар нэг юм авсан уу? гэж ноён Уизли их л сониучирхав.

- Үгүй ээ, тэд харин юм зарсан.

- А-а, сэтгэл нь хямарсан хэрэг. Би түүнийг ямар нэг юмаар барих хэрэгтэй байгаа юм! гэж ноён Уизли хангалуун хэллээ.

- Артур минь, болгоомжтой байгаарай. Энэ гэр бүлийнхэн аюултай шүү.

Зажлахгүй залгих гэдэг л болох вий! гэж хатагтай Уизли доош тонголзох албингийн ард байгаа банкыг ажиглангаа анхааруулан хэллээ.

- Намайг Малфойг зүгээр л өнгөрөөнө гэж санаа юу? гэж ноён Уизли хэлснээ

Гермионагийн эцэг эхийг хараад түүний тухай шууд мартжээ.

Грэйнджерийнхэн гантиг өрөөний ханын дагуу байгаа тавцангийн дэргэд зогсоцгоож байв. Тэд Гермионаг эцэг эхээ танилцуулахыг хүлээн илэрхий догдлож байв.

- Сайн байна уу, андууд аа! Маглууд! Та нар чинь жинхэнэ Маглууд! Бид танилцсанаа тэмдэглэх хэрэгтэй! Мөнгөө солиулахаар ирцгээв үү? Хараач, Молли. Жинхэнэ фунт байна гэж ноён Уизли баясан хэлээд ноён Грэйнджерийн гарт байгаа арван фунтын дэвсгэртийг зааж харуулав.

- Тэнд уулзацгаая, Гермиона гэж Рон хэлээд Уизлийнхны гэр бүл Харритай хамт шүүгээнүүд байдаг банкны доод давхар луу явлаа.

Шүүгээнүүд рүү очих тэргэнцэрийн төмөр зам байна. Тэргэнцэрийг албинууд жолоодон шидтэнгүүдийг нааш цааш зөөх ажээ. Банкны газар дорх бүх байруудыг төмөр зам холбосон байдаг эжээ. Энэ аялал Харрид их таалагдлаа. Толгой эргэм хурдан давхих юм! Ингээд Уизлийхны шүүгээнд ирлээ. Шүүгээний үүд нээгдэхэд харри Догшин гудамжинд байснаасаа ч долоон дор байдалд оров. Төмөр хайрцаг дотор хэдхэн мөнгөн сикль ердөө л ганц алтан галлеон байлаа. Хатагтай Уизли байгаа буланг нь сайтар тэмтрэн байгаа мөнгийг хамж аваад цүнхэндээ хийлээ. Тэгээд Харрийн шүүгээ рүү очлоо. Тэгэхэд Харри санаагаар унажээ. Өөрийн нь шүүгээнд бүхэл бүтэн баялаг хадгалагдаж байдаг! Андуудаа гомдоохгүйн тулд Харри шүүгээнд байгаа зүйлээ биеэрээ халхлаад ширэн цүнхэнд хэдэн атга зоос хурдхан хийлээ. Тэгээд тэргэнцэр ирэхийг хүлээж байснаа цөмөөрөө дээш явлаа.

Гантиг шатан дээр гараад тэд салцгаав. Перси шинэ үзэг авах юм болж, Фред Жорж хоёр сургуулийн анд Жордантайгаа тааралдлаа. Ноён Уизли танилцсан баяраа тэмдэглэхээр Грэйнджерийнхнийг «Цоорхой тогоо»-нд урьж хатагтай Уизли, Жинни хоёр хувцасны мухлаг руу яаран оджээ.

- Цагийн дараа «Флориш, Блоттс» номын дэлгүүрт уулзаж бүгдээрээ сурах бичгээ авцгаана шүү. Догшин гудамжны тухай мартаарай! гэж тэрбээр ихрүүдийн араас хашгираад Жиннийг хөтлөн хувцасны мухлаг руу оров.

Харри, Рон, Гермiona гурав бул чулуугаар өнгөлсөн тахир гудамжаар тэнэж явлаа.

«Харри! Харри! Биднийг үр! Ямар нэг юм аваач!» гэж Харрийн халаасанд байгаа алт, мөнгөн зооснууд хангинана. Харри шоколад гүзээлзгэнэ бүхий гурван том зайрмаг худалдаж авав. Андууд түүнийгээ амтархан долооно.

Тэд мухлагийн лангууг ажиглан удаан явлаа. Гэнэтхэн Роны нүд гялалзлаа.

«Квиддичийн бүх зүйл» гэдэг мухлагийн цонхоор Роны дэмждэг «Педдлийн их буунууд» багийн янз бүрийн зураг харагджээ. Гермiona түүнийг тэр мухлагаас хүчээр холдуулж зэргэлдээх бичгийн хэрэгсэл зардаг мухлаг руу бэх, цаас авахаар дагуулж оров. Тэнд тэд ихэр хоёр болон Ли Жордантай тааралджээ. Тэд доктор Фойерверкусын хүйтэн, чийглэг шидэт цаасан буу бүхий лангууны дэргэд зогсож байв. Харин хугархай шидэт саваа, эвдэрхий зэс жинлүүр, хуучин жанч болон бусад элдэв зүйл зардаг жижигхэн мухлагт Перситэй таарлаа. Тэрээр лангууны дэргэд зогсоод «Эрх мэдэлд хүрсэн ахлагчид» хэмээх уйтгартай ном шимтэн уншина.

- «Хогвартсын ахлагч нар ба тэдний цаашдын амьдралын зам» гэж Рон арын хавтсан дээрх сэдвийг чангаар уншлаа.

- Бүү саад бол! гэж Перси номноос нүд салгалгүй хэлэв.

- Манай хүн алдар хүндэд дуртай, өөрийн гэсэн зорилготой. Шидтэнгүүдийн яамны сайд болох хүсэлтэй юм гэж ахаасаа холдоод Рон тэдэнд шивнэн хэлжээ.

Цагийн дараа тэд «Флориш, Блоттс» дэлгүүр лүү яарцгаав. Зөвхөн тэд ч яарсан бус гэдгийг хэлэх хэрэгтэй. Андууд дэлгүүр рүү дөхөж очоод дотогшоо тэмүүлэх олон хүмүүсийг хараад их л гайхацгаав. Үүний гол шалтгаан нь дээд талын цонхон дээр байгаа зарлал байсан юмсанж. Тэнд:

Алтан хонгиот Туг үс

«Би шидтэн» гэдэг намтар зохиолдоо гарын үсэг зурж байна. Өнөөдөр 12.30-16.30 цагт гэсэн байв.

- Бид одоо Туг үсийг өөрийг нь харах юм байна. Тэр чинь бидний жагсаалтанд байгаа бараг бүх сурах бичгийг зохиосон хүн шүү дээ! гэж Гермiona баярлаж хөөрөн хэллээ.

Хүмүүсийн ихэнх нь хатагтай Уизлийн насны авгайчууд ажээ. Үүдний дэргэд толгойгоо ороосон шидтэн зогсоод:

- Хатагтай нар аа, тайван байцгаа! Битгий түлхээрэй! Номоо болгоомжтойхон бариарай! гэж эцэс төгсгөлгүй давтана.

Харри, Рон Гермiona гурав догтогш чихэлдэн орлоо. Үгүй ер өө! Дараалал дэлгүүр дотор сунаж Алтан хонгиот номондоо гарын үсэг зурж буй нөгөө булан хүртэл үргэлжилжээ. Тэр гурав «Хөгшин шулмастай өнгөрүүлсэн амралт» номоос нэг нэгийг аваад Уизлийнхан болон Гермionaгийн аав ээж зогсон байгаа дараалал руу очлоо.

- Та нар ирэв үү? Сайн байна! Одоохон бид түүнийг харна! гэж хатагтай Уизли догдлон хэлээд үсээ илэв.

Ингээд л аз болоход түүнийг хардаг байжээ! Тэрбээр өөрийнхөө хөргийг тойруулан тавьсан ширээний ард суугаад хүндлэн хайрлах хүмүүст сайхан инээмсэглэл бэлэглэх аж. Амьд Туг үс маань цэнхэр нүд бүхий хөх жанч нөмөрсөн байв. Алтлаг тус үсэн дээрээ шидэт бүрхээ хэлтгйдүү тавьжээ.

Сэтгэлийн хөдөлгөөнтэй бололтой намхан нөхөр ширээ тойрон явж зургийн том дурангаа байн байн шардхийлгэхэд гэрэл гялалзах бүрийн дараа өтгөн улаан утаа суунаглана.

- Бүү саад бол! Би «Өдөр тутмын зөнч» сонинд зураг авч байгааг харахгүй байна уу хэмээн тэр Роныг зандраад арагш болохдоо түүний хөл дээр гишгичхэв.

- Харж байна аа! гэж хэлээд Рон гишгүүлсэн хөлөө нөгөө хөлөөрөө үржээ.

Энэ дууг Туг үс сонсоод Роны зүг харлаа. Тэгснээ гэнэтхэн дэлгүүрт нисдэг таваг газардав уу гэлтэй үсрэн босов.

- Байж боломгүй юм! Энэ чинь Харри Поттер өөрөө байна! гэж тэр уулга алдлаа.

Хүмүүс эргэн шивнэлдсээр зай завсар гаргав. Туг үс хүү рүү үсрэн очоод гараас нь хөтлөн ширээ рүү авчрав. Хүмүүс алга нижигнүүлэн ташлаа. Туг үс гэрэл зургийн дурангийн өмнө зогсоод ичиж улайсан Харрийн гарыг атган чанга чанга сэгсэрлээ. Зургийн дуран галзуурсан мэт шажигнахад өтгөн утаа Уизлийхны зүг суунаглана.

- Харри! Инээмсэглээрэй! Чи бид хоёр эхний нүүрийг чимэх болно! гэж хэлээд Туг үс өөрөө баясгалантай инээх ажээ.

Намхан нөхөр зураг авч дуусахад Туг үс хүүгийн гарыг тавилаа. Харри хөшсөн хуруугаа хөдөлгөх зуураа өөрийнхөн рүүгээ очих гэсэн боловч Туг үс мөрнөөс нь бариад алхам ч хөдөлгөсөнгүй. Тэрбээр Харрийг өөр лүүгээ татаад, чимээгүй байхыг анхааруулан гараа зангаснаа, хөөр баяртайгаар:

- Ноёд, хатагтай нараа! Үл мартагдах мөч ирлээ! Та бүхэнд нэгэн багаахан мэдээлэл хүргэхийг болгооно уу. Өнөөдөр «Флориш, Блоттс» дэгүүрээс миний гарын үсэгтэй номыг худалдан авахаар залуу Харри хүрч иржээ. Гэхдээ түүнд мөнгө үрэх хэрэг гарахгүй юм. Би өөрийн бүх номоо түүнд бэлэглэж байна гэлээ.

Хүмүүс ахиад алга ташицгаав.

- Бас болоогүй ээ. Харри чи зөвхөн миний «Би шидтэн» номыг аваад зогсохгүй.

Одоо чи болон чиний нөхөд шидтэн миний биеийг өөрийн мэдэлдээ авцгаах болно. Тийм үү, эрхэм ноёд, хатагтай нараа. Энэ есдүгээр сарын нэгнээс намайг ид шидтэний «Хогвартс» сургуулийн хар урлагаас хамгаалах хичээлийн багш, профессор болгохоор урьсан гэдгийг бахархалтайгаар сэтгэл хангалуун мэдэгдэе! гэж Туг үс Харрийг яльгүй дугтарахад, түүний шил хамар дээр нь гарчихжээ.

Хүмүүс Туг үсэд баяр хүргэн хашгиралдаж, Туг үс өөрөө Харрид өөрийнхөө долоон номыг бэлэглэлээ. Харри тэгээд нэг юм арайхийн суларчээ. Танхимын үзүүрт зогсож байгаа Жиннийг хармагцаа Туг үсийн хэлсэн үгний хүндэд дарагдсан мэт гуйвагнан очоод:

- Май Жинни. Би өөртөө авчихна. Сайн сураарай гэж хэлээд түүний дэргэд шалан дээр байгаа тогоонд нь бүх номоо хийлээ.

- Азтай байгааг чинь харж байна! гэх дуу ард нь гарахад Харри шууд л танилаа.

Харри цэх зогсоно. Түүний дэргэд Малфой Драко увайгүй инээмсэглэн зогсож байлаа.

- Алдарт Харри Поттер! Номын мухлагт орж амжаагүй байхдаа л «Зөнч» сонины эхний нүүрт гарчих юмдаа. Жинни Драког гайхан харлаа.

- Түүнийг бүү оролд! Харри өөрөө үүнийг хүсээгүй юм гэж Жинни гэнэтхэн хэлэв. Жинни охин Харрийн дэргэд анх удаа ам нээж байгаа нь энэ.

- Болзоот хосууд! Ха-ха-ха! гэж Драко даажигнан инээлээ.

Жиннийн царай улайжээ. Рон Гермiona хоёр тусгүй юм болж байгааг хараад туслахаар яарцгаав. Тэр хоёрын гарт Туг үсийн баахан сурах бичгүүд байлаа.

- А-а, энэ чинь чи юу! Энд Харрийг хараад гайхаж байгаа чинь мэдээж гэж Рон хэлээд Драког эгээл үмхийрсэн жоом лугаа харлаа.

- Би чамайг энэ дэлгүүрт хараад л бүр их гайхлаа. Ямар их юм аваа вэ! Эцэг эх чинь бүтэн сар хоосон нойтон явах хэрэг гарч дээ.

Рон маань Жиннигээс ч илүү улайжээ. Тэрбээр номуудаа тогоо руу шидчихээд Малфойн зүг ухасхийсэн авч Харри Гермiona хоёр жанчны хормойноос нь завдан шүүрлээ.

- Рон! Одоохон боль! Гадагшаа гарцгаа. Энэ чинь дэлгүүр биш галзуу хүмүүсийн байр байна гэж хэлээд ноён Уизли ихэр хоёроо дагуулан хүмүүсийн дундуур чихэлдэв.

- Өө-ө! Энэ чинь хэн бэ? Артур Уизли!

Энэ бол ноён Малфой байлаа. Тэрбээр хүү рүүгээ очоод мөрөн дээр нь гараа тавиад инээмсэглэв. Яг л Дракотой адилхан юм.

- Сайн байна уу, Люциус гэж ноён Уизли хөндийхөн мэндэллээ.

- Яамныхан ажил ихтэй болсон гэж дуулсаан. Шалгалт болж байгаа гэж мэдэлгүй яахав! Та нарт илүү цагийн мөнгө гэж өгдөг юмуу даа?

Ингэж хэлээд тэр Жиннийгийн тогоо руу гараа шургуулж Туг үсийн олон сайхан номон дотроос «Ид шид эхлэн сурагчдын гарын авлага» гэдэг хуучин үнгэгдсэн сурах бичиг гаргаж ирлээ. Тэгээд:

- Үгүй байлгүй дээ. Хэрэв мөнгө өгдөггүй юм бол шидтэнгүүдийн нэрийг хугалах хэрэг байна уу? гэж хэлээд санаа алдав.

Ноён Уизли хүүхдүүдээсээ ч илүү улайжээ.

- Шидтэнгүүдийн нэрийг хугалах тухай ойлголт өөр шүү, ноён Малфой гэж тэр хэллээ.

- Тэгэлгүй яахав. Хэнтэй л нийлээд байна даа! Үүнээс дор орно гэж юу байхав гэж хэлээд ноён Малфой гялалзсан нүдээр Гермionaгийн аав ээжийг харахад тэд маргагчдыг айсан нүдээр харж байв.

Тэгтэл ноён Уизли тэссэнгүй. Тэрбээр өрөвдөлтэй жингэнэх тогоог өшиглөснөө ноён

Малфой руу үсрэн очоод энгэрээс нь зуурснаа номын тавиур дээр шидчихлээ.

- Миний андуудыг гомдоовол яадгийг үзүүлээд өгнөө гэж хашгираад дээрээс нь унах хүнд номуудыг барин авч байлаа.

- Зүйтэй аав аа! Түүнийг болгоод өг! гэж ихрүүд хашгирна.

- Артур минь! Хэрэггүй, чамайг гуйя гэж хатагтай Уизли үглэнэ, Хүмүүс замдаа байгаа номын тавиурыг дайрч хөдөлгөн үүд рүү тэмүүлцгээв.

- Ноёд оо! Больж үзээч! гэж худалдагч цөхрөнгөө баран хэлээд юм хумаа янзлах санаатай оролдоно.

- Ёстой л галзуу хүмүүсийн байр юм! Эндээс бүгд зайлцгаа гэх нүргэлсэн дуу гарав.

Мэдээж, Хагрид туслахаар яаран ирсэн ажээ. Тэрбээр овоорсон номуудын дундуур амархан гараад зууралдсан хоёрыг агшин зуур хоёр тийш салгалаа. Ноён Уизлийн уруул язарч, ноён Малфойн нүдний дор том хөхөрчээ. «Хорт мөөгний нэвтэрхий толь» гэдэг зузаан номоор цохиулсан юм чинь аргагүй шүү дээ. Эцэг Малфой Жиннийн сурах бичгийг барьсан хэвээр ажээ. Тэрбээр номыг тогоонд буцааж хийхдээ нүдээ таагүйхэн гялалзуулж байв.

- Охин минь, энэ чиний ном. Аав чинь үүнээс илүүг авах чадал байхгүй гэж хэлээд ноён Малфой Хагридын гараас мултран гарч хүүгээ хянамгай харснаа хоёулаа яаран гарч одлоо.

- Артур чи дэмий юмнуудтай орооцолдох хэрэггүй. Эд чинь чөмгөө хүртэл ялзарчихсан хүмүүс! Эднээс болоод санаагаар унах явдалгүй. Мангуу амьтад! Хурдхан гадаа гарцгаая гэж хэлээд Хагрид ноён Уизлийн жанчыг дугтран засах үед цаадах нь арай л шалан дээр уначихсангүй.

Тэд бүгдээрээ дэлгүүрээс гарцгаалаа. Худалдагч тэднийг саатуулах гэсэн авч Хагридын дөнгөж бүсэлхийгээр байсан болохоороо зүрхэлсэнгүй. Ноён Грэйнджер, хатагтай Грэйнджер хоёр айсандаа чичирч хатагтай Уизлийн уур хилэн бадарч байв.

- Хүүхдүүддээ сайхан үлгэр үзүүлж байх шив ... Зодолдож нүдэлдээд л ...

Бурхан минь! Алтан хонгиот Туг үс юу гэж бодсон бол?

- Алтан хонгиот Туг үс бүр баярлачихсан байна билээ! Сонины тэр нөхөрт зодооны тухай сурвалжлага оруул гэхийг дуулаагүй юу. Харин би сонссоон. Алдар хүндэд нь гай болж л дээ! гэж Фред ээжээ тайтгаруулна.

Тэд бүгдээрээ «Цоорхой тогоо»-нд толгойгоо унжуулсаар орцгоов.

Грэйнджерийнхэн маглуудын гудамж руу явдаг нөгөө хаалгаар гарав. Автобусны буудал яаж үйлчилдэгийг ноён Уизли асуух гэсэн авч эхнэрийнхээ харцанд захирагдан дуугүй болов. «Үүр»-эндээ буцаж очих болсон тул Уизлийн гэр бүлийнхэн Харрийн хамт ханан зуух руу яарлаа.

Нисдэг дарь чимхэж авахаасаа өмнө Харри Поттер юутай ч атугай нүднийхээ шилийг авч халаасандаа хийжээ. Тээврийн энэ хэрэгсэл түүнд тохирохгүй нлт.

БҮЛЭГ 5: ШАЖИГНУУР УД

Харрийн бодсоноор зуны амралт хачин хурдан дуусчээ. Тэрбээр Хогвартсаа санагалзан уйдаж байсан ч Уизлийн гэрт өнгөрөөсөн нэг сар бол түүний амьдралын хамгийн аз жаргалтай үе байлаа. Дурслийхныг эргэн дурсаж, сургуулиас буцаж ирэх

үед Улаан модон гудамжинд чухам ямар уулзалт хүлээж байгааг бодохдоо Ронд атаархахгүй байхын аргагүй.

Тэр үдэш галын наадам болсноор өндөрлөлөө. Жорж, Фред хоёр бенгалын гал асааж бараг л хагас цаг шахам улаан одод ханан дээгүүр бүжиглэв. Тэгээд аяга аяга халуун шоколад ууснаа унтахаар явцгаажээ.

Өглөөгүүр тэд удлаа. Уул нь эрт сэрсэн авч юу ч хийж амжихгүй юм шиг санагджээ. Ноён Уизлийн сэтгэл санаа тавгүй үзэг, цэвэр оймс хайн өрөөн дотуураа харайлган явахад «Үүр»-ний бусад хүмүүс хувцасаа хагас дутуу өмсөж гартаа барьсан юмаа явдал юундаа идэх аж. Ноён Уизли Жиннийн хүнд чемоданыг чирэн хашаа руу гаргаад тэнд тэнэж явсан гүнжий тахиаг гишгичих шахан бүдэрлээ.

Бүхэл бүтэн найман хүн, зургаан чемодан, хоёр ууль, нэг харх «Англи» гэдэг жижигхэн форд машинд яаж багтдаг байнаа гэж Харри гайхан бодно. Тэрбээр ноён Уизли машинаа хэрхэн янзалж өөр болгосныг мэдээгүй бүлгээ.

- Моллид ганц ч үг хэлж болохгүй шүү хэмээн тээшнийхээ савыг онгойлгох зуураа ноён Уизли Харрид хэлэв. Тэгээд ямар нэг юм дартал тээшний сав нь томорч нөгөө нүсэр чемоданууд хялбархан гэгч нь багтлаа.

Эцсийн эцэст бүх юм болж хатагтай Уизли, Жинни хоёр урд суудалд суулаа. Тэрхүү суудал нь цэцэрлэгт тавьсан сандлаас ч урт болон сунасан байв. Харри, Рон, Жорж, Перси нарыг ард аятайхан суусныг харсан хатагтай маань багагүй гайхаж:

- Эгэл хүмүүс бидний бодсоноос ч илүү юм аа. Ямар их багтаамжтай машин бэ! Харахад бол ийм баймааргүй л юм гэв.

Ноён Уизли түлхүүрээ түлхэн машинаа асаахад жижигхэн форд дүнгэнэн хашаанаас гарлаа. Харри эргэж харав. Байшинтай салах ёс гүйцэтгэх гэсэн хэрэг. Хэзээ нэгэн цагт дахин харах л байх даа. Тэгээд машинаа хурд авч гүйцээгүй байтал Жорж цаасан буу бүхий хайрцгаа мартсан аж. Ахиад таван хором болоход Фред мартсан шүүр лүгээ ухасхийх хэрэг гарав. Тэгтэл бас Жинни өдрийн тэмдэглэлээ мартсан байдаг байгаа. Өдрийн тэмдэглэлээ авахаас өөр яахав. Тэгээд цагаа харсан чинь юу юугүй галт тэрэгнээс хожимдох нь ээ. Байдал улам хүндрэв.

Ноён Уизли эхнэр лүгээ царайчилсан маягтай хараад:

- Молли, хайрт минь ээ ... гэхэд

- Яагаад ч үгүй шүү, Артур аа! гэв.

- Биднийг хэн ч харахгүй шүү дээ. Хөдөлгүүрт би өөрөө энэ бяцхан товчлуурыг хийсэн юм. Ердөө л нисэх үедээ түлхэхэд л бид үүлэн дотор харагдахгүй

болно. Арван хором гэхэд газар дээрээ очсон байх юм. Хэн ч мэдэхгүй гэдгийг чамд тангараглая ...

- Артур минь, би үгүй гэж хэлсэн шүү. Тэгээд ч гэгээн цагаан өдрөөр шүү!

Арван цаг арван таван минут гэхэд тэд Кингс-Кросс буудалд зогсож байлаа. Ноён Уизли тээш зөөх тэрэг авчирахаар гудамж хөндлөн гүйх үед бүгд л яаран тавцан руу явцгаалаа.

Харри ноднин жил мөн л Лондон-Хогвартс гэдэг буухиа галт тэргэнд суухаар яарч явсан даа. Маглуудад харагддаггүй есөн бүхэл дөрөвний гурав гэдэг тавцан руу очих гэж яаж сандарч байлаа. Тавцанг хүлээх тасалгаанаас төмөр сараалжаар тусгаарладаг юм. Түүнийг нэвт гараад (өвдөхгүй л дээ) эгэл хүмүүст харагдалгүй орох хэрэгтэй.

- Перси түрүүлээд яв гэж хатагтай Уизли сэтгэл нь хямран цагаа харангаа хэллээ.

Галт тэрэг хөдлөхөд ердөө л таван хором үлджээ. Гэтэл тэд наймуулаа байдаг. Бас ядахдаа энэ хаалт саад.

Перси урагш огцом алхсанаа алга боллоо. Араас нь ноён Уизли тэгээд Фред Жорж нар оров.

- Би Жиннийг авч явлаа. Та нар араас очоорой гэж хатагтай Уизли хэлэв.

Тэгээд Жиннийн гараас хөтлөн урагш алхлаа. Нүд ирмэхийн зуур охинтойгоо алга болов. Араас нь Рон Харри хоёр хөдлөв.

- Хамт явцгаая. Ердөө л ганцхан хором үлдлээ гэж Рон санаа тавилаа.

Харри тортой Хэдваг уулиа чемодан дээр сайн суусан эсэхийг шалгаад тэргээ хаалт руу чиглүүлэв. Тэрбээр тун тайван байлаа. «Нисдэг дарь» үүнээс хамаагүй аймшигтай юм чинь. Андууд маань тэрэг рүүгээ бөхийцгөөн хориг саадыг чиглэн хором тутам алхаагаа хурдасган урагшлав. Хориг хаалт хүртэл ердөө л хэдхэн алхам үлдээд байхад гүйж гарсан чинь:

Түн! гэдэг байгаа.

Тэрэг хоригт тулаад арагш ухарлаа. Роны чемодан түжигнэн унаж Харри бүдэрч, тортой ууль тавцан дээгүүр өнхрөхөд Хэдваг маань муухай дуугаран гадагш гарчээ. Эргэн тойронд байгаа хүмүүс юу болоод байгааг ойлгохгүй нүд бүлтийлгэн харцгаана.

- Та нар чинь яагаад байнаа! гэж буудлын нэгэн жижүүр хүүхдүүдэд хэллээ.

- Тэргээ авч явж чаддаггүй ээ гэж Харри шалтаг тоочин хөл дээрээ босохдоо өвдсөн газраа үрж байв.

Рон Хэдваг уулийг барих санаатай хөөцөлдөн хавийн хүмүүсийн гайхшыг барлаа. Шувуудтай тэгж хамаагүй хандаж болохгүй шүү дээ.

- Бид яагаад хаалтыг нэвтэрч чадсангүй вэ? гэж Харри шивнэн Раноос асуулаа.

- Мэдэх юм алга ...

Рон гайхаш барсан байдалтай эргэн тойрноо харлаа. Баахан хүмүүс тэднийг гайхан ширтэх ажээ.

- Бид галт тэрэгнээс хоцрох нь ээ. Яагаад хаалт нээгдээгүйг ойлгох юм алга ... гэж Рон дорой дуугаар хэллээ.

Харри буудлын том цагийг харснаа зүрх нь түгшив. Арван агшин ... ес ...

Ахиад л нэвтрэх гээд үзэв. Бүр сайн чиглүүлж байгаад тэргээ халт руу түлхтэл ахиад л туллаа.

Гурван агшин ... хоёр ... нэг ...

- Гүйцээ. Галт тэрэг явчихлаа. Аав ээж хоёр нөгөө талаас гарч ирэхгүй бид тэдэнтэй уулзахгүй бол яанаа? Чамд ядахдаа Маглуудын жаахан мөнгө бий юу? гэж Рон цөхрөнгөө баран хэлэв.

- Мөнгө гэнээ? Дурслийнхан надад халаасны мөнгө гэж сохор зоос ч өгч байгаагүй юм гэж Харри гунигтайяа инээмсэглэн хэллээ.

Рон хүйтэн төмөр хаалтанд чихээ наан чагнав.

- Юу ч дуулдахгүй байна. Одоо хоёулаа яах вэ? Эцэг маань биднийг хэр удаан эрэх бол? гэж Рон санаашрангуй бувтана.

Тэд эргэн тойрноо харахад хүмүүс тэднийг анхаарч ажигласан хэвээр аж. Хамгийн гол нь Хэдваг чанга орилсоор байсан юм чинь аргагүй шүү дээ.

- Бид машин руугаа буцаж очвол дээр байх аа. Энд хүмүүс биднийг хараад байна ... гэж Харри хэлэв.

- Харри! Машин! гэж Рон уулга алдахад түүний нүдэнд баярын оч гялалзаж байлаа.

- Машин юу гэж?

- Бид Хогвартс руу машинаараа нисэж болно шүү дээ!

- Гэхдээ би бодохдоо ...

- Бид гарцаагүй байдалд орлоо, тийм ээ? Сургуульдаа очих хэрэгтэй байдаг.

Онцгой тохиолдолд насанд хүрээгүй шидтэн хүртэл ид шид хэрэглэж болно гэж байдаг юм. Журмын есдүгээр зүйлд тэгж заасан шиг санагдана ...

- Чи нисдэг машин жолоодож чадах юм уу? гэж Харри асуув. Цөхрөнгөө барсан байдал нь тогт үгүй болж сэтгэл нь догдлож хөөрсөн харагдана.

- Чадалгүй яахав. Хурдхан явцгаая! Лондон-Хогвартсын буухиа галт тэргийг хурдхан гүйцэе. Бид галт тэрэгний сүүлэн дээр буух болно гэж Рон тэргээ буудлын гарах хаалга руу эргүүлэх зуураа хэллээ.

Андууд тэргээ хүмүүсийн дэргэдүүр түрсээр буудлын дэргэдэх талбайд гарч ирээд

«Англи» гэдэг хуучин форд машинаа байгаа гудамжны зүг баруун тийш эргүүлэв.

Рон шидэт саваагаар хэд хэд цохин тээшний савыг онгойлгоод чемодануудаа хийж, Хэдвигийн торыг ар талдаа тавин өөрсдөө урд суудалд сууцгаалаа.

- Хэнд ч харагдахгүй байх ёстой шүү гэж Рон хэлээд шидэт саваагаараа ахин нэг тогшиж машинаа асаав.

Харри цонхоор цухуйн харахад гудамжинд хөдөлгөөн их байсан ч тэдний байгаа хэсэгт огт хүнгүй нам гүм ажээ.

- Бүх юм зүгээр байна гэж тэр мэдэгдэв.

Рон хянах самбар дээрх жижигхэн мөнгөлөг товчлуурыг дарлаа. Жижиг форд агаарт хөөрөхөд тэд ч хамт хөөрөв. Суудал нь чичигнэн доргихыг Харри мэдэрч бас хөдөлгүүрийн чимээг сонсож байлаа. Алгаараа өвдгөө тэмтэрхэд шил нь тэнд унасан байв. Ямартай ч атугай тэрбээр машинаар дүүрэн хүн зонгүй тэр гудамжны дээд талд хоёр метр зайд хөөрсөн хоёр нүд болон хувирсан бололтой.

- Гараанаас гаръя гэх Роны дуу баруун талд нь гарна.

Хоёр талаараа улаан хүрэн барилга бүхий гудамж хаашаа ч алга болжээ. Ахиад хэдэн агшин өнгөрөхөд бүх Лондон тэр аяараа алган дээр нь байгаа юм шиг харагдах агаад зарим хэсэгт нь гэрэл гэгээ гялтганаж зарим нь утаанд бүрхэгдсэн үзэгдэнэ. Тэдний нисэхийг хэн ч хараагүй бололтой.

Гэтэл ямар нэг юм гэнэтхэн шажигнаж машин Харри Рон цөмөөрөө харагдах төрхөө оллоо. Рон байдаг чадлаараа товчлуурыг дарна.

- Нэг юм нь болохоо байлаа гэж Рон аргаа барсан байдалтай өгүүлэв. Товчлуурыг хоёулаа ээлжлэн цохилоо. Машин ахиад л харагдахгүй болов. Тэгснээ ахиад юу ч болоогүй юм шиг ил гарав.

- Тэсээрэй! гэж Рон хашгираад машины хурдасгуурыг огцом гишгэтэл машин дээш хөөрч өтгөн үүлний давхарга дотор орчихлоо. Өтгөн үүл манад ниснэ гэдэг сохортой адил.

- Хаашаа явах вэ? гэж машины бүх талаар хүрээлсэн өтгөн цагаан үүл мананг харангаа Харри асуув.

- Одоо галт тэргийг олох хэрэгтэй.

- Тэгвэл хурдхан доошлоорой ...

Машин үүлний давхрагаас гарахад хоёр хүү өөр өөрсдийн суудал дээрээс доош харцгаалаа.

- Тээр урд явж байна! Би харлаа гэж Харри баярлан хэлэв. Лондон Хогвартсын галт тэрэг доор нь аварга могой мэт мурилзана.

- Яг хойшоо явж байна. Хагас цаг тутамд чигээ шалгаж байх юм шүү. Одоо сайн бариарай ... гэж Рон хянах самбар дээр байгаа луужингаар чигээ тодорхойлоод хэллээ.

Машин үүлийг нэвт гараад нарны гэрэлд ил гарчээ.

Орчлон хорвоо орвонгоороо өөрчлөгдөв. Дугуй дор нь эцэс төгсгөлгүй хөвөн зөөлөн цагаан үүл эргэн тойронд нь хязгаар хярхаггүй хөх тэнгэр дээр нь хурц улаан наран харагдана.

- Энд онгоцтой таарахаас айх хэрэгтэй гэж Рон хэллээ.

Тэр хоёр бие биеэ хараад инээд алдав. Тэд тасралтгүй инээсээр л байлаа, инээлдээд л байлаа.

Тэд яг л шидэт зүүд зүүдэлж байгаа мэт. Энэ бол жуулчлах хамгийн сайн арга юм байна гэж Харри бодлоо. Өндөр цамхаг өтгөн үүлсийн хажуугаар нисэхэд машин дотор гэрэл гялалзаж, тэдний тавьсан цахилдаг цэцгийн ундаа харагдана. Мөдхөн Хогвартсын ойролцоох ногоон зүлэг дээр ёслол төгөлдөр газардахад ихэр Фред Жорж хоёр атаархангуй харах байх даа.

Тэд умар зүг нисэх зуураа хагас цаг тутам доошлон чигээ шалгаж байлаа. Доорх дүр зураг ямагт өөрчлөгдөх ажээ. Лондон аль хэдийн ард хоцорч, сайтар арчилсан ногоон талбай улайран үзэгдэх хоосон газраар солигдож, энд тэнд эртний сүм хийд бүхий жижигхэн тосгод харагдана. Бас олон өнгийн шоргоолж мэт жижигхэн машинууд гудамжаар нь хөлхөх том хот тааралджээ.

Иймэрхүү байдлаар хэдэн цаг ниссэний дараа Харрийн гайхаж шагширах нь илэрхий буурчээ. Ундаанаас уумаар санагдахын дээр хэтэрхий халуун байсан болохоор тэр хоёр цамцаа тайлжээ. Гэсэн ч Харрийн дотуур цамц суудалд наалдан нүдний шил нь байн байн хөлөрсөн хамар луу нь бууж ирнэ. Тэрбээр үүлсийн сайхан дүрсийг хайхрахаа больжээ. Тэртээ дор төмөр замаар яваа галт тэрэгний аль нэг сэрүүн өрөөнд суугаад эелдэг, тарган лусын авчирч өгөх хулууны аяга хүйтэн шүүс ууж явбал юутай сайхан байх билээ! Гэхдээ тэд чухам яагаад есөн бүхэл дөрөвний гуравдугаар тавцан дээр гарч чадсангүй вэ?

- Одоо мөдхөн хүрэх байх аа? гэж хэдэн цагийн дараа Рон сөөнгөтөн хэлэв.

Наран үүлсийн цаагуур хөвж тэдний бүх юм улаан өнгөтэй үзэгдэнэ.

- Ахиад доошилдог ч юм билүү?

Галт тэрэг урьдын адил тэдний дор цаст оргил бүхий уулсын хормойгоор явах ажээ. Нарыг халхалсан үүлсийн дор илэрхий харанхуй юм.

Рон машины хурдасгуурыг дарахад ахиад л дээш хөөрсөн авч хөдөлгүүр яагаад ч юм муухай дуугарлаа.

Харри, Рон хоёр бие биенээ гайхан харав.

- Машин маань ядарсан байх аа. Ийм удаан завсарлагагүй ажилласан юм чинь!
гэж Рон хэллээ.

Тэр хоёр юу ч болоогүй юм шиг дүр эсгэж байсан ч машины орилох дуу улам нэмэгдсээр. Тэгтэл үдшийн бүрий болж харанхуйд одод гялалзана. Харри цамцаа өмсөх зуураа, яагаад ч юм чичигнэх болсон шил цэвэрлэгчийг харахгүйг хичээнэ. Шил цэвэрлэгч дургүйцлээ илэрхийлэх мэт ажээ.

- Бид ойртоод ирлээ гэж Рон Харрид гэхээсээ илүү машиндаа хандан хэлээд хуруугаараа хянах самбарыг тоншино.

Тэд ахиад л доошлон харанхуйд таних зүйл байгаа эсэхийг хайж харлаа.

- Хараач! Яг зөв явж байна! гэж Харри гэнэтхэн хашгирав.

Шөнийн харанхуйд сүүмийн үзэгдэх нуурын дээр өндөр цохион дээр Хогвартсын шилтгээн цамхагууд харагдаж байлаа.

Гэтэл машин улам бүр чичигнэж, хурдаа алдаж байв.

- Дахиад жаахан явчих. Бид бараг хүрээд ирлээ гэж Рон царайчлан хэлээд залуураа мушгина.

Хөдөлгүүр орилсоор. Машины хамраас нарийхан уур суунаглана. Тэд нуур луу ойртсон учир Харри суудлынхаа ирмэгээс зуурчээ.

Машин огцом донсоллоо. Харри цонхоор харсан чинь доор нь усны хар ногоон мандал үзэгдэв. Рон хуруугаа цайртал чангаар залуураасаа зуурчээ. Машин ахиад л донслолоо.

- Ахиад жаахан гэж Рон хэлэв.

Нуурын дээгүүр яг шилтгээн чиглэн нисэж явлаа. Рон хөшүүргийг гишгэлээ. Гэтэл чанга хяхтнах дуу гарч тас няс хийгээд хөдөлгүүр бүрэн унтарлаа.

- За-а гэж Рон нам гүмийг эвдэн дуугарав.

Машины хамрын таглаа доош нисэн одлоо. Машин хурдаа аван дээшилснээ ахиад л доошлон энэ хэвээрээ явбал одоохон шилтгээний бат бөх ханыг мөргөх нь ээ.

- Алив хүлээгээч! гэж Рон орилоод залуураа эргүүлнэ.

Машин хананд сөөм хэртэй ойртсоноо эргэж өндөр нуман хаалгаар шилтгээн рүү нисэн орлоо. Доор хүлэмжнүүд түүний цаанаас ногооны талбай, зүлэг харлан харагдана. Машин доошилсоор.

Рон залуураа орхиод арынхаа халааснаас шидэт саваагаа гаргалаа.

- Зогс, зогсоорой! гэж хашгиран хэлэх зуураа саваагаараа салхины шилийг балбах авч машин газар луу унасан хэвээр.

- Болгоомжлоорой, мод байна! гэж Харри хашгираад залуур руу ухасхийлээ.

Гэхдээ оройтжээ. Тар, няр!

Машин бүдүүн мод мөргөхөд хангир жингэр хийсэн муухай дуу гаран газарт унаад бөмбөг шиг ойж гарлаа. Машины хамраас өтгөн уур савсана. Хэдвиг айсандаа муухай дуугаар орилж байлаа. Харри салхины шилийг духаараа мөргөсөн болохоор өндөгний чинээ булдруу гарчээ. Рон цөхрөнгөө барсан дуугаар хашгирчээ.

- Чи амьд уу? гэж Харри айсан дуугаар асуулаа.

- Миний саваа ямар болсныг хараач гэж Рон хоолой чичрүүлэн хэлэв. Саваа нь хоёр хэсэг болоод хэсэгхэн хальсаар торгоогджээ.

Шидэт савааг сургуульд засаж болно гэж тайвшруулах санаатай Харрийг ам нээтэл зүүн талын хаалганд их бууны сум тусах шиг боллоо. Тэрбээр Роныг даран унатал ахиад л нэг цохилт ирэх нь тэр.

- Юу болоод байна? гэж Рон хэлээд салхины шилийг хармагцаа уулга алдлаа. Харри эргэн харвал могойн хэртэй бүдүүн мөчир шил ороолгож байхыг харав.

Тэдний дайрсан мод хариу цохилт өгсөн хэрэг ажээ.

Бас нэг тахир мөчир баруун хаалгыг цохин хонхойлгосон байв. Сарвууны ястай адил мөчирт цохиулсан салхины шил доргиж хуучин эвэр шиг махийсэн бас нэг том мөчир оройг цохин цоолж орхижээ.

- Энэ ч арай дэндлээ! Эндээс хурдан явъя! гэж Рон уулга алдлаа.

Рон машины хаалгыг бүх биеэрээ түлхтэл түүнийг буцаан Харрийн өвдөг дээр хүчээр хаячихав.

- Бид бүр баларлаа гээд Рон уйлах шахлаа. Машин гэнэтхэн доргисноо хөдөлгүүр аяндаа унтрав.

- Ухраад! гэж Харрийг хашгирахуй машин арагш ухарлаа.

Харин нөгөө бургас могой адил мөчрөөрөө тэдэнд хүрэхээр хичээнэ. Андууд түүний үндэс хэрхэн шажигнахыг сонсчээ. Зодоонч бургас хариу авах хүсэлдээ шатаад эгээтэй л газраас суга үсэрчихсэнгүй.

- Бид ч үхлийн ирмэг дээр байлаа шүү. Форд маань овоо доо! гэж Рон амьсгаагаа дарж ядан хэллээ.

Харин форд машины тэсвэр алдагдсан бололтой. Муухай хяхтнан дуугараад хоёр үүдээ нээн хүүхдүүдийг хажуу тийш шидэхэд тэд газар дээр үхэдхийн унажээ. Ард нь чанга чимээ гарсныг бодоход машин тэдний чемоданыг гаргаж чулуудсан хэрэг. Толгой дээгүүр нь Хэдваг ууль тортойгоо нисэн өнгөрөв. Торны үүд нээгдэж Хэдваг чөлөөтэй боллоо. Ууль ууртайгаар гууглаад сургуулийн зүг алгуурхан нисэн одов.

Зурагдаж хонхойсон форд уур утаа манаруулан арынхаа гэрлийг харанхуйд улалзуулан уухилж дургүйцлээ илэрхийлэх ажээ.

- Буцаад! Буцаад! Аав намайг баллана шүү дээ! гэж Рон араас нь хашгирлаа. Гэвч форд машин яндангаараа сүүлчийн удаа тургиад харанхуйд уусан алга болов.

- Бидэнд аз таарсангүй ээ. Үгүй ер! Эдний бүх модон дотроос хариугаа авдаг модыг олж мөргөх ч гэж дээ! хэмээн Рон ялархан хэлээд Короста хархаа авахаар тонгойжээ.

Тэрбээр хөгшин удыг эргэн харахад мөчрөө хонзонтой нь аргагүй сарвалзуулж байв.

- Тийм ээ, аз таарсангүй. Одоо шууд сургууль руугаа явцгаая гэж Харри уруу царайлан хэллээ.

Буцаж ирсэн байдал нь тэдний төсөөлсөнчлөн төдий л их бадрангуй биш байв. Ядарч зүдэрсэн, хөхөрч хавдсан тэд чемоданыхаа бариулаас зуурсаар сургуулийн аварга том царсан хаалгыг чиглэн толгод тийш өгслөө.

- Нээлтийн ёслолын ажиллагаа аль хэдийн эхэлчихсэн байлгүй гэж Рон хэлээд чемоданаа гол шатны дэргэд тавилаа. Тэгээд хурц гэрэлтэй цонх руу сэмхэн дөхөж очоод дотогш харснаа:

- Харри нааш хүрээд ир. Хуваарилалт эхэлчихсэн байна! гэв.

Харри дөхөж очоод тэр хоёр их танхимд болж буй ёслолын ажиллагааг харлаа.

Асаж буй олон лаа бүтээлгээр бүтээсэн дөрвөн том ширээн дээгүүр хөвөн хөөрч гэрэлд нь алтан сав суулга, цом аяганууд солонгын өнгөөр туяаран гялалзах ажээ. Харин лааны дээд талаар адрын дагуу танил болсон одод хурц гэрэлтэн харагдана. Адрын шидэт чанар бол тэнгэрийн байдлыг толь шиг тусгадагт байгаа юм.

Шовх оройтой шинэс моддын дундуур айсан шинжтэй нэгдүгээр дамжааныхан ар араасаа цувран танхимд орж явааг Харри олж харлаа. Тэдний дунд Жинни явна. Уизлийн гэрийхний гол ялгарах онцлог болсон тод улбар шар үсээр нь Харри түүнийг шууд таньжээ. Нүдний шил зүүж, үсээн дагзан дээрээ овоолон зангидсан профессор МакГонагалл шинэ сурагчдын тэнхимүүдэд хувиарладаг нөгөө алдартай бүрх малгайг мухар сандал дээр тавьсан байв.

Хичээлийн шинэ жил болгоны эхэнд далан нөхөөс, хир тортог болсон эртний энэ бүрх хэнийг дөрвөн тэнхимийн алинд суралцах ёстойг (Гриффиндор, Пуффендуй, Когтевран, Слизерин) шивнэн хэлж өгдөг билээ. Яг жилийн өмнө энэ бүрхийг өмсөөд өөрийнхөө хувь заяаг сэтгэл түгшин хүлээж байснаа Харри сайн санадаг юм. Бусад тэнхимүүдийг бодвол хар шидтэн, жатгачин түлхүү гаргадаг Слизеринд хуваарилагдчих вий гэж их эмээж байсан сан. Бүрх малгай хэдэн агшин чимээгүй байснаа Рон болон түүний ах нар бас Гермiona нарын хуваарилагдсан Гриффондор тэнхимийг түүнд сонгож өгсөн юм. Ноднин жил Рон тэд нар тэнхим хоорондын тэмцээнд Гриффондорыг түрүүлэхэд тусалсан билээ. Сүүлийн долоон жилийн туршид анх Слизерин ард хоцорсон бүлгээ.

Бүрх малгай тавьсан сандал руу бор саарал үстэй жаахан хүү дөхөж ирлээ. Харри түүнийг хальт харснаа багш нарт зориулсан цайллагын ширээний ард хуваарьлалтыг ажиглан суугаа сургуулийн захирал профессор Дамблдор дээр анхаарлаа төвлөрүүлэв. Түүний цагаан сахал мөнгөрөн туяарч, олон зуун лааны цоролзох дөлөнд нүдний шил нь гялалзана. Түүнээс хэдэн суудлын зайд урт нөмрөг бүхий Алтан хонгиот Туг үс суух ажээ. Ширээний ард үс ноос болсон ойн харуул Хагридын дүрс үзэгдэнэ.

- Хараач. Багш нарын ширээний ард нэг суудал хоосон байна. Снегт багш алга.

Тэр хаана байгаа юм бол? гэж Харри Ронд шивнэлээ.

Профессор Северус Снегт түүний хамгийн дургүй багш юм. Харри ч бас түүний хайртай шавь байсангүй. Ёжтой ширүүн Снегт шингэний тухай хичээл ордог байсан бөгөөд түүний удирдсан Слизерин тэнхимийнхэн л профессорыг хүндэтгэдэг байлаа.

- Тэр өвдсөн байж ч магадгүй гэж Рон найдангүй өнгөөр хэлэв.

- Бүр явчихсан юм болов уу? Хар урлагаас хамгаалах хичээлийн багшийн суудал түүнд дахин олдоогүйгээс болов уу?

- Түүнийг хөөсөн байж магадгүй ээ? Түүнийг бүгд үздэггүй шүү дээ ... гэж Рон урамтай өгүүлэв.

- Бас та хоёрыг сургуульдаа яагаад галт тэргээр ирээгүйг сонсох санаатай хүлээгээд зогсож байж ч магадгүй юм гэх хүйтэн дуу ард гарлаа.

Харри агшин зуур эргэн харав. Ердөө л хоёр алхмын зайд Северус Снегт багш өөрийн биеэр зогсох агаад хар жанч нь салхинд намиран хийснэ. Тэрбээр маш туранхай шаргалдуу царайтай унжуу монхор хамартай агаад тосолсон юм шиг хар үс нь мөрөн дээр нь асарна. Түүний инээмсэглэж байгааг хараад Рон тэр хоёрыг ихээхэн муу юм хүлээж байгааг ойлголоо.

- Миний араас яв! гэж ширүүн профессор тушаав.

Хөвгүүд бие биеэ ч харж зүрхлэлгүй түүний араас даган шатаар өгсөн, өчүүхэн чимээ хүртэл доргин цуурайтдаг том танхимд орцгоолоо. Танхимыг бамбарын дөл

гийгүүлнэ. Их танхимаас хоолны сайхан үнэр ханхлах авч Снегт багш тэднийг газар дор аваачдаг нарийхан чулуун шатаар буулган гэрэл дулаанаас холдуулав.

- Орцгоо гэж хэлээд тэрбээр эхний талбай дээрх үүдийг нээлээ.

Даарч чичирсэн азгүйхэн жуулчид маань Северус Снегтийн танхимд орлоо. Хөрч хоосорсон задгай зуух аятайхан яриа болохгүйг гэрчлэх мэт. Ханын дагуух тавиур дээр Харрийн сонирхолыг огт татдаггүй, харахаас дур гутам эвгүй зүйл хийсэн том шилэн сав ярайлган өрсөн байхыг бүдэг бадаг гэрэлд харж байв. Снегт багш хаалга хаагаад олзлогдогчдыг харлаа.

- Тэгэхлээр галт тэрэг бол алдарт Харри Поттер түүний үнэнч аялдан дагалдагч Рон Уизли нарын хувьд тохирохгүй унаа болж таарлаа. Сургуульдаа ёслол төгөлдөр утгуулж ирэх гэсэн юм биз дээ? гэж тэрбээр намуухан дуугаар яриагаа эхлэв.

- Үгүй ээ, ноёнтоон. Кингс-Кросс буудлын хаалтаас болоод л ...

- Дуугүй бай! Та нар тэр машинаа яасан бэ?

Рон хүндээр санаа алдав. Снегт багш бусдын бодол санааг мэдэж чаддагийг Рон урьд нь мэднэ дээ хэмээн Харри бодлоо. Гэвч профессор «Үдшийн зөнч» хэмээх өнөөдрийн сонин дэлгэхэд ямар учиртайг Харри ойлгожээ.

- Та нарыг маглууд харчихжээ гэж гарчгийг заангаа сийгүүлэн хэлэв. Тэгээд чанга дуугаар:

- «Тэнгэрээр нисэх «Англи» гэдэг форд маглуудыг гайхуулав» гэж уншсанаа цааш нь:

- Хуучин форд машин шуудангийн байшин дээгүүр нисэж явахыг харсан гэж Лондонгийн хоёр иргэн мэдүүлж байна ... Үд дундын үед хатагтай Хетти Бейлисс Норфолкод хашаандаа угаасан юмаа өлгөж байхдаа ... Пиблзийн иргэн ноён Ангус Флит цагдаагийн газарт мэдээлэхдээ ... гэх мэт мэдээлэл зургаа, долоо байна. Би андуураагүй бол аав чинь «эгэлчүүдийн бүтээлийг хууль бусаар ашиглахтай тэмцэх» хэлтэст ажилладаг байх аа? Та нар бодоод үз дээ ... Түүний хүү нь ... хэмээн Ронд хандан ёсжтой хэллээ.

Уурласан уд бургасны хамгийн том мөчрөөр ороолгох шиг Харрид санагджээ. Энэ машиныг ноён Уизли илбэдсэн гэж мэдвэл яанаа? Тэгвэл юу болох вэ? Энэ тухай эрт бодохгүй яав даа?

- Би цэцэрлэгт хүрээлэн үзэж явахдаа унжгар удны ховорхон төрөл болох үнэт шажигнуур удыг ихээхэн гэмтээснийг харлаа гэж Снегт багш хэлэв.

- Харин тэр шажигнуур уд чинь бидэнд их хохирол учруулсан шүү! гэж Рон шуудхан хэллээ.

- Дуугүй бай! Та нар манай тэнхимд суралцдаггүй, би та нарыг хөөж чадахгүй нь туйлын харамсалтай байна. Гэхдээ энэхүү азтай эрхийг атган буй хүмүүс рүү би

та нарыг аваачих болно. Харин одоохондоо та нар эндээ хүлээж бай гэж Снегг багш зандарлаа.

Цонхийн цайсан Харри Рон хоёр бие биеэ арга барсан байдалтай харна. Харин елсөхөө больжээ. Харрийн дотор эвйрч Снеггийн ширээн дээр тавиурт байгаа шилэн савнуудыг харахгүйг хичээнэ. Тэрхүү ногоон шингэн дотор том, бөөн юмнууд хөвөх ажээ. Хэрэв Снегг багш Гриффиндор тэнхимийн эрхлэгч, профессор МакГонагаллын хойноос явсан бол зүгээр өнгөрнө гэж бүү бод. Тэр эмэгтэй Снеггийг бодвол илүү шударга боловч бас л хатуу хүн билээ.

Арван хормын дараа Снегг багш буцаж ирэхдээ профессор МакГонагаллыг дагуулж ирсэн нь мэдээж. Харри түүний уурласан байхыг хэд хэдэн удаа харсан ч гэлээ уурласан үедээ уруулаа хэрхэн жимийдгийг нь мартсан ч юм уу, эсвэл ийм их уурласан байхыг нь хараагүй ч юмсан уу. Тэрбээр танхимд орж ирэнгүүтээ шидэт саваагаараа даллахад багачууд айсан боловч зүгээр л ханан зууханд гал асаасан хэрэг байжээ. Гал дорхноо дүнгэнэтэл асав.

- Сууцгаа гэж тэрбээр хэллээ.

Тэр хоёр галын ойролцоо байгаа сандал дээр суулаа.

- Одоо яриад байгаарай! гэж МакГонагалл нүдний шилээ ууртайгаар гялалзуулан шаардав.

Рон шидэт тавцан дээр гаргаагүй хаалтнаас эхлэн золгүй явдлаа ярьж эхэллээ.

- ... Ноён профессор минь, бидэнд өөр арга байсангүй. Бид яагаад ч галт тэргэндээ сууж чадахааргүй байлаа.

- Та нар яагаад уулиараа захидал илгээгээгүй юм. Чамд ууль бий биз дээ? гэж хэлээд профессор Харрийг ширүүн харлаа.

Харри толгойгоо гудайлгав. Үнэндээ ингэх ёстой байжээ ...

- Би ... би санасангүй ...

- Энэ ч тов тодорхой байна.

Энэ үед хаалга тогшиход Снегг баяр хөөрөөр гэрэлтэн үүдийг нээлээ. Танхимд сургуулийн захирал профессор Дамблдор орж ирэв.

Харри бүр атийн суулаа. Дамблдорын төрх байдал тун ч ширүүн ажээ. Тэрбээр махир хамраа өргөн хүүхдүүдийг харав. Энэ үед Харри харанхуй цэцэрлэгт хүрээлэнгийн шажигнуур удын ширүүн цохиолтод Роны хамт өртөхсөн гэж боджээ.

Дамблдор удтал дуугүй суусны эцэст:

- Яагаад ингэх болсноо тайлбарлахгүй юу гэлээ.

Түүний гомдсон дууг сонсоход уул нь тэднийг хашгирч загнасан бол хавьгүй дээр байхаар байлаа.

Харри яагаад ч юм захирлынхаа нүүрийг харж чадахгүй ярих нь түүнд биш өвдгөндөө өгүүлэх мэт ажээ. Тэрбээр илбэдүүлсэн машин ноён Уизлийнх гэдгээс бусдыг маш дэлгэрэнгүй ярьжээ. Түүний яриагаар бол Рон тэр хоёрт аз тохиосон болж таарлаа. Буудал орчмын зогсоол дээр нисдэг машин тааралдсан байна. Хэдийгээр Дамблдор юу ч асуугаагүй боловч түүнд итгэсэнгүй гэдэг нь шууд л ойлгогдов. Эцэст нь Харри гунигт явдлаа ярьж дуусахад захирал маань өрөвдөлтэй хүүхдүүдийг нүдний шилнийхээ цаанаас харж дуугүй суусан хэвээр.

- Бид явж ачаа тээшээ янзлая даа гэж Рон тун аядуухан хэллээ.
- Рональд Уизли та юун тухай яриад байна? гэж профессор МакГонагалл ширүүн асуув.
- Та бүхэн биднийг сургуулиас хөөх юм байгаа биз дээ? Харри Дамблдорыг түргэн зуур гүйлгэн харлаа.
- Өнөөдөр биш ээ, ноён Уизли. Гэхдээ би та хоёрт сүүлийн удаа сануулж байна.

Та хоёр тун айхтар хэрэг мандуулжээ. Би өнөөдөр л гэр бүлийнхэнд чинь захидал бичих болно. Хэрэв ахиад ингэх юм бол хөөхөөс өөр аргагүй болно доо гэж захирал хэлэв.

Снеггийн нүүрэнд тодорсон инээмсэглэл дорхноо алга боллоо. Өвлийн амралт өөрчлөгдсөн гэвэл л ингэх байсан байх даа.

Тэрбээр ханиалган захирал руу хандан:

- Профессор Дамблдор гуай, энэ хүүхдүүд бага насны хүүхдийн хийх ид шидийг хязгаарласан хуулийг зөрчиж маш үнэтэй уд модыг сүрхий гэмтээсэн шүү ... Энэ бол танхайрсан явдал ... гэлээ.
- Тэднийг шийтгэх асуудлыг профессор МакГонагалл шийднэ биз. Танай тэнхимд суралцдаг болохоор та л хариуцах учиртай. Би цайллага руу явлаа. Минерва та хэд хэдэн юм зарлах хэрэгтэй. Явъя Северус минь биднийг ямар сайхан бялуу хүлээж байгаа гээч! хэмээн Дамблдор тайван хэлэв.

Харри, Рон хоёр луу хорт могойн харц чулуудсанаа Снегт багш захирлыг дагалдан танхимаас гарлаа. Шүүгдэгч хүүхдүүд тэднийг хатуу боловч шударгуу харцаар ширтэх профессор МакГонагаллын хамт үлдэв.

- Уизли чи одоо эмнэлэг рүү явбал таарна. Духан дээрх шархнаас чинь цус гарч байна.
- Нэг их өвдөхгүй байнаа. Профессор оо, би дүүгээ хаана хуваарилагдахыг харах юмсан гэж Рон ханцуйгаараа духаа арчингаа яаран хэлэв.

- Хуваарилах ёслолын ажиллагаа аль хэдийн дууссан. Дүү чинь бас л Гриффиндорт орсон доо.

- Сайн байна!

- Харин Гриффиндорын хувьд ... гэж МакГонагаллыг ярьж эхэлтэл:

- Профессор оо, биднийг машинд суух үед сургуулийн хичээл эхлээгүй байсан шүү дээ. Тэгэхээр ... Гриффиндороос оноо хасахгүй биз дээ? гэж Харри санаа зовон дундуур нь орон асуулаа.

Профессор МакГонагалл түүнийг хөдөлгөөнгүй ширтэх үед уруулд нь инээмсэглэл тодрох шиг түүнд санагджээ. Ямар ч гэсэн уруулаа жимийгээгүй байв.

- Үгүй ээ, би тэнхимийн онооноос хасахгүй. Гэхдээ та нар шийтгүүлэх нь гарцаагүй. Хичээлийн дараа нийгмийн тустай хөдөлмөр хийх болно.

Харрин сэтгэл амарлаа. Түүний бодсоноос хавьгүй аятайхан өнгөрөв. Дурслийнханд бичсэн захиаг ямар шийтгэл гэх билээ. Шажигнуур уд түүнийг бүрмөсөн хөнөөчихгүй дээ л гэж харамсах байлгүй.

Профессор МакГонагалл шидэт саваагаа Снеггийн ширээн дээгүүр даллав. Тэгтэл ширээн дээр хаанаас гараад ирснийг нь бүү мэд хачиртай талх дүүрэн таваг хулууны шүүс бүхий хоёр аяга гараад иржээ.

- Идэцгээ, тэгээд унтлагынхаа өрөө рүү марш. Харин би цайллага руу буцаж очих хэрэгтэй.

Түүнийг хаалга хаан одоход Рон чанга гэгч нь үргэлжлүүлэн исгэрч:

- Би ч сургууль баяртай л гэж бодлоо шүү! гэж хэлээд хачиртай талхыг ховдоглон шүүрлээ.

- Би ч бас гэж Харри хэлээ түүний жишээгээр талх авлаа.

- Бид ямар азгүй байв аа! Фред, Жорж хоёр энэ машинаар тав, зургаан удаа нисэхдээ нэг ч эгэл хүнд харагдаагүй юм даг. Гэхдээ бид яагаад хаалтыг нэвтрэн тавцан дээр гарч чадсангүй вэ? гэж тахианы махтай талх үмхлэн залгих зуураа Рон хэллээ.

Харри мөрөө хавчив.

- Одоо алхам бүрээ цэнэх хэрэгтэй. Биднийг цайллагад оруулаагүй нь харамсалтай ... гэж хэлээд Харри мөнгөн аяганд мөстэй хийсэн хулууны шүүснээс дуртайяа халбагадаж байв.

- Тэр биднийг бусдаас нуухаар шийджээ. Энэ орой хэн ч бүү яриг гэсэндээ.

Гэхдээ л сургуульдаа машинаар нисэж ирэх сайхан байлаа!

Тэд цадгалаа идэж аваад танхимаас гарч танил замаараа Гриффиндорын шилтгээн рүү явлаа. Аяга таваг нь өөрөө хураагддаг аж. Шилтгээнд нам гүм байхыг бодвол баяр дууссан бололтой. Тэд үглэн ярих хөрөг хангир жингэр хийх баатрын дуулганы дэргэдүүр өнгөрч нарийн чулуун шатаар өгсөн, ягаан торгон даашинзтай тарган хатагтайн хөргөөр далдлагдсан Гриффиндор шилтгээний нууц хаалганд хүрлээ.

- Нууц үг? гэж ойртон буй хүүхдүүдийг хараад хатагтай асуулаа.

- М-м-м ... гэж Харри санах гэж буй мэт дүр үзүүлэн гүнгэнэв.

Тэд Гриффиндорын ахлагч нартай уулзаагүй юм чинь шинэ нууц үгийг мэдэхгүй байлаа.

Тэгтэл тусламж амжиж ирэв. Ард нь хэн нэгний хурдан алхах чимээ гарахад эргэж харвал Гермиона тэднийг гүйцэн иржээ.

- Та нар байх чинь! Хаана байсан юм бэ? Та нарыг нисдэг машинаа эвдсэн сургуулиас хөөгдсөн гэж цуураад л байна.

- Үгүй ээ, бид хөөгдөөгүй гэж Харри батлан хэллээ.

- Та нарыг сургуульдаа нисэж ирсэн гэж хэлэхгүй байх гэж найднам ... хэмээн

Гермиона яг л МакГонагалл багшийн дуугаар хэлэв.

- Наад яриагаа түр хойшлуул. Нууц үгээ хэлсэн чинь дээр! гэж Рон тэсгэлгүй шаардлаа.

- «Цацагт хяруул», гэхдээ энэ бол гол биш ... гэж Гермиона уурсангуй өгүүлэв.

Гэхдээ түүний үг алга таших чимээнд дарагджээ. Хатагтай бүхий хаалга нээгдэхэд тэд их танхимын босгон дээр зогсож байв. Тэнхим даяараа унтаагүй байгаа мэт. Хүүхдүүд өрөөнд дүүрэн тэр ч байтугай яйжгар сандал ширээн дээр хүртэл гарч зогсчээ. Тэднийг аль түрүүнээс хүлээж байсан нь илт. Олон арван гар тэднийг хатагтайн хаасан хаалгаар чирэн оруулжээ. Гермиона ч арайхийн оржээ.

- Гайхамшигтай! Үнэхээр агуу! Ингээд хүрээд ирдэг байж! Шажигнуур удыг мөргөсөн гээд байгаа! Сургууль энэ явдлыг зуун жил ч мартаггүй! гэж Ли Жордан хашгирлаа.

- Сайн эрс! гэж урьд өмнө Харритай нэг ч удаа ярилцаж байгаагүй тавдугаар дамжааныхан магтах ажээ.

Саяхан холын зайны гүйлтэнд түрүүлээд ирсэн мэт хэн нэг нь түүний мөрийг алгадна. Фред Жорж хоёр хүүхдүүдийн дундуур зүтгэсээр нүүрэнд гарч ирлээ.

- Та нар яагаад биднийг дуудсангүй вэ? Бид дорхноо буцаад очих байсан!

Роны царай улайж гэмшингүй инээмсэглэв. Харри гэнэтхэн олны дундаас нэгэн гомдонгуй царай олж харлаа. Энэ бол нэгдүгээр дамжааныхан дунд зогсох Перси

ажээ. Тэрбээр тэдний тухай бодсоноо хэлэх санаатай ойртож байв. Харри Роны хажуу руу нудраад ахлагчийн зүг тлгой дохин заалаа. Рон байдлыг асар хурдан ойлгов.

- Бид нилээд ядарчээ. Дээшээ гарцгаая гэж хэлээд тэр хоёр хүүхдүүдийн дундуур зүсэн явж танхимын нөгөө талд байгаа унтлагын өрөө рүү ордог шатны зүг тэмүүллээ.

- Баяртай гэж хэлээд Харри Гермiona руу гар даллахдаа яг л Перси шиг зэмлэнгүй харцтай байхыг харжээ.

Тэднийг шатны талбай хүртэл гайхаж бахархсан хүүхдүүд ууц нурууг нь нөхөрсөгөөр алгадаж байв. Андууд бараг гүйх шахам дээш зүтгэлээ. Тэдний унтлагын өрөө яг дээвэр дор байх бөгөөд үүдэн дээр нь «2-р дамжаа» гэсэн хаяг гоёмсог харагдана. Тэд өндөр нарийхан цонх хилэн бүтээлэг бүхий таван ортой танил дугуй танхимдаа оров.

Чемодануудыг нь хэн нэгэн хүн авчирч орны хөлд тавьжээ. Рон Харрийг гэмшингүй байдалтай харав.

- Баярлаад байх юмгүй гэдгийг би ойлгож л байна. Гэхдээ ...

Үүд нээгдэж унтлагын өрөөнд хоёрдугаар дамжааны Симус Финниган, Дин Томас, Невилл Долгопупс нар орж ирэв.

- Итгэмээргүй юм! гэж Симус хэлээд туяарна.

- Уран зөгнөл! гэж Дин нэмлээ.

- Гайхамшигтай! гэж Невилл хэлэхдээ нүд нь айж бахархсан янзтай гялалзана.

Гайхуулж бахархаад байх юм байхгүй гэдгийг Харри мэдэж байсан ч өөрийн эрхгүй сэтгэл хангалуун инээмсэглэжээ.

БҮЛЭГ 6: АЛТАН ХОНГИОТ ТУГ ҮС

Гэхдээ маргааш нь Харри инээхтэй мантай байв. Өглөөнөөс эхлээд л үйл хэрэг бүтдэггүй. Их танхимын шидэт адарт уйтгартай саарал үүл хөшиглөжээ. Хоолны дөрвөн ширээн дээр хошуу будааны чанамал, утсан май загас, шарсан өндөг, мах дүүрэн тавагнууд өрөөстэй байлаа. Харри Рон хоёр «Цус сорогчтой тулгарсан нь»

гэдэг дуртай номоо шунан унших Гермionatoй хамт ширээнд суужээ. Тэднийг хууль бусаар ниссэнд охин уурласан хэвээр байсан тул тэдэнтэй хөндий хүйтэн мэндэлсэн юм. Харин Невилл Долгопупс бүр эсрэгээр инээмсэглэл тодруулан малилзах аж. Невилл бол цаг ямагт будилж байдаг дугуй царайтай хүү билээ. Юм хумаа дандаа мартана.

- Одоохон шуудан ирнэ. Эмээ маань надад юм явуулна даа. Би бүгдийг нь аваагүй л байж таарна гэж тэрбээр өгүүлэв.

Үнэхээр ч Харрийг будаагаа идэж эхлээгүй байтал толгой дээгүүр нь лав л зуугаас доошгүй ууль далавчаа сэржигнүүлэн нисэж ирлээ. Тэд танхим дотуур эргэлдэж охид хөвгүүдийн дууг даран гуугчиж энд тэндгүй захидал, илгээмж унагаж байв. Нэг том боодолтой юм шууд Невиллийн толгой дээр буутал бас нэг том сэгсгэр юм Гермionatoгийн тавагт унаж хүүхдүүдийг сүү өдөөр будлаа.

- Сум байна! Аймаар юм! гэж Рон уулга алдаад норж бохирдсон уулийг савраас нь татан тавагнаас гаргав. Ууль ширээн дээр дээш харан хөдөлгөөнгүй хэвтэх агаад хошуунд нь нойтон улаан дугтуй байна.

- Зүгээр ээ, тэр амьсгаатай байна гэж Гермionato хэлээд хурууныхаа үзүүрээр уулийг илбэнэ.

- Энэ тухай бишээ. Өөр юм байхгүй юу? гэж хэлээд Рон улаан дугтуйг заалаа.

Харрийн бодлоор бол дугтуйд онцгой юм ер алга. Харин Рон Невилл хоёр түүнийг одоохон дэлбэрэх гэж байгаа юм шиг харна.

- Юу болсон бэ? гэж Харри асуулаа.

- Ээж ... ээж надад аяндын мэдээ ирүүлжээ хэмээн Рон шивнэн хэллээ.

- Хурдхан задал. Тэгэхгүй бол муу шүү. Манай эмээ бас нэг удаа ийм захиа явуулсан юм даг. Харин би тэр тухай мартчихжээ. Тэгээд юу болсон гэж санана! хэмээн Невилл аяархан хэлэв.

- Аяндын мэдээ гэдэг чинь юу юм бэ? хэмээн асуухдаа Харри харцаа анд нарынхаа айсан царайгаас улаан дугтуй рүү шилжүүлээ.

Рон булангаасаа уугин эхэлж байгаа дугтуйг нүд салгалгүй ширтэнэ.

- Задлаарай! Одоохон шатна шүү! гэж Невилл хэлээд Роныг нударлаа.

Рон чичирсэн гараа сунган дугтуйг уульны хошуунаас аваад задаллаа. Невилл хуруугаараа чихээ бөглөв. Чухам яагаад тэгснийг Харри тэр дороо ойлголоо. Эхлээд түүнд захидал дэлбэрэх шиг санагджээ. Том танхимд нүргэлэх чимээ гарахад адраас тоос пүргэж байв. Гэнэт нүргэлсэн чимээн дундаас үг ялгарч:

«... Машин хулгайлна гэдэг чинь. Хэрэв чамайг сургуулиас хөөвөл гайхах юм алга. Би чам дээр очно гайгүй. Бид машинаа байхгүй болохоор чухам ясныг чи мэдэж байгаа байлгүй ...» хэмээн хэлэх дуулдав.

Хатагтай Уизли ерийнхөөсөө лав зуу дахин чанга хашгирсан биз. Чулуун хананд цуурайтах дуунаас нь болоод ширээн дээрх таваг халбага ойж бууж байлаа. Ширээний ард суугаа хүүхдүүд энэхүү захидлыг авсан азгүй хүүг нүдээрээ эрэн сандал дээрээ эргэлдэнэ. Рон ичсэндээ болоод сандлаасаа бараг гулган унаж зөвхөн хавдартай дух нь харагдана. Энэ үед захидал:

«Орой нь ... Дамблдороос захиа ирлээ. Эцэг чинь гомдсондоо үхэх байлгүй гэж би бодож байсан шүү. Бид чамайг арай өөр журмаар өсгөсөн юм сан. Харри та хоёр үрэгдэж болох байлаа!» хэмээн үргэлжлүүлсээр.

Харри нэрээ гарахыг хүлээн суусан билээ. Тэрбээр чихний нь хэнгэрэгийг балбан буй ярьдаг захидлыг сонсоогүй мэт дүр эсгэнэ.

« ... үнэхээр аймаар юм. Эцгийг чинь ажил дээр нь авч хэлэлцэх гэж байна. Үүнд чи л буруутай. Ахиад чи иймэрхүү явдал нэг л удаа гаргах аваас бид чамайг сургуулиас яаралтай гаргаж авна».

Захиадал ингээд дууслаа. Танхимд нам гүм болжээ. Роны гараас унасан улаан дугтуй дүрэлзэн шатаад чимх үнс үлджээ. Харри Рон хоёр дөнгөж саяхан давалгаанаар шидүүлсэн мэт амьсгаадан нүдээ бүлтийлгэн сууна. Олон хүүхэд инээлдсэн авч ахиад л яриа хөөрөө дэгджээ.

Гермиона номоо хаагаад Роныг харлаа.

- Рон чиний юу хүссэнийг мэдэхгүй юм. Гэхдээ чи ...
- Намайг гавъяа байгуулсан гэж бүү яриарай гэж Рон хэлэв.

Харри будаатай тавгаа түлхлээ. Түүний чих халуу оргиж байв. Ноён Уизлийг ажил дээр нь мөрдөн шалгах юм байна! Ноён Уизли хатагтай Уизли хоёр зунжингаа түүний төлөө зүтгэсний дараа шүү ...

Гэхдээ энэхүү гунигт бодлоо үргэлжлүүлэх хугацаа байсангүй. Профессор

МакГонагалл ширээний дагуу явж хүүхэд бүрт хичээлийн хуваарь тарааж байв.

Харри хуудас цаасыг хараад тэдний ангийн эхний хоёр цагт ургамал судлал орох юм байна гэж мэдлээ. Пуффендуй тэнхимийнхэн хамт орох юм байна.

Харри, Рон, Гермиона нар цамхагаас гарч ногооны талбайн дэргэдүүр өнгөрөн шидэт цэцэг ногоо ургадаг хүлэмж рүү яаран явлаа. Аянгын мэдээт захидал үгүй дээ гэхэд нэг сайн үйлс бүтээжээ. Гермиона хөвгүүдийг сайтар шийтгүүлсэн гэж үзээд ахиад л хөгжилтэй дотно эелдэг болов.

Тэд хүлэмжинд дөхөж очоод ангийнхан нь профессор Стеблийг хүлээн хаалганы дэргэд байхыг харлаа. Тэрхэн агшинд профессор маань Алтан хонгиот Туг үсийн хамт хүрч ирэв. Тэд шажигнуур удны тэндээс зүлгэн дээгүүр явж иржээ. Профессор Стеблийн гарт боолт шохойн сойлго харагдана. Харри уд модыг харсан чинь түүний хэд хэдэн мөчрийг шохойдсон байлаа. Харрийн сэтгэл ахиад л шаналав.

Профессор Стебль бол даахирсан үсэн дээрээ далан долоон нөхөөс болсон бүрх малгай тавьж явдаг жижигхэн бумбагар эмэгтэй байлаа. Түүний даашинз ямагт газар шүргэж хэрэв Петунья эгч хумсыг нь харвал ухаан алдаж унамаар. Алтан хонгиот Туг үс бол тэс өөр цаг ямагт цэмцгэр явах агаад ногоон нөмрөг нь намирч, алтан шаргал туг үс нь мөн тийм өнгийн малгайтайгаа гайхалтай зохицоно. Малгай нь алтан эмжээртэй байдаг юм.

- Бүгдийн амрыг эрье! Би шажигнуур удыг яаж эмчлэхийг профессор Стебльд зааж өгсөн юм! Гэхдээ профессорыг ургамал судлал надаас дутуу мэддэг гэж бүү бодоорой! Би энд тэндгүй бадарчилж явахдаа янз бүрийн ургамал янзлах хэрэг гардаг байсан юм ... гэж тэрбээр сурагчдад алсаас хашгиран инээмсэглэж байлаа.

- Хүүхдүүд ээ, гуравдугаар хүлэмж! гэж илэрхий сэтгэлээр унасан профессор Стебль хэллээ. Тэрбээр өнөөдөр урьдынх шигээ хөгжилтэй елдэг байсангүй.

Хүүхдүүд баахан шуугилдлаа. Ноднин жил тэд зөвхөн нэгдүгээр хүлэмжинд л хичээллэдэг байсан юм. Гуравдугаар хүлэмжинд байгаа ургамлууд илүү сонирхолтой, тэр ч байтугай аюултай ажээ. Профессор маань бүснийхээ цаанаас том түлхүүр гаргаж ирээд хүлэмжийн үүдийг нээлээ. Тэндээс бүлээн агаар пүнхийж нойтон шороо бордоо адраас дүүжлэгдэн ургасан шүхрийн чинээ том цэцэгсийн анхилуун үнэр Харрид үнэртэнэ.

Тэрбээр Рон Гермiona хоёрын араас дотогш алхсан авч Алтан хонгиот түүнийг зогсоолоо.

- Харри! Хоёулаа хэд гурван үг солих хэрэгтэй байна. Харрийг гурван хором хожимдуулахыг профессор та татгалзахгүй биз дээ?

Нүүр царайг нь харвал Стебль багш татгалзаж байгаа нь илт.

- За тун сайн байна гэж Алтан хонгиот хэлээд ургамал судлалын багшийн хамрыг тасдах шахам хаалгаа хаалаа.

- Харри! Харри! Харри минь! гэж Алтан хонгиот уулга алдан толгой сэгсрэхэд түүний том хурц цагаан шүд нарны гэрэлд гялалзаж байв.

Юу ч ойлгоогүй Харри Алтан хонгиотыг гайхан харна.

- Би энэ тухай дуулаад шууд л ойлгосон юм. Бүх болсон явдалд би буруутай.

Би өөрийгөө алахад ч бэлэн байлаа!

Харри юун тухай ярьж байгааг нь ойлгохгүй болохоор шуудхан асуух гэсэн боловч

Алтан хонгиот:

- Би амьдралдаа хэзээ ч ингэж гайхаж байсангүй! Хогвартс руу машинаар нисээд ирсэн байдаг! Чамайг яагаад ингэх болсныг би ойлгосоон. Төв тодхон байна! Харри! Харри! Харри минь!

Алтан хонгиот дуугүй байхдаа хүртэл сувдан шүдээ ил гаргаж харуулдаг нь гайхалтай юм.

- Би чиний бардам занг хөдөлгөчихжээ! Тийм биз дээ? Надаас ийм халдвар авсан юм шиг байна. Чи бид хоёр сонины эхний нүүрэнд гарсан шүү дээ. Ахиад ийм явдал болохыг чи хүлээж чадсангүй ...

- Үгүй ээ, профессор оо зүгээр л ...

- Харри! Харри! Харри! гээд Алтан хонгиот түүний мөрөөр чанга тэврэн:

- Би ойлгож байнаа. Нэгэнт л амтанд нь орсон хойно алдар хүнд мөрөөдөхөөс өөр яахав. Би чиний өмнө их буруутай. Энэ мансуурал чиний толгой тархинд нэвтэрчээ. Гэхдээ ойлгох хэрэгтэй. Өөрийгөө бусдад анзааруулахын тулд машинаар нисэж болохгүй. Биеэ аятайхан авч яв, болно биз? Том болоход чинь чамд цаг хугацаа боломж өчнөөн олдоно. Тийм ээ, тийм одоо чиний юу бодож байгааг би мэднэ! «Ярих ч амархан л даа. Тэртээ тэргүй дэлхий даяар нэрд гарсан шидтэн юм чинь!» гэж чи бодож байгаа. Гэхдээ арван хоёр настай байхдаа чам шиг л нусан жур байлаа. Чамаас ч дор байсан юм. Чи бол ямар нэг хэмжээгээр нэрд гарчихсан юм чинь. Тийм биз дээ? Би Хэцүү нэрттэй тохиолдсон явдлын тухай ярьж байна! гээд Харрийн духан дээрх цахилгаантай адил сорвийг анхааралтай харлаа.

- Мэдэж байнаа, мэдэж байна. Энэ бол хамгийн сайхан инээмсэглэлд олгодог «Шидэт долоо хоног» сонины шагналыг таван удаа авахтай огт адилгүй хэрэг. Гэхдээ эхлэл гэхэд зүгээр шүү, Харри минь. Маш сайн хэрэг!

Тэгээд нөхөрсөгөөр нүдээ ирмэснээ Алтан хонгиот хөөр баяртай холдон одлоо. Харри хэдэн агшин хэртэй гайхсандаа болоод учраа олохгүй байснаа хичээл эхлээд таван хором өнгөрснийг санамагцаа хүлэмжний үүдийг нээгээд дотогш сэмхэн оров.

Профессор Стебль хүлэмжний гол дахь модон сандлын дэргэд зогсоно. Сандал дээр хорь орчим хос чихэвч хэвтэх ажээ. Харрийг Гермionaгийн хажууд зэрэгцэн суух хүртэл хүлээгээд профессор хичээлээ эхлэлээ.

- Өнөөдөр бид мандрагор шилжүүлэн суулгана. Энэ ургамлын шинж чанарын тухай хэн ярих вэ?

Гермионаг түрүүлэн гар өргөхөд хэн ч гайхсангүй.

- Мандрагор буюу мандрагорум бол эрүүл мэндийг сэргээх зориулалттай хүчтэй үйлчлэгч ургамал юм.

Хараалд өртсөн хүнийг буцааж хэвд нь оруулахад мандрагорыг хэрэглэдэг хэмээн

Гермиона сурах бичгийг цээжилсэн юм шиг дуржигнуулав.

- Сайн байна. Гриффиндорт арван оноо өглөө. Мандрагор бол хорын эсрэг үйлчилгээтэй ихэнх ургамалд гол суурь эзэлдэг юм. Гэхдээ мандрагор тийм ч аюулгүй биш ээ. Яагаад гэдгийг хэн хэлэх вэ? гэж профессор Стебль хэллээ.

Гермиона ахиад л гараа дээш гозолзуулахдаа Харрийн нүдний шилийг золтой л унагачихсангүй.

- Мандрагорын уйлахыг сонсох юм бол үхлийн аюул учирдаг хэмээн Гермиона түгдрэлгүй хариулав.

- Яг зөв. Ахиад арван оноо өглөө. Одоо та нарын өмнө байгаа мандрагор бол нялхаараа байгаа суулгац.

Ингэж хэлээд профессор гүнзгий хайрцгуудыг заахад хүүхдүүд сайтар харахын тулд урагшилцгаав. Хайрцагт буй хөрснөөс улаавтар ногоон навчис эгнээ эгнээгээрээ цухуйсан үзэгдэнэ. Хайрцаг болгонд зуу орчим жижигхэн мандрагор байх ажээ. Харрид ер бусын юм юм ч үзэгдээгүй болохоор «мандрагор уйлах» гэдэг нь огт барьцгүй сонсогджээ.

- Чихэвчээ авчгаая гэж профессор Стебль заавардлаа.

Хүүхдүүд бие биеэ түлхэн сандал руу ухасхийцгээв. Бүх хичээлийн турш хиймэл сарнайн дунд суухыг хэн ч хүсээгүй нь мэдээж.

- Намайг «Чихэвч зүү» гэж хэлэхэд юу ч сонсогдохооргүй зүүх хэрэгтэй.

Чихэвчээ авах болоход чинь би эрхий хуруугаа гозойлгоно. Чихэвчээ зүүцгээе!

Харри чихэвчээ хурдхан зүүтэл чив чимээгүй болчихлоо. Профессор Стебль нөмрөгөө нөмрөөд ханцуй шамлан нэг ургамлаас сайтар бариад хүчтэй чангаалаа.

Харри тэсэлгүй уулга алдсан боловч түүний дууг хэн ч сонссонгүй.

Шороонд дотроос үндэсний оронд шороо болсон хэлбэр дүрсгүй бяцхан амьтан шиг юм гарч ирлээ. Яг орой дээр нь навчис ургасан байх агаад цайвар ногоон хальстай, янз бүрийн өнгийн толботой тэрээр үзтэл хашгиран байх мэт.

Профессор Стебль ширээн дороос цэцгийн том ваар гаргаж ирээд мандрагорын бутлаг навчсыг үлдээн чийглэг хар хөрсөнд суулгалаа. Тэгээд гарынхаа шороог сэгсэрснээ эрхий хуруугаа гозойлгоод чихэвчээ авав.

- Манай мандрагор одоохондоо нялх байгаа болохоор уйлахад нь үхчихгүй ээ.

Гэхдээ л тэдний орилох дуу дөрвөн цаг хэртэй мангууруулж чадна шүү. Та нарын хэн ч гэсэн эхний өдрийн хичээлийг таслахгүй юмсан гэж байгаад би итгэлтэй байна. Тийм болохоор чихээ чихэвчээрээ сайтар битүүлээрэй. Хичээл дуусахад би дохио өгнө. Хайрцаг бүр дээр дөрвөн хүн ажиллана. Ялзмаг энэ уутанд байгаа. Бас түлдэг ургамалын тэмтрүүлд хүрэх юм бол түлэгдэнэ гэдгийг анхаар гэж профессор тайван тайлбарлахдаа харсаар байтал ямар нэгэн ид шид үзүүлсэн биш зүгээр л таримал цэцэг уласан юм шиг харагдана.

Ингэж ярих зуураа өргөстэй багир улаан ургамлыг нилээн чанга алгадлаа. Тэрхүү ургамал тэмтрүүлээ түүний мөр лүү сэмхэн сунгаж байснаа агшин зуур татан авч байв.

Харри, Рон, Гермиона гурав дээр Пуффендуй тэнхимийн нэг бужгар хүүхэд нэмэгджээ. Харри түүнийг харж байсан ч нэг ч удаа ярилцаагүй билээ.

- Жастин Финч-Флетчли гэж тэр өөрийгөө танилцуулан найрсгаар гараа сунган

Харрийн гарыг атгалаа. Тэгснээ:

- Би таныг мэдэлгүй яахав. Чи бол алдарт Харри Поттер ... Харин чи бол бүх хичээлдээ гарамгай Гермиона Грэйнджер байна гээд Гермионагийн гарыг атгахад охины нүүрэнд баяр хөөр тодров.

- Чи бол Рон Уизли байна. Нисдэг машин чинийх байсан уу? гэж асуулаа.

Рон хариулах гэсэн боловч түгдэрчээ. Аянгын мэдээ түүний ухаан санаанаас гараагүй байгаа нь илт. Тэд дөрвүүлээ лууны шивхээр бэлдсэн хөрсөөр цацгийн ваарыг дүүргэж байв.

- Алтан хонгиот багш хүчтэй шүү! Яг л арслан шиг зоригтой. Та нар түүний номыг уншсан уу? Намайг утасны бүхээгт байхад цус сорогч дайрвал би айснаасаа болоод үхэх байлгүй. Харин түүнд бол юу ч биш! Тулалдаанд ялсан. Үлгэр шиг л! Эцэг, эх маань намайг Итонд бүртгүүлсэн авч би энд суралцаж байгаадаа баяртай байна. Ээж минь жаахан гонсгор байсан боловч би түүнд Алтан хонгиотын номыг уншуулахаар өгсөн юм. Тэгээд л ээж маань гэртээ шидтэнтэй, тэр дундаа сайн боловсролтой шидтэнтэй байх сайхан юм гэж ойлгосон доо ... хэмээн Жастин хөврүүлнэ.

Тэгээд Жастин дуугүй болж ахин яриа хөөрөө гарсангүй. Хүүхдүүд чихэвчээ зүүгээд мандрагороо шилжүүлэн суулгаж эхлэлээ. Профессор Стебль ургамал судлалын эрдэмтэн болохоороо эхний суулгацыг амархан суулгажээ. Гэхдээ энэ бол амар ажил биш байлаа. Мандрагорууд дассан газраасаа сугарч өөр вааранд очихыг огт хүсэлгүй сравалзан тийчилж, хурц чанга нударгаар балбаж шүдээ тачигнуулж байв. Харри нэг айхтар бүдүүн мандрагорыг вааранд суулгах гэж арван хором хичээл дуусах үед тэрбээр бусдынхаа адил хөлөрчихсөн тоос шороо болчихсон гар хуруу нь өвдчихсөн

байлаа. Бохирдож ядарсан хүүхдүүд арайхийн шилтгээнд очиж халуун шүршүүрт орсны дараа Гриффиндорынхон хувиргалын хичээлд суухаар явцгаав.

Профессор МакГонагаллын хичээл ямагт хүнд байдаг ч өнөөдөр бүр хэцүү байлаа. Ноднин жил сурсан бүх зүйл нь зуны туршид Харрийн толгойноос хийсэн оджээ. Хичээл дээр өгөгдсөн үүрэг бол живхний цохыг том товч бол болгон хувиргах явдал байв. Харри яаж ч мэрийгээд болж өгсөнгүй. Хичээлийн туршид тэрбээр нөгөө цохыг шидэт саваанаас зугтан тэгш гадаргуу дээр давхих дасгал хийлгэжээ.

Роны хувьд бүр ч бүтэлгүй болов. Хичээл эхлэхийн өмнө тэрбээр нэг хүүхдээс хэсэгхэн шидэт наалдамхай тууз авч шидэт саваагаа ороожээ. Гэвч саваа огт хэрэгцээгүй болсон юм шиг байв. Саваа нь юм л бол шажигнаж, оч хаялж, Роныг цохоо хувиргахаар оролдох үед ялзарсан өндөгнийх шиг үмхий үнэртэй утаа

баагиулсан аж. Утаан дунд юу ч харагдахгүй байсан болохоор Рон санамсаргүй тохойгоороо цох хорхойгоо няц дарчихаад ахин шинэ цох гуйх хэрэг гарчээ. Ингэхэд профессор МакГонагалл тун ч их гомдсон юм.

Хичээл дуусан хонх дуугарахад Харри санаа алдлаа. Тархи толгой нь ядарч гүйцжээ. Рон, Харри хоёроос бусад хүүхдүүд ангиас гүйн гарцгаав. Рон шидэт саваагаараа ширээ балбан ууртайгаар:

- Хувиа бодсон тэнэг саваа! гэж үглэнэ.
- Гэрийнхэндээ захидал бич. Тэд шинэ саваа явуулах байлгүй гэж Харри түүнд зөвлөлөө. Саваанаас оч хаялсан хэвээр.
- Тэгвэл бас нэг аянгын мэдээ авах болно доо гэж Рон хэлээд санаа алдсанаа саваагаа цүнхэндээ хийв. Энэ үед саваа нь:

«Бүхэнд өөрөө л буруутай ...» гэж үглэж байлаа.

Тэд гуанзанд хоол идэхээр явцгаав. Гермiona хувиргалын хичээл дээр гаргаж авсан атга шахам сайхан товч үзүүлсэн ч Роны сэтгэл амарсангүй.

- Үдээс хойш ямар хичээлтэй билээ? гэж Рон асуув.
- Хар урлагаас хамгаалах хичээл гэж Гермiona дор нь хариулжээ.
- Яагаад чиний хуваарь дээр Туг үсийн орох хичээл болгоны ард бяцхан зүрх байгаа юм бэ? гэж Рон Гермionaгийн гараас хичээлийн хуваарь авч хараад асуулаа.

Гермiona түүнээс хуваариа булааж аваад царай нь улайжээ.

Хоолны дараа тэр гурав хашаанд гарахад тэнгэрт бараан үүл хуралдсан байв. Гермiona чулуун шатан дээр суугаад ахиад л «Цус сорогчидтой тулгарсан нь» гэдэг номоо шагайна. Харри, Рон хоёр квиддичийн тухай ярилцан дэргэд нь зогсож байлаа. Харри гэнэтхэн хэн нэгэн хүн хараад байгааг мэдрэв. Тэрбээр харцаа дээшлүүлэн, хуваарилах ёслолын үеэр их танхимын цонхоор харахад байсан саарал

үстэй нөгөө хүүхдийг олж үзлээ. Тэр хүү яг л илбэдүүлсэн юм шиг нүдээ бүлтийлгэн Харрийг ширтэнэ. Тэрбээр гартаа харахад маглуудынхтай адил гэрэл зургийн дуран барьжээ. Тэрбээр Харрийн харж байгааг мэдмэгцээ хавч адил улайв.

- Битгий уурлаарай, Харри. Би Колин Криви. Бас л Гриффиндорт сурдаг. Хэрэв би ... зураг авбал чи зөвшөөрөх үү? гэж нэг амьсгаагаар хэлснээ урагш алхан дурангаа өргөлөө.

- Зураг гэнээ? гэж Харри учрыг ойлголгүй лавлав.

- Тийм ээ, зураг авъя. Биднийг танил гэдгийн баталгаа болог. Бүгд л чиний тухай мэддэг юм чинь. Хэцүү нэрт чамайг алах гэсэн ч чи аврагдаж, тэр өөрөө үүрд алга болсон гээд л чиний тухай зөндөө юм ярьдаг юм ... Бас духан дээр чинь цахилгаантай адил сорви байдаг гэсэн (хүүгийн харц Харрийн духан дээр тогтлоо). Манай ангийн нэг хүүхэд хэрэв хальсыг тусгай уусмалд хийвэл зураг хөдөлгөөнтэй гардаг гэсэн юм. Тэгвэл ямар гоё вэ? Намайг гэртээ

байхад янз бүрийн хачирхалтай зүйл тохиолддог байсан ч энэ бол ид шид гэж би мэддэггүй байлаа. Сүүлд Хогвартсаас захидал авсан хойноо л учрыг ойлгосон доо. Аав маань сүүний худалдагч болохоороо одоо ч ид шидэнд итгэдэггүй юм. Би түүнд олон янзын гэрэл зураг явуулмаар байна. Чиний зургийг авбал мөн сайхан аа. Харин найз чинь намайг чамтай хамт зогсоогоод зураг авч чадах болов уу? Чи гэрэл зурагтаа гарын үсэг зурна биз дээ? хэмээн Колин үргэлжлүүлэн дуржигнуулж ахин нэг алхам ойртлоо. Тэрбээр сэтгэл хөдөлсөндөө болоод тасралтгүй ярих зуураа Харрийг гуйсан байртай харна.

- Гэрэл зурагт гарын үсэг зурна гэнээ? Поттер чи гарын үсэгтэй зургаа тарааж байгаа юм уу?

Драко Малфойн чанга шоолсон дуу хашаагаар нэг хадлаа. Харахад цааз гүйцэтгэгч баймаар Крэбб Гойл хэмээх үнэнч хоёр андаа дагуулсан тэрбээр Колины ард зогсох ажээ.

- Дараалалд зогсохоор яараарай! Харри Поттер гарын үсгээ тарааж байна! гэж хашаанд байгаа хүүхдүүдэд хандан Малфой байдгаараа хашгирна.

- Би юу ч тараагаагүй байна. Малфой минь дуугүй байж гэж Харри нударга зангидан хэллээ.

- Чи атаархаад байгаа юм байна гэж Крэббийн хүзүүнээс ч нарийхан биетэй

Колин палхийтэл хэлчихэв.

- Би юу? Атаархлаа гэв үү? Юунд нь атаархах юм бэ? Магнайгаа хага зүсүүлэх гэж тэр үү? Үгүй ээ, баярлалаа! Би тийм тэнэг хүн биш гэж Драко хэдийгээр хашгиралгүй хэлсэн авч хашаанд байгаа зарим хүүхдүүд сонсож байлаа.

Крэбб Гойл хоёр тэнэг юм шиг инээлдэв.

- Малфой чиний гэдэс нялцгар өтөөр дүүрэг! гэж Рон дүрсхийлээ.

Крэбб инээхээ болиод туулайн бөөр модны самар шиг ясархаг нудрагаа зангидан заналхийлэх ажээ.

- Хэлэхэд амархаан., Уизли. Би чиний оронд байсан бол зодоон хийхгүй л байх сан. Ээж чинь сургуулиас гаргана гэж байсныг мартаа юу гэж Малфой сануулаад:

- «Ахиад чи иймэрхүү явдал нэг л удаа гаргах аваас ...» гэж дуурайн хэллээ. Слизериний тавдугаар дамжааныхан чанга инээлдэв.

- Поттер оо, Уизли ч бас чиний гарын үсэгтэй зураг авахыг бодож байгаа даа.

Энэ үнэт зүйл чинь тэдний байшингаас ч илүү үнэтэй байх болно гэж Малфой уруулаа ёжтой мушийлган өгүүлэв.

Рон туузаар ороосон саваагаа далайсан авч Гермiona номоо хаагаад түүнд:

- Боль! гэж шивнэн хэлээд ойртон ирж буй Алтан хонгиот Туг үсийг харцаараа заалаа.

- Энд юу болоод байна? гэж хэлээд Алтан хонгиот эгээ л хөх шувуухай шиг нисэн ирэхэд номин хөх жанч нь салхинд намиран хатаж буй даавуу шиг дэрвэлзэнэ. Тэрбээр:

- Хэн гарын үсэгтэй зургаа тараагаад байгаа юм бэ? гэж асуув.

Харри болсон явдлыг тайлбарлах гэсэн авч Туг үс түүний мөрөөр тэврэн,цагаан шүдээ яралзуулан инээж:

- Асуух хэрэггүй байж л дээ! Харри чи бид хоёр ахиад таарлаа! Ноён Криви та эхлэ. Бид бэлэн байна! гэж Колиныг урамшууллаа.

Туг үстэй бараг наалдан ичиж зовсон Харри орчин тойрныхоо хүүхдүүдэд ямар нэг юм ярьж сэтгэл хангалуун арзайтал инээх Малфойг харж байв.

- Хоёр зураг шүү, ноён Криви. Үүнээс өөр сайхан юм байхгүй. Бид хоёулаа гарын үсэг зурна! гэж Туг үс заавардлаа.

Колин дурангаа нилээд оролдож байснаа зураг автал хичээлд орох хонх жингэнэв.

- Ангидаа ороорой! Хурдхан! гэж Туг үс тушаагаад өөрөө ч хаалга руу явлаа.

Тэрбээр Харрийн мөрөөр тэвэрсэн хэвээрээ байхад агшин зуур алга болох ид шид сураагүйдээ хүү харамсаж байв.

- Соломон хааны шийдвэр. Залуу Кривитэй тохиолдсон энэ явдалд би чиний бамбай боллоо. Чи бид хоёрын зургийг авсан болохоор чамтай атаархагчид чамайг өөрийгөө өндөрт өргөгч хэмээн хэл амаа шилэмдэнэ ... гэж Туг үс ихэмсэг хэлээд хажуугийн хаалгаар Харритай хамт орлоо.

Харрийн тайлбарлаж ядах үгийг огт сонсолгүй хичээлдээ яаран яваа хүүхдүүдийн дэргэдүүр түүнийг дагуулан хонгилоор явав.

- Алдар хүндийн энэ үедээ гарын үсэг бүхий зураг тараана гэдэг бодлогогүй ажил шүү гэж шуудхан хэлмээр байна. Яг л над шиг боодол боодол зураг бэлэн байлгах хэрэгтэй цаг үе ирнэ. Гэхдээ өнөөдөр бол арай л эрт байна даа гэж тэрбээр хэлээд хөгжилтэй инээлээ.

Эцэст нь Туг үсийг танхимд ороход Харри арайхийн нэг юм чөлөөтэй болжээ. Тэрбээр жанчаа тайлаад арын эгнээнийн ширээний ард суун Алтан хонгиотын долоо номыг урдаа овоолж аваад ард нь нуугдлаа.

Тэгтэл үлдсэн хүүхдүүд чанга ярилцаар танхимд орж ирцгээв. Рон Гермiona хоёр

Харрийн зүг яаран хүрч ирээд нэг нь зүүн талд нөгөө нь баруун талд нь суулаа.

- Нүүрэн дээр чинь өндгөн жаврай шарсан ч болохоор байна! Колин, Жинни хоёрыг бүү танилцаасай гэж бурханд залбираарай. Тэгэхгүй бол Харри Поттерыг дэмжигчдийн клуб байгуулж мэднэ хэмээн Рон шивнэн хэлэв.

- Чимээгүй бай! гэж Харри Роныг тохойгоороо нударлаа. Роны сүүлчийн үгийг Туг үс сонсох л дутаад байж гэнэ.

Бүгд суудлаа эзлэхэд Туг үс чанга ханиалган анги даяараа чимээгүй боллоо. Тэрбээр гараа сунган Невилл Долгопупсын урд байгаа «Савдгийн жимээр» гэдэг номыг авч дээш өргөн хавтсан дээрх өөрийнхөө нүд ирмэх зургийг харуулав.

- Энэ бол би. Мерлиний гуравдугаар зэргийн одонт баатар, хар хүчээс хамгаалах багийн хүндэт гишүүн, «Шидэт долоо хоног» сонины хамгийн сайхан инээмсэглэгчийн таван удаагийн шагналт Алтан хонгиот Туг үс. Гэхдээ энэ тухай одоо ярихгүй. Үхэл таригч ирландын хий үзэгдлээс зөвхөн инээмсэглээрээ салаагүй гэдэгт итгээрэй! гэж хэлээд бас л нүдээ ирмэнэ.

Алтан хонгиот хүүхдүүдийн инээлдэхийг хүлээн чимээгүй болов. Хэдхэн сурагч л нилээд гашуувтар байдлаар инээмсэглэлээ.

- Бүгд миний номын иж бүрдлийг худалдан авцгаасныг би харж байна. Энэ бол сайн хэрэг! Шалгалтын ажлаар хичээлээ эхлэдэг юм билүү дээ. Айх хэрэггүй! Би зөвхөн номоо анхааралтай уншсан эсэх, бас юу тогтоож авсныг л шалгах гэсэн юм ...

Хүүхэд болгонд асуулт бүхий хуудас тарааж өгөөд Алтан хонгиот ширээ рүүгээ эргэлээ. Тэгээд:

- Та нарт хагас цагийн хугацаа өгье. Эхлэцгээ гэлээ. Харри нэгдүгээр хуудсыг уншвал.

1. Алтан хонгиот Туг үс ямар өнгөнд дуртай вэ?

2. Алтан хонгиот Туг үсийн нууц мөрөөдөл юу вэ?

3. Таны бодлоор өнөөдөр Алтан хонгиот Туг үсийн байгуулсан хамгийн том гавъяа юу вэ? гэх мэтийн асуулт байв. Сүүлчийн тавин дөрөв дүгээр асуулт нь:

54. Алтан хонгиот Туг үсийн төрсөн өдөр хэдийд болох, таны бодлоор түүнд тохирсон хамгийн аятайхан бэлэг юу вэ? гэсэн байна.

Хагас цагийн дараа Туг үс бүх хариултыг хурааж аваад түргэн зуур уншлаа.

- Ай-яа-яа! гээд толгой сэгсэрснээ:

- Миний дуртай өнгө ягаан гэдгийг та нарын бараг хэн нь ч мэддэггүй юм байна. Энэ тухай би «Йоркширийн алмас» номондоо бичсэн билээ. Бас зарим нь «Цус сорогчидтой тулгарсан нь» гэдэг номыг анхааралтай уншвал зүгээр юм сан. Арван хоёр дугаар бүлэгт би цагаан дээр хараар миний төрсөн өдрийн хамгийн аятайхан бэлэг бол шидтэн, эгэл бүх л хүмүүсийн хоорондын дотно харьцаа гэж бичсэн байгаа. Гэхдээ Огдены шил сайн вискинээс бол ч татгалзахгүй л дээ! гэлээ.

Тэгээд Туг үс ахиад л дүрсгүй маягаар нүд ирмэв. Рон үл ойлгосон байдлаар Туг үсийг ширтэх ажээ. Урд нь суугаа Симус Финниган, Дин Томас хоёр инээдээ барьж ядан чичигнэнэ. Харин Гермiona бүр анхааралтай сонсож байв. Түүний нэрийг анги даяар тод дуудахад сая сэхээ оров бололтой.

- Харин хатагтай Гермiona Грэйнджер миний мөрөөдлийг мэддэг юм байна.

- Тийм ээ, би хорвоо ертөнцийг муу муухайгаас салгаж өөрийнхөө зохион бүтээсэн үсээ хэвээр байлгах төхөөрөмжөөр зах зээлийг дүүргэх гэж хүсдэг юм. Ухаантай охин! Энэ охин хамгийн өндөр үнэлгээ авлаа. Хатагтай Гермiona Грэйнджер хаана байна? хэмээн түүний хариултыг дахин эргүүлэнгээ асуулаа.

Гермiona чичирсэн гараа өргөв.

- Онц сайн! Нэмэх онц! Гриффиндорт арван оноо өглөө. Одоо ажилдаа орцгооё ... гэж Туг үс баярлан хэллээ.

Ингэж хэлээд тэрбээр ширээнийхээ араар тонгойн даавуугаар бүтээсэн том тор гаргаж ирэв.

- Өнөөдөр би та бүхэнд шидтэнгүүдийн ертөнцөд байдаг хамгийн муухай амьтдыг хязгаарлан тогтоох аргыг зааж өгнө. Энэ өрөөнд аймшигтай зүйл харах болно гэдгийг анхааруулж байна. Гэхдээ намайг дэргэдээ байхад айх явдалгүй. Та нарт муу юм юу ч болохгүй. Тайван байгаарай гэдэг ганцхан зүйлийг л хүсье.

Харри болж байгаа явдлыг сайн харахын тулд өөрийн эрхгүй хаалтныхаа араас цухуйлаа. Туг үс торыг бүтээсэн даавуун дээр гараа тавив. Дин Симус хоёр инээхээ больжээ. Нэгдүгээр эгнээний ширээний ард суусан Невилл айж байгаа нь илт.

- Та нар чимээгүй байгаарай. Эдгээр амьтад хөөрч магадгүй хэмээн Туг үс дуугаа аяасрган хуруугаараа занган хэлэв.

Анги даяараа амьсгал дарах үед Туг үс бүтээлгийг авлаа.

- Энэ бол нөгөө амьтад. Дөнгөж сая барьсан корнуэлийн шунгинуурууд гэж жүжигчин аятай хэлэв.

Симус Финниган тэсвэр алдав бололтой чанга инээхэд Туг үс түүнийг айсандаа хашгирлаа гэж боджээ. Тэрбээр:

- Юу болов? хэмээн инээмсэглэн асуулаа.

- Үгүй ээ ... эд чинь ... аюулгүй амьтад байна шүү дээ гэж Симус инээсэн хэвээр өгүүлэв.

- Тэгж болохгүй ээ. Эд нар дүрсгүйтвэл тун эвгүй юм болно гэж Туг үс толгой сэгсрэн хэллээ.

Шунгинуур гэдэг нь тод цэнхэр өнгөтэй хорин сантиметр шахам биетэй урт хоншоортой амьтан аж. Тэд харанхуйгаас гэрэлд гараад чанга орилолдох нь ангид баахан бүрээчид орж ирсэн мэт санагдуулна. Амьтад торон дотуураа чавхдан торны ханыг балбан хүүхдүүдийг дооглож ч байгаа юм уу, эсвэл хөгжөөж ч байгаа юм уу, элдэв маягаар аашлана.

- Одоо та нарын яахыг харъя! гэж Алтан хонгиот Туг үс чангаар хэлээд торыг нээлээ.

Тэгтэл юу болсон гээч! Санаанд ч оромгүй юм! Шунгинуурууд торноос яг л бяцхан пуужин шиг шунгинан гараад тал тал тийшээ чавхдаж өглөө. Хоёр шунгинуур Невиллийн чихнээс зуурч адар луу чирэв. Тав зургаан амьтад цонх хагалж, арын эгнээний ширээг шилээр дүүргээд ангиас нисэн одлоо. Үлдсэн амьтад гартаа тааралдсан бүхнийг галзуурсан хирс шиг ноцон ноолж эвдэн сүйтгэв. Бэхтэй савыг хагалж дэвтэр номыг хэсэг хэсэг болгон урж ханын зургийг хуулж хагархай цонхоор сурах бичиг, цүнхийг чулуудаж хаялаа. Таван хором ч өнгөрөөгүй байхад бүх хүүхдүүд ширээн доогуураа оржээ. Хөөрхий Невилл ч чийдэнгийн бүрхүүлээс зууран адар дор санжигнана.

- Та нар юундаа айсан юм бэ? Хөдлөөрэй! Тэднийг торонд нь буцааж оруул!

- Энэ чинь зүгээр шунгинуур шүү дээ гэж Туг үс хашгирна. Тэрбээр ханцуйгаа шамлан, шидэт саваагаараа дохиод:

- Пескипикси пестерноми! хэмээн хурдхан хэллээ.

Гэхдээ түүний үг догширсон амьтдыг зогсоож чадсангүй. Тэр ч байтугай нэг нь Туг үсийн шидэт савааг шүүрэн аваад цонхоор шидчихлээ. Туг үс уулга алдан ширээн доогуураа оров. Тэгтэл ч чийдэнгийн бүрхүүл тэсэхээ болиод Невилл маань хэдхэн агшны өмнө профессорын зогсож байсан газарт уначихлаа.

Яг энэ үед хонх дуугарч, хүүхдүүд үүд рүү ухасхийцгээв. Танхимд нам гүм болж Туг үс ширээн дороосоо гарч ирээд салж хагацдаггүй мань гурвыг үүд рүү зугтахад бэлэн байгааг харснаа:

- Андууд минь, үлдсэн шунгинууруудыг торонд буцааж оруулаач гэж хэлэв. Профессор тэдний дэргэдүүр хурдхан өнгөрөөд хаалгыг тас хийтэл хаалаа.

- Ийм явдлын дараа чи түүнд итгэх үү? гэж Рон ууртай хэллээ. Тэрбээр хөөрсөн нэг амьтанд нилээн сайн дөнгүүлсэн ажээ.

- Тэр чинь биднийг амьдралын бодит байдалтай танилцуулах гэсэндээ л ингэсэн юм гэж Гермиона тайлбарлав. Тэрбээр төдийлөн бодсон ч үгүй осгоох шившлэг хэлэхэд хоёр шунгинуур торондоо амархан буцаж орлоо.

- Чинийхээр бол энэ амьдралын бодит байдал уу? Туг үс тэднийг чухам яахаа өөрөө мэддэггүй юм байна! гэж Харри хэлэв. Түүний өмнө нэгэн жижигхэн чөтгөр хэлээ гарган бүжиглэж байсан юм.

- Тэнэг гэдэг нь. Чи түүний номуудыг уншсан шүү дээ. Түүний байгуулсан гайхамшигт ялалтуудыг санаач гэж Гермиона тайван өгүүлэв.

- Тэрбээр зөвхөн ялалт байгуулсан гэж бичдэг л байхгүй юу гэж Рон тодотгон хэлжээ.

БҮЛЭГ 7: ЭРЛИЙЗ БА НУУЦЛАГ ДУУ

Харри хэдэн өдрийн турш Алтан хонгиот Туг үсийн нүдэнд харагдахгүйг хичээсэн нь ёсоор болжээ. Харин Харрийн хичээлийн хуваарийг цээжилчихсэн юм шиг санагдах Колин Кривитэй уулзахгүй байна гэдэг ярвигтай ажээ. Колин хөөр баяраар дүүрэн байлаа. Өдөрт арван удаа: «Ажил ямар байна Харри?» гэж асуугаад «Зүгээр, Колин» гэсэн хариулт сонсох агаад энэхүү үгсийг уурсангүй хэлсэн ч тоодоггүй байв.

Нөгөө машинаар ниссэнээс болоод Хэдваггийн уур гараагүйн дээр Роны шидэт саваа одоо болтол олигтой ажиллахгүй хэвээр. Баасан гаригын өглөө шившлэгийн хичээл дээр тэрхүү саваа бүр замбараагаа алджээ. Роны гараас мулт үсрээд хөгшин

Флитвикийн духан дундуур том ногоон бундуу гартал татсан юм. Тэгж тэгж амралтын өдөр болоход Харри сэтгэл амран санаа алдлаа. Андууд хамтдаа ойн сахиул Хагридын очихоор зэхэцгээж байв. Гэтэл тэр өглөө хар үүрээр түүнийг нэгэн хүн сэрээжээ. Тэрбээр нүдээ арайхийн нээгээд харсан чинь Оливер Вуд байлаа.

- Юу ... юу болоо вэ? гэж Харри нойрмоглох үглэнэ.

- Бэлтгэл! Бос! гэж Вуд эрс тэс хэллээ.

Харри цонхоор харав. Үүрийн алтлаг ягаан тэнгэрт сэмжин үүл хөвөрч шувууд чанга дуугаар жиргэцгээнэ. Эд харин ягаад үүнээс эрт сэрээчихсэнгүй вэ.

- Оливер минь, одоо дэндүү эрт байна гэж Харри хэллээ.

- Чухам тийм учраас. Бэлтгэлийн шинэ хөтөлбөр бидэнд байгаа. Шүүрээ аваад явцгаая! Өөр багууд бэлтгэлээ хийж эхлээгүй болохоор энэ жил бид түрүүлнээ ... гэж хэлэхэд энэхүү зургадугаар дамжааны өндөр, чийрэг хөвгүүний нүдэнд хүсэл зоригийн оч гялалзан бадарч байлаа.

Харри эвшээж, суниасаар орноосоо сугараад чемодандаа байгаа биеийн тамирын хувцасаа эрэв.

- Сайн байна! Би чамайг арван таван хормын дараа талбай дээр хүлээж байя. Биеийн тамирын улаан хувцасаа өмсөж өглөө сэрүүхэн байсан болохоор дээрээс нь

жанч хөдрөөд, Гермionatoй хамт цэнгэлдэх хүрээлэнд очоорой гэсэн бичиг Ронд

үлдээв. Мөрөн дээрээ «Нисдэг лус-2000» шүүрээ тавиад их танхим руу буун хонгилд гарах гэтэл ямар нэгэн чимээ гарчээ. Эргэлдэн тойрч буудаг шатаар Колин Криви гартаа ямар нэг юм барьсаар бууж ирэв. Хүзүүндээ зүүсэн дуран нь ийш тийшээ савчих ажээ.

- Нэг хүн чиний нэрийг хэлсэн шүү, Харри! Надад юу байгааг хараач! Би угаачихаад чамд үзүүлэх гэж ...

Харри өмнөө байгаа гэрэл зургийг гайхашран харав. Хар цагаан зураг дээр Туг үс хэн нэгнийг гараас нь татан зурагт оруулахыг хичээж байлаа. Харри зураг дээрх

өөрийнхөө гарыг таниад Туг үсээс сайтар татгалзсанаа санан баяслаа. Туг үс тэгсхийгээд зөөлөрч гэрэл зургийн цагаан дэвсгэр дээр ядрангуй байртай гарчээ.

- Гарын үсгээ зурах уу? гэж Колин найдлага тавин асуув.

- Үгүй ээ. Уучлаарай Колин, би яарч байна. Одоо би бэлтгэлд гарах ёстой гэж

Харри хэлээд орчин тойрноо хурдхан ажлаа. Өрөөнд азаар хэн ч байсангүй. Ингэж хэлээд тэрбээр шууд хонгил руу явлаа.

- Үгүй ер өө! Хүлээгээч! Квиддич тоглохыг би амьдралдаа үзээгүй юм байна!

гэж Колин хашгирсаар Харрин араас мөр даган гүйв.

- Сонирхолтой юм юу ч болохгүй ээ. Зүгээр л бэлтгэл хийнэ гэж Харри хэлсэн авч Колин нэг чихээрээ оруулаад нөгөө чихээрээ гаргажээ. Баярлаж догдолсондоо түүний царай ягаарч туяарна.

- Чи сүүлийн зуун жилийн хамгийн залуу тоглогч биз дээ? Тийм үү, Харри? Чи суут тоглогч байх аа. Харин би хэзээ ч нисэж үзээгүй. Хэцүү биз дээ, тийм үү? Энэ чинь шүүр юм уу? Хамгийн сайн загвар уу? гэж Колин Харригаас салахгүй даган шалгаана.

Харри түүнийг яаж зогсоохоо мэдэхгүй байв. Хэзээ ч салдаггүй сүүдэртэйгээ ярихаас ялгаа юун.

- Би бүр квиддичийн дүрэм журмыг хүртэл мэдэхгүй гээч. Дөрвөн бөмбөгөөр тоглодог гэж үнэн үү? Хоёр нь өөрөө нисэн тоглогчдыг шүүрнээс унагаадаг гэсэн үү? хэмээн Колин хором ч дуугүй бололгүй давхцуулан асууна.

- Тийм ээ. Энэ бөмбөгийг блажер гэдэг юм. Баг бүр хоёр довтлогчтой тэд өөрсөдөө байдаг тусгай цохиураар нөхөд рүүгээ нисэж яваа блажерыг цохиж зайлуулдаг юм. Гриффиндорын довтлогчид бол Фред Уизли, Жорж Уизли нар гэж Харри баргар царайлан хэллээ. Тэрбээр тоглоомын нарийн ширийнийг тайлбарлаж ярихыг хүссэнгүй.

- Бусад бөмбөгнүүд нь яадаг юм бэ? гэж Колин асуугаад Харриг бишрэн харж явснаа бүдрээд эгээтэй л уначихсангүй.

- Квоффл гэдэг том улаан бөмбөгөөр оноо оруулна. Тоглогчид эсрэг багийнхаа цагаригт оруулахаар бие биедээ дамжуулдаг юм. Царигыг өндөр шонд бэхэлдэг. Талбайн хоёр хэсэгт гурав гурван цагариг байна гэж Харри тайлбарлаж өглөө.

- Дөрөв дэх бөмбөг нь?

- Дөрөв дэх бөмбөг бол алтан снитч. Энэ жижигхэн бөмбөг их хурдан нисдэг болохоор барихад тун хэцүү. Энэ бол баригчын үүрэг. Баригч снитчийг барих юм бол тэмцээн дуусна. Бөмбөгийг баривал шууд л зуун тавин оноо авдаг учраас тэр баг хождог юм.

- Чи Гриффиндор багийн баригч биз дээ? гэж Колин биширсэн маягтай асуув.

- Тийм ээ. Бас баг бүрт хаалгач бий. Тэд цагаригыг хамгаалдаг юм. Ингээд л бүх зүйл болж байна даа гэж Харри хэлэв. Тэд шилтгээнээс гараад шүүдэрт норсон ногоон дээгүүр явж байлаа.

Гэхдээ Колин биеийн тамирын талбай хүртэл Харрийг асуултаар булахаа больсонгүй. Харри түүнээс өлгүүрт орох үүдний өмнө л арайхийн нэг юм саллаа.

- Би явж өөртөө аятайхан суудал олноо! гэж Колин араас нь хэлээд үзэгчдийн байр луу явав.

Хувцасны өрөөнд бүгд цугласан байлаа. Нойрмог үс нь арзайсан Фред, Жорж хоёр дөрөвдүгээр дамжааны Алисия Спиннеттэй зэрэгцэн суужээ. Тэр охин ар тийш налан үүрэглэнэ. Тэдний нөгөө талд Кэти Белл, Анжелина Жонсон гэдэг хоёр ангуучин эвшээн сууна. Вуд харин цовоо сэргэлэн байлаа. Огт нойрмоглосонгүй.

- Өө, Харри ирлээ. Чи яагаад удав аа? Эхлээд би шинэ аргаа би тайлбарлаж өгье. Би энэ аргыг зунжингаа боловсруулсан болохоор энэ жил сургуулийн аварга болоход туслана гэдэгт итгэлтэй байна ... хэмээн Вуд хэллээ.

Тэгээд Вуд самбарт янз бүрийн шугам сум хэрээс дүүрэн квиддичийн талбай зурсан цаас самбарт наав. Саваагаа гаргаж ирээд самбарыг тогшиход нөгөө сумнууд амилан авгалдай адил зургийн дагуу мөлхөж эхлэлээ. Вудыг шинэ аргаа тайлбарлаж байх зуур Фред Уизли маань Алисийн мөрөн дээр толгойгоо тавиад хурхирч байв.

Эхний аргыг тайлбарлахад хориод хором зарцуулагджээ. Тэгээд Вуд хоёрдугаар дараа нь гуравдугаар зургийг гаргалаа. Харри нойрмоглож байгаагаа мэдэж байв.

- Бүгд тодорхой юу? Асуух юм байна уу? гэж Вуд чангаар асуухад Харри амтат нойрноосоо саллаа. Уул нь энэ үед их танхимд суугаад өглөөний зоогоо барьж байна гэж зүүдэлжээ.

- Надад асуулт байна. Энэ бүхнийг өчигдөр орой арай сэргэлэн байхад ярьж болоогүй юм уу? гэж Жорж нүдээ нээн асуулаа.

Асуулт Вудэд таалагдсангүй бололтой.

- Алив, та нар сэрцгээ. Өнгөрсөн жил бид сургуулийн хамгийн сайн баг байсан боловч цом авч чадаагүй. Бидэнд ... тийм ээ ... онцгой явдал саад болсон л доо

... хэмээн дуугаа өндөрсгөн нөгөөдүүлээ таагүй харцаар харан хэллээ.

Харри буруугаа хүлээсэн мэт тонгойно. Сүүлчийн тэмцээн явагдсан тэр улиралд эмнэлгийн орон дээр ухаангүй хэвтэж байсан билээ. Гриффиндор багийнхан талбайд баригчгүй гарсан болохоор сүүлийн гурван жилд гараагүй шившигтэй ялагдал хүлээсэн юм.

Вуд биеэ барихыг хичээн дуугүй сууна. Ноднингийн ялагдал түүнийг одоо болтол зовоосоор байгаа аж.

- Алив, бэлтгээрэй. Энэ жил бид шаргуу бэлтгэх хэрэгтэй. Одоо шинэ онолоо амьдрал дээр хэрэглээд үзье! гэж хэлээд тэрбээр шүүрээ аван үүд рүү яаран явлаа. Түүний араас багийнхан нь эвшээсээр дагалдав.

Вуд өөрийнхөө аргыг тайлбарлах гэж бүр залхжээ! Хэдийгээр өвс ногоон дээр манан суунагласан хэвээр авч наран нэгэнт хөөрсөн байлаа. Харри талбайд гараад үзэгчдийн суудалд суугаа Рон Гермiona хоёрыг олж харав.

- Та нар бэлтгэлээ дуусаагүй байгаа юм уу? гэж Рон гайхан асуулаа.

- Эхлээ ч үгүй байна. Вуд бидэнд шинэ аргаа тайлбарласан юм гэж Харри бувтнан хэлээд андуудынхаа авчирсан жимсний чанамалтай аягыг атаархангуй харав.

Тэрбээр шүүрээ унаж аваад хөлөөрөө түлхтэл тэнгэрт хөөрлөө. Ахиад талбай дээр гарахад юутай сайхан! Харри хамаг хурдаараа цэнгэлдэх хүрээлэнг тойрон нисэж Фред, Жорж нарыг гүйцлээ.

- Юун хачин чимээ гараад байнаа? гэж талбайн нөгөө зах хүрээд нисэхдээ Фред гайхан асуув.

Харри үзэгчдийн суудал руу харлаа. Хамгийн дээд талд Колин сууж байна. Тэрбээр зургийн дурангаа завсар зайгүй шажигнуулахад дуу чимээ нь хоосон цэнгэлдэх хүрээлэнд тов тодхон сонсогдоно.

- Харри, наашаа хар! Наашаа хар! гэж Колин цөхрөнгөө баран хашгирна.

- Энэ чинь хэн бэ? гэж Фред асуулаа.

- Мэдэхгүй ээ гэж Харри худал хэлээд байрнаасаа огцом хөдөллөө. Энэ хөгийн хүүхэд бүр залхааж гүйцлээ!

- Юу болоод байнаа? Яагаад нэгдүгээр дамжааны хүүхэд бидний зургийг аваад байгаа юм бэ? Надад таалагдахгүй байна. Слизериний тагнуул бидний шинэ аргыг мэдэх гэж байгаа юм биш байгаа даа гэж түүний зүг нисэж ирсэн Вуд хөмсөг зангидан асуув.

- Үгүй ээ, энэ чинь Гриффиндорынх гэж Харри ахлагчаа тайвшруулав.

- Оливер минь, слизерийнхэнд тагнуул огт хэрэггүй гэж Жорж хэллээ.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? хэмээн Вуд түүнийг хардангуй харан асуув.

- Тэд энд хүрээд ирсэн байнаа гэж хэлээд Жорж ногоон хувцас өмсөөд шүүрээ мөрөн дээрээ тавин талбай дээр гарч байгаа тоглогчдыг заалаа.

- Тэд хаанаас хүрээд ирэв ээ? Би цэнгэлдэх хүрээлэнг өнөөдрийн турш авсан шүү дээ! За яахав, одоо учрыг нь олноо! гэж Вуд нударга зангидан хэлэв.

Нилээд уурласан тэрбээр доошоо огцом буусан учир яггүй ширүүн газарджээ. Харри болон хоёр ихрийн хамт слизериний хүүхдүүд рүү явж байхдаа яльгүй гуйвна.

- Хөөе Флинт! Одоо бидний цаг шүү! Бид бараг үүрээр боссон! Эндээс явцгаа гэж Вуд нөгөө багийн ахлагчид хандан хэллээ.

Маркус Флинт биеэр Вудаас том хүүхэд. Харрид заримдаа савдагтай адилхан санагддаг юм. Одоо ч тэрбээр ээлжит аргаа олсон савдаг лугаа тэнэгдүү янзаар инээмсэглэнэ.

- Энд бид цөмөөрөө багтанаа, Вуд минь.

Алисия, Кэти, Анжелина нар хүрч ирлээ. Багтаа охидгүй Слизерийн багийнхан мөр мөрөө түшин атаархангүй инээмсэглэн зогсох аж.

- Би цэнгэлдэх хүрээлэнг урьдчилан авсан! Урьдчилан авсан! гэж Вуд хашгирлаа.

- Чи урьдчилан авсан юм байж. Гэхдээ надад профессор Снеггийн зөвшөөрсөн бичиг бий шүү. Унш л даа «Шинэ баригчаа сорих болсонтой холбогдуулан Слизерин багийнхныг квиддичийн талбай дээр бэлтгэл хийхийг профессор С. Снегг миний бие зөвшөөрөв».

- Танайх шинэ баригчтай болсон юм уу? Шинэ мэдээ байна! Хаанаас авсан юм бэ? гэж Вуд асуулаа.

Зургаан тоглогчийн араас нилээд намхан долоо дахь тоглогч гарч ирэв. Түүний цонхигор малигар нүүрэнд сэтгэл хангалуун инээмсэглэл тодроно. Энэ бол Драко Малфой байлаа.

- Чи Люциус Малфойн хүү биш биз? гэж Драког ширтэх зуураа Фред асуув.

- Чи түүний эцгийн нэрийг дурдсан чинь сайн хэрэг. Тэрбээр манай багт өгөөмөр сэтгэлээр тусласан юм. Чи өөрөө хар даа! гэж Флинтийг хэлэхэд Силзеринийнхэн улам баясгалантай инээв.

Тэд долуулаа шүүрээ урагш сунгажээ. Гялалзсан гялтганасан цоо шинэ, «Нисдэг лус-2001» гэсэн алтан үсэгтэй шүүрнүүд өглөөний нарны туяанд гялалзан нүд гялбуулна.

- Сүүлчийн загвар. Ердөө л сарын өмнө гарсан юм. «Нисдэг лус-2000»-аас хавьгүй дээр. Харин «Зүлгэгч»-ийн хувьд бол үүнтэй зэрэгцүүлэх аргагүй гэж хэлээд Фред, Жорж нарын барьсан хуучин шүүрийг доромжлонгуй харлаа. Флинт огт тоолгүй шүүрээ арчин зүлгэх ажээ.

Гриффиндорын тоглогчид юу гэж хариулахаа мэдсэнгүй. Баярлаж хөөрсөн Малфойн ширүүн нүд зураас болон хувирчээ.

- Хараач. Гриффиндорынхны туслахууд нь ирж явна хэмээн Флинт гараараа заалаа.

Учрыг олохоор шийдсэн Рон Гермиона хоёр талбай дундуур тоглогчид руу явж байв.

- Юу болсон юм бэ? Та нар яагаад тоглохгүй байгаа юм? гэж Рон Харригаас асуулаа.

Тэрбээр Слизерин багийнхны дүрэмт хувцас өмссөн Малфойг гайхан харлаа.

- Би Слизериний шигшээгийн шинэ баригч болсон, Уизли минь. Бид шүүрээ сонирхоцгоож байна. Манай багт зориулан аав маань худалдан авч өгсөн юм гэж Малфой сэтгэл хангалуун хэллээ.

Рон долоон сайхан, хурдан шүүрнээс бахархсан харцаа салгаж чадсангүй.

- Сайхан байгаа биз? Гуних хэрэггүй ээ. Хөгжөөн дэмжигчдээсээ мөнгө цуглуулаад ийм шүүр авчих. Эсвэл өөрсдийнхөө «Зүлгэгч-5» шүүрээ дуудлагын худалдаанд оруул. Дэлхийн бүх музей булаацалдаад л авна гэж Малфой даажигнана.

Слизерин багийнхан цөм инээлдлээ.

- Гэхдээ манай нэг ч тоглогч өөрийнхөө байр суурийг худалдаж аваагүй юм шүү. Бүгд л авъяасаараа орцгоосон гэж Гермиона эрсхэн хэлэв.

Малфойн хангалуун царайд уур хилэн тодорлоо.

- Эрлийз минь, чамаас хэн ч юу ч асуугаагүй байна! гэж Малфой хэлэв.

Малфой ямар нэг аймшигтай юм хэллээ гэж Харри шууд ойлголоо. Учир нь түүнийг амаа ч хамхиж амжаагүй байтал санаанд оромгүй их шуугиан дэгджээ. Фред Жорж нарын нударгаас Малфойг хамгаалахаар Флинт ухасхийв. Алисия: «Чи ингэж хэлж чадлаа гэж үү!» хэмээн хашгирч, Рон: «Малфой чи үүнийхээ шанг авнаа!» хэмээн орилоод халааснаасаа шидэт саваагаа гарган авч Флинтийн гар доогуур шургуулан шууд л Малфойн нүүр лүү чиглүүллээ. Цэнгэлдэх хүрээлэн даяар чанга дуу цуурайтан, савааны нөгөө үзүүрээс ногоон оч харван Роны гэдсийг оночихов. Рон унаад ногоон дээгүүр өнхрөнө.

- Рон, чи зүгээр үү? гэж Гермиона түүнээс асуув.

Рон хариу хэлэх гэж ам нээсэн авч ... огиулж гарлаа. Түүний амнаас нь нялцгай өтнүүд гарч Гриффиндорынхныг бүр айлгаж орхив.

Харин Слизеринийхэн инээдээ барьж чадсангүй. Хэрэв шүүргүйсэн бол Флинт ногоон дээр өнхрөн унах байсан биз. Малфой хөл дээрээ тогтолгүй дөрвөн хөллөөд гараараа газар балбан эцэс төгсгөлгүй инээнэ. Гриффиндорынхон гялалзсан том нялцгай өтөөр бөөлжих Роныг тойрон зогслоо. Тун ч эвгүй зүйл айсан болохоор хэн ч туслаж зүрхэлсэнгүй.

- Хагрид рүү аваачъя. Тэднийх ойрхон гэж Харри Гермионад хандан хэлэв.

Охин зоригтойгоор толгой дохиод андууд Роныг сугадан хөл дээр нь босгов.

- Юу болсон бэ, Харри? Юу болов? Тэр өвдсөн юм уу? Гэхдээ чи түүнийг эмчилж чадна биз дээ? гэж үзэгчдийн суудлаас гүйж ирээд Харри, Гермиона хоёрыг тойрон дэлдэгнэх Колин дуржигнуулан байцаана.

Рон ахиад л огиход бас баахан нялцгай өт амнаас нь асгарлаа.

- Ой-ёо! Харри! Түүнийг түр зуур барьж байгаач! гэж Колин баярлан хэлээд дурангаараа шагайлаа.

- Колин, замаас зайл! гэж Харри уурлав. Тэд Роныг дэмжин түшсээр цэнгэлдэхээс гарч Хориотой ойн зүг явлаа.

- Рон оо, бид бараг хүрээд ирлээ. Хоёр хормын дараа бид очноо ... Чи арай гайгүй болох биз ... гэж Гермиона түүнийг зоригжуулан хэлээд моддын дундуур үзэгдэх ойн сахиулын байшинг харлаа. Байшин хүртэл таван метр үлдээд байтал хаалга нээгдэв. Гэхдээ эзэн гарч ирсэнгүй. Энэ удаа ягаан жанч нөмөрсөн Алтан Хонгиот Туг үс том том алхлан үүдээр гарч иржээ.

- Наашаа гэж Харри шивнээд Роныг түлхэн ойрын бутны ард нуугдав.

Гермиона дуртай дургүй түүнийг дагалджээ.

- Энэ бол тун амархан. Зөвхөн юу хийхээ мэдэх хэрэгтэй! Хэрэв тусламж хэрэгтэй бол намайг яаж олохоо мэднэ шүү дээ! Би танд өөрийнхөө номыг явуулнаа. Одоо болтол миний номыг аваагүй байгаа чинь хачирхалтай юм. Өнөө орой би гарын үсгээ зураад явууламз. Баяртай! гэж Туг үс профессорын дуугаар хэлээд шилтгээний зүг явлаа.

Харри түүний далд орохыг хүлээж байснаа Роныг бутны цаанаас гаргаад үүд рүү ярав. Гурвуулаа хаалгыг балбалаа.

Хагрид тэр дороо үүдээ нээсэн авч нэг л янзгүй царайтай байж аж. Гэхдээ тэднийг хармагцаа хөөр баяраар гэрэлтэж:

- Та нар хаашаа алга болчихов оо! Орцгоо, орцгоо! Би профессор Алтан үсийг буцаад ирлээ гэж бодсон юм ... гэлээ.

Харри, Гермиона хоёр унтлагын зочны хоолны өрөө нэгэн зэрэг болдог Хагридын цорын ганц өрөөнд Роныг чирэн оруулав. Нэг хананы дэргэд том ор байх агаад ханан зууханд гал хөгжилтэй шажигнана. Роны сандалд суулгаад Харри болсон явдлын тухай яаран ярьсан авч өг хорхойн тухай яриа аварга биетийг огт сандаргасангүй бололтой.

- Дотор байснаас гадагш гарвал дээр дээ. Рон минь, ичих хэрэггүй гэж Хагрид хөгжилтэй хэлээд Роны өмнө том зэс түмпэн тавилаа.

Рон түмпэн дээр бөхийв.

- Бид өөрөө зогсохыг нь хүлээх хэрэг гараваа даа? Энэ хараалыг зайлуулахад амаргүй, тэгээ ч саваа нь хугархай болохоор ... гэж Гермиона санаа зовон хэллээ.

Хагрид цай уухаар бэлтгэн ширээ бүтээж нааш цааш холхино. Чоноч нохой Соёот

Харрид дөхөж ирээд өвдөг дээр нь толгойгоо тавин шүлсээр жанчыг норгож байлаа.

- Алтан үст чамаас юу хүссэн юм бэ, Хагрид аа? гэж Соёотын чихний ард маажих зуураа Харри асуув.

- Худгийн замаг цэвэрлэхийг надад заасан юм. Би түүнтэй түүнгүй мэднэ. Үхэл дуудагч хий үзэгдлийн тухай жаал дэмий ярилаа. Түүнийг ... хаанаас ч юм

хөөсөн бололтой. Үйлсгүй худал залах юм даа! гэж Хагрид хагас зумласан тахиаг ширээнээс зайлуулж, оронд нь данх тавингаа өгүүлэв.

Энэ бол урьдын Хагрид биш байлаа. Тэрбээр Хогвартсын профессоруудыг хэзээ ч муулж байгаагүй юм. Харри ойн сахиулыг гайхан харж дуугүй сууна. Харин Гермiona дуугүй сууж чадсангүй дуугаа чангаруулан:

- Хагрид чамайг шударга бус байна гэж бид бодлоо. Профессор Дамблдор өөрөө түүнийг хар урлагаас хамгаалах хичээлийн багшаар сонгож тавьсан гэлээ.

- Хэнээс сонгох юм бэ? Хамгаалахыг чинь ... чи бод л доо ... хэн ч заахыг хүсдэггүй юм. Энэ бол хараал идсэн ажил болохоор жилээс илүү тэсдэггүй л байхгүй юу! За яахав, энэ хэнийг илбэдэх гэсэн юм бэ? гэж Роны зүг толгой дохин асуув. Хагрид тэдэнд таваг дүүрэн бурмаар хийсэн чихэр тавьж өгчээ (Рон түмпэн дээр тонгойсон хэвээр).

- Малфойг. Тэр Гермionaг доромжилсон юм. Маш бүдүүлэг үг хэлсэн болохоор бүгд л уурлацгаасан шүү.

- Шившигтэй нэр өгсөн юм. Түүнийг эрлийз гэж байсан ... хэмээн Рон түмпэн дээрээс толгойгоо өргөн арайхийж хэлэв. Түүний цонхийсон нүүрэнд дээр хөлсний дусал бурзайна.

Тэгснээ ахиад л огин түмпэн рүүгээ тонгойлоо. Хагрид уурласандаа баргар улаан болоод:

- Муухай амьтан! гэж хэлэнгээ Гермionaг эргэж харав.

- Юу гэсэн үг гэдгийг нь би мэдэхгүй л дээ. Гэхдээ аймаар бүдүүлэг гэж л ойлгож байна хэмээн Гермiona аяархан хэллээ.

- Энэ бол хамгийн муухай доромжлол гээд Рон дахин толгойгоо өндийлгөн:

- Маглуудын гэр бүлд төрсөн хүмүүсийг эрлийз гэдэг юм. Эцэг эх нь шидтэн биш гэсэн үг шүү дээ. Шидтэнгүүдийн дунд өөрийгөө бусдаас илүү гэж боддог хүн бий. Жишээ нь Малфой. Тэдний судсаар хамгийн цэвэр цус урсаж байгаа гэж онгирцгоодог юм гэж хэлээд ахин огисноо тоссон гар дээрээ жижигхэн өт нулимж гаргаад:

- Ер нь шидтэнгүүд үүнийг огт тоодоггүй юм. Ид шидтэн эгэл байх хоёрын ялгаа юун! Невилл Долгопупсыг аваад үз л дээ. Хэдийгээр цэвэр цустай ч тогоогоо тэгшхэн тавьж чаддаггүй биз ээ гэж хэлээд тэрбээр нөгөө өтийг авч түмпэнд хаялаа.

- Харин, манай Гермiona бүгдийг чадна! Охин минь ... баахан ... үгүй ээ, бүх шившлэгийг мэднэ! гэж Хагрид бардам хэллээ.

Гермиона ийм магтаал сонсоод намуу цэцэг шиг улайв.

- Хүмүүсийг ингэж нэрлэх нь тусгүй дээ. Эрлийз гэнэ шүү! Цусны тухайл тэр!

Одоо ихэнх шидтэнгүүд холимог цустай шүү дээ. Хэрэв бид эгэлүүдтэй

гэрлэдэггүй бол аль хэдийн сөнөх байсан даа гэж Рон чичирсэн гараараа хөлсөө арчин хэллээ.

Тэгснээ ахиад л огиж ширээн доогуур оров.

- Чи ... түүнийг илбэдэх гэсэн чинь огт буруугүй. Саваа чинь ажиллаагүй нь ч болж. Драког илбэдсэн бол Люциус Малфой дорхноо л сургууль дээр хүрээд ирнэ. Тэгвэл ч ёстой гайтай явдал болно! гэж түмпэнд унаж буй өтний чимээг дарахын тулд Хагрид чангаар хашгиран хэллээ.

Нялцгар өтнөөс илүү муу юм байж блохгүй хэмээн хэлэхийг Харри хүссэн авч амаа нээж чадсангүй. Хагридын өгсөн бурман чихэрт эрүү нь зуурчээ.

- Харри, би бараг гомдох шахлаа. Чи гэрэл зурган дээрээ гарын үсгээ зурж байгаа юм шив дээ. Надад гарын үсэг зурж бэлтгэсэн үү? Намайг бусдаас дор гэж бодоогүй биз хэмээн Хагрид ямар нэг юм санасан мэт гэнэтхэн түүнээс асуулаа.

Харри яльгүй сандарснаа, ямар ч атугай ам нээхтэй болов.

- Би ямар ч гэрэл зурагт гарын үсэг зураагүй. Хэрэв Туг үс ярьж байгаа бол ... хэмээн дүрсхийн хэллээ.

Хагрид инээд алдав.

- Би тоглосон юм аа. Чи гарын үсгээ зураагүй. Би Туг үсэд Харри бол тэртэй тэргүй алдартай юм чинь гэж хэлсэн хэмээн аварга хүн Харрин нурууг нөхөрсгөөр алгадахад Харри бараг ширээ мөргөх шахлаа.

- Ингэж хэлэхэд дургүйцэнэ дээ гэж хэлээд Харри эрүүгээ арчив.

- Бүр хадуурч гүйцжээ! Би түүний номыг авч уншаагүй нь ямар хамаатай юм.

Харин тэр үсрэн босоод ... явчихсан шүү. Бурам идэх үү, Рон? гэж Хагрид хэлэхдээ нүд нь гялалзана.

- Үгүй ээ, баярлалаа. Аюул болж магадгүй гэж хэлээд Рон ширээний араас гарч ирлээ.

- Явж миний юу тарьсныг харцгаая гэж Харри Гермиона хоёрын цайлж дууссаны дараа Хагрид хэлэв.

Байшингийн арын жижигхэн талбайд аварга том хулуунууд шахалдан ургажээ. Хэмжээгээрээ том бул чулуу шиг юм.

- Сайхан хулуу байгаа биз? Хэллоуйны баяраар хэрэглэнэ. Тэр үед ч ... илүү том болно доо ... хэмээн Хагрид уулга алдана.

- Эднийг юугаар томруулдаг юм бэ? гэж Харри асуув.

- Чи мэднэ дээ ... өө-ө ... үүнийг томруулахад ... хэмээн Хагрид байшингийн ард өөр хүн байхгүй гэдгийг шалгаж итгээд үглэлээ.

Ханын дэргэд Хагридын ягаан шүхэр байхыг Харри харав. Энэ ч жирийн шүхэр биш гэдгийг харахад илт. Энэхүү ерийн зүйл дотор Хагридын сургуульд байхдаа хугалсан саваа байгаа гэдэгт Харри итгэлтэй байлаа. Хагрид ид шид хэрэглэх эрхгүй билээ. Түүнийг гуравдугаар дамжаанд байхад хөөсөн авч чухам яагаад гэдгийг Харри мэдэж чадаагүй юм. Энэ тухай ярих үед Хагрид дүлий мэт царайлан ханиагаад Харри ярианыхаа сэдвийг өөрчлөх хэрэгтэй болдог байлаа.

- Бөмбийлгөх шившлэг, тийм үү? Чи эднийг сайн томруулжээ хэмээн Гермiona хэлэхдээ гайхаж бахархсан шинж илэрхий байв.

- Дүү охинд чинь бас л таалагдсан. Өчигдөр харсан юм. Тэр хэлэхдээ ... хавь орчныг сонирхож байна ... бас ... энд нэг хүнтэй таарч магадгүй гэж бодсон гэнээ. Гарын үсэгтэй зурагнаас татгалзахгүй бололтой ... гэж Ронд хандан хэлснээ Харрийг харж инээмсэглэн нүд ирмэжээ.

- Болиоч дээ! гэж Харри уулга алдав. Рон огиулан талбай дээр өтөөр бөөлжлөө.

- Болгоомжтой байгаарай гэж Хагрид хэлээд үнэт хулуунуудаасаа Роныг яаран холдуулав.

Үдийн хоолны цаг дөхжээ. Харри өдрийн турш амандаа юу ч хийсэнгүй (Хагридын өгсөн бурмыг тооцохгүй бол). Тийм болохоор сургууль руугаа буцахаар яаравчлав. Андууд Хагридтай салах ёс гүйцэтгээд шилтгээн рүү явлаа. Рон хааяа огих боловч нялцгай өт нь дууссан бололтой. Замын туршид ердөө л хоёр жижигхэн өт бөөлжиж гаргажээ.

Танхимын босго дөнгөж алхтал өөрсдийнхөө нэрийг дуудахыг сонслоо.

- Поттер, Уизли нар арайхийн ирэв үү. Орой шийтгэлээ эдлээрэй гэж профессор МакГонагалл дөхөж ирээд хэлэв. Байдал төрх нь ширүүн ажээ.

- Бид юу хийх вэ, профессор оо? гэж Рон огиулахгүй санаатай асуулаа.

- Уизли та хүндэтгэлийн танхимд байгаа мөнгөн эдлэлийг Филчийн хяналтын дор цэвэрлэх болно. Ямар ч ид шид хэрэглэж болохгүй. Уизли та зөвхөн гараараа ажиллана шүү гэж профессор МакГонагалл хэлэв.

Рон санаа алдлаа. Аж ахуйн эрхлэгч Аргус Филчийг Хогвартсын бүх сурагчид үзэн яддаг билээ.

- Харин Поттер та профессор Туг үсэд туслана. Бишрэн шүтэгчид нь түүнийг захидлаар дарсан юм байна.

- Үүнээс өөрөөр шийтгээч дээ! Би хүндэтгэлийн танхимын мөнгөн эдлэлийг цэвэрлэж болохгүй юм уу? гэж асуухдаа Харри цөхөрсөн шинжтэй харагдана.

- Болохгүй ээ. Чухам чамаар туслуулаач гэж профессор Туг үс гуйсан юм. Яг наймд, хожимдож болохгүй! гэж хэлэхдээ профессор МакГонагалл гайхан хөмсөг өргөжээ.

Сэтгэл санаа дор оронд орлоо. Харри Рон хоёр унжийсаар их танхимд ороход Гермiona араас нь даган. «Сургуулийн дүрэм журмыг зөрчих хэрэггүй байсан юм» гэж түүний нүүрэн дээр бичээстэй байлаа. Бөөртэй хуушуур хүртэл өнөөндөр Харрид амтгүй санагдана. Шийтгэл хүнд туслаа гэдэгт тэр итгэлтэй байв. Харин Рон түүнийг зөвшөөрсөнгүй.

- Филч намайг шөнөжингөө байлгана даа. Ямар ч шид шид хэрэглэж болохгүй гэнээ! Тэр танхимд гурван зуугаад цом байдаг юм! Би маглууд чиг гараараа ажиллаж чадахгүй шүү дээ хэмээн Рон байж ядна.

- Би чамтай дуртайяа солих сон. Дурслийнд байхдаа би хийж сурсан юм. Туг үсийн бишрэгчдэд хариу захидал бичнэ гэдэг ... Ёстой аймаар юм! гэж Харри өрөвдөлтэй дуугаар үглэнэ. Бямба гариг хурдан өнгөрлөө. Харрийг эргэж харж амжаагүй байхад шахам цагийн зүү наймд тав дутуу байгааг заах нь тэр. Тэрбээр хөлөө арайхийн зөөсөөр хоёрдугаар давхрын хонгил дагуу Туг үсийн танхимыг чиглэн салдирхалав. Үүдний өмнө очоод хэсэг зогссоноо шийдсэн бололтой шүд зуун тогшлоо. Үүд дорхноо нээгдэв. Туслагч ирснийг хараад Туг үс баярлан инээмсэглээд:

- Аа-аа хэрэг таригч! Ор ор, Харри гэлээ. Танхимыг олон лаа гэрэлтүүлэх аж.

Туг үс өөрийнхөө зургийг ханаар дүүрэн наасан тул хана огт харагдахгүй байв. Ширээн дээр дугтуй овоолоостой харагдана.

- Чи хаяг бичээрэй! Энэ бол Глэдис Гажены захидал байна. Миний хамгийн үнэнч шүтэн бишрэгч энэ хүн энх тунх оршитугай гэж Туг үс баяртай хэлээд үүнд Харрийг ихээхэн баярлана гэж бодсон бололтой.

Цаг хугацаа яст мэлхийнээс удаан урагшлана. Харри Туг үсийн ярьсныг огт сонсолгүй, хааяа нэг «М-м-м», «Тийм!», «За» гэж хэлэх бүлгээ. Харин «Алдар нэр бол анд нөхөр биш шүү, Харри», «Алдартай хүн л алдартай үйлс бүтээн» гэх мэтийн үгс түүний ой тойнд тусаж байна. Лаанууд богниссоор гэрэл нь бадамлан Туг үсийн тоо тоомшгүй зураг дээгүүр бүжиглэнэ. Харри магадгүй мянга дахь дугтуйгаа эргүүлэн мянга нэг дэх дээр нь Вероника Сметла ч гэнэ үү нэг хаяг бичиж байлаа.

«Эцэс төгсгөл гэж алгаа! Энд суух тэнхээ хүрэхгүй нь ...» гэж Харри бодов. Энэхэн агшинд ямар нэгэн чимээ сонсогдлоо. Шатаж дуусах лааны чимээ, Туг үсийн шүтэн

бишрэгчдийнхээ тухай хүүрнэх дуунаас өөр авиа аж. Энэ бол сонсоход амьсгал давхцам судсан дахь цус царцам хүчтэй хөлдүү хортой дуу байлаа.

Наашаа ... над руу хүрээд ир ... би чамайг барьж ... урж ... хорлох ... гэсэн юм.

- Харрийг үсрэн босоход Вероника Сметлагийн оршин суудаг гудамжны хаяг ягаан толбонд дарагдлаа.

- Юу гэнээ? хэмээн тэрбээр чанга дуу алдав.

- Чи сонсож байгаа биз дээ? Бүхэл бүтэн хагас жил хамгийн гүйлгээтэй номын тоонд завсаргүй орлоо. Ийм явдал байгаагүй юм шүү гэж Туг үс хэллээ.

- Би энэ тухай яриагүй ээ. Дуу чимээ гараад байна! гэж хэлээд Харри толгойгоо сэгсэрчээ.

- Дуу хоолой гэнээ? Ямар дуу хоолой? гэж Туг үс гайхан асуув.

- Нууцлаг дуу хоолой нэг юм хэлсээн ... Та юу ч сонсоогүй юу? Туг үс Харрийг гайхан харлаа.

- Харри чи юун тухай яриад байна аа? Зүүрмэглэсэн юм уу? Хэдэн цаг болж байгааг хараа биз! Өө! Бид бараг дөрвөн цаг суучихсан юм байна! Огт мэдсэнгүй шүү. Цаг хугацаа агшин зуур өнгөрчээ.

Харри дуугүй л байв. Нууцлаг хоолойг ахин сонсох гэж мэрийсэн авч гагцхүү Туг үсийн ярих л дуулдана. Шийтгүүлэхийн оронд дөрвөн цаг Алтан хонгиот Туг үстэй хамт өнгөрүүлэх завшаан ахиж тохиохгүй л байгаасай. Харри гайхаж цөхөрсөөр байрандаа ирлээ. Орой үдшийн энэ цагаар Гриффиндорын их танхим бараг хоосон ажээ. Харри шууд л унтлагын өрөө рүү явлаа. Рон буцаж ирээгүй байв. Харри хувцасаа тайлан орондоо ороод тэсвэртэй хүлээж эхлэлээ. Хагас цагийн дараа Рон баруун гараа зүүн гараараа барьсаар орж ирэв. Мөнгө цэвэрлэгч бодисын хурц үнэр Харрийн хамрыг цоргино.

- Гар бадайрчихчээ. Квиддичийн цомыг надаар бүр арван дөрвөн удаа арчуулсан шүү! Би «Сургуульдаа онцгой гавъяа байгуулсаны төлөө» цом цэвэрлэж байхдаа ахиад өтөөр бөөлжсөн. Түүнийгээ арчих гэж бараг л зуун жил боллоо. Харин Туг үсийнд ямар байв даа? гэж Рон орон дээрээ унан асуув. Невилл Дин Симус нарыг сэрээхгүйн тулд Харри дуугаа аяарсган орон дээрээ суугаад нөгөө нууцлаг дуу хоолойн тухай ярилаа.

- Туг үс тэгээд юу ч сонсоогүй гэсэн үү? Тэр худал хэлсэн юм биш үү? Би огт ойлгохгүй байна ... Үл үзэгдэгчид үүд хаалга хүртэл нээчихдэг юм гэж Рон ярина. Сарны гэрэлд түүний анд хэрхэн царайгаа барайлгахыг Харри харжээ.

Тэгэлгүй яахав. Би ч бас огт ойлгохгүй байна гэж хэлээд Харри хөнжилдөө шургав.

БҮЛЭГ 8: ҮХЛИЙН ОЙН БАЯР

Аравдугаар сар болж орчин тойрон төдийгүй шилтгээнд ч хүйтэн, чийглэг боллоо. Бүх хүүхэд ханиалгаж, найтаалгаж байсан болохоор хатагтай Помфри огт завгүй. Түүний «Сэргээгч чинжүүт уусмал» агшин зуур үйлчилдэг авч гурван цагийн дараа уусан хүний чихнээс утаа баагидаг сөрөг нөлөөгүйсэн бол сайн л байхаар байв. Жинни Уизли нэг л унжгар, уруу царайтай явна. Перси түүнийг эмнэлэгт аваачаад энэ уусмалыг уулгах ажээ. Харин түүний гал шаргал үсийг нэвтлэн утаа баагихыг харахад хөөрхий Жинни шатаж байх шиг санагдсан аж.

Шилтгээний цонхын борооны дусал долоо хоног тасралтгүй балбалаа. Нуур үерлэн эргээсээ хальж, цэцгийн мандал шавар болсны дээр Хагридын хулуунууд тэрэг шиг том болжээ. Гэхдээ энэ бүхэн Оливер Вудын эр зоригийг шанталсангүй. Чухам ийм учраас Хэлоуйны баяр болохын урьдхан Харри цамхагтаа шал нойтон болсон иржээ. Ийм цаг агаартай үед элгэмсүү эзэн бол нохойгоо ч гэрээсээ гаргахгүй биз.

Бэлтгэл сургуульд баярлаад байх юм огт үгүй. Энэ нь гагцхүү цаг агаар муугаас ч болсон юм биш. Фред Жорж хоёр Слизеринийхний бэлтгэл хийхийг нууцаар хараад шинэ «Нисдэг лус-2001» гэгч чухам юу болохыг өөрсдийнхөө нүдээр үзжээ.

Өрсөлдөгчид нь талбай дээгүүр яг л тийрэлтэт онгоц шиг дүүлж, тэднийг ялгаж танихад ч бэрх ажээ.

Хоосон хонгилоор явж байхдаа Харри зөвхөн ганцаараа уруу царайлаад байгаа биш гэдгээ анзаарчээ. Гриффиндор шилтгээний хий үзэгдэл, бараг толгойгүй Ник цонхоор гөлийн ширтээд:

- Тэдний шаардлагад нийцэхгүй гэнэ ... хэрэв тэгвэл хэдхэн сантиметр ... гэж хамраараа гүнгэнэнэ.

- Сайн уу, Ник гэж Харри хэллээ.

- Сайн, сайн гэж Ник давхийн хэлээд цонхноос эргэв.

Тэрбээр өд хатгасан хуучин бүрх өмссөн агаад дороос нь том том мушгиа үс мөрөн дээр нь асгарна. Босоо захтай өргөн цамц өмсчээ. Энэ захны ачаар л бараг тасарсан толгой нь мэдэгддэггүй байв. Тэрбээр утаа шиг хагас тунгалаг биетэй. Цонхоор харагдах бараан тэнгэр шил даган урсах борооны усыг Харри түүний биеэр нэвт харах ажээ.

- Чи нэг л санаа зовсон байдалтай харагдаж байна гэж Ник хэлээд тунгалаг хуудас цаасыг эвхэн халаасандаа нуув.

- Чи ч бас адил гэж Харри хэллээ.

- А-а, зүгээрээ ... Би тийшээ элсэх гэж нэг их сүйд болоогүй юм л даа ... Зүгээр л өргөдөл өгье гэж бодсон юм. Гэтэл «тэдний шаардлагад нийцэхгүй гэнэ» ...

Ник хайхрамжгүй байгаа дүр үзүүлэх гэсэн авч гомдлоо нууж чадахгүй байлаа

- Мохоо сүхээр хүзүүн дундуур нь дөчин таван удаа цохь! Толгойгүй ангуучдын клубт авахад энэ бол бага гэж үү? хэмээн хэлээд халааснаасаа захидлыг гаргаж ирэв.

- Гм-м гэж Харри хамраараа гүнгэнэлээ. Түүний оролцоо хэрэгтэй гэдгийг мэдэж л байв.

- Би ингэж хэлмээр байна. Бүх юм зүй ёсоороо болоосой гэж би хамгийн их хүсэж байсан юм. Толгой маань их биеэсээ зохих ёсоороо салаасай гэж. Нэг их айхтар өвдөөгүй юм шүү дээ! Гэтэл ийм хоёрдмол байдалд орчихдог байна шүү. Гэхдээ ...

Бараг толгойгүй Ник тунгалаг хуудас цаасыг сэгсрээд дургүйцэж жингэнэсэн дуугаар:

- «Бид толгойгүй ангуучид клубт толгой нь их биеэсээ бүрэн тусгаарлагдсан хий үзэгдлийг хүлээн авах болно. Энэхүү нөхцлийг биелүүлэлгүйгээр толгойгоороо тоглон морин дээр давхих, салсан толгойгоороо поло тоглох зэрэг арга хэмжээнд орж болохгүй. Та манай тавьсан шаардлагад тохирохгүй гэдгийг гүн

харуусалтайгаар бид танд мэдэгдэх ёстой. Сайн сайхныг хүсэн ерөөсөн, ноён Патрик Делэйни-Подмор» гэж уншлаа.

Тэгээд бараг толгойгүй Ник гүнзгий санаа алдсанаа захидлаа халаасандаа шургуулав.

- Харри минь, миний толгой яльгүй жаахан арьс, хэдхэн шөрмөсөөр л тогтож байдаг юм! Бүгд л толгойг минь огтлуулсан гэж үздэг авч бүх дүрэм журмын дагуу толгойгоо тасдуулсан ноён Патрикын хувьд энэ маань хангалтгүй гэнэ. Залуу анд минь, чи юунд гомдоо вэ? би ямар нэг юмаар туслаж чадахгүй юу? гэж бараг толгойгүй Ник хэд хэдэн удаа санаа алдан тайван хэлэв.

- Үгүй ээ, баярлалаа. Хэрэв чи слизеринийхэнтэй хийх тэмцээнд зориулж «Нисдэг лус-2001» гэдэг долоон шүүр үнэ төлбөргүй олж чадахгүй л бол ...

Гэнэтхэн муур чангаар дуугаран түүний үгийг таслалаа. Харри доош харснаа асан байгаа дэнлүү шиг хоёр шар нүдтэй харц тулгарчаа. Энэ нүд бол аж ахуйн эрхлэгч Аргус Филч болон түүний сурагчидтай хийх эцэс төгсгөлгүй тулаанд үнэнчээр туслагч, туранхай саарал муур ноён Норрисийнх билээ.

- Харри эндээс хурдхан яв. Филч одоо их ууртай байгаа. Тэрбээр салхинд цохиулсны дээр гуравдугаар дамжааны нэг сурагч газар доорх тавдугаар өрөөний таазыг санамсаргүй мэлхийн тархиар будчихжээ. Филч өдрийн турш түүнийг арилгасан юм. Хэрэв тэр чиний тарьсан шавар шавхайг харах юм бол

... гэж Ник зөвлөв.

- Тийм ээ, үнэн гэж хэлээд Харри ноён Норрисын харцнаас мултрах санаатай ухарлаа. Харамсалтай нь зугтаж амжсангүй.

Филч, түүний муур хоёр тун хачирхмаар холбоотой байлаа. Ноён Норрис ямар нэг дүрсгүйтсэн учралтай таарах аваас Филч нүд ирмэхийн зуур л хүрээд ирнэ. Одоо ч гэсэн тэрбээр хивсний цаанаас ханиаж найтаалгасаар элдэв явдлыг нам дарахад

бэлэн үсрэн гарч ирлээ. Нүдэнд нь аянга цахилгаан гялалзаж улайсан хамар нь хавдаад дөрвөлжин судалтай хүзүүний ороолтоор толгойгоо ороожээ.

- Шавах шавхайг! гэж Филч шүдээ тачигнуулан хашгирлаа.

Харрийн биеийн тамирын хувцаснаас дусан тунасан ус шавхайг хуруугаараа заагаад нүд нь аяганаасаа бүлтрэх шахан:

- Шилтгээн даяар шавар шавхай, шавхай! Би чадахгүй нь ээ! Поттер миний хойноос! гэлээ.

Харри бараг толгойгүй Ник рүү баргар царайлан гар даллаад Филчийн араас доош явав. Бохир мөр хоёр дахин их болжээ.

Харри урьд нь хэзээ ч Филчийн өрөөнд орж байгаагүй бөгөөд сурагчид түүнээс дайждаг юм. Цонхгүй өрөө бүгчим харанхуй агаад намхан адраас дүүжилсэн шатдаг тосон дэнлүү түүнийг гэрэлтүүлнэ. Хоёр ханын дагуу бичиг баримт хийх шургуулга бүхий шүүгээнүүд байна. Шургуулга бүр дээр хэрэг хийсэн сурагчдын овог нэр үсгийн дарааллаар, шургуулга дотор оногдсон шийтгэлийн тухай бичгүүд байх ажээ. Фред Жорж хоёрт бүр тусгай шургуулга гаргасан байлаа. Хананд гялалзтал зүлгэсэн гав гинж өлгөөтэй байв. Шийтгүүлэх сурагчдыг хөлөөр нь таазнаас дүүжлэх тухай зарлиг хэрэгжүүлэхийг Филч Дамблдорос байнга шаарддаг нь нууц биш.

Филч савнаас үзгээ сугалж аваад цэвэр цаас эрэн шажиг шужиг хийлгэнэ.

- Шивх, лууны хоржигносон нус ... мэлхийн тархи ... хархын өлөн ... Би тэсэхээ болилоо ... Бусдад үлгэр дууриал болохоор хатуухан шийтгэх хэрэгтэй ... Маягт хаана байнаа? ... Өө ... гэж Филч ууртай үглэнэ.

Тэрбээр ширээний нүднээс хуйлаастай цаас гаргаж ирээд дэлгэн урт хар үзгээ бэхэнд дүрэв.

- Нэр: Харри Поттер. Хэрэг: - ...

- Би бага шавхайдсан! гэж Харри өөрийгөө зөвтгөхийг оролдоно.

- Чамд бол бага, надад бол бүтэн өдрийн хүнд ажил! гэж Филч хашгирлаа.

Зантайсан хамрын үзүүрт нь нэг таагүй юм бөнжигнөнө.

- Хэрэг: шилтгээн завааруулсан. Оногдох шийтгэл:- ...

Нойтон хамраа арчих зуур Филч Харрийг ууртай хялайн харна. Харри амьсгал даран, түүний ярихыг хүлээн зогслоо.

Филч цаасан дээр юм бичихийг завдтал дээр нь нэг юм түжигнэн унаж, адар доргин, дэнлүү савлан жингэнэлээ.

- Пивз! Энэ удаа би чамайг гүйцнээ! Үнэхээр гүйцнэ гэж Филч орилоод уурласандаа болоод үзгээ чулуудлаа.

Филч Харрийн тухай таг мартаад чанга алхалсаар өрөөнөөс гарч одлоо. Араас нь

Норрис муур ч давхина.

Пивз бол сургууль даяар нисдэг аянга байсан юм. Түүний амьдралын зорилго бол хүмүүст түвэг учруулж таагүй явдал гаргах аж. Харри хэдийгээр түүнд дургүй ч одоо түүнд талархаж байлаа. Яг хэрэгтэй цагийг нь олж хэрэг болдог байжээ! Энэ удаа тэрбээр яггүй том зүйл эвдсэн бололтой. Шийтгүүлэхгүй өнгөрөх найдвар Харрид төрж байлаа.

Гэхдээ Филчийг хүлээх хэрэгтэй. Харри давирхай болсон сандал дээр суулаа. Ширээн дээр Филчийн бөглөж эхлэсэн маягтаас гадна мөнгөн бичиг бүхий гялалзсан

ягаан дугтуй хэвтэнэ. Харри үүд рүү хяламхийн харснаа дугтуйг авч: «ТҮРГЭН ИД ШИД. Эхлэн суралцагчдад зориулсан ид шидийн эчнээ хичээл» гэж бичсэнийг уншлаа.

Харри сониуч зандаа хөтлөгдөн дугтуйг нээгээд мөнгөлөг үсгээр бичсэн бичигтэй хуудас цаас гаргаж ирэв. Тэнд:

Орчин үеийн ид шидтэй хөл нийлүүлэн алхах хэцүү байна уу? Хамгийн энгийн шившлэг мэдэхгүйдээ ичиж сандрав уу? Шидэт саваа зөв барьж чадахгүй элэг доог болж байна уу?

Энэ бүхний шийдэж болноо!

Түргэн ид шид бол цоо шинэ маш энгийн, үр дүнгээ агшин зуур өгдөг шид шидийн зуун хувь найдвартай хичээл юм. Түргэн ид шидийн аргыг эзэмшсэн олон зуун ид шидтэнгүүд амьдралаа сайжруулжээ!

Хатагтай З. Крапивинс Топшэмээс бичихдээ:

«Би шившлэгүүдийг огт цээжилж чадахгүй, миний бэлдсэн уусмалыг манайхан шоолж инээлддэг байлаа! Одоо түргэн ид шидийн хичээл үзсэний дараа намайг орой үдшээр урин залдаг болсон юм. Андууд маань миний уусмыл жорыг гуйдаг боллоо» гэжээ.

Харин Дидсберийн иргэн, ид шидтэн Д. Ж. Шилоу:

«Намайг шившлэг муу мэддэг гэж эхнэр маань шоолдог байв. Гэхдээ түргэн ид шидийн аргаар ердөө л нэг сар хичээллэсний дараа би түүнийг сарлаг болгон хувиргаж дөнгөлөө! Түргэн ид шидэд их баярлалаа!» гэж ярьж байв гэсэн бичиг байлаа.

Сониуч Харри дугтуй дотор байсан өөр цаасуудыг ч үзэв. Филчид яагаад түргэн ид шид хэрэгтэй болов оо? Энэ чинь Филч ямар ч ид шидтэн бус гэсэн үг үү? «Шидэт савааг хэрхэн барих тухай (ашигтай хэдэн зөвлөгөө)» гэсэн эхний хичээлийг уншиж байтал хаалганы цаана хөлийн чимээ гарлаа. Харри цаасыг дугтуйд яаран хийгээд ширээн дээр дөнгөж тавьтал үүд нээгдэж Филч ялсан баатрын дүртэй орж ирэв.

- Энэ хуучны тавилгын загвар болсон алга болдог шүүгээ тун ч үнэтэй эд байлаа! Энэ удаа Пивзэд үзүүлээд өгнөө гайгүй гэж тэрбээр алгаа баяртайяа үрчин муурандаа хэлэх ажээ.

Тэгснээ Харрийг хараад ширээн дээрх дугтуй руугаа ухасхийлээ. Дугтуй урд байсан газраасаа бараг хагас метрийн зайд хэвтэхийг Харри гэнэтхэн ажиглажээ.

Филчийн цонхигор царай ув улаан боллоо. Одоо ширүүн давалгаанаас илүү зүйл дайрна даа хэмээн бодсон Харри бүр агийн суужээ. Сургуулийн аж ахуйн эрхлэгч ширээ рүү дүүлэн хүрээд дугтуйг шүүрэн авч хайрцагт хийлээ.

- Чи ... чи ... уншсан уу? гэж Филч хүчлэн асуув.

- Үгүй гэж Харри огт түгдрэлгүй заллаа. Филч овгор товгор үетэй гараа базлана.

- Мэдээж, чи миний хувийн захидлыг уншихгүй л байж таарна ... Миний захиа ч биш ... андын миаань захиа ... Гэхдээ юу ч байлаа гэсэн ...

Харри Филчийг түгшин харна. Түүний иймэрхүү байхыг хэзээ ч харсангүй. Нүд нь орой дээрээ гарч баруун хацар нь татганан, толгойгоо ороосон ороолт нь аж ахуйн эрхлэгчийг хянах чадвараа алдсаныг илтгэнэ.

- За яахав ... яв даа ... Хэнд ч бүү яриарай. Тэгэхгүй бол ... Чи амжаагүй байж ч болох юм ... Явж үз, би Пивзийн талаар илтгэх хуудас бичих учиртай ... За яв

...

Харри ийм юм болсонд итгэлгүй танхимаас сум шиг үсрэн гарч доош харайлгав. Филчийн өрөөнөөс шийтгэл хүлээхгүй гарах хүн гэж байдаггүй юм. Үүнийг сургуулийн дээд амжилт гэж болно!

- Харри! Харри! Болсон уу? гэж Харрийн өнгөрөх гэж буй хаалганы дэргэд бараг толгойгүй Ник нисэн ирээд асуув.

Харри зогсоод танхимыг хартал тун ч өндрөөс унасан бололтой том алтлаг хар шүүгээний эвдэрхий харагдах нь өрөвдөлтэй.

- Би түүнийг Филчийн танхим дээрээс чулууд гэж Пивзийг ятгасан юм.

Ингэвэл анхаарлыг нь сарниулна гэж бодлоо ... хэмээн Ник баяртай өгүүлнэ.

- Чи ингэсэн юм уу? Болсон шүү! Надад сануулах шийтгэл ч оногдуулаагүй.

Баярлалаа, Ник минь! гэж Харри талархан хэллээ.

Тэр хоёр хонгилоор хамт явав. Ник нөгөө золгүй захидлыг цаг ямагт гартаа үнгэж байхыг Харри ажиглажээ.

- Толгойгүй ангуучдын клубд ороход чинь би ямар нэг тусламж үзүүлж чадах болов уу? гэж Харри ачийг ачаар хариулах санаатай асуув.

Тойрог дээр бараг толгойгүй Ник зогсоход Харри цааш явлаа. Ай яа! Энд ирэхэд хүйтэн усанд орсон мэт таагүй санагдана.

- Чи миний төлөө юухан хээхэн хийж чадна шүү! Харри ... Би дэндүү их юм гуйж байж ч магадгүй ... Чи татгалзах байлгүй дээ ... гэж Ник догдлонгүй хэллээ.

- Шууд л хэл! гэж Харри шаардав.

- Энэ Хэллоуйны өдрөөр би үхсэнийхээ таван зуун жилийн ойг тэмдэглэх юм гэж бараг толгойгүй Ник хэллээ.

- Өө-ө ... Яг үнэхээр үү? гэж үүнд баярлах гомдохын алийг нь мэдэхгүй Харри итгэл муутай асуув.

- Би газар доорх том хонгилуудын нэгэнд хүлээн авалт хийнэ. Британий энд тэндээс найз нөхөд маань ирцгээх юм. Хэрэв чи баярт хүрэлцэн ирэх аваас надад их хэрэг болно доо. Хүлээн авалт дээр ноён Уизли, Грэйнджер авхай гээд анд нар чинь байвал би тун ч их баярлана дээ. Гэхдээ та нар Хэллоуины үеэр сургуулийнхаа цайллагыг илүүд үзэх байлгүй, тийм үү? гэж Ник хэлэв.

Ник Харрийг асуусан маягтай харна.

- Үгүй ээ, яалаа гэж. Би заавал ирнэ гэж Харри бодож төдсөнгүй шийдвэр гаргалаа.

- Өө, тун сайн жаал! Харри Поттер миний үхлийн ойн баярт ирнэ. Харин чи миний ямархуу аймшигтай төрхтэй байдгийг ноён Патрикт санамсаргүй юм шиг хэлчихэж чадах уу? Ник баярлан хэлэв.

- Тэ ... тэгэлгүй яахав гэж Харри түгдрэн өгүүллээ. Бараг толгойгүй Ник хөөр баяраар гэрэлтэнэ.

Харри цэвэр хуурай хувцас сольж өмсөөд их танхимд байгаа андуудтайгаа нийлэв.

- Үхлийн ойн баярын хүлээн авалт гэнээ? ийм хүлээн авалтанд оролцсон гэх амьд хүн цөөн гэж юугаар ч хамаагүй мөрийцмөөр байна. Тун гайхамшигтай юм болох байх аа! гэж Гермiona сониучирхана.

- Өөрийнхөө үхлийн ойн баярыг тэмдэглэнэ гэж хэний санаад орох билээ!

Минийхээр бол аймаар гунигтай болох байх аа ... гэж Рон эсэргүүцэн толгой сэгсрэнэ. Тэрбээр уусмал бэлтгэх хичээлийн гэрийн даалгавар хийж байсан бөгөөд ийм үедээ зан муутай байдаг юм.

Цонхны бараан шилийг бороо балбаж байсан ч өрөөнд нь гэрэлтэй, тавлаг байлаа. Ханан зууханд гал дүрэлзэнэ. Зөөлөн сандалд суусан сурагчид ном уншиж юм ярьж хичээлээ хийцгээнэ. Фред Жорж хоёр хэрэв тожмой лууд доктор Фойерверкусын бенгалын галыг өгвөл юу болох тухай туршилт хийж байлаа. Шидэт амьтдыг арчилдаг өрөөнөөс Фред нэгэн улбар гүрвэлийг «гяндангаас чөлөөлсөн» нь одоо баахан хүүхдүүдийг тойруулан ширээн дээр утаа баагиулан хэвтэж байна.

Харри маань Рон Гермiona хоёр Филч болон түүний «Түргэн ид шид»-ийн гарын авлагын талаар ярих гэсэн авч тожмой луу гэнэтхэн дээш хөөрөөд чанга дуугаран, оч цацруулан өрөөн дотуур галзуурсан юм шиг нисэж гарлаа. Амнаас нь улаан одод асгарах агаад яльгүй архиран, галд дөл болсон тожмой луу алга боллоо. Перси ихэр хоёрыг хооллогоо сөөтөл хашгиран загнаж байхад Харри Филч түүний ягаан дугтуйд байсан зүйлийн тухай мартсан байлаа.

Хэллоуйны баяр дөхөх үеэр Харри хүү бараг толгойгүй Никийн хүлээн авалтад очно хэмээн яаран ам өгсөндөө харамсаж эхлэв. Хэллоуйны баярын үеэр болох цайллагад сургууль даяараа бэлтгэж байлаа. Уламжлал ёсоор их танхимыг амьд сарьсан багваахай, Хагридын аварга хулуугаар хийсэнд дэнлүүгээр чимжээ. Хулуу болгонд гурван хүн багтаах ажээ! Дамблдор баахан бүжиглэгч араг яс баярт урьсан гэж дуулдана.

- Ам алдвал брж болдоггүй. Чи Никийн баярт очно гэж амласан гэж Гермiona эрс тэс хэлжээ.

Орой яг долоон цагт Харри, Рон, Гермiona гурав лаа асаж, ширээн дээр алтан сав суулга гялалзсан их танхимын дэргэдүүр өнгөрлөө. Андууд хам хум хооллоод доод хонгил руу буудаг шат руу очив.

Тэгээд Ник хүлээн авалтаа зохион байгуулах гэж байгаа газар доорх том танхим руу явдаг хонгилд орлоо. Хонгилд лаа асаасан нь байдлыг улам баргар болгожээ. Урт нарийхан хар лаанууд тод цэнхэр дөл бадруулан асах агаад тэрхүү гэрэлд гурван анд маань хий үзэгдэл шиг харагдана. Алхах тутам хонгилд улам хүйтэрсээр. Харри атийн жанчаараа сайтар ороолоо. Гэнэтхэн мянган хумсаар аварга том самбар нэгэн зэрэг маажих мэт чих дүлийрэм чимээ сонсогджээ.

- Энэ ямар хөгжим бэ? гэж Рон айж шивнэлээ.

Андууд булан тойроод хар хилэнгээр биеэ ороосон бараг толгойгүй Никийг олж харав. Тэрбээр ирсэн зочидтой мэндлэн танхимын үүд хавиар хөвөн хөөрөх аж.

- Эрхэм андууд минь, тавтай морилоорой. Тавтай морилоорой! Та нар ирж надад хүндэтгэл үзүүлсэнд баярлалаа хэмээн Ник гашуудлын өнгөөр хэллээ.

Тэрбээр өдөөр гоёсон бүрхээ аваад доош мэхийн ёслож тэднийг дотогш урив.

Тэдний нүдэнд ер бусын зүйл харагджээ. Газар доорх танхимд олон зуун хий үзэгдэл дүүрэн байв. Бүжгийн талбайд гучин хөрөөн хөгжмийн сэтгэл сэрдхийлгэсэн аялгуунд хос сувдан цагаан хий үзэгдэл эргэлдэн бүжиглэх ажээ. Тавцан дээр хар хилэн хувцастай хөгжимчид хөгжимдөн байна. Адраас асар том лааны суурь дүүжлэн, олон мянган лааны гэрэл танхимыг шөнийн цэнхэр туяагаар сүлэх аж. Танхимд яг л хөргүүрт байгаа мэт хүйтэн болохоор анд нарын амнаас уур савсана.

- Танхим дундуур явах уу? гэж Харри яльгүй дулаацаж магадгүй гэсэндээ хэллээ.

- Болгоомжтой байгаарай. Аль нэг зочныг нэвтрэн гарчих вий гэж Рон сэтгэл хямран хэлээд гурвуулаа тал тал тийшээ харсаар бүжгийн талбайн хажуугаар урагш явцгаав. Тэд баахан гэлэн гинжтэй хүн, Пуффендуйн хөгжилтэй хий үзэгдэл болох бүдүүн Номлогч, духандаа сум зоолгосон баатрын дэргэдүүр явж өнгөрлөө. Слизериний газар дорх хий үзэгдэл Цуст бароноос бүх хий үзэгдэл зэнзийрхэж

байгааг Харри хараад огт гайхсангүй. Энэ бол туранхай бүлтгэр нүдтэй цусны мөнгөлөг толбо бүхий жанч нөмөрсөн өвгөн байлаа.

- Хүүхдүүд ээ, хурдхан буцаад явцгаая! Би уйланхай Миртлтэй ярилцмааргүй байна ... гэж Гермiona байрандаа зогсоод шивнэн хэлэв.

- Хэнтэй гэнээ? хэмээн Харри буцаж явах зуураа асуулаа.

- Энэ бол хоёрдугаар давхрын охидын бие засах газрын хий үзэгдэл гэж Гермiona хэлжээ.

- Бие засах газрын хий үзэгдэл гэнээ? хэмээн Харри лавлав.

- Тийм ээ, бие засах газар ажиллаагүй жил болж байна. Учир нь Миртл байнга уйлсаар байгаад байрыг усаар дүүргэчихсэн. Би тун их сандарсан үедээ л хааяа ордог юм. Хэрэг болоод тийшээ орвол Миртл хараад л уйлж эхлэнэ ... гэж Гермiona хэлэв.

- Цайллагын ширээг хараач! гэж Рон таслан дуу алдлаа.

Эсрэг талын хананы дэргэд үнэхээр хар хилэнгээр бүтээсэн нэгэн урт ширээ харагдана. Өлсөж амжсан мань гурав шүлсээ залгисаар алхаагаа хурдасгав. Дотор муухай оргимоор үнэр үнэртэж, харин идэх уух юмны бараа хармагцаа тэд хөшсөн мэт зогсчээ. Сайхан мөнгөн тавагтай муудсан том загаснууд, зөөх тавиуртай хар болтлоо түлэгдсэн жигнэмэг, өт арзганасан том тавагтай хонины дотор гэдэс, ногоон хөгц болсон зүсэм бяслалг харагдах ажээ. Ширээний голд шарилын чулуу шиг хэлбэртэй баярын бялуу байх агаад дээр нь хар чихрээр: «Ноён Николас де Мимси-Дельфингтон. 1492 оны аравдугаар сарын 31-нд нас барсан» гэж бичжээ.

Харри нэгэн том биетэй хий үзэгдлийг гайхан харна. Тэрбээр ширээ рүү дөхөж очоод ангайсан амандаа муудсан загас яг таарахаар бөхийн урагш явж өнгөрлөө.

- Хоол хүнсийг нэвтрэн гарахдаа амтыг нь мэддэг үү? гэж Харри түүнээс асуув.

- Бараг мэднэ гэж хий үзэгдэл гунигтайхан хэлээд салгалан одлоо.

- Амт үнэрийг нь улам хүчтэй болгохын тулд хоол хүнсээ зориуд муутгадаг юм байна гэж Гермiona итгэл төгс хэлээд хамраа чимхэн хонины муудсан гэдэс дотрыг сайтар харахаар тонгойв.

- Эндээс явцгаая. Дотор муухай оргиод байна гэж цонхийж цайсан Рон хэллээ.

Тэднийг ширээнээс холдож амжаагүй байтал дороос нь жижигхэн хүн гэнэтхэн нисэн гарч ирээд тэдний өмнө агаарт тогтов.

- Пивз сайн уу гэж Харри болгоомжтой хэллээ.

Тэрбээр цайруу биш, тунгалаг бишээрээ бусад хий үзэгдлээс ялгагдана. Тод улбар цаасан малгай өмсөж эрвээхэй зангиа зүүжээ. Муухай царайд нь инээмсэглэл тодроно.

- Самар идэх үү? гэж асуугаад муудсан самар бүхий таваг сарвайлаа.
- Үгүй ээ, баярлалаа гэж Гермиона толгой сэгсрэн өгүүлэв.
- Хөөрхий Миртлийн тухай чиний ярихыг сонссоон. Чи хөөрхий Миртлийн тухай тун бүдүүлэг ярилаа. Хүүе, Миртл ээ! гэж түүнийг хэлэхэд нүдэнд нь таагүй оч гялалзаж байлаа.
- Хэрэггүй ээ, Пивз минь. Түүний тухай ярьсан гэж түүнд битгий хэлээрэй. Би уул нь тэгж хэлэх гээгүй, тэс өөр юм ... гэж Гермиона цөхрөнгүй шивнэснээ:
- Хөөе, Миртл минь сайн уу! хэмээн дуу алдлаа.

Тэдний зүг бүдүүн намхан хий үзэгдэл хөвөн ирэв. Охины нүүрний хагасыг сэгсийсэн урт үс солонгын өнгө цацруулах том шил халхалжээ.

Ийм зүдэг төрхийг Харри амьдралдаа хэзээ ч хараагүй билээ.

- За юу гээв? хэмээн хий үзэгдэл асуув.
- Ажил ямар байна даа, Миртл ээ? Чамайг бие засах газарт бус өөр газарт харсандаа баяртай байна гэж Гермиона зориуд хөгжилтэй дүр эсгэн хэллээ.

Миртл найтаалгав.

- Грэйнджер авхай дөнгөж сая чиний тухай ярьж байлаа гэж Пивз Миртлийн чихэнд хоржоонтой байдлаар шивнэнэ.
- Би ... би ... өнөөдөр чамайг сайхан харагдаж байна гэсэн юм хэмээн Грэйнджер итгэл муутайхан хэллээ.

Гермиона Пивзийг ууртай харна. Харин Миртл Гермионаг итгэлгүй харцаар ширтэх ажээ.

- Чи намайг шоолжээ гэж тэрбээр хэлээд жижигхэн тунгалаг нүдэндээ мөнгөлөг нулимс мэлтрүүлэв.
- Үгүй дээ, үнэн шүү! Миртл өнөөдөр сайхан харагдаж байна гэж би та нарт хэлээ биз дээ? хэмээн Гермиона хэлээд эхлээд Роныг дараа нь Харрийг тохойгоороо өвдтөл нударлаа.
- Т-ийм ээ ... хэмээн Харри өвдсөндөө ярвайн хэлэв.
- Яг тэгж хэлсэн гэж Рон давтана.

- Намайг бүү хуур! Миний араар юу гэж ярьдгийг намайг мэдэхгүй гэж бодоо юу? Тарган Миртл гэдэг шүү дээ! Муухай Миртл! Уйланхай Миртл! хэмээн уйлагнан ярьж байхад ард нь Пивз зогсоод шогширч байв.

- Чи «батгатай Миртл» гэж хэлэхээ мартсан байна хэмээн Пивз түүний чихэнд шивнэлээ.

Уйланхай Миртл бүр цурхиран уйлсаар хонгилоос нисэн гарчээ. Түүний араас нөгөө гомдоосон этгээд маань хий үзэгдлийг муудсан самраар шидэн:

- Батгат! Батгат! гэж чанга хашгирсаар дүүлэв.

- Хөөрхий амьтан! гэж Гермiona гунигтайяа санаа алджээ.

Тэр хүмүүсийн дундуур зүтгэсээр ирж яваа бараг толгойгүй Никийг олж харлаа.

- За, та нарт таалагдаж байна уу? гэж Ник сониучирхав.

- Маш сайхан байна гэж мань гурав зэрэг хэлжээ.

- Бараг бүх уригдагсад ирсээн. Уйлдаг бэлэвсэн авгай Кентээс ирсэн юм ... одоо миний үг хэлэх цаг боллоо. Очиж хөгжимчдөд хэлье гэж Ник бардам байдалтай ярина.

Гэвч Никийг байрнаасаа хөдөлж амжаагүй байтал найрал хөгжим гэнэтхэн чимээгүй боллоо. Хөгжимчид, зочид бүгд л дуугүй болцгоов. Ангуучны эвэр бүрээний дуу дуулдана.

- Тэд нар байна гэж бараг толгойгүй Ник гунигтай хэллээ.

Тунгалаг арван морь унасан толгойгүй хүмүүс хана нэвтрэн орж ирэв. Цугларагсад алгаа чангаар ташицгаана. Харри бас алгаа ташсан авч Никийн гунигтай царайг хараад больжээ.

Морьд бүжгийн талбайн голд давхиж очоод дээш цоройн туурайгаараа шал цавчлана. Тэрхүү үйл явдлыг хацраа түмбийлгэн эвэр бүрээ үлээх толгойгоо сугавчилсан өндөр хий үзэгдэл толгойлох ажээ. Тэрбээр мориноосоо үсрэн буугаад цугласан хүмүүсийг сайтар харахын тулд сахал үстэй толгойгоо дээш агаарт чулуулав. Зочид зэрэг инээд алдацгаалаа. Толгойгүй хий үзэгдэл нөгөө толгойгоо байгалиас заяасан газарт нь тавиад бараг толгойгүй Ник рүү хурдан алхалсаар ирэв.

- Ник! Ажил ямар байна? Толгой чинь торгоогдсон хэвээр үү? хэмээн үргэлжлүүлэн асуулаа.

Тэрбээр чанга инээд алдан бараг толгойгүй Никийн мөрийг алгадна.

- Патрик минь, тавтай морилоорой хэмээн Ник биеэ барин хэлжээ.

- Өө, амьд хүмүүс! гэж Патрик нөгөө гурвыг хараад уулга алдлаа. Тэрбээр гайхаж цочсондоо дээшээ үсэртэй толгой нь ахиад л мөрөн дээрээс нь өнхрөн унажээ. Танхим даяар инээд цуурайтна.

- Маш хөгжилтэй байна гэж бараг толгойгүй Ник баргар царайлан хэлжээ.

- Больж үз, Ник ээ! Түүнийг клубт аваагүй гэж Ник гонсойсон хэвээр байгаа!

Би хэлж чадах байна. Түүнийг хар л даа гэж шалан дээр хэвтэх Патрикийн толгой хашгирах ажээ!

- Түүнийг хар л даа. Никийн төрх байдал ууртай, аймшигтай байна гэж ...

Харри хэллээ. Ник түүний зүг учир битүүлэг харсан юм.

- Ха! Ник та нарт ингэж хэлсэн гэж мөрийцөхөд бэлэн байна хэмээн шалан дээр хэвтэх толгой уулга алдлаа.

- Анхаарлаа хандуулахыг хүсье! Би үг хэлмээр байна гэж хэлээд бараг толгойгүй Ник тайз руу дөхөж очоод үсрэн гарч хөх цэнхэр гэрлийн дунд орчихлоо.

- Нас барсан намайг болон аав ээж анд нарыгаа дурсан уйлсан эрхэм ноёд, хатагтай нар аа. Би та нарт дараах зүйлийг гүн харуусалтайгаар мэдэгдэх гэсэн юм ... хэмээн үгээ эхлэлээ.

Гэвч түүнийг хэн ч сонссонгүй. Ноён Патрик ангуучдын клубын гишүүдтэй толгойгоороо хоккей тоглож тоглоом харж улайрсан зочид Никийн тухай мартжээ. Бараг толгойгүй Ник тэдний анхаарлыг татах гэж байдгаараа хичээсэн авч чангаар алга таших чимээн дор ноён Патрикийн толгой дэргэдүүр нь өнгөрөхдөө нүд ирмэхэд нь бууж өгчээ.

Харри гэнэтхэн их даарч байгаагаа мэдлээ. Хоосон ходоод нь ч түүнд сануулга өгчээ.

- Та нар яавал яа, би лав энд байж чадахгүй нь гэж Рон даарсандаа шүдээ тачигнуулан хэлэв.

Найрал хөгжим дахин эгшиглэж хий үзэгдлүүд бүжгийн талбай руу хошуурцгаалаа.

- Эндээс явъя гэж Харри зөвшөөрчээ.

Тэд баруун зүүн тийш инээмсэглэн мэхэлзсээр үүд рүү ухарлаа. Хормын дараа андууд хар лаагаар гэрэлтүүлсэн шатаар өгсөж явав.

- Амттан өгөх үед амжиж очиж магадгүй гэж Рон найдсан байдалтай үглэнэ. Харри бас л иймэрхүү юм хэлэх гэсэн авч дуу гарч өгсөнгүй.

- ... ур ... тасд ... хөнөө ... гэж хэлэхийг тэрбээр тодхон сонсчээ.

Энэ бол Алтан хонгиот Туг үсийн өрөөнд байхад түүнд анх сонсогдсон нөгөө хүйтэн аймшигтай нууцлаг дуу байлаа.

Харри бүдрээд уначихгүйн тулд хүйтэн хана түшлээ. Тэрбээр эргэн тойрноо болон бүдэг гэрэлтэй хонгилыг сайтар ажиглан чих тавин чагнав.

- Харри, чи юу болов оо? гэж Роныг хэлтэл Харри таслаад:
- Ахиад л нөгөө дуу! Түр чимээгүй байгаач ... гэлээ.
- ... их өлслөө ... их удлаа ...
- Сонсов уу? гэж Харри асуув.

Рон, Гермиона хоёр түүнээс нүд салгалгүй зогсоно.

- ... хөнөө ... хөнөөх цаг боллоо ...

Дуу хоолой аяархан болжээ. Тэр дуу хоолой холдон, дээш одож байна гэдэгт Харри итгэлтэй байлаа. Харри айсандаа харцаа дээшлүүлэн харанхуй адар ширтэв. Энэ дуу хоолой яаж дээшээ хөдлөж байгаа юм бол? Хэрэв ямар ч саад хаалтыг нэвтэлж чаддаг хий үзэгдэл байвал яанаа?

- Хурдлаарай! гэж Харри хашгираад танхим руу очдог шатаар гүйв.

Гэхдээ энд юу ч сонсогдох аргагүй аж. Их танхимаас Хэллоуйны баярыг тэмдэглэх хөгжилтэй дуу хадна. Харри гантиг шат руу очоод хоёрдугаар давхар өөд харайхад Рон Гермиона хоёр хоцорсонгүй.

- Харри, чи яагаад ... гэж гүйсэндээ амьсгаадсан Рон ярихыг оролдоно.
- Ш-ш-ш! гээд Харри чих тавин чагнав. Дээрээс гуравдугаар давхраас бололтой аяархан дуу гарч:
- Надад цус үнэртэж байна! ... Надад цус үнэртэж байна ... гэх ажээ. Харрийн зүрх зогсох шахлаа.
- Тэр хэн нэгнийг алах гэж байна! гэж Харри хашгираад Рон Гермиона нарын гайхсан царайг огт тоолгүй дээш өгсөн дэгдэв. Тэрбээр шатны гишгүүрийг гурав гурваар алгасан харайлгах зуураа хөлийнхөө чимээний хажуугаар өөр юм олоод сонсох санаатай чагнаархана.
- Харри юм болсон бэ? Би юу ч сонсохгүй байна ... хэмээн Рон амьсгаадан хэлэв.

Харри гуравдугаар давхарт гараад хонгилоор гүйхдээ баруун, зүүн тийш ээлжлэн харсаар. Рон, Гермиона хоёр амьсаадсан ч түүнээс хоцорсонгүй.

Урд нь нэг юм гэрэлтэн байхыг хараад Гермиона уулга алдлаа. Тэд ийш тийшээ харсаар тэр зүг рүү дөхөв. Хоёр цонхны хооронд бамбарын гэрэлд гялалзан харагдах том үсэг харагдлаа. Тэнд:

«НУУЦ ӨРӨӨ ДАХИН НЭЭГДЛЭЭ. УДАМ ЗАЛГАМЖЛАГЧДЫН ДАЙСНУУД ЧИЧИРЦГЭЭ!» гэж бичсэн байв.

- Энэ чинь ... энэ чинь юун бичиг өлгөөстэй байна? гэж Рон чичирхийлсэн хоолойгоор асуулаа.

Тэд болгоомжтой дөхлөө. Шалан дээр ус тунасан байснаас Харри халтирчээ. Рон Гермiona хоёр түүнийг түшсэн тулдаа л унасангүй. Тэр аймшигтай үгсийн дор холоос харахад бараан сүүдэр шиг юм харагдсан нь сургуулийн аж ахуйн эрхлэгчийн муур ноён Норрис байсныг тэд шууд л танилаа. Тэд хаанаас ч юм гарч ирсэн усыг үсчүүлсээр арагш ухарцгаав.

Тэрхүү муурыг бамбар тогтоох зориулалттай дэгээнээс сүүлээр нь дүүжилчихсэн байжээ. Хөшсөн муурын нүд бүлтийсэн байлаа.

Тэд муурыг хэдэн агшин хөдлөлгүй, юм ч ярилгүй харан зогсов. Эхлээд Рон үг хэлэхтэй болж:

- Эндээс хурдан явъя гэлээ.

- Гэхдээ ямар нэг юм хийх хэрэгтэй ... Үүнд туслах сан ... гэж Харри хулчгардуухан өгүүлэв.

- Бид эндээс хурдхан явбал дээр. Хэн нэг нь биднийг харчихвал!

Гэвч оройтжээ. Хонгилд хүүхдүүдийн шуугилдах чимээ дуулдана. Цайллага дууссан хэрэг. Хонгилын нөгөө үзүүрээс олон арван хөлийн чимээ ойртох дуулдана. Дураараа юм амтархан идэх охид хөвгүүдийн хөгжилтэй яриа сонсогдоно. Ахиад түр хугацаа өнгөрөхөд баярлаж хөөрсөн хүүхдүүд тэднийг тойрон зогсож байв.

Эхлэн дөхөж ирсэн хүүхдүүд дүүжлээстэй муурыг хармагц хонгилд нам гүм боллоо. Тойрсон хүүхдүүдийн голд Харри, Рон, Гермiona гурав зогсоод хэдийгээр арын сониуч хүүхдүүд юу болсныг мэдэх гэж шахцалдан байсан авч хэн ч түүний зүг ойртож зүрхэлсэнгүй.

- Удам залгамжлагчдын дайснууд чичирцгээ! Эхлээд муур, дараа нь бохир цус судсаар нь гүйх бүх хүн! гэж хэн нэгэн чангаар хашгирчээ.

Энэ бол Драко Малфой байлаа. Тэрбээр хүүхдүүд дундуур шахалдан гарч ирэхэд ямагт хүйтэн байдаг нүд нь гэрэлтэж, цонхигор царай нь ягааран туяарчээ. Хөдөлгөөнгүй байгаа муурыг хараад тэрбээр мушийн инээмсэглэв.

БҮЛЭГ 9: ХАНАН ДЭЭРХ БИЧИГ

- Юу болоод байнаа? Аа? гэсээр Малфойн хэлснийг дуулсан Аргус Филч хүүхдүүдийг түлхсээр хүрч ирснээ ноён Норрис муурыг хараад айсандаа толгойгоо тэврэн ухраад:
- Муурыг маань яачих нь энэ вэ? Юу болов оо? гэж нүд бүлтийлгэн орилов. Тэгээд Харрийг харснаа:
- Чи хүрээд иржээ! Чи л миний муурыг алсан! Би бас чамайг ... чамайг даа ... гэлээ.
- Аргус минь, тайвширч үз.

Дамблдор захирал хэд хэдэн профессор дагуулсаар хүрч ирлээ. Тэрбээр гурван андын дэргэдүүр албархуу алхаж өнгөрөөд ноён Норрис муурыг бамбар тогтоох дэгээнээс болгоомжтойхон мулталж авав.

- Аргус та надтай хамт яв. Ноён Поттер, Уизли, Грэйнджер нар ч бас адил. Туг үс инээмсэглэсээр Дамблдор руу дөхөж очлоо.

- Ноён захирал аа, миний танхим хамгийн ойрхон шүү дээ. Ердөө л шатны дээд талд. Манай өрөө рүү очицгооё.

- Алтан хонгиот танд баярлалаа гэж захирал хэлэв.

Тэд чимээгүй хөдөлцгөөлөө. Бардам сэтгэл хангалуун Туг үс Дамблдорын араас түүний хойноос профессор МакГонагалл, Снегг нар явцгаана.

Тэднийг танхимд дөнгөж ормогц хананд байсан туг үсийн бүх зурагнууд тал тал тийшээ алга болжээ. Зарим зураг нь үсээ буржийлгахаар ороосон ороолттойгоо байв. Амьд туг үс маань ширээн дээрх лаа асаагаад Дамблдорт суудлаа тавьж өгөн холдлоо. Дамблдор муурыг ширээн дээр тавиад анхааралтай харна. Харри, Рон, Гермiona гурав бие бие харснаа лаанаас хол байгаа сандал дээр сууцгаав.

Дамблдор нүдний шил тохсон монхор хамраа муурны арьсанд хүргэх шахан тэмтрэн үзэж байлаа. Профессор МакГонагалл бас л мууран дээрээс Дамблдор багш шиг өнгийн ширтсээр тонгойно. Снегг багш сүүдэрт зогсох агаад уруулаа яльгүй мушийлган инээмсэглэнэ. Туг үс элдэв таавар хэлсээр танхим дотуур холхих аж. Тэрбээр:

- Муурыг хараалаар алсан нь тодорхой байна. Хувиргалын тамлал юм болов уу даа. Иймэрхүү юм болохыг би олон удаа харсан юм. Тэр үед дэргэд нь байгаагүй маань харамсалтай. Уул нь би хариу шившлэг мэддэг юм. Муурыг аврах л байж ... гэж ярина.

Филч ширээний дэргэдэх сандалд суугаад гараараа нүүрээ даран Туг үсийн хэлсэн үг бүрийн дараа мэлмэрүүлнэ. Тэрбээр Норрис муураа харж зүрхлэхгүй ажээ. Харри

хэдийгээр Филчийг үзэн яддаг боловч Филчийг хэрэндээ л өрөвдөж байв. Хэрэв Дамблдор Филчийн үгэнд итгэх аваас эд хогшлоо цуглуулаад сургууль баяртай гэхээс өөр арга байхгүй.

Дамблдор ноён Норрис муурыг шидэт саваагаараа тоншин юм хум шивнэх авч муур яг л чихмэл мэт амьдын тэмдэг алга хэвээр.

- Угадугуд хэд хэдэн удаа ийм явдал болсон юм. Эдгээр тохиолдлыг би өөрийнхөө намтарт бичсэн билээ. Тэр үед хэд хэдэн онгон тарааж аюул ослыг зайлуулсан санагдана ... гэж явах зуураа Туг үс ярина.

Туг үсийн зургууд ханандаа буцаж ирээд толгой дохих агаад нэг нь үснийхээ торыг авахаа мартсан байлаа.

Эцэст нь Дамблдор эгц зогсоод бодлогошронгуй янзаар:

- Аргус минь, дөнгөж л амьд байна даа гэв.

Туг үс гомдон дуугүй боллоо. Тэр олон аллагыг зайлуулсан гэж одоо хэн итгэх билээ.

- Амьд гэнээ? Гэхдээ ... гэхдээ бүр хөшчихсөн байна гэж Филч дуулдахтай үгүйтэй хэлээд ноён Норрис муурыг хуруугаараа заана.

- Татчихсан байна. Яагаад гэдгийг би одоохондоо мэдэхгүй байна ... гэж Дамблдор залруулан хэллээ.

- (Энэ бол цэлмэг өдөр шиг тодорхой! гэж Туг үс оролцлоо).

- Мэддэг хүн нь тэр байна! гэж Филч хэлээд нулимстай нүднээсээ гараа салган

Харрийг харав.

- Хоёрдугаар дамжааны сурагч үүнийг хийж барахгүй ээ. Энэ бол нилээн сайн хар ид шидийн хүч ... гэж Дамблдор татгалзлаа.

- Энэ хүү мөн. Яг мөн. Түүний ханан дээр юу бичсэнийг та нар харсан даа.

Тэрбээр миний өрөөнөөс ... намайг ... тэр намайг сангасваа гэж мэднэ хэмээн яльгүй ичингүйрэн аяархан хэлэв.

Би ноён Норрист огт гар хүрээгүй. Сангасваа гэдгийг чинь би ер дуулаагүй юм байна гэж Харри эрс шулуухан хэллээ. Ханан дээрх Туг үсийн зургууд хүртэл түүнийг сэжиглэнгүй харж байсан болохоор түүнд эвгүй санагдана.

- Бүү худлаа ярь! Чи надад байсан «Эхлэн суралцагчдад зориулсан ид шидийн эчнээ хичээл»-ийг харсан шүү хэмээн Филч уурсав.

- Ноён захирал аа, би нэг юм хэлье гэх Снеггийн дуу сүүдрээс сонсдоход Харри улам атиллаа. Снеггээс аятайхан юм гарна гэж хүлээх хэрэггүй.

- Поттер болон түүний андууд гэмт хэргийн газарт санамсаргүй очсон байж болох л юм. Гэхдээ тэд чухам яах гэж хонгил руу гарсан нь сонин юм биш үү? Тэд яагаад хий үзэгдлийн баяраас явсан юм бэ? гэж өөрийнхөө ч үгэнд итгэхгүй байгаа мэт дүр эсгэн инээмсэглэсээр хэлэв.

- Бүх хий үзэгдлүүд биднийг тэнд харсан ... гэж гурвуулаа нэгэн зэрэг өөрсдийгөө өмөөрлөө.

- Тийм байж, гэхдээ та нар яагаад явсан юм бэ? Та нарт дээшээ гарах ямар хэрэг байсан юм? гэж Снегг багш шалгаахад хар нүдэнд нь лааны гэрэл туяарна. Рон Гермiona хоёр Харрийг харлаа.

- Бид ... бид ... бид их ядраад унтмаар санагдсан юм гэж Харри түгдрэн хэлэв.

Өөрөөс нь өөр хэн ч сонсохооргүй хэлсэн үгэнд нь тэд итгэнэ гэж байхгүй л дээ. Харрийн зүрх галзуурсан мэт булгилна.

- Оройн хоолоо яасан бэ? Хий үзэгдлийн үдэшлэг дээр идчихмээр юм байдаггүй шиг санагдана хэмээн хэлэх Снеггийн нүүрэнд хоржоонтой инээмсэглэл тодроно.

- Бид юм идмээргүй байсан юм гэж Роныг хэлэх үед гэдэс ходоод нь өрөвдөлтэй хоржигнож байлаа.

Снегг багш ярзайн инээгээд:

- Ноён захирал аа, миний бодлоор Поттер ямар нэг юм нуугаад байна. Түүнийг шийтгэх аваас үнэнийг хэлэх байлгүй. Би л байсан бол түүнийг Гриффиндорын шигшээгээс хөөх байсан юм гэлээ.

- Болноо, Северус минь, шууд л хөөх юм гэнэ! Муурыг шүүрний ишээр балбачихаагүй юм байна. Түүнийг Поттер алсан гэх ямар ч баталгаа алга гэж профессор МакГонагалл ярианд оролцов.

Дамблдор Харрийг эгцлэн ширтэнэ. Түүний цэнхэр нүд Харрийг нэвт харж байх шиг санагдах ажээ.

- Тэр буруугүй ээ, Северус минь. Одоохондоо батлах юм байхгүй гэж

Дамблдор Снегг профессорт сануулав. Снегг багш тэсэж ядсандаа чичирч байлаа. Филч нүдээ ахиад л бүлтийлгэв.

- Миний муур татчихжээ. Түүнийг шийтгэх ёстой! гэж тэрбээр орилно.

- Бид таны муурыг буцааж илбэднээ. Профессор Стебльд мандагор байгаа.

Түүнийг ургаж гүйцэхэд бид эм бэлдээд ноён Норрис муурыг амилуулна гэж захирал Филчийг тайвшрууллаа.

- Энэ эмийг би бэлтгэнэ. Надад асар их туршлага бий! Би мандагорын рашааныг нүдээ аниад ч бэлтгэж чадна ... гэж Туг үс хэллээ.

- Уучлаарай, сургуулийн уусмал бэлддэг мэргэжилтэн би л баймаар юм гэж

Снегг багш хүйтэн өнгөөр татгалзав. Хэсэг зуур дуу чимээгүй, эвгүй боллоо.

- Та нар явцгаа гэж Дамблдор нөгөө хагацаж салдаггүй гуравт хэлэв.

Харри, Рон, Гермиона гурав Туг үсийн өрөөнөөс гүйхээрээ гарч нэг давхар дээшлэн ангидаа ороод хаалгаа хаалаа. Харри унжгар царайлсан нөхдөө хяламхийн харав.

- Нөгөө нууцлаг дуу хоолойн тухай ярих хэрэгтэй байсан юм биш биз?

- Яалаа гэж дээ. Чамд ямар нэг юм дуулдаад байгаа юм бол энэ чинь муу совин байж таарна. Ид шидийн ертөнцөд ч тэр гэж Рон хэлжээ.

- Гэхдээ чи надад итгэдэг биз дээ?

- Тэгэлгүй яахав ... гэхдээ ... энэ бүхэн хачирхалтай гэдгийг ... чи мэдэж байгаа шүү дээ ...

- Хачирхалтай гэдгийг ч мэдэж байнаа. Гэтэл бас ханан дээр «НУУЦ ӨРӨӨ ДАХИН НЭЭГДЛЭЭ» гэсэн бичиг байх юм. Энэ юу гэсэн үг вэ? гэж Харри асуув.

- Би хэнээс ч юм Хогвартсын нууц өрөөний тухай дуулсан санагдана. Биллээс билүү, өөр хүнээс билүү ... гэж Рон сунжруулан ярилаа.

- Сангасваа гэж юу юм бэ? гэж Харри асуув. Рон түүнийг тоосонгүй.

- Үүнд инээдтэй юм бага л даа. Гэхдээ Филч бол. Сангасваа гэдэг бол ид шидтэний гэр бүлд төрсөн боловч төрсөн цагаасаа ид шидийн хүч чадал олж аваагүй хүмүүс байдаг юм. Маглуудаас арай өөр. Сангасваа тун ховор. Филч үнэхээр «Эхлэн суралцагчдад зориулсан ид шидийн эчнээ хичээл»-ийн номыг үзэж байгаа юм бол сангасваа байж болох л юм. Чухам яагаад сурагчдыг үзэн яадах болсон нь одоо тодорхой байна ... Үнэндээ өрөвдмөөр юм аа гэж Рон харамсангуй хэлээд инээмсэглэв.

Хаа нэгтээ цаг дуугарлаа.

- Шөнө дөл болжээ. Хурдхан унтлагын өрөө лүүгээ очихгүй бол Снегт багш дахин хүрч ирээд ямар нэг юмнаас зуурах болно гэж Харри яаруулав.

Хэдэн өдрийн турш ганцхан ноён Норрисын тухай л ярьцгааж байлаа. Бүгд л Филчээс болсон гэнэ. Тэрбээр буруутанг хүлээх мэт муураа илбэдүүлсэн газрыг эргэн тойрсоор. «Хатагтай Цэвэрлэгчийн шидэт толбо арилгагч»-ын тусламжтайгаар ханан дээрх бичгийг арилгах гэж цөхрөлтгүй оролдохыг Харри өөрөө харжээ. Филч хонгилд нуугдаад сурагчид руу давшлан тэднийг «дэндүү чанга амьсгалсан»,

«хэтэрхий хөгжилтэй байсан» гэх зэрэг шалтгаанаар буруутгах гэж оролдоно.

Филчийн мууранд тохиолдсон азгүй явдлаас хойш Жинни Уизли нэг л хачин болчихжээ.

- Чи Норрис муурыг огт мэддэггүй байсан шүү дээ. Харин ч түүнийг үгүйд аятайхан байна. Санаагаар унасны хэрэггүй гэж Рон тайтгаруулахад Жиннийн уруул өмөлзөнө.

- Дүү маань мууранд дуртай юм аа. Ийм явдал хэзээ ч тохиолдож байсангүй.

Сэтгэл мэдрэлийн өвчтэй тэр амьтныг барьж аваад эндээс хөөнө гэдэгт эргэлзэх юм алга. Уул нь эхлээд Филчийг татуулсан бол дээр байсан юм гэж

Рон андууддаа ярьжээ.

Гермиона ч бас хачин болсон байлаа. Тэрбээр ном унших дуртай ч одоо бүр номын донтой болжээ. Юу болоод байгааг Харри Рон хоёр мэдэхийг хүссэн ч талаар өнгөрлөө. Харин лхагва гаригт л зарим нэг юмны учир олдов.

Уусмал бэлтгэх хичээлийн дараа Снегг багш Харрийг ширээн дээрх туршлагын өтнүүдийг цэвэрлэ гэж үлдээжээ. Энэ таагүй ажлаа дуусгачихаад Харри хурдхан хоолоо идсэнийхээ дараа Роны хүлээж байгаа номын сан руу яаран очив. Замдаа ургамал судлалын хичээл дээр хамт ордог Пуффендуй тэнхимийн Жастин Финч-Флетчлитэй тааралдаад мэндлэх гэсэн авч тэрбээр түүнийг хармагцаа огцом эргээд зугтан алга болжээ.

Харри Роныг номын сангийн нэг буланд сууж байхад нь оллоо. Тэрбээр ид шидийн хичээлээр өгсөн гэрийн даалгавараа хэмжиж байв. Профессор Бинс «Европын ид шидтэнгүүдийн дундад зууны үеийн бүрэлдэхүүн» гэдэг сэдвээр нэг метр урт зохион бичлэг бичих даалгавар өгчээ.

- Зовлонтой юм аа. Бүхэл бүтэн хорин сантиметр дутаад байдаг ... Гэтэл Гермиона бүр метр хагас цаасыг жижигхэн бичгээр дүүргэчихсэн шүү ... гэж Рон хуйлсан цаасаа дэлгэнгээ ярьжээ. Цаас буцаад хуйлагдав.

- Тэр өөрөө хаана байгаа юм бэ? гэж Харри өөрийнхөө зохион бичлэгийг дэлгэх зуураа сониучирхаж асуулаа.

- Тэнд. Ямар нэгэн ном эрээд байгаа юм. Шинэ жил гэхэд номын сангийн бүх номыг уншиж дуусган дээд амжилт тогтоохоор шийдсэн бололтой гэж Рон номын тавиурын урт эгнээг гараараа заан хэллээ.

Жастин Финч-Флетчли түүнээс бултан зугтсан тухай Харри ярив.

- Тэглээ гээд яах юм! Жастин тэнэг гэдэг нь тодорхой. Туг үсийн өмнө бхөлзөөд л ... гэж Рон хэлээд сүүлчийн зайг том том бичгээр дүүргэж байв.

Номын тавиурын араас цөхрөнгөө барсан Гермиона гарч ирлээ.

- «Хогвартсын түүх» гэдэг номыг бүгдийг тараачихжээ. «Тэмдэглүүлээд хоёр долоо хоног хүлээ» гэнээ! Би тэр номыг гэртээ үлдээчихсэн юм л даа. Туг үсийн номнуудаас болоод л тэр. Чемоданд багтахгүй байсан юм ... гэж тэрбээр андуудтайгаа зэрэгцэн суугаад дургүйцэн хэлэв.

- Чи «Хогвартсын түүх»-ээр яах гэсэн юм бэ? гэж Харри сонирхлоо.

- Бүгдэд хэрэгтэй болоод л тэр. Нууц өрөөний тухай домог унших гэсэн юм.

- Энэ чинь ямар өрөө гэж?

- «Түүх»-энд энэ домог бий. Бусад номуудад байхгүй. Би тэр домгийг санадаггүй ээ ... гэж хэлээд Гермиона хөмхийгөө зуужээ.

- Гермиона минь дээ, чи надад зохион бичлэгээ уншуулчих гэж Рон цагаа харснаа аргаа баран хэллээ.

- Гуйгаад нэмэргүй ээ. Арван өдрийн турш чи юу хийсэн юм бэ? гэж Гермиона уурлав.

- Надад ердөө л тавхан сантиметр үлдээд байна. Чамд харамсалтай байна гэж үү?

Хонх дуугарч, андууд ид шидийн хичээлд орохоор гүйцгээв. Рон, Гермиона хоёр замын турш толхилцжээ.

Энэ хичээлээс илүү уйтгартай зүйл гэж байсангүй. Хичээлийг сургуульд цорын ганц байдаг хий үзэгдэл багш профессор Бинс заадаг байв. Аймаар уйтгартай агаад ноён Бинс хичээлийн самбараас шууд гарч ирдэг нь л сонирхол татдаг юм. Эртний энэ хүнийг хэрхэн үхсэнээ мэдэхгүй өнгөрсөн гэж ярилцдаг билээ. Нэг удаа хичээлд ирэхдээ их биеэ багш нарын өрөөний ханан зуухны дэргэд үлдээчихсэн гэдэг.

Өнөөдөр ч профессор Бинс урьдын адил тэмдэглэлээ дэлгээд тослоогүй тэрэг шиг хяхтнаж гарлаа. Ангид цөмөөрөө үүрэглэн, хааяа зарим нэг хүүхэд сэрмэгцээ нэр он сар зэргийг бичиж аваад ахиад л зүүрмэглэнэ. Ингэж хагас цаг хэртэй хяхтасны эцэст нэг сонин юм боллоо. Гермиона гараа өргөжээ.

1289 онд болсон ид шидтэнгүүдийн олон улсын хэлэлцээрийн тухай хичээлийнхээ дунд нь хүрч байсан профессор Бинс гайхшран харцаа дэвтрээсээ салгажээ.

- За, хатагтай ... өө-ө ...

- Грэйнджер, профессор оо. Би танаас нууц өрөөний тухай асуух гэсэн юм хэмээн Гермиона тов тодорхой хэлэв.

Цонхоор ширтэж байсан Дин Томас ухаан орж зөрүүлсэн гар дээрээ толгойгоо тавин ширээгээ тэгнэн хэвтэж байсан Лаванда Браун цочиж, Невилл ширээн дээрээс гараа татаж авчээ.

Профессор Бинс нүдээ анивчсаар.

- Миний заадаг хичээл бол ид шидийн түүх. Грэйнджер авхай, би зөвхөн баримт түшдэг болохоос элдэв үлгэр домог хамаагүй. Энэ оны есөн сард Сардиний ид шидтэний дэд хороо ... гэж профессор нэгэн хэмийн дуугаар сөөнгөдүү ярина. Тэрбээр хуурай шохой бужигнуулсан мэт ханиалган ярьсаар.

Тэгтэл Гермиона ахиад л гараа өргөсөн учир яриа тасалджээ.

- Юу вэ, Грэйнджер авхай?

- Гэхдээ домог болгон баримт дээр үндэслэсэн байдаг биз дээ?

Профессор бүр гайхаж орхисон нь түүнийг амьд үхсэн аль ч үед хэн ч энэ тухай асууж байгаагүй юм шиг Харрид санагджээ.

- За яахав. Таны зөв байж болох юм. Гэхдээ таны асуусан домог бол огт үндэсгүй, цэвэр зохиосон, тэр ч байтугай ... хэмээн Бинс яриа зуураа Гермionaг анх удаа харж байгаа юм шиг гайхан ширтэх ажээ.

Гэхдээ бүх ангиараа чих тавин чагнаж байсан болохоор зайлах арга байсангүй. Бинс бүх хүүхдүүдийг тойруулан харлаа. Олон арван нүд түүнийг асуусан янзтай ширтэнэ.

- За яахав. Би санах гээд үзье ... Нууц өрөө ... гэдэг чинь ... нууцын өрөө ...

«Хогвартс» сургууль мянга гаруй жилийн тэртээ үндэслэгдсэн гэдгийг та бүгд мэдэж байгаа. Яг он сар нь байдаггүй юм. Сургуулийг тухайн үеийн дөрвөн томоохон шидтэн байгуулсан юм. Манай тэнхимүүд тэдний нэрээр нэрлэгддэг билээ. Годрик Гриффиндор, Пенелопа Пуффендуй, Кандида Когтевран, Салазар Слизерин нар. Тэд тухайн үеийн маглуудын нүднээс хол энэхүү шилтгээний хамтран барьсан юм. Тэр үед эгэл хүмүүс ид шидээс айдаг байсан болохоор ид шидтэн, илбэчингүүд нуугдах хэрэг гардаг байжээ гэж хэлээд сурагчдыг үзэн ядсан байртай харснаа цааш үргэлжлүүлэн:

- Тэд нилээд урт хугацааны турш эвтэй найртай амьдарч, авъяас чадвартай залуу хүмүүсийг эрж олон энэ сургуульд элсүүлж, чадах ядахаараа сургадаг байжээ. Тэгснээс Слизерин болон бусад хүмүүсийн хооронд ан цав гарах нь тэр. Слизерин маш хатуу сонголт шаарддаг байлаа. Тэрбээр ид шидийн нууц бол цэвэр цусны шидтэнгүүдийн гэр бүлд л хадгалагдана гэж үздэг байв. Маглуудад итгэдэггүй байжээ. Эцсийн эцэст Слизерин, Гриффиндор хоёр хэрэлдээд Слизерин сургуулийг орхиж явсан гэдэг гээд профессор Бинс хөмхийгөө зуухад нүүр царай нь үрчийсэн хөгшин яст мэлхийтэй адил харагдана.

- Он дарааллын сударт ингэж л дурдсан байдаг юм даа. Гэхдээ цаг хугацаа өнгөрөхөд нууц өрөөний тухай домог баримт сэлтийг дарагдуулжээ. Слизеринийг шилтгээнд нууц өрөө хийсэн гэж ярьцгаадаг л юм. Ингэж л домог төрсөн хэрэг. Хэрэв домгоор бол Слизерин сургуулиа орхихоосоо өмнө өрөөг тарнидсан гэдэг юм. Тэр үеэс л өрөөнд хэн ч орж чадахаа больсноор барахгүй зөвхөн Слизериний удам судрынхан тарнийг зайлуулж, аймшгийн өрөөн хоригдогчдыг суллан, түүний тусламжтайгаар ид шидийн урлагийг судлаж чадахгүй хүмүүсийг сургуулиас хөөх учиртай гэдэг.

Бинсийг яриагаа дуусгахад ангид нам гүм болсон хэвээр. Сурагчид Бинсээс нүд салгалгүй, үргэлжлүүлэн ярихыг хүлээсэн авч энэхүү дэмий яриа Бинсийг залхаажээ.

- Энэ бүхэн үлгэр домог юм. Өрөөг хэд хэдэн удаа хамгийн чадалтай шидтэн, лус савдгууд эрсэн юм даг. Тийм өрөө байхгүй. Энэ бол ердөө л тэнэг хүмүүст зориулсан аймшигт үлгэр.

Гермиона ахиад л гараа өргөв.

- Ноёнтоон, «Аймшгийн өрөөнд хоригдогч» гэдэг чинь юу гэсэн үг вэ?
- Домогт гардгаар бол зөвхөн Слизериний үе залгамжлагчдад захирагдах учиртай ширүүн хүн байх ёстой гэж Бинс хөндий, хоржигносон дуугаар тайлбарлав.

Сурагчид бие биеэ айсан байдалтай харцгаалаа.

- Айх хэрэггүй, ямар ч өрөө байхгүй. Өрөө ч байхгүй догшин ширүүн хүн ч байхгүй гэж профессор Бинс цаас шажигнуулах зуураа хэлэв.

- Гэхдээ өрөөг зөвхөн Слизериний жинхэнэ залгамжлагч л нээж чадна гэж та ярьлаа шүү дээ. Энэ чинь залгамжлагч ирэх хүртэл хэн ч тэр өрөөг олохгүй гэсэн үг биш үү? хэмээн Симус Финниган асуужээ.

- Энэ чинь тэнэг хэрэг. Тийм өрөө байхгүй. Сургуулийн нэг ч захирал түүнийг олоогүй юм чинь ... хэмээн профессор Бинс уурлалаа.

- Уучлаарай профессор оо. Энд зүгээр л хар шид шид хэрэгтэй байгаад тэр нь бидэнд байхгүй байж болох юм гэж Парвати Патил хэлэв.

- Хэрэв ид шидтэн хар шид шид үзүүлдэггүй бол түүнийг сураагүй гэсэн үг биш шүү дээ. Дамблдорын өмнөх үеийнхэн ... гэж Бинсийг дуугаа чангаруултал:

- Гэхдээ Слизеринтэй хамаатан байх хэрэгтэй байж магадгүй юм. Харин захирал маань ... гэж Дин Томасыг ярьж эхэлтэл профессор Бинс байж суух газраа олж ядлаа.

- Энэ тухай одоо болноо! Энэ бүгд үлгэр домог, хууч яриа. Та нар ухааныхаа цурамд тогтоож ав. Өрөө байхгүй. Слизерин шилтгээнд нууц булан барьж байгуулсан гэдэг баталгаа байхгүйтэй адил. Энэ тэнэг түүхийг би ярьж өгсөндөө харамсаж байна. Одоо жинхэнэ найдвартай, шалгагдсан баримт бүхий үнэн түүх рүүгээ эргэж орцгооё гэж тэрбээр хэллээ.

Таван хором ч өнгөрөөгүй байтал хүүхдүүд ахиад л үүрэглэж байв.

- Салазар Слизерин шахалтанд орсон байлгүй дээ. Цэвэр цус энээ тэрээ гэдэг үгийг хэн яагаад яариад байдаг нь ойлгогдлоо. Би л лав энэ танхимд яагаад ч орохгүй байсан даа. Хэрэв бүрх малгай намайг тийш нь хуваарилсан бол би юу ч бодолгүй гэртээ харих байсан ... гэж хичээлийн дараа Рон ярьжээ. Харри Гермиона тэр гурав хүүхдүүдийн дундуур зүтгэсээр цамхаг руугаа очоод цүнх саваа орхиж оройн хоолоо идэхээр яарчээ.

Гермиона ойлгосон мэт толгой дохиход Харри дуугүй байлаа. Роны хэлсэн үгэнд дотор нь хүйт оргижээ.

Жилийн өмнө бүрх малгай түүнийг Слизеринд суралц гэж санал болгосныг Харри нөхдөөсөө нуудаг байлаа. Бүрх малгай түүний чихэнд: «Чи агуу их хүн болно ... Слизрин чамайг алдрын оргилд аваачна. Бүү эргэлз ...» хэмээн шивнэсэн юм даг.

Гэвч Харри Слизеринээс зөвхөн хар шидтэн гардаг гэдгийг мэддэг байсан болохоороо эрс татгалзсан билээ. «Зөвхөн Слизерин л биш байгаасай!» гэж дотроо бодож байтал бүрх малгай: «За яахав, дураараа л бол ... Гриффиндорт ор ...» гэсэн юм.

Хүүхдүүдийн дунд тэд Колин Кривитэй тааралдлаа.

- Сайн уу, Харри.

- Сайн уу, Колин.

- Харри, манай ангийн нэг хүүхэд чамайг ... гэтэл хүүхдүүд түүнийг дундаа хавчуулан их танхим руу авч одлоо. Жижигхэн, хөнгөхөн Колин ямар ч атугай: «Баяртай, Харри!» гэж алсаас хашгирч амжаад харагдахаа больжээ.

- Түүний ангийн хүүхэд юу хэлсэн юм бол? гэж Гермiona сонирхов.

- Намайг Слизериний залгамжлагч гэсэн юм байлгүй гэж хэлээд Харрийн сэтгэл зүрх гомдлоор дүүрэв. Үдийн хоолны дараа Жастин Финч-Флетчли яг л галаас дүрвэсэн юм шиг түүнээс зугтаасныг эргэн саналаа.

- Тэдний аль дэмий юм бодож олохыг тэр гэхэв! гэж Рон хэлээд царайгаа үрчийлгэв.

Шилтгээний тойруулган шатан дээрх хүүхдүүд цөөрчээ.

- Нууц өрөө гэж үнэхээр байдаг гэж бодож байна уу? гэж Рон Гермionaгаас асуув. Хэн мэдэх вэ? Дамблдор гуай ноён Норрис муурыг амилуулж чадаагүй болохоор түүнийг ... лав л хүн тарнидаагүй байх гэж Гермiona хөмөг зангид хэллээ.

Шатны нэг булангаас нөгөө ноён Норрисыг олсон хонгил эхлэдэг юм. Бүгд урьдын адил байсан авч бамбар тогтоох дэгээнд муур байхгүй, «НУУЦ ӨРӨӨ ДАХИН НЭЭГДЛЭЭ» гэсэн бичгийн оронд сандал тавьсан байлаа.

- Үүнийг Филч тавьжээ. Энд жижүүрлэж байгаа юм гэж Рон тодруулав. Одоо хонгилд хоосон ажээ. Гурвуулаа ийш тийшээ харцгаав.

- Алив эрцгээе! Ямар нэг ул мөр үлдсэн байж болох юм гэж хэлээд Харри цүнхээ чулуудан дөрвөн хөллөөд мөлхөх зуураа:

- Энд хар толбо байна! Энд бас ... гэтэл:

- Наашаа ир. Үүнийг хараач гэж Гермiona инээд алдан хэлжээ.

Харри босоод ханан дээрх бичгийн дэргэдэх цонх руу очлоо. Гермiona дээд талын шилийг заана. Шилэн дээр гарсан яльгүй завсрыг чиглэн баахан аалз цувран гүйлдэх

ажээ. Тэдний араас утаа мэт мөнгөлөг, урт аалзны тор хөвөрнө. Аалзнууд гадагш гарахаар яарч байгаа нь илт.

- Эд нар яасан юм болоо? Иймэрхүү юм урьд нь огт үзсэнгүй гэж Гермиона хэлэв.

- Би ч бас. Харин Рон чи харсан уу? Рон оо? гэж Харри асуулаа. Харри эргээд харсан чинь Рон нилээд хол айсан шинжтэй зогсоно.

- Чи яасан бэ? гэж Харри асуув.

- Би ... аалзнаас айдаг юм ... гэж Рон хүчлэн хэллээ.

- Тийм үү? Чи аалзаар мянган удаа уусмал бэлтгэсэн биз дээ гэж Гермиона гайхав.

- Хатаасан аалз яах ч үгүй ээ. Харин амьд аалз бол ... гэж хэлээд Рон аалзны зүг харж зүрхэлсэнгүй.

Гермиона инээд алдав.

- Инээх юм байхгүй. Би гурван настай байхдаа Фредийн тоглоомон шүүрний ишийг хугалчихсан юм. Тэрбээр уурласандаа болоод миний хилэн бамбаруушыг том аравгар аалз болгочихож билээ. Тийм үед чамайг ямар байхыг чинь харах юм сан ... гэж Рон хэлээд дотор нь муухай оргижээ.

Гермиона инээдээ арай ядан барьж байв. Харри тэр хоёрыг аалзнаас хөндийрүүлэх санаатай:

- Тэр үед энд шалан дээр ус байсныг санаж байна уу? Ус хаанаас гарсан бэ?

дараа нь арччихсан байсан гэж асуулаа.

- Санаж байна. Энэ хаалганы дэргэд ус байсан гэж хэлээд Рон үүд рүү очин гараа сунган татлаа.

- Чи яаж байнаа хэмээн Харри гайхав.

- Тийшээ орж болохгүй ээ. Охидын бие засах газар.

- Тэгээд яагаав. Тэртээ тэргүй ажилладаггүй юм чинь. Тэнд уйланхай Миртл суудаг юм. Явж харъя гэж хэлээд Гермиона үүд рүү очлоо.

Тэгээд «Жорлон ажиллахгүй» гэсэн бичгийг ч хайхралгүй Гермиона үүдийг дэлгэв. Энэ жорлон ямар муухай замбараагүй байсан гээч! Цав гарч толбо болсон урт толины доод талд хагарч хэмхэрсэн угаалтуур ярайна. Бүгдэг бадаг гэрэлтүүлэх хугархай лааны гэрэл нойтон шалан дээр туяарах аж. Бүхээгний үүдний будаг ховхорч, нэг бүхээгний хаалга ганцхан нугасан дээр санжиганан байлаа.

Гермиона хуруугаа уруулдаа наагаад сүүлчийн бүхээг рүү явав.

- Сайн байна уу, Миртл ажил ямар байна?

Рон Харри хоёр дөхөж очлоо. Миртл эрүүн дээрх батгаа шахсаар усны савны дээгүүр хөвөн хөөрч байв.

- Энэ бол охидын бие засах газар. Гэтэл эд нар чинь охид биш байна гэж Миртл хэлэхдээ Рон Харри хоёрыг сэжиглэнгүй харж байлаа.

- Тийм ээ, тэдэнд би энд ямар ... аятайхан байдгийг үзүүлэх гэсэн юм гэж

Гермиона зөвшөөрөн хэлэв.

Тэгээд гараараа бүдгэрсэн толь норсон шалыг заах мэт дүр үзүүлжээ.

- Миртлийг ямар нэг юм харсан уу гэж асуухгүй юм уу? гэж Харри шивнэв.

- Та нар юун тухай шивнэлдээд байна? гэж Миртл хэлээд Харрийг сэжиглэнгүй харлаа.

- Бид шивнэлдээгүй байнаа. Би зүгээр л юм асуумаар санагдаад ... гэж Харри хэлэв.

- Яагаад дандаа надад мэдэгдэлгүй шивнэлдээд байдаг юм бэ? Хэрэв би үхсэн л бол гомдож чадахгүй болж таарч байна уу? гэж Миртл уйлагнана.

- Хэн ч чамайг гомдоох гээгүй байна. Харри зүгээр л ... гэж Гермиона түүнийг тайтгаруулахаар оролдоно.

- Хэн ч гомдоохыг хүсээгүй гэнэ! Би амьдралдаа дандаа хэлмэгдэж байх юм.

Бүгд дахин давтагдаж байна.

- Сүүлийн үед чамайг ямар нэг ер бусын юм харсан уу? гэдгийг бид асуух гэсэн юм. Баярын үеэр чиний жорлонгийн хаалганы эсрэг талд хэн нэгэн хүн муурыг хэлмэгдүүлсэн байна гэж Гермиона шууд л асуулаа.

- Энд хэн нэгэн хүн байсан юм болов уу? гэж Харри нэмэрлэв.

- Би хэнийг ч хараагүй. Намайг баяр дээр их гомдоосон болохоор би буцаж ирээд үхмээр санагдсан ч ... гэнэтхэн өөрийгөө ...

- Үхсэн гэдгийг санасан гэж Рон туслав.

Миртл гомдонгуй уйлагнаад усны саван дээгүүр ниссэнээ шууд л суултуур руу шумбан унаж хүүхдүүдийг толгойноос хөл хүртэл норгочихлоо. Усны хоолойноос бүдэг бадаг хашгирах чимээ сонсдоно.

Рон Харри хоёр гайхан амаа ангайж Гермиона мөрөө хавчин:

- Үүнийг Миртлийн зугаа цэнгээ гэж үзэж болно. Эндээс явцгаая гэлээ.

Рон жорлонгийн үүдийг дөнгөж хаатал, хаана ч юм ус булиглах чимээ гарснаа, дээрээс хэн нэг хүн: «Рон!» гэж чанга дуудахад тэр гурав огло үсэрчээ. Талбай дээр тэнхимийн ахлагч Перси Уизли зогсож байв.

- Энэ чинь охидын бие засах газар. Та нар тэнд юу хийсэн юм бэ? гэж Преси шүднийхээ завсраар сийгүүлэн асуулаа.

- Юу ч болоогүй ээ. Бид эд мөрийн баримт хайсан юм гэж Рон мөрөө хавчин хэлэв.

Перси яг л хатагтай Уизли шиг ширүүн төрхтэй болоод:

- Эндээс хурдхан явцгаа ... Хачин юм болох нь шив?! Бүгд хоолоо идэж байхад эд нар энд ахиад л байж байдаг! гэж гараа алдлан хэлээд тэднийг шатаар буулгахаар иржээ.

- Тэгээд яагаав? Бид мууранд хуруугаа ч хүргээгүй юм чинь! гэж Рон зогсоод

Персийг эгцлэн харж хэлэв.

- Би Жиннид бас ингэж хэлсэн. Чамайг сургуулиас хөөгдөх байх гэж айгаад өдрийн турш усан нүдлэж яваа шүү. Чи ядахдаа түүнийг бодмоор юм!

- Жиннийн тухай надад яриад яах юм бэ? Чи түүнийг тоодоггүй шүү дээ. Чи зүгээр л энэ бүхнээс болоод ахлагчаасаа огцорно гэж л айж байгаа гэж хэлээд Роны чих улайжээ.

- Гриффиндорт хасах таван оноо өглөө. Та нарт сургамж болог. Одоо дахин ямар ч мөрдөн байцаах ажил хийхгүй шүү! Тэгэхгүй бол захидал бичнэ гэж Перси уурсан хэлээд ахлагчынхаа тэмдгийг тэмтэрлээ.

Персийн хүзүү Роны чихнээс илүү улайгаад эргэн явж одлоо.

Харри, Рон, Гермiona гурав их танхимд очоод Персигээс хол суужээ. Рон гэрийнхээ даалгаврын ид шидийн томъёон дээрээ бэх дусаачихаад түүнийгээ арилгах санаатай шидэт саваагаа аван дохисон авч зохион бичлэг бүхий цаасаа санамсаргүй шатаачихжээ. Цаас дүрэлзэн шатахад Рон ч бүр цөхрөнгөө баржээ. Гараараа дохисноо шившлэгийн номоо хаахад Гремиона ч бас түүнийг дуурайхад Харри их гайхсан аж.

- Ер нь хэн муурыг тэгдэг байнаа? Сангасваа, маглууд сургуульд байхгүй бол хэнд хэрэгтэй юм бэ? гэж мартсан яриагаа үргэлжлүүлж байгаа өнгөөр Гермiona аядуухан асуулаа.

- Тийм шүү, хэн маглуудыг ингэтлээ үзэн яддаг блээ? гэж Рон сайтар ухааралгүй асуултыг асуултаар хариулав.

- Чи Малфойн тухай яриад байна уу? гэж Гермиона Роныг асуусан байртай харна.
- Өөр хэний тухай асуух юм бэ? Чи түүнийг «Холимог цустай та нар дараа нь» гэж хэлэхийг сонссон шүү дээ. Санаж байна уу? Чи түүнийг харх шиг царайлсныг хараарай. Юугаар ч мөрийцсөн бэлэн байна ...
- Малфой чинь Слизериний залгамжлагч гэж үү? Итгэмээргүй юм гэж Гермиона хэлжээ.
- Тэдний гэр бүл ямар билээ? Бүгдээрээ л Слизеринд суралцсан. Малфой энэ тухай байнга ярьдаг юм. Тэд цөм Слизериний хамаатнууд байж болох юм бишүү? Малфойн эцэг хар шидтэн шүү дээ гэж хэлээд Харри бас л номоо хойш тавилаа.
- Малфойнхонд нууц өрөөний түлхүүр олон зуун жил хадгалагдсан байж магадгүй. Эцгээсээ хүүд дамжуулаад л гэж Рон хэлэв.
- Тийм ч байж магадгүй юм гэж Гермиона итгэл муутайхан өгүүлжээ.
- Тийм байлаа ч гэсэн батлаж чадахгүй юм даа гэж хэлээд Харри хөмсөг зангидав.
- Нэг арга байна. Энэ арга үнэндээ маш хэцүү, тун эвгүй байх юм. Энэ аргыг хэрэглэвэл сургуулийн бүх дүрэм журмыг зөрчих болно гэж Гермиона шивнэн хэлээд Персийн зүг айсан маягтай харлаа.
- Гурав дөрвөн долоо хоногийн дараа тэр аргаа бодож боловсруулаад бидэнд хэлээрэй гэж Рон ёжлоно.
- Бодоод олчихсон юм аа. Слизериний их танхимд нэвтэрч ороод Малфойн нууцаа ярихыг өөрт нь мэдэгдэлгүй сонсох хэрэгтэй гэж Гермиона тайван хэлжээ.
- Яаж ингэх юм бэ? гэж Харри сайтар ухааралгүй асуух зуур Рон чангаар инээж байв.
- Амархаан, хөвгүүд ээ. Зөвхөн хувиргах уусмал л чанах хэрэгтэй.
- Ямар уусмал гэнээ? гэж Рон, Харри хоёр зэрэг асуув.
- Энэ тухай Снегг багш нэг хичээл дээр ярьсан юм ...
- Снегг багшийн хичээлийг сонсохоос өөр юм чамд байх биш дээ гэж Рон үглэнэ.
- Энэ бол нэг хүнийг өөр хүн болгодог ундаа байгаа юм. Бид өөрсдийгөө Слизериний нэг хүүхэд болгоод хувиргачихвал хэн ч мэдэхгүй байх болно. Тэгээд л Малфойн чалчихыг сонсох юм. Тэр чинь бардамнах дуртай гэж Гермиона Роны үглэхийг тоолгүй ярина.

- Чиний санал надад нэг л таалагдахгүй байна. Бид үүрд Слизеринийх болоод үлдчихвэл яах юм бэ? гэж Рон баргар царайлан хэлэв.

- Тэнэг гэдэг нь. Уусмалын үйлчилгээ дорхноо гарчихдаг юм. Харин жор яаж олох билээ? «Хүчтэй үйлчлэгч уусмал» гэдэг номонд бий гэж Снегг багш ярьж байсан. Тэр ном сургуулийн номын сангийн тусгай хэсэгт байдаг байлгүй гэж Гермиона ярина. Тусгай хэсгийн номыг зөвхөн багшийн зөвшөөрлийн бичгээр олгодог юм.

- Бид яаж зөвшөөрөл олж авах вэ? Энэ ном зүгээр л бидэнд хэрэг болсон гэхэд хэн итгэх юм бэ? Биднийг ямар нэгэн уусмал бэлтгэх гэж байна гэдгийг захын тэнэг ойлгоно хэмээн Рон уруу царайлан хэлэв.

- Уусмал бэлтгэх онол бидэнд их сонирхолтой байна гэж хэлж болно биз дээ?

- Үгүй ер өө! Манай профессоруудыг мэдэхгүй биш дээ! Хувиа бодсон амьтад!

гэж Рон татгалзан хэлжээ.

БҮЛЭГ 10: ГАЛЗУУРСАН БӨМБӨГ

Хичээлийн жилийн эхэнд Туг үс ангид корунэллийн шунгинууртай танилцуулах хичээл зохион байгуулсан авч төдий л амжилттай болоогүй билээ. Түүнээс хойш тэрбээр хичээл дээр өөрийнхөө номын хэсгээс уншиж өгөх болсон бөгөөд заримдаа тэндээс хэсэгчилсэн тоглолт хийлгэхдээ өөрөө хамгийн сайн боллоо гэж боддог байв. Өөрөө шидтэний дүрд тоглож бусад дүрд ихэвчлэн Харрийг сонгон авдаг балаа. Харри ангийнхныхаа өмнө чалчих шившлэгээс болоод хэлмэгдсэн хөдөөгийн тариачин эсвэл хатгалгаа туссан алмас эсвэл Туг үстэй дайралдсанаасаа хойш цус үзэж чадахаа больж, зөвхөн ногоогоор хооллох болсон Цус сорогчийн дүрийг бүтээнэ.

Нэг хичээл дээр Харри хар урлагаас хамгаалах хичээл дээр хувилгааны дүрд тоглосон бол дараа нь энэ дүрээс татгалзмаар санагдсан аж. Гэхдээ одоо Туг үсийн сайхан сэтгэлийг сэвтүүлэхгүй байх нь чухал.

- Харри чи сайхан улилаа. Яг л жинхэнэ юм шиг. Би түүнийг довтлон газар унагаагаад хоолойд нь шидэт саваагаа тулгасан юм. Сүүлчийн хүчээ шавхан эргүүлэх хэцүүхэн шившлэг хэлэхэд мань хувилгаан өрөвдөлтэй орилж билээ. Алив,

Харри дуурайгаад үз! Илүү чангаар! Ай даа, яг болж байна. Түүний үс ноос унаж, араа соёо нь жижигрээд ерийн нэгэн болж хувирсан юм даг. Жирийн юм шиг авч тэр тосгоны оршин суугчид огт марталгүй намайг баатар гэдэг юм. Тэдний хувилгаанаас салгасан юм чинь.

Хонх дуугарч, Туг үс ширээний араас бослоо.

- Гэрийн даалгаварт Вага-Вагагийн хувилгааныг би хэрхэн алсан тухай шүлэг зохиоцгоо. Сайн зохиосон хүүхдэд «Би шидтэн» номоо гарын үсэг зурж дурсгана.

- За яах вэ? гэж Харри сэмхэн асуулаа.

- Хүүхдүүдийг явахыг хүлээе. Одоо явцгаая ... гэж Гермiona догдлон хэлэв.

Гермиона сэтгэл түгшин гартаа хуудас цаас барьсаар Туг үс рүү очлоо. Рон, Харри хоёр ч араас нь яарав.

- П ... профессор Туг үс гуай ... би ... би номын сангаас энэ номыг авмаар байна.

Түүнийг унших гэсэн юм хэмээн Гермiona түгдрэн хэлээд номын нэр бичсэн цаасаа чичирсэн гараараа түүнд сунгаж:

- Гэхдээ энэ ном тусгай хэсэгт байдаг болохоор ... өө ... багшийн зөвшөөрөл хэрэгтэй гэнээ. Таны «Ороолонтой орооцолдсон нь» гэдэг номдоо бичсэн удаан үйлчилгээтэй хорны тухай мэдмээр байна ... гэлээ.

- Аа, «Ороолонтой орооцолдсон нь» гэдэг чинь миний хамгийн хайртай ном.

Танд таалагдсан юм уу? гэж Туг үс хэлээд цаасыг авангаа баясан инээмсэглэжээ.

- Маш их таалагддаг. Та цайны шүүрийн тусламжтайгаар хорыг тун чадмаг шүүсэн байдаг шүү! гэж Гермiona уриалгахан хэллээ.

- За яахав, хамгийн сайн сурагчдаа туслах нь миний үүрэг гэж Туг үс инээмсэглэн хэлээд тогосны өдөөр хийсэн том үзгээ гаргаж ирлээ. Роныг давхийхэд Туг үс өөрөөр ойлгоод:

- Сайхан байгаа биз, тийм үү? Би гарын үсгээ үүгээр зурдаг юм гэлээ.

Тэрбээр ороолдсон гарын үсгээ зураад нөгөө цаасаа Гермiona д өгөхөд охин түүнийг яаран авч цүнхэндээ хийлээ.

- Маргааш улирлын анхны тэмцээн болно биз дээ? Гриффиндор Слизеринтэй тоглоно гэнээ? Чамд их найддаг гэлцэж байна билээ. Би ч бас баригч байсан юм шүү. Намайг улсын шигшээд урьсан авч би татгалзаад дэлхийг хар хүчээс хамгаалах ажилд амьдралаа зориулсан юм даа. Гэхдээ би одоо ч гэсэн муугүй тоглодог болохоор чамд ганц хоёр арга хэлж өгч болох л юм. Эхлэн суралцагчдад би туршлагаасаа хэлж өгөх дуртай ... гэж Туг үс Харрид хандан хэлэв.

Харри талархсанаа бувтнан хэлээд нөхдийнхөө араас яарлаа. Тэд хонгилд очоод алхаагаа саалаа.

- Үгүй ер, ямар ном гэдгийг нь харах ч үгүй зурчихдаг байна шүү гэж Харрийг гайхан хэлээд Туг үсийн гарын үсгийг харав.

- Хоосон толгойт хувиа боддогч. Гэхдээ хүссэн юмаа авсан болохоор бидэнд ямар ялгаа байх вэ дээ гэж Рон явах зуураа өгүүлнэ.

- Тэр чинь хоосон толгойт хувиа бодогч биш ээ гэж Гермiona хэллээ.

- Тэгэлгүй яахав, чи түүний хамгийн сайн сурагч юм чинь ...

Номын санд зөвхөн шивнэн ярих учиртай болохоор андууд дуугаа аяарсгав.

Хатангир туранхай өлсгөлөн бүргэдтэй адилхан хатагтай Пинс Туг үсийн гарын үсэгтэй цаас руу сарвайсан авч Гермiona түүнийг тавьсангүй.

- «Хүчтэй үйлчлэгч уусмал» гэнээ? хэмээн хатагтай Пинс хардангуй давтаад Гермionaгаас нөгөө цаасыг дахин авах гэлээ.

- Би зөвшөөрлийг өөртөө үлдээж болох уу? гэж Гермiona хулчгардуухан асуув.

- За яая гэхэв. Өөр гарын үсэг авна биз. Туг үс юун дээр ч хамаагүй зурдаг юм чинь гэж хэлээд Рон цаасыг охиноос булаан авч хатагтай Пинст өгчихлөө.

Хатагтай Пинс цаасыг жинхэнэ эсэхийг шалгах бололтой гэрэлд барьж харснаа цааш яваад таван хормын дараа эргэж ирэхдээ гартаа хуучин том болт барьсан байлаа. Гермiona номоо цүнхэндээ болгоомжтой хийгээд тэр гурав номын сангаас ямар ч гэмгүй мэт алгуурхан гарч одлоо.

Тэд уйланхай Миртлийн жорлонд орж цоожлов. Рон эхлээд дургүйцсэн авч

Гермiona зүгээр, хэн тийшээ орё гэж яаж санах юм бэ? хэмээн уруу татжээ. Хэн ч саад болохгүй юм шиг санагдсан юм байлгүй. Үнэндээ ч Миртл урьдын адил бүхээгтээ цурхиран байсан авч тэр тэдэнд, тэд түүнд ямар хамаа байх билээ.

Гермiona «Хүчтэй үйлчлэгч уусмал» номыг болгоомжтойхон нээхэд андууд шарласан хуудас руу тонгойцгоов. Номыг зүгээр ч нэг онцгой хэсэгт хадгалдаггүй аж. Зарим уусмал үнэхээр аймшигтай үйлчилгээтэй аж. Толгой дээрээ гараа тавьсан хүн, шулмасын гэдэс дотрыг нь эргүүлсэн зургийн тухайд бол ярих ч юм алга.

- Энэ байна хэмээн Гермiona «Хувиргах уусмал» гэсэн гарчигтай хуудсыг олоод баярлан хэллээ. Эргэн хувирах дүр төрх тэр хуудсан дээр зураатай байв. Хүмүүсийн зовж шаналсан царай бол зураачийн сэтгэмж гэж Харри үнэхээр найдахыг хичээж байв.

- Ямар хэцүү найрлагатай юм бэ! гэж Гермiona мөр дагуулан хуруугаараа заах зуураа хэллээ. Тэгээд:

- Алтан нүдэн цэцэг, хануур хорхой, замаг, мөөгөнцөр энэ бүхэн уусмал хадгалах зориулалт бүхий шүүгээнд бий. Бас хос эвэртийн үйрүүлсэн эвэр байна! Үүнийг хаанаас олох вэ? Бас бумслангийн арьс? Бас хувиргах хүнийхээ биеийн яльгүй хэсэг гэдгийг яах болж байна? гэлээ.

- Юу гэнээ? Ямар хэсэг болж таарах вэ? Би Крэббийн хумсыг залгих болж байна уу? гэж Рон үрчийн хэллээ.

- Аз болоход энэ хэсэг хамгийн сүүлд хэрэг болох юм байна гэж Гермiona түүнийг сонсоогүй дүр эсгэн ярина.

Рон Харрийг анзаарах байх гэж найдсан авч Харри өөр юманд санаа зовж байлаа.

- Гермiona минь, сонсооч. Ямар олон юм хулгайлах хэрэгтэй болж байна!

Бумслангийн арьс сургуулийн шүүгээнд байхгүй болохоор Снегг багшийн хувийн нөөц рүү орох хэрэг гарах нь ээ? Энэ чинь тун ч ...

Гермiona тэсгэл алдан номоо чанга хамшилаа.

- За, за дураараа л болцгоо. Та нар айгаад бйгаа юм бол би ч бас сургуулийн дүрэм журам зөрчөөд байх хэрэг алга. Харин хөөрхий маглуудыг өөрөөр яаж аврах юм бэ? Уусмал бол аврах цорын ганц арга. Тэдний дайсан та нарт хамаагүй гэдэг нь илт байна. Би одоохон энэ номыг эргүүлж өгье ... гэж хэлэхдээ Гермionaгийн хацар түмбийж, нүд нь гялалзаж байв.

- Хачин юм даа! Гермiona өөрөө биднийг сургуулийн дүрэм журмыг зөрч гэж байх шив. Тийм аваас би юу ч хийхэд бэлнэ байна ... Гэхдээ хумс залгихгүй бол зүгээр сэн! гэж Рон гараа савчин хэлэв.

Гермiona тайвшраад номоо дахин дэлгэлээ.

- Тэр уусмалыг бэлтгэхэд удах болов уу? гэж Харри асуув.

- Замгийг тэргэл сартай үед түүдэг юм. Алтан нүдэн цэцэг гурван долоо хоногт уусна. Тэгэхээр хэрэгтэй бүх зүйлийг цуглуулах юм бол бараг нэг сар гэсэн үг.

- Нэг сар гэнээ? Нэг сарын дотор Малфой маглуудын тэн хагасыг зовоох байлгүй! За яахав, нэгэнт өөр төлөвлөгөө байхгүй болохоор урагшаа! гэж хэлэхээс өөр арга алга гэж Роныг хашгиран хэлэхэд Гермionaгийн ширүүн харц арай зөөлөрлөө.

Гермiona ойр хавьд хүн байгаа эсэхийг шалгахаар жорлонгоос гарахад Рон хүү

Харрийн чихэнд:

- Маргааш Малфойг шүүрнээс нь унагчихаарай гэж шивнэжээ.

Бямба гаригийн өглөө Харри эрт сэрээд одоо болох тэмцээний тухай хагас цаг шахам бодлоо. Слизеринийхэн дэлхийн хамгийн хурдан шүүртэй. Гриффиндорынхон хожигдвол ахлагч нь яасан их уурлах бол! Энэ муухай Слизеринийхнийг яая даа байз! Харри сэтгэл тавгүй босоод хувцаслан өглөөний ундандаа явлаа. Их танхимын урт ширээний ард бүх багаараа чимээгүй авч өндөлзөн суух ажээ.

Тэр өдөр бүрхэг хэцүү одоохон аянга ниргэх гэж байгаа юм шиг байв. Үд дунд гэхэд сургууль даяараа цэнгэлдэх хүрээлэнд очжээ. Рон Гермиона хоёр Харрид амжилт хүсэхээр хувцасны өрөө рүү очлоо. Тоглогчид Гриффиндорын улаан жанч сольж өмсөж, Вуд урьдын адил багийнхаа тамирчдын сэтгэл санааг өөдрөг болгох үг хэлжээ.

- Слизеринийхэн сайн шүүртэй ч гэсэн манайх сайн тоглогчидтой. Бид бэлтгэл сургууль их хийж, ямар ч цаг агаартай үед нисэж сурсан даа (Есдүгээр сараас эхлээд л голдоо ортол норсон гэж Жорж үглэнэ). Малфой тэдний багт өөрийгөө худалдсан тэр өдрийг хараал идэх болтугай гээд Вуд Харрид хандан:

- Харин чи тэдэнд үзүүлээд өгөөрэй. Баригч болоход баян эцэг бус авъяас хэрэгтэй гэдгийг харуулах юм шүү. Гэмтэж бэртсэн ч хамаагүй Малфойгоос түрүүлж снитчийг барих ёстой. Өнөөдөр бид ялах болно! гэлээ.

- Ямар нэг юм болбол бид хажууд чинь байгаа гэж Фред нүд ирмэн хэлжээ.

Үзэгчид Гриффиндорынхныг хөөрч баясан хашгирсаар угтлаа. Тэднийг өөрийн төдийгүй Когтевран, Пуффендуйн хөгжөөн дэмжигчид дэмжиж байсан юм. Слизеринийхэн дуугүй суусангүй. Тэд эсрэг багийнхныг шүтэлдэж, орилон угтжээ. Шүүгч хатагтай Нугарагч Флинт Вуд хоёрыг гар бариулахаар урив. Тэр хоёр бие биеэ догшин харцаар харан гараа чанга атгацгаажээ.

- Шүглийн дуугаар! Гурав ... хоёр ... нэг ... гэж хатагтай Нугарагч хашгирлаа. Хүмүүсийн хашгиралдах чимээн дор арван дөрвөн тоглогч бараан тэнгэрт дүүлжээ.

Харри нүдээ онийлгон снитчийг олж харах санаатай мэрийсээр бүхний түрүүнд довтолгоно.

- Хөөе, сорвит оо! гэж Малфой хашгираад шинэ шүүрээ унан бардам явж өнгөрлөө.

Харри хариу хэлсэнгүй. Түүний зүг том хар бөмбөг нисэн ирэхэхд арай л оногдсонгүй бултаж амжлаа. Бүр үсийг нь шүргэх шахжээ.

- Арай л оночихсонгүй гэж Жорж хашгираад Харрийн дэргэдүүр өнгөрөхдөө цохиураараа бөмбөгийг хүчтэй цохин Эдриан Пьюсийн зүг илгээсэн авч замын хагасаас бөмбөг дахин эргэж Харрийн зүг нислээ.

Харри хурдаа огцом саахад Жорж байдаг хүчээрээ блажерыг Малфой руу цохив. Гэвч бөмбөг яг л өөрөө эргэгч мод шиг буцан ирж Харрийг оносон хэдий ч аз болоход зөөлөн цохижээ.

Харри хурдаа нэмж талбайн нөгөө тал руу дүүлэхэд бөмбөг шуугин араас нь дагана. Юу болоод байна? Дүрэм ёсоор бол блажер нэг хүнийг дагаад байлгүй аль болох олон хүнийг онох ёстой сон.

Талбайн нөгөө талд бөмбөгийг Фред Уизли хүлээн авлаа. Харрийг тонгойход Фред байдаг чадлаар бөмбөгийг цохин холдуулав.

- Ура! гэж Фред ялсан дүртэй хашгирлаа.

Тэгтэл бас л болсонгүй. Дуулгаваргүй бөмбөг Харрийг ахиад л элдэхэд зугтаахаас өөр аргагүй болжээ.

Бороо орж эхлэлээ. Бороон дусал нүүр ороолгон, нүдний шилийг цантуулна. Тэмцээнд аль баг давамгайлж байгааг Харри мэдээгүй байтал тайлбарлагч Ли Жордан:

- Жар тэгийн харьцаагаар Слизерин хожиж байна гэж хашгирах дуулав. Гайхаад байх юм алга. Тэдний шүүр илүү хурдан, тэгээд ч энэ бөмбөг түүнийг галзуурсан юм шиг элдээд байхад. Үнэндээ ихрүүд түүнийг сайн буцааж байсан авч нэмэр бага ажээ. Эргэн тойрон нисэж цохиураараа даллаж байхад снитчийг олж харах аргагүй юм.

- Энэ бөмбөгийг ... хэн нэг нь ... илбэдчихжээ гэж Фред нөгөө бөмбөгийг Харригаас холдуулан цохих үедээ амьсгаадан хэлэв.

- Завсарлага авцгаая гэж Жорж хэлэх зуураа Вудэд дохио өгөх гэж мэрийн, бас Харрийн нүүр лүү нисэн явах бөмбөгийг буцаан цохилоо.

Вуд зөвшөөрөн толгой дохиж, шүүгчийн шүгэл дуугарахад Харри, ихэр хоёрын хамт галзуурсан блажераас бултан Слизериний хөгжөөн дэмжигчидийн чих дүлийрүүлэм шүгэлдэхийг сонсон газар луу тэмүүлэв. Вуд бүх багийнхныгаа тойруулан зогсоогоод:

- Юу болоод байна? Ингээд байвал амархан хожигдохоор байна шүү! Фред, Жорж хоёр яагаад Анжелинад туслахгүй байгаа юм бэ? Тэр чинь оноо авах сайхан боломжтой байсан шүү дээ! Та нар хаана байв аа? гэлээ.

- Бид түүнээс арван таван метрийн өндөрт байсан, Оливер оо! Харрийг алах шахсан блажераас аварсан юм. Энэ бөмбөгийг илбэдчихжээ. Харригаас огт

салахгүй байна. Бөмбөгийн хувьд өөр тоглогч гэж алга. Энэ бол

Слизеринийхний хийсэн ажил байлгүй! гэж Жорж омогдов.

- Дэмий юм! Бэлтгэл дээр бүгд л зүгээр байсан даг. Тэгээд бүх бөмбөгийг цоожилсон юм чинь ... гээд Вуд итгэсэнгүй.

Хатагтай Нугарагч талбай дундуур тэдний зүг ирж явна. Ард нь Слизериний тоглогчид нүүр амаа элдэвлүүлэн инээлдэж, Харрийг хуруу гараараа заах ажээ.

- Тойрон байрлацгаая. Хэрэв та хоёр миний урдуур бөртгөнөөд байвал би снитчийг хэзээ ч барьж чадахгүй. Снитч өөрөө л ханцуйд ороод ирдэггүй юм бол. Бусдыгаа хамгаал. Харин бөмбөгтэй би өөрөө учраа олохыг бодъё гэж Харри сэтгэл догдлон хэллээ.

- Тэнэг хэрэг. Бөмбөг чиний толгойг тасдана гэж Фред эсэргүүцэв. Вуд ахлагч Харри болон ихэр хоёрыг харлаа.

- Оливер чи түүний хэлснийг яагаад сонсохгүй байна? Түүнийг дангаар нь тийм бөмбөгтэй үлдээж болно гэж үү?! Заавал мөрдөн шалгах хэрэгтэй ... гэж Алиса Спиннет уурлав.

- Тэгвэл оноо алдана. Энэ муу бөмбөгөөс болоод тэмцээнд хожигдох нь дутаж гэнэ. Оливер чи тэдэнд намайг орхи гэж хэл.

- Үүнд чи буруутай «Гэмтэж бэртсэн ч хамаагүй снитчийг барь» гээ биз дээ.

Үүнээс арай дээр юм бодож олж чадсангүй дээ! гэж Жорж Вудыг буруутгалаа.

Хатагтай Нугарагч хүрч ирэв.

- Бэлэн үү?

Вуд Харрийг хараад ямар ч байсан ялах зүрх зориг дүүрэн байгааг мэдлээ.

- Фред, Жорж та хоёр Харрийг орхиорой. Өөрөө блажерын учрыг олно биз. Бороо улам ширүүссээр. Шүүгчийн шүгэлдэх дуунаар Харри тэнгэрт хөөрөхдөө

блажер араас нь агаарт сүнгэнэн нисэж явааг сонслоо. Харри улам өндөрт хөөрснөө доош чулуу шиг нисэн, зүгээ буруулж ийш тийшээ тойрон нисэж байв. Бүр толгой нь эргэж байсан ч сайтар харсан хэвээр! Шүүрээ унасан хэвээр годройтон нисэх үед борооны дусал шилийг нь балбан, хамар луу нь урсан орж байлаа. Үзэгчид суудал дээрээ алга ташин инээлдэх аж. Сайн нисэгч! Харрийн цорын ганц аврал энэ байсан бөгөөд бөмбөг түүнийг яг дагаж чадахгүй байв. Харри яг л «Америкийн уулс» дээгүүр явах мэт талбай дээр дүүлж, Эдриан Пьюсийг нүднийхээ булангаар ажиглана. Тэр хүү Вудыг гүйцэж Гриффиндорын нэг цагаригт хүрэхээр тэмүүлж байв.

Бөмбөг чихний нь хажууханд шуугиснаа ахиад л онсонгүй. Харри арагш зугтаахад бөмбөг бас л дагасан авч, тэрбээр ээрүүл шиг эргэлдлээ.

- Поттер чи бүжгэн жүжгээр хичээллэж байгаа юм уу? гэж Малфой хашгирав.

Харри хажуу тийшээ нисэх зуураа Малфой руу эргэж үзэн ядсан байдалтай харжээ. Түүний зүүн чихний дээхэн талд алтан снитч үзэгджээ. Малфой инээд алдан снитчийг харахтай манатай байлаа.

Харри байрандаа хөшчихлөө. Малфой гэнэтхэн толгойгоо өргөөд түрүүлж баривал яанаа!

Гэнэтхэн тас няс!

Бөмбөг ямар ч байсан түүнийг онож баруун гарыг нь хугалчихлаа. Гар нь өөрийн мэдрэлгүй унжлаа. Гол тасартал өвдөхөд Харрийн нүд харанхуйлжээ. Тэрбээр нойтон шүүрэн дээрээсээ золтой л гулсаад уначихсангүй. Нөгөө муухай бөмбөг бас л эргээд Харрийн толгойг чиглэн нисэв. Харри бултсан авч толгойд нь: «Снитч, снитч ...» гэсэн бодол эргэлдэнэ.

Борооны дусал, өвдөх гараа тоолгүй Харри Малфойн зүг хурдаллаа. Түүний шоолонгуй царай айсан төрхөөр солигдов. Харри түүнтэй үзэлцэх гэж байгаа юм шиг түүнд санагджээ.

- Чи яаж байнаа! гэж Малфой орилоод хажуу тийш бултан нислээ.

Харри шүүрээ тавиад эрүүл гараа сарвайн нойтон хүйтэн снитчийг шүүрэн авав. Өвдгөөрөө шүүрээ хавчин тогтоогоод, ухаан алдахгүйг хичээн доош унаж эхлэлээ. Үзэгчид айсан байдалтай дуу алдана.

Харри шаварт унахад хугархай гар нь санжиганаж, шүүр нь өөр тийш нисэн одлоо. Үзэгчид суудал дээрээ орилон шүгэлдэхэд айхтар өвдсөндөө болоод хөгжөөн дэмжигчид өчнөөн хол байх шиг түүнд санагджээ. Тэгэхэд л Харри гартаа алтан снитч байгааг мэдэрлээ.

- Хожсон шүү гэж арайхийн хэлээд ухаан алджээ.

Тэгээд мөн л талбай дээр ухаан оров. Бороо нүүр лүү нь цутган, хэн нэгэн хүн дээрээс нь тонгойн инээмсэглэх ажээ.

- Та байгаа юм уу? Холдвол дээр дээ гэж Харри шивнэв.

- Энэ маань яаж байнаа? Сандрах хэрэггүй. Би одоохон түүнийг эмчилнэг гэж

Туг үс түүнийг тойрон хүрээлсэн Гриффиндорынхныг харан хэллээ.

- Хэрэггүй ээ! Ингээд л байж байг ... хэмээн Харри татгалзав.

Харри суух гэсэн ч тэсвэрлэшгүй өвдсөн болохоор чадсангүй. Тэгтэл гэрэл зургийн дуран тачигнаж гарлаа.

- Колин намайг ийм байхад зураг авч яах нь вэ? гэж Харри эсэргүүцнэ.
- Хэвт, хэвт. Би одоохон шившлэг уншина. Айх явдалгүй, би ийм юм анх үзэж байгаа биш хэмээн Туг үс халамжтай нь аргагүй зөвлөв.
- Би эмнэлэгт очвол дээр байхаа гэж Харри зуусан шүднийхээ завсраар сийгүүлэн хэллээ.
- Тийм шүү, профессор оо. Харри чи бөмбөгийг сайн барилаа. Ёстой сайхан гэж Вуд инээмсэглэн хэлжээ. Хэдийгээр баригч нь гэмтсэн ч тэд ялсан юм чинь аргагүй ээ.

Фред, Жорж хоёр солиорсон блажерыг хайрцагт хийх гэхэд бөмбөг яаж эсэргүүцэн байхыг Харри хүүхдүүдийн хөлийн хоорондуур харжээ.

- Эндээс холдоорой гэж Туг үс хэлээд ногоон ханцуйгаа шамлаж байна.
- Хэрэггүй юм биш үү ... гэж Харри санаа алдлаа.

Гэхдээ Туг үсийг зогсооно гэж байхгүй л дээ! Тэрбээр шидэт саваагаа эргүүлж байснаа шууд хугарсан гар луу чиглүүллээ.

Гараас нь агаар соруулаад авчих мэт мөрнөөс нь эхлээд хурууны үзүүрийг хүртэл нэг л сонин боллоо. Харрийг нүдээ анин эргэхэд хүүхдүүдийн нэг нь дуу алдаж, Колин Криви гэрэл зургийн дурангаа шүршдэг буу шиг тачигнуулж байв. Гар нь өвдөхөө больжээ. Харри гар байгаа үгүйг ч мэдэхгүй байлаа.

- М-м. За, зүгээр ээ. Ийм болдог юм. Гэхдээ одоо хугарсан яс байхгүй! Энэ л чухал. Эмнэлэг хүрчихэж дөнгөнө биз дээ? Ноён Уизли, хатагтай Грэйнджер хоёр түүнийг хүргэж өгөөрэй. Тэнд хатагтай Помпфри ... хэвд нь оруулах байлгүй гэж Туг үс сэтгэл зовсон байдалтай хэлэв.

Харри хөл дээрээ босоход өрөөсөн тал нь байхгүй мэт санагдана. Тэрбээр гүнзгий амьсгал авснаа гараа хараад эгээтэй л ухаан алдчихсангүй.

Ханцуйнаас нь түүхий махтай адил өнгөтэй, үлээсэн хаймран бээлий шиг юм цухуйх ажээ. Харри хуруугаа хөдөлгөх гэтэл огт болсонгүй!

Туг үс хугархайг эмчилсэнгүй, зүгээр л гарын бүх ясыг мултлаад авчихсан ажээ. Хатагтай Помфри Харрийн гарыг үзээд уурлаж гарлаа.

- Шууд л наашаа хүрээд ирэх хэрэгтэй байсан юм. Яс бороолуулах амархан, харин шинэ яс ургуулна гэдэг ... хэмээн хэлээд ясгүй зөөлөн гарыг тэмтрэн үзнэ.
- Гэхдээ та чадна биз дээ? гэж Харри найдангуй асуулаа.

- Чадалгүй яахав. Харин их өвдөнө гэдгийг хэлэх хэрэгтэй. Залуу минь, чи энд л унтах хэрэг гарч дээ ... хэмээн хатагтай Помфри халамжлангуй байдлаар хэлээд Харрид хүрэм авч өглөө.

Гермиона хөшигний цаана хүлээж, Рон хүрэм өмсөхөд нь Харрид туслаж байв. Ясгүй гар ханцуйд орно гэдэг бэрх.

- Одоо чи Туг үсийг хамгаалсаар байх уу? гэж Рон Гермионаг тавлангаа Харрийн пэмбэгэр хурууг арайхийн ханцуйд шургуулав. Тэгээд:

- Туг үсийг ясгүй болгоод аль гэж гуйгаагүй л юм сан гэлээ.

- Алдахгүй хэн байдаг юм бэ? Ямар ч атугай гар өвдөхөө больсон байна. Тийм биз дээ, Харри? гэж Гермиона татгалзана.

- Тийм ээ. Гэхдээ энэ чинь одоо гар биш.

Харри дэвсгэр дээрээ үсрэхэд хөөрхийлөлтэй гар нь мэдрэлгүй санжиганана. Гермиона хатагтай Помфри хоёр хөшигний цаанаас гарч ирлээ. Эмч гартаа «Яс ургуулагч» гэсэн бичигтэй лонх барьжээ.

- Чи ч урт шөнийг өнгөрөөх хэрэг гарах нь дээ. Яс ургуулна гэдэг тийм ч сайхан ажил биш дээ гэж хэлээд аяга дүүрэн уусмал Харрид өглөө.

- «Яс ургуулагч» уух ч бас амаргүй, хоолой ам түлчих гээд байв. Харри нэг балгаад ханиалгалаа. Хатагтай Помфри аюултай спорт, чадваргүй багш нарын тухай нэг юм үглэсээр холдов. Рон Гермиона хоёр Харритай үлдээд нөгөө эмийг усаар даруулж уулгалаа. Тэгэхгүй бол тун ч муухай эд юм.

- Бид ямар ч байсан хожсон шүү. Чи снитчийг мөн сайхан барьсан даа!

Малфойг тэгэхэд харсан ч болоосой ... Чамайг тасдан хаяхад бэлэн байсан гэж хэлээд Рон инээмсэглэв.

- Тэр бөмбөгийг чухам яаж илбэдсэнийг мэдэх юм сан гэж Гермиона хөмсөг өргөн хэллээ.

- Хувиргах уусмалаа бэлдчихээд зориуд асуух юм шүү. Харин уусмал маань энэ эм шиг муухай юм бүү байгаасай гэж хэлээд Харри дэрэн дээр толгойгоо тавив.

- Ярих юмаа олов оо! Слизеринийхний хумстай уусмал гээд л бодчих хэмээн

Рон ярвайна.

Тасгийн үүд нээгдэн шавар шавхай болж, голдоо ортол норсон Гриффиндор багийнхан бүгдээрээ орж ирлээ.

- Хөөе Харри! Жинхэнэ нисгэгч! Чи Малфойг Флинтэд загнуулж байхыг харсан ч болоосой. Снитч яг чихний нь хажууд байхад хардаггүй гэнээ. Хөөрхий амьтан номхорсон доо гэж Жорж баясангүй байдалтай ярина.

Хүүхдүүд авчирсан амттан бялуу хулууны шүүсээ Харрид өгч тойрон суутал:

- Энэ чинь юу болж байнаа? Өвчтөн амрах хэрэгтэй. Түүнд гучин гурван яс ургуулах ёстой юм. Явцгаа! Явцгаа! Эндээс явцгаа! гэж уурлан хөөлөө.

Ингээд өвдөж шаналсан Харри цор ганцаараа үлджээ.

Хоёр цагийн дараа Харри харанхуйн дунд сэржээ. Гарыг нь хурц юмаар хатгах шиг санагдана. Гэхдээ Харри өвдсөндөө сэрээгүй юм. Хэн нэгэн хүн харанхуйд түүний духыг арчсан ажээ. Харри айсандаа чичирч байв.

- Хэн бэ? Добби та юу?! гэж тэрбээр хашгирлаа.

Гэрийн үйлчлэгч одон бөмбөг шиг том нүдээр Харрийг өрөвдөлтэй ширтэн байхад урт унжгар хамрыг нь даган нулимс урсана.

- Харри Поттер ахиад л сургуульдаа орчихож. Добби уул нь Харри Поттерт сануулж хэлсэн л юм сан. Сануулсан шүү дээ! Ноёнтоон та яагаад Доббийн үгэнд орсонгүй вэ? Харри Поттер галт тэрэгнээсээ хоцорсон мөртөө яагаад гэртээ харьсангүй вэ? гэж Добби шивнэнэ.

Харри суугаад гэрийн үйлчлэгчийн гарыг түлхэв.

- Та энд яаж ирсэн юм бэ? Галт тэрэгний тухай яаж мэдсэн бэ? гэж асуулаа. Доббийн уруул чичигнэнэ. Харри гэнэтхэн ухаарч:

- Аа, та байсан юм уу?! Та биднийг хаалт нэвтрүүлээгүй юм байна!

- Тийм ээ, би. Добби нууцаар Харри Поттерыг харж байгаад галт тэрэг рүү орох орцыг тарнидчихсан юм. Үүнийхээ төлөө Добби гартаа огт харамсахгүй, ноёнтоон. Добби өөрөө Харри Поттерыг аюулаас аварч байна л гэж бодсон. Харри Поттерыг сургуульдаа машинаар нисээд очно гэж Добби бодсонгүй гэж тэрбээр ярихад чих нь далбаганаж байлаа. Бас боолттой гараа түүнд харуулжээ.

Гэрийн үйлчлэгч инээдэмтэй толгойгоо сэгсрэн хойш, урагш холхино.

- Харри Поттер сургуульдаа буцаж ирснийг мэдээд Добби их гайхсан. Бүр эзнийхээ хоолыг хүртэл түлчихсэн. Ноёнтоон минь, Доббийг ёстой балласан даа, жинхэнэ балласан ...

Харри дэрэн дээрээ ойчлоо.

- Танаас болоод Рон бид хоёрыг сургуулиас эгээтэй л хөөчихсөнгүй. Эндээс явж үз. Миний яс мөдхөн ургаад гүйцэхээр надад муу юм хийх аваас би таныг хөнөөх болно гэж Харри уурлан хэллээ.

Добби гунигтай инээмсэглэж:

- Доббийг ална гэж дандаа л хэлдэг юм. Эзэд маань Доббийг ална гэж өдөрт таван удаа заналхийлдэг гэлээ.

Тэгээд гэрийн үйлчлэгч бохир дэрний уутныхаа нэг буланд нусаа нийв. Түүний дүр төрх тун өрөвдмөөр байсан учир Харри өөрийн эрхгүй уурлахаа болиод:

- Добби, та яагаад энэ дэрний уутыг өмсөж явдаг юм бэ? гэж сонирхов.

- Дэрний уут уу, ноёнтоон? Энэ бол боолын тэмдэг, ноёнтон минь. Хэрэв эзэн нь түүнд хувцас бэлэглэх аваас Добби эрх чөлөөтэй болох юм. Гэвч тэд тун болгоомжтой. Доббийг бүр явчихна гэж айгаад Доббид оймс ч өгдөггүй юм гэж дэрний уутаа илэн хэллээ.

Добби нулимсаа арчсанаа гэнэтхэн:

- Харри Поттер гэртээ харих ёстой! Добби бодохдоо бөмбөг ... гэтэл:

- Бөмбөг өө? Бөмбөг намайг алах шахсан маань тантай холбоотой байх нь ээ?

гэж Харри ахин уурсаж асуулаа.

- Та яаж байнаа! Бөмбөг таныг алахгүй шүү. Добби болохоор Харри Поттерыг аврах гэсэн юм. Ноёнтон минь энд үлдсэнд орвол гэртээ тахир дутуу болж харьсан чинь дээр. Харри Поттер гэртээ харих ёстой гэж гэрийн үйлчлэгч айсан байртай хэлэв.

- Яагаад ч үгүй! Гэхдээ яагаад ингэх болсноо ярьж өгөөч. Яагаад намайг тахир дутуу болгох гэсэн юм бэ? гэж Харри асуулаа.

- Ай, Харри Поттер үүнийг мэддэг ч болоосой гэж Добби санаа алдан хэлэхэд нулимс нь урсан дэрний уутанд шингэнэ. Тэгснээ:

- Хэрэв ид шидийн ертөнцийн тасархай болсон золгүй боол бидний хувьд чухам хэн гэдгээ мэддэг бол ингэхгүй л дээ. Хэцүү нэртийн ноёлж байсан үеийг Добби санадаг юм. Гэрийн үйлчлэгч бидэнтэй яг л харх, жоом шиг харьцдаг байсан даа, ноёнтон минь. Доббитой одоо ч тэгж харьцдаг нь үнэн. Гэхдээ Хэцүү нэртийг та ялсан цагаас хойш амьдрал арай дээр болсон. Хар ноёнтон хамаг хүчээ бараад Харри Поттер амьд үлдсэн юм. Энэ бол бидний хувьд үүрийн туяа гэсэн үг. Харри Поттер найдварын гэрэл цацруулж байна ... Хар өдрүүдийн төгсгөл ирэх л байх гэж бодох юм ... Харин одоо Хогвартсад ахиад л аймшигт явдал давтагдахад бэлэн төдийгүй аягүй бол эхэлчихсэн дээ. Тэгээд л Добби Харри Поттерыг энд үлдээж болохгүй гээд байгаа юм ... Нууц өрөө дахин нээгдсэн болохоор аюул давтагдаж магадгүй гэж хэлээд гэрийн үйлчлэгч дэрний уутаараа нулимсаа арчлаа.

Добби хэтэрхий их юм ярьсанаа гэнэт ойлгоод айсандаа дуугүй болчихов. Шургуулган дээрээс домботой ус аваад нүднээсээ оч бутарч шалан дээр унатал толгойгоо цохилоо. Тэгээд ахиад л орон дээр гарч ...

- Добби муу, маш муу ... гэж үглэнэ.
- Тэгэхлээр нууц өрөө үнэндээ байдаг байх нь ээ? Түүнийг нэгэн цагт нээгдсэн гэж та хэлэв үү? гэж Харри гайхлаа.

Гэрийн үйлчлэгч домбоны хагархай авахаар сарвайсан авч Харри нарийхан шуун дээрээс нь барин хорьж энэ удаа өөрийгөө шийтгэхээс аварчээ.

- Би магл биш болохоор надад аюулгүй Добби минь.
- Ноёнтон минь, бүү асуу, хөөрхий Доббигоос бүү асуу. Энэ сургуульд хар үйл болох гэж байна. Харри Поттер явах ёстой. Явж үз, ноёнтон минь, гэртээ харь. Энд дэндүү аюултай болохоор яарах хэрэгтэй ... гэж гэрийн үйлчлэгч түгдрэн хэллээ.
- Добби минь, нууц өрөөг хэн нээсэн юм бэ? Надад хэн гэдгийг нь хэлчихгүй юу? гэж хэлээд Харри түүнийг ахин өөрийгөө шийтгэхээс сэргийлэн гарыг нь барьж байв.
- Добби хэлж болохгүй, ноёнтон минь. Добби хэлэх ёсгүй! Гэртээ харь, ноёнтоон, явж үз гэж гэрийн үйлчлэгч орилно.
- Би хаашаа ч явахгүй. Миний сайн андуудын дотор магл охин ч бий. Хэрэв үнэхээр нууц өрөө онгорхой юм бол хамгийн түрүүлээд түүнд муу юм болно ... гэж Харри уурсангүй хэлэв.

Харри Поттер найз нарынхаа төлөө амиа золиослоход бэлэн байна! Юутай зоригтой! Ямар эрэлхэг хүү вэ! Гэхдээ тэр өөрийгөө аврах ёстой. Харри Поттер бол ... хэмээн гэрийн үйлчлэгч дуу алдлаа.

Тэгснээ гэнэт үгээ таслан чих тавин чимээ чагнахдаа сарьсан багваахайтай адил харагдана. Хонгилд хөлийн чимээ гарчээ.

- Добби явах ёстой гэж гэрийн үйлчлэгч айн шивнээд түүний атгасан гарыг хоосон орхиж, шар шур хийсэн чимээ гарган алга боллоо.

Харри дэрээ налан хэвтээд үүд рүү түгшин харна. Хөлийн чимээ улам ойрсоор.

Тасагт урт ноосон нөмрөг, шөнийн угладаг малгай өмссөн Дамблдор, араас нь профессор МакГонагалл орж ирлээ. Тэд нэг хөшөө шиг юм дамжлан авчирч сул орон дээр тавив.

- Явж хатагтай Помфрийг олоод ир гэж Дамблдор шивнэн хэллээ.

Профессор МакГонагалл Харрийн дэргэдүүр өнгөрөн өрөөнөөс гарав. Харри унтаж байгаа мэт хөдөлгөөнгүй хэвтэнэ. Тэгтэл түгшсэн дуу гарч, профессор МакГонагаллын хамт хатагтай Помфри орж ирээд унтлагын хувцсан дээгүүрээ цамц давхарлан өмслөө. Хатагтай Помфри хөшөөг харснаа уулга алдав.

- Юу болсон юм бэ? гэж Дамблдороос шивнэн асуугаад нөгөө хөдөлгөөнгүй юмыг тонгойн харжээ.

- Шинэ дайралт. Минерва МакГонагалл профессор бид хоёр түүнийг шатан дээрээс оллоо гэж захирал тайлбарлав.

- Хажууд нь баахан усан үзэм асгарсан байсан. Поттерыг эргэж гэж явж байсан юм байлгүй дээ гэж профессор МакГонагалл нэмж хэллээ.

Харрийн дотор арзасхийж, тэрбээр сэмхэн өндийгөөд сарны гэрэлд туяарах хөшөөний нүүр царайг харав.

Энэ бол Колин Криви байлаа. Колины нүд айсандаа дүгрэглэн, гартаа гэрэл зургийн дуран барьжээ.

- Хөшөөх тарни уу? гэж хатагтай Помфри асуув.

- Тийм ээ. Ийм юм болох гэж ... Альбус халуун шоколад авчрахаар доош яваагүй бол юм болохыг хэн мэдлээ ... гэж профессор МакГонагалл хэллээ.

Тэр гурав Колиныг харж зогсоно. Дамблдор багш тонгойн гэрэл зургийн дуранг лавхан бариад Колины гараас суга татан авлаа.

- Дайрсан хүний гэрэл зургийг авч амжсан юм биш биз? гэж профессор МакГонагалл асуув.

Дамблдор дурангийн тагийг автал утаа баагин гарлаа. Бүр гурван орны цаана хэвтэж байсан Харрид шатсан хальсны үнэр үнэртжээ. Хатагтай Помфри нэг алхам ухраад аргаа барсан байдалтай:

- Хайлуулчихсан байна ... гэж шивнэлээ.

- Энэ юу гэсэн үг вэ, Альбус аа? гэж профессор МакГонагалл асуув.

- Нууц өрөө үнэхээр нээлттэй гэсэн үг дээ гэж Дамблдор хариулжээ.

Хатагтай Помфри айсандаа алгаараа амаа таглав. Профессор МакГонагалл Дамблдорыг асуусан янзтай харна.

- Хэн байх вэ, Альбус аа? ...

- Хэн гэдэг нь гол биш яаж гэдэг нь л чухал ... гэж Дамблдор захирал Колиноос нүд салгалгүй хэлэв.

Гэрэл асаагаагүй ч Харри профессор МакГонагаллын царайг харсан аж. Түүний царайд үл ойлгосон байдал тодорхой байлаа.

БҮЛЭГ 11: ХАЛЗ ТУЛААНЫ КЛУБ

Харри ням гаригын өглөөгүүр сэрэхэд гарын яс нь бороолсон хэдий ч муу хөдөлж байлаа. Цонхны цаана өвлийн наран гэрэлтэнэ. Харри орон дээрээ сандайлж суугаад Колины хэвтэж буй орыг хөшгөөр тусгаарласныг харжээ. Хатагтай Помфри түүний сэрснийг мэдмэгцээ өглөөний цай унд авчирахад Харри солгой гараараа будааг эв хавгүйхэн халбагадаж бйав. Нөгөө гараа атгаж, тэнийлгэж үзэхэд хуруунууд нь тус тусдаа хөдлөх ажээ.

- Чи эрүүл болсоон. Өглөөнийхөө цайг уугаад явж болно хэмээн хатагтай Помфри хэлэв.

Харри яаран хувцаслаад Добби, Колин нарын тухай андууддаа ярихаар Гриффиндорын шилтгээн рүү гүйжээ. Гэвч Рон Гермиона хоёр их танхимд байхгүй байв. Тэд хаашаа алга болчихов оо? Харрийн гар яаж байгаа нь тэдэнд сонин бус гэж үү?

Харри хонгилд гартал номын сангаас ирж яваа Перси Уизлитэй тааралджээ.

- Сайн уу, Харри. Өчигдөр чи маш сайн тоглосон шүү, маш сайн! Тавин оноогоор шагнуулсан! Одоо тэнхим хоорондын тэмцээнийг Гриффиндор хошуучилж явна гэж ахлагч таатай инээмсэглэн хэлэв.

Харри толгой дохиод:

- Чи Рон, Гермиона хоёрыг харсан уу? гэж асуулаа.

- Үгүй ээ. Роныг ахиад л охидын жорлонд орчихоогүй байх гэж найдъя хэмээн Перси царайгаа түвшин болгож хэлэв.

Харри Персийг булангийн цаагуур ортол инээмсэглэн зогсож байгаад шууд тийшээ гүйлээ. Ойр хавьд хүн байгаа эсэхийг тойруулж харснаа уйланхай Миртлийн хоргодох байр луу ухасхийн ороод андуудынхаа дууг сонслоо.

- Би байна гэж тэрбээр хэлээд хаалгаа сайтар хаав.

Нэг өрөөнд юу ч юм унахад ус цалгих чимээ гарч Гермиона уулга алдан жижигхэн завсраар харлаа.

- Өө, чи биднийг айлгачихлаа. Хурдхан ор. Гар чинь яаж байна?

- Шинэ юм шиг л болсон гэж Харри хэлээд бүхээгт оров.

Суултуур дээрх хуучин, муу тогооны дор ямар нэг юм шажигнана. Харри гал юм байх даа гэж бодов. Усыг огт тоодоггүй бяцхан тогоо бол Гермионагийнх. Харри үүдээ арайхийн хаав. Давчуухан боловч аюулгүй бүхээг ажээ.

- Бид өглөөний цайны дараа л шууд чам руу очъё гэж бодож байлаа. Тэгснээ сүүлдээ хувиргах уусмалаа оролдъё гэж шийдсэн юм гэж Рон тайлбарлав.

Харри Колины тухай ярьж эхэлтэл Гермиона дундуур нь оржээ.

- Бид бүгдийг мэднэ. Өглөөгүүр МакГонагалл багшийг профессор Флитвиктэй ярьж байхыг сонссон юм. Тэгээд л уусмалаа хурдан бэлтгэх хэрэгтэй гэж бодлоо.

- Энэ бүхний ард Малфой байгаа эсэхийг хурдхан мэдэх хэрэгтэй. Малфой тэмцээний дараа их уурласан даа. Тэгээд л Колинийг дөнгөсөн байх гэж Рон хөмсөг зангидан хэлэв.

- Энэ ч бас бүгд биш ээ. Шөнө Добби над дээр хүрч ирсэн гэж ярих зуураа уур савсах тогоонд хэсэг хэсэг мөөгөнцөр хийж байгаа Гермионаг ажиглана.

Сөхрөн суусан Рон, Гермиона хоёр гайхан толгойгоо дээшлүүлэв. Харри Доббийн хэлснийг дэлгэрэнгүй яриад өөрийнхөө бодол саналыг ч нэмэрлэжээ. Тэрбээр Доббийг зарим юмыг яриагүй гэж бодсон аж.

- Урьд нь нууц өрөөг хэн нэгэн хүн онгойлгож байсан болов уу? гэж Гермиона асуув.

- Байж болох л юм! Тэр нэгэн удаа өрөөг Люциус Малфой онгойлгосон. Тэр чинь бас Хогвартст сурч байсан шүү дээ. Тэнд ямар юм байгааг л мэдэх юм сан. Хэн ч түүнийг олж харахгүй юм гэж үү? Тэр амьтан шилтгээн даяар түйвэргээд байх шиг хэмээн Рон сэтгэл догдлон хэллээ.

- Үл үзэгдэгч амьтан байж болох юм. Эсвэл хувилгаан юм болов уу? Жишээ нь баатрын баримал болоод хувирчихдаг байж магадгүй. Би хувирдаг ороолонгийн тухай уншиж байсан гэж Гермiona хэлээд буцалж буй ус руу хануур хорхойг саваагаараа хийлээ.

- Бага унших хэрэгтэй шүү гэж Рон хэлэнгээ хатсан алтан нүдэн цэцгийг уусмалд хийгээд цаасан уутыг нь базаж хаясныхаа дараа Харрийг харснаа:

- Тэгэхлээр Добби биднийг галт тэрэг рүү оруулаагүй, бас чиний гарыг хугалсан болж таарах нь ээ. Хэрэв чамайг цашид иймэрхүү байдлаар аврах юм бол сайн юм болохгүй нь мэдээж гэж толгой сэгсрэв.

Даваа гариг гэхэд Колиныг хэн нэгэн хүн довтолж хөшөөчихөөд эмнэлэгт хэвтүүлсэн тухай яриа сургууль даяар тархжээ. Нэг нь нөгөөгөөсөө илүү аймшигтай байж боломгүй таавар дэвшүүлцгээнэ. Нэгдүгээр дамжааныхан довтолгоонд өртөж магадгүй гэж айгаад ганц нэгээрээ явахаа больжээ.

Жинни охин Колинтой нэг ширээнд суудаг байсан болохоороо бүр царай алдаж гүйцэв. Фред, Жорж хоёр түүнийг янз бүрээр айлгана. Нэг бол үс ноос болсон эсвэл шидэт булдруугаар дүүрсэн амьтан баримлын цаанаас үсрэн гараад ирнэ гэх мэт зүйлийг санаанаасаа зохиоцгооно. Үүнээс болоод охин шөнө хар даран зүүдэлдэг болжээ. Тэдний ингэж даажигнадгийг Перси мэдээд гэр лүүгээ захиа бичнэ хэмээн сүрдүүлсэн аж. Ах нар нь ч охин дүүгээ тэгтлээ дамшиглахаа болилоо.

Хүүхдүүд багш нараасаа нуун элдэв сахиус, онгон, шүтээн наймаалцгаана. Невилл Долгопупс нэг том болцуу сайтар зүлгэсэн улаан талст, шанаган хорхойны муудсан сүүл хадгалах болжээ. Түүнийг цэвэр цусны шидтэн болохоор яах ч үгүй гэж Гриффиндорынхон ятгаад нэмэр болсонгүй.

- Тиймээ, эхнийх нь Филч байсан. Намайг бараг сангасваа гэдгийг цөм мэднэ хэмээн Невилл айсандаа чичрэх бүлгээ.

Арванхоёрдугаар сарын хоёрдугаар долоо хоногт профессор МакГонагалл өвлийнхөө амралтаар сургуульдаа үлдэх хүсэлтэй хүүхдүүдийн нэрийг бичиж авчээ. Тэдний дотор Харри, Рон, Гермiona гурав байлаа. Тэд бас Малфой үлдэх болсныг дуулцгаажээ. Хэдийгээр сэжигтэй санагдсан ч хувиргах уусмалаа хэрэглэж, нууцыг нь мэдэж авахад хялбар байх биз.

Уусмал бараг бэлэн болжээ. Гагцхүү ганц эвэртийн эвэр, бумслангийн арьс л дутуу байв. Тэдгээрийг Снеггийн өрөөнд хадгалдаг юм. Харрийн бодлоор бол уусмал бэлтгэгч багшийн саварт орсноос нууц өрөөний гайхал амьтантай тулгарсан нь хамаагүй дээр ажээ.

- Анхаарлыг нь сарниулах арга бодож олох хэрэгтэй. Түүний хичээл үдээс хойш орно. Тэгэхэд л өрөөнд нь шургаж амжина гэж пүрэв гаригын өглөө Гермиона хэлжээ.

Энэ үгэнд Харри Рон хоёр гайхсангүй.

- Би хулгайлах болно. Хэрэв та хоёр баригдах аваас сургуулиас хөөгдөнө шүү дээ. Би одоохондоо хэрэг түвэг тарьчихаагүй байна. Та хоёрын үүрэг бол таван хором хэртэй бужигнуулах явдал гэж Гермиона тайван хэллээ.

Харри сэтгэл түгшин инээлээ. Снегг багшийн хичээл дээр үймүүлнэ гэнэ шүү! Энэ чинь үүрэглэж буй луугийн нүдийг саваагаар чичихээс ч долоон дор.

Уусмал бэлтгэх хичээл газар дор нэгэн багаахан танхимд болдог байлаа. Өнөөдрийн хичээл ч өмнөхөөсөө ялгарах юм байсангүй. Снегг багш хөөлгөгч уусмал бэлтгэх даалгавар өгчээ. Ширээн дээр төмөр жинлүүр, янз бүрийн юмтай сав суулга гялалзах агаад ширээнүүдийн хооронд өөрөө чанагч тогоо хөөрөн байв. Снегг багш Гриффиндорынхонд зэмлэсэн үг чулуудан анги дотуур холхиход Слизериний хүүхдүүд дэмжин инээлдэнэ. Снегг багшийн хайртай шавь Драко Малфой Харри, Рон хоёрыг загасны хатаасан нүдээр сэмхэн чулуудах ажээ. Хариу шидэх юм бол зайлшгүй шийтгүүлнэ гэдгээ тэр хоёр мэдэж байв.

Харрийн уусмал тун шингэн болчихжээ. Снегг багш түүний «ус»-ыг шоолон инээмсэглэхэд Харри хөмсөгөө ч хөдөлгөсөнгүй. Гермионагийн дохиог хүлээж байв. Снегг багшийг Невилл Долгопупс руу очих үед Гермиона толгойгоо үл мэдэг дохижээ.

Харри тогооныхоо ард хурдхан нуугдаад, халааснаасаа цаасан буу гаргаж ирээд саваагаараа асаалаа. Цаасан буу шуугиж байснаа оч хаялж эхлэхэд Харри түүнийгээ яг Гойлын тогоог чиглүүлэн шидчихэв.

Дэлбэрэх чимээ гарснаа Гойлын чанаж байсан уусмал ангиар дүүрэн асгарлаа. Хүүхдүүд хашгиралдав. Малфойн нүүрэнд уусмал үсэрсэн болохоор хамар нь яг л агаарын бөмбөлөг шиг хөөн хавдаж эхлэв. Гойл тал тал тийшээ үсэрч, таваг шиг том болсон нүдээ алгаараа дарна. Снегг багш хүүхдүүдийг чимээгүй болгож, юу болоод байгааг мэдэхээр мэрийх аж. Энэ үеэр Гермиона үүдний цаагуур годхийн оржээ.

- Чимээгүй! Чимээгүй! Гэмтсэн хүүхдүүд наашаа ирцгээ. Би жин тавьж өгье.

Хэн ингэснийг мэдсэнийхээ дараа ... гэж Снегг багш байдгаараа орилно.

Бараг хулуу шиг том болсон хамраа даахгүй шахам тонгойсоор Снегг багшийн ширээ лүү очиж байгаа Малфойг хараад Харри инээд алдах шахжээ. Малфойн ард баахан хүүхдүүд цувран зогсоно. Заримын нь гар бороохой шиг болтлоо хавдан, заримын нь уруул үг хэлж болохооргүй пэмбийжээ.

Ингэж бужигнаж байх хооронд Гермиона ангидаа сэмхэн буцаад орж ирэхэд нь харвал өвөр нь яльгүй түнтийсэн байв.

Хавдрын эсрэг ханд сайн нөлөө үзүүлж хүүхдүүдийн хацар хамар гар эргээд хэвийн байдалдаа оржээ. Снегг багш Гойлын тогоо руу дөхөж очоод шатсан цаасан бууны тасархай гаргаж ирэв. Хүүхдүүд айсандаа чимээгүй сууцгаана.

- Үүнийг хийсэн хүүхэд сургуулиасаа явах хэрэг гарч дээ хэмээн Снегг багш сийгүүлэн хэллээ.

Харри юу ч ойлгоогүй дүр үзүүлэхийг хичээж байв. Учир нь Снегг багш түүнийг сэжиглэнгүй харцаар нэвт өрөмдөн харж байсан юм. Гэтэл аз болоход хонх жингэнэн дуугарч хичээл дуусчээ.

- Тэр таамагласан байхаа. Түүнийг гадарласан гэж толгойгоо ч өгөхөд бэлэн байна гэж Харри маань уйланхай Миртлийн хоргодох байр луу явж байхдаа андууддаа хэлэв.

Тэд өрөөнд ормогцоо Гермiona амь дүйн байж олсон нунтгаа тогоонд хийгээд буцалгах зуураа сайтар хутгаж байлаа.

- Одоо ингээд боллоо. Хоёр долоо хоног хүлээх хэрэг гарна гэж тэрбээр инээмсэглэн хэлэв.

- Снегг багш чамайг хийсэн гэж огт сэрдэхгүй. Уурлавал уурлаж л байг гэж

Рон Харрийг тайтгаруулна.

- Надад хамаагүй ээ. Тэртэй тэргүй надад муу юм чинь гэж хэлээд Харри тогоонд пор порхийн буцлаж буй хувиргах уусмалыг харж суув.

Долоо хоногийн дараа гурван анд маань их танхимд орохдоо ээлжит зарлалыг уншин зогсох бөөн хүүхдүүдийг харжээ. Симус Финниган, Дин Томас нар тэднийг самбар луу дуудан гар даллаж байв.

- Халз тулааны клуб нээгджээ! Сайхан даа! Өнөөдөр анхны цугларалт. Яг болж байна! хэмээн Симус дуу алдана.

- Халз тулаанд мангасыг дуудмаар байна уу? гэж Рон тоглоомоор асуув.

Үнэндээ бол шинэ клубыг өөрөө ч сонирхож байсан юм.

- Муугүй л санаа байна гэж гуанз руу явах үедээ Харри Гермionaд хэлжээ.

Андууд ч түүнтэй санал нэг байв. Найман цагт тэр гурав их танхимд очлоо. Хоолны ширээг хурааж, хилоэн хар адрын дор лаа асааж, нэг ханын дагуу алтан тавиур тавьжээ. Сурагчид бараг бүгдээрээ цугласан байх агаад гартаа шидэт саваагаа барьж, сэтгэл догдолсон харагдана.

- Хэн дасгалжуулагч юм бол? Флитвик багш юм болов уу? Түүнийг залуудаа шидэт саваагаар халз тулалдах урлагийн аврага байсан гэлцдэг юм билээ гээд Гермiona хүүхдүүдийн дундуур зүтгэлэв.

- Хэрэв тийм бол ... Харри хэлснээ яриагаа таслав. Дэвжээн дээр сайхан ягаан жанч нөмөрсөн Алтан хонгиот Туг үс өдөр тутмын хар хувцастай Снегг багшийг дагуулан гарч ирлээ.

Туг үс чимээгүй болохыг шаардаж гараараа дохиод:

- Наашаа ойртоцгоо! Бүр наашаа! Бүгд намайг харж байна уу? Үг маань дуулдаж байна уу? Сайн байна! Сургуульд халз тулалдааны клуб байгуулах санааг минь профессор Дамблдор дэмжсэн юм. Та нар клубт явснаар шаардлагатай үед биеэ хамгаалж сурах болно. Ийм шаардлага цөөн бус удаа гардгийг миний амьдралын туршлага харуулж байна. Энэ тухай миний номноос уншаарай. Надад профессор Снегг туслах болно гэж цагаан шүдээ яралзуулан инээмсэглэж хэллээ. Тэгээд:

- Снегг багш халз тулааны талаар жаал зугаа юм мэддэг гэсэн. Тэгээд л надад туслахыг зөвшөөрсөн юм. Одоо бид халз тулалдах хүмүүс шидэт саваагаараа яаж үзэлцдэгийг үзүүлэх болно. Залуу нөхөд минь, айж сандрах хэрэггүй. Би та бүхэнд уусмал бэлтгэх профессорыг чинь бүрэн бүтэн буцааж өгнө гэлээ.

- Хэрэв тэд бие биеэ хөнөөчихдөг бол аштай юу! гэж Рон Харрид шивнэв. Снегг багш мушийн инээмсэглээд Туг үсийг харахад тэрбээр инээмсэглэсээр байлаа.

«Снегг багш намайг ингэж инээмсэглэн харсан сан бол би ертөнцийн хязгаар руу зугтаах байж дээ» гэж Харри бодно.

Халз тулалдагчид бие бие рүүгээ эргээд мэндэлцгээв. Туг үс өвдгөөрөө нахисхийхэд Снегг ууртай байдлаар толгой мэхийн ёсложээ. Тэд шидэт саваагаа илд лугаа өргөн барьцгаав.

- Саваагаа ийм байдалд чухам яаж барьдгийг анхаарч хараарай. «Гурав» гэхэд шившлэгээ хэлцгээнэ. Үхлийн аюулд хүргэхгүй л дээ гэж Туг үс чимээгүй харах сурагчдад тайлбарлав.

- Нэг, хоёр, гурав ...

- Саваанууд гозосхийхүй Снегг:

- Экспеллиармус! гэж алдлаа.

Нүд гялбуулам хурц гэрэл гялсхийж, Туг үс хан руу ойн үсрээд дэвжээн дээр хана даган унажээ.

Малфой болон Слизериний хүүхдүүд хи, хи гэж инээлдэнэ. Гермiona өлмий дээрээ өндийн айсандаа алгаараа амаа таглажээ.

- Тэр амьд уу? гэж Гермiona шивнэнэ.

- Үгүй ч байсан яах вэ дээ! гэж Рон Харри хоёр зэрэг хэллээ. Малгай нь унаж, буржгар үс нь сэгсийсэн Туг үс арайхийн босоод:

- Сайн шившлэг! Профессор Снегг зэвсэггүй болгох шившлэг хэлээд намайг гар мухар болгохыг та нар харлаа. Ноён Браун танд баярлалаа! Саваагүй болсон би гаргүйтэй л адил. Профессор Снегг сайн байна! Та намайг уучлаарай. Уул нь таны санааг тааварлаад цохилтыг буцаавал болох л байлаа. Гэхдээ хүүхдүүдэд энэ нь аймшигтай ... гэж хэлтэл Снегг уурласандаа царай нь хөхрөхөд Туг үс яарч сандран:

- Үзүүлэх тоглолт үүгээр дууслаа. Одоо дасгал сургуульдаа орцгооё. Та нарыг хос хос болгон хуваарилна. Профессор Снегг та надад туслахгүй юу хэмээн нэмж хэллээ.

Туг үс багш Жастин Финч-Флетчийн эсрэг Невиллийг тавихад Снегг багш Харри

Рон хоёр луу ойртож ирээд:

- Салдаггүй хоёрыг салгах хэрэг гарлаа. Уизли Финнигантай тулалдах болно.

Харин Поттер ...

Харри удаан бодсонгүй Гермionaгийн урд очих зогслоо.

- Ө-ө, үгүй шүү! Ноён Малфой, нааш хүрээд ир. Алдарт Харри Поттер тантай яаж тулалдахыг харъя. Харин хатагтай Грэйнджер та Булстроудтай тулалд гэж Снегг багш хүйтнээр инээмсэглэн хэлэв.

Малфой биеэ тоосон мэт инээмсэглэсээр заасан газарт зогслоо. Бахим эрүүтэй «Хөгшин шулмастай өнгөрүүлсэн амралт» номын харгис илбэчинтэй яг адилхан охин Гермionaгийн өмнө байраа эзлэв. Гермiona түүнийг инээмсэглэн харахад цаадах нь үзэн ядсан байдалтай хамраа сөхжээ.

- Харилцан мэндэлцгээ! гэж Туг үс дэвжээн дээрээс тушаав. Харри, Малфой хоёр бие биеэсээ харц салгалгүй толгой дохижээ.

- Саваагаа бэлэн бариарай! «Гурав» гэхэд өрсөлдөгчөө зэвсэггүй болгох гээд үзээрэй. Харин хүч хэрэглэж болохгүй. Нэг ... хоёр ... гурав!

Харри саваагаа далласан авч Малфой «хоёр» гэж тоолмогц түүнээс түрүүлэн дохисон аж. Харрийн тархин дундуур шилээврээр татаад авах шиг боллоо. Тэрбээр гуйвсан хэдий ч хөл дээрээ тэсэж зогсоод, саваагаа Малфой руу чиглүүлэн:

- Риктусемпра! гэж хашгирав.

Мөнгөлөг оч харван Малфойн гэдсийг оноход тэрбээр дуу алдан цагариглан унажээ.

- Хүч хэрэглэхгүй гэж би хэлсэн шүү! гэж Туг үс айсан мэт орилоод шалан дээр унасан Малфойг хүүхдүүдийн толгой дээгүүр харав.

Харри Малфой руу инээх шившлэг илгээхэд цаадах нь инээд алдсаар татвалзаж байлаа. Харрийн толгойд ойчсон хүнийг нэрмэдэггүй гэсэн бодол гялсхийн орж

ирэхэд саваагаа буулгав. Малфой энэ агшныг ашиглан, саваагаа Харрийн хөл рүү чиглүүлээд:

- Таранталлегра! гэж дуу алдлаа. Ингээд Харри бүжиглэж гарах нь тэр.
- Больцгоо! Одоохон боль! гэж Туг үс хашгична. Тэгтэл Снегг багш энэ явдалд оролцон:
- Фините инкантатем! гэдэг тохирох шившлэгийг хэлэв.

Харрийн хөл бүжиглэхээ больж хүрэн улаан болсон Малфойн инээд арайхийн зогсчээ.

Тэр хоёр ногоовтор утаагаар бүрхэгдсэн тулааны талбарыг харав. Невилл, Жастин хоёр шалан дээр амьсгаагүй шахам хэвтэнэ. Үхсэн хүн шиг цонхигор царайлсан Симус агаарт хөвж Рон хугархай саваа буруу ажилласанд түүнээс уучлал гуйж байлаа. Гермiona, Милисент хоёр саваагаа шалан дээр шидчихээд гараараа тулалдсан хэвээр. Харри Гермionaд туслахаар яаран түүнийг өрсөлдөгчөөс нь арайхийн салгав. Өрсөлдөгч нь түүнээс бараг хоёр дахин хүнд юм чинь.

- Ой-ёо-ёо! МакМиллан болиорой! Ноён Фосетой болгоомжтой! Бут минь, чангахан дараад цусаа тогтоочих ... Ер нь хамгаалалтаас эхлэвэл дээр юм байна гэж хэлэх зуураа Туг үс нэг тулалдагчаас нөгөө тулалдагч руу гүйх аж. Тэгээд Снеггийн зүг цөхрөнгөө барсан байдалтай харснаа түүний нүдэнд хүйтэн оч гялалзахыг ажаад биеэ барьж, эрс дуугаар:

- Сайн дурын хоёр хүнийг урьж байна. Долгопупс, Финч-Флетчли хоёр үзээд алдах юм биш үү? гэлээ.

- Профессор Туг үс минь, ингэж таарахгүй. Долгопупс хамгийн энгийн шившлэг хэлээд л Финч-Флетчлийн үлдэгдлийг шүдэнзний хайрцагт хийж эмнэлэгт аваачихаар болгочихно гэж хар жанч өмссөн аварга том сарьсан багваахайтай адил харагдах Снегг багш хэлэв.

Ягаан хацартай, дүгэрэг царайтай Невилл час улайлаа.

- Би бол Малфой, Поттер хоёрыг тулалд гэмээр байна хэмээн мушийн инээмсэглэн Снегг санал болголоо.

- Энэ чинь сайн хэрэг! гэж Туг үс хэлээд Драко, Харри хоёрыг танхимын төвд гар даллан урив.

Хүүхдүүд зай тавьж өглөө.

Драко шидэт саваагаар довтлоход Харри ч бас тийм арга хэрэглэж хариу өгөх юм.

Туг үс саваагаараа агаарт далласан авч саваагаа алдчихлаа. Снегг муухан инээмсэглэхэд Туг үс саваагаа аваад, толгой сэгсрэн:

- Энэ муу савааг! Өнөөдөр бүр болохгүй байнаа! гэлээ.

Снегг багш Малфойн чихэнд нэг юм шивнэхэд цаадах нь хорон инээмсэглэж толгой дохих аж. Харри үүнийг ажиглаад хамгаалах аргаа давтан үзүүлэхийг Туг үсээс гуйлаа.

- А-а, айчихаж! гэж Малфой Туг үсэд сонсогдохооргүй шивнэв.

- Гайгүй байлгүй! гэж Харри шүднийхээ завсраар сийгүүлэн хэллээ. Туг үс Харрийн мөрийг алгадан:

- Аргыг ойлгов уу? Алив, давтаач! гэв.

- Саваагаа алдах юм уу? Гэвч Туг үс сонссонгүй.

- Гурав ... хоёр ... нэг!

Малфой агшин зуур саваагаа даллаад:

- Серпенсортиа! гэж хашгирав.

Яг буудсан юм шиг чимээ гарчээ. Гайхаж хоцорсон Харрийн нүдэнд Малфойн саваанаас урт хар могой нисэн гарч шалан дээр унах нь харагджээ.

Урд зосох үзэгчид айсандаа арагш ухарцгаав. Хэн нэг нь чангаар хашгирчээ.

- Поттер, хөдлөхгүй зогсож бай. Би түүнийг одоохон зайлуулна гэж Снегг багш сэтгэл хангалуун хэлээд Харрийн аргаа барсан байдлыг тааламжтайяа харна.

- Үгүй ээ, би зайлуулчихъя! гэж Туг үс хажуугаас хэлээд саваагаа могой руу чиглүүлэв.

Гэвч могой алга болсонгүй, харин агаарт хөөрснөө ахиад л шалан дээр унажээ. Могой исгэрэн дуугараад Жастин Финч-Флетчлийн зүг мөлхөн дөхөөд сүүлэн дээрээ цогнойн сууж амаа ангайснаа үсрэхэд бэлтгэв.

Тэгтэл хачирхалтай явдал боллоо. Харри юу болсноо ч мэдэлгүй байрнаасаа үсрэн босоод могойд хандан:

- Эндээс зайл! гэж хашгирав. Ингэснийгээ дараа нь өөрөө ч мэдээгүй юм.

Гайхалтай юм! Бүдүүн хар могой дуулгавартайяа толгойгоо буулган цэцэрлэг услах хөндий хоолой шиг цагариглан хэвтээд хөдөлгөөнгүй харцаар Харрийг ширтэнэ. Харри яагаад ч юм могой дахин хэнийг ч довтлохгүй гэдэгт итгэлтэй байсан учир зориг оржээ.

Тэрбээр Жастины гайхаж талархахыг хүлээн инээмсэглэн харсан авч түүний айж хулчийсан харцтай тулгарав. Хүү:

- Жүжиг үзүүлж байх шив! гэж хэлээд танхимаас сум шиг үсрэн гарчээ.

Снегг багш могой руу очоод шидэт саваагаараа дохитол, могой жижигхэн хар үүл болон хувирлаа. Профессор Снегг ямар нэг юм бодон нүдээ онийлгоно. Харри түүний царайг хараад яах учраа олохгүй байв. Эргэн тойронд хүүхдүүд шивнэлдэн, хэн нэгэн түүний жанчнаас угзран татжээ.

- Явцгаая! Эндээс хурдхан явцгаая гэх Роны дуу түүний чихэнд сонсдов.

Тэгээд Харрийг танхимаас авч гарлаа. Гермиона тэднээс нэг алхам ч хоцорсонгүй. Үүдний дэргэд байгаа хүүхдүүд солиотой хүн харсан мэт зам тавьцгаана. Харри юу ч ойлгосонгүй. Рон, Гермиона хоёр амандаа ус балгасан мэт дув дуугүй явна. Тэд их танхимд очиж сандалд суусан хойноо л ярьж эхэлжээ.

- Чи чинь могойн хэлтэн юм байна гэж Рон хэлэв. Харри ойлгосонгүй:

- Хэн гэнээ? гэж асуулаа.

- Могойн хэлтэн. Могойн хэлтэй шидтэн. Өөрөөр хэлбэл могойтой ярьж чадна гэсэн үг. Чи үүнийгээ яагаад бидэнд яриагүй юм бэ?

Би могойтой хоёрхон удаа л ярьж үзсэн. Эхний удаа амьтны хүрээлэнд. Аварга могойг Дадли руу илгээсэн юм. Аварга могой надад хэзээ ч төрөлх Бразилдаа байж үзээгүй гэж хэлсэн шүү. Яагаад гэдгээ ч мэдэхгүй би түүнийг суулсан юм даг. Тэгэхэд би өөрийгөө шидтэн гэж мэддэггүй байлаа.

- Аварга могой Бразилд хэзээ ч байж үзээгүй гэж чамд хэлсэн юм уу? Тэгээд чи ойлгосон хэрэг үү? гэж Рон нүдээ бүлтийлгэн асуув.

- Тэгээд юу гэж? Бүх шидтэн ойлгоно шүү дээ.

- Бүх шидтэн гэнээ. Могойг ойлгоно гэдэг маш муу явдал.

- Минийхээр муу юм огт алга! Та нар яагаад байнаа? Хэрэв би могой руу хашгираагүй бол хөөрхий Финч залгиулах байсан даа.

- Чи Жастинд бүү хүр гэж түүнд тушаасан юм уу?

- Би эндээс зайл гэсэн. Чи сонсоогүй юм уу?

- Би могойн хэлээр ярихыг чинь л сонссон. Юу гэдгийг нь ойлгоогүй. Харин Жастин түүнийг өөр лүү нь турхирлаа гэж бодсон байлгүй. Тэгээд л айгаад зугатаачихсан.

Харри чихэндээ ч итгэсэнгүй.

- Тэгэхлээр би тэс өөр хэлээр ярьсан хэрэг үү? Тийм юм байж болох уу? Өөр хэлээр яриад өөрийнхөө хэлээр сонсоно гэж?

Рон толгойгоо сэгсрэв. Гермиона тэр хоёр гашуудал дээр байгаа мэт харагдана. Харри учраа олохгүй хэвээр.

- Би аймаар юм хийчихсэн юм бэ, хэлээд аль. Би Жастиныг аварч могойд залгиулаагүй хориглосон. Яаж гэдэг нь хамаатай юм уу?

- Хамаатай. Могойн хэлээр хэн ярьдаг байсныг мэдэх үү? Салазар Слизерин.

Чухам ийм учраас л тэдний тэнхимийн сүлдэн дээр могой байдаг юм гэж

Гермиона хэлжээ. Харри бүр гайхаж хоцорлоо.

- Тийм ээ. Одоо сургууль даяараа чамайг түүний гуч, дөч, жич гэж бодох болно! гэж Рон батлан хэлэв.

- Би ямар ч гуч, дөч биш! гэж Харри уурлалаа.

- Үүнийг чинь яаж батлах юм бэ? Слизерин мянган жилийн тэртээ амьдарч байсан. Юу ч болж болно шүү дээ гэж Гермиона уруу царайлан хэлэв.

Харри шөнийн турш унтсангүй. Тэрбээр дутуу хаасан хөшигний завсраар гадаа цас орохыг харж, юм бодож байлаа.

Үнэндээ Слизериний гуч, дөч, жич байж болох л юм. Өөрийнхөө удам судрыг Харри мэдэхгүй. Тэдний төрөл төрөгсөдийн тухай ярихыг Дурслийнхан хориглодог юм чинь.

Харри могойн хэлээр ямар нэг юм хэлж үзэх гэсэн авч болсонгүй. Могойн хэлээр зөвхөн могойтой л ярьж болдог юм байлгүй дээ. Лав л өөртэйгөө ярьж болохгүй юм байна.

«Гэхдээ би Гриффиндорт суралцдаг. Хэрэв би Слизериний цустай бол бүрх малгай намайг энэ л тэнхимд хувиарилах байсан!» гэж Харри бодлоо.

Гэтэл толгойд нь бүрх малгай чамайг Слизеринд явуулахаар оролдсон шүү дээ! гэсэн нэгэн бодол орж ирэв.

Харри нөгөө хажуугаараа хэвтлээ. Маргааш ургамал судлалын хичээл дээр могойг түүн рүү турхираагүй. Харин хөөж явуулсан гэдгээ Жастинд тайлбарлах хэрэгтэй юм байна. Үүнд эргэлзэх зүйлгүй юм чинь?! Тэрбээр уурсан гараараа дэрээ балбажээ.

Шөнө орж эхэлсэн зөөлөн цас өглөө гэхэд жинхэнэ шуурга болжээ. Ургамал судлалын сүүийн хичээлийг оруулсангүй. Профессор Стебль мандрагороо хурдхан ургуулахын тулд өөрөө янзлахаар шидсэн юм. Мандрагоргүйгээр ноён Норрис, Колин Криви хоёрт өгөх эмчилгээний хандыг бэлтгэх аргагүй.

Гурван анд хичээлгүй болохоороо Гриффиндорын их танхимд очлоо. Харри ханан зуухны дэргэд суув. Жастинтай ярилцаж чадаагүйдээ сэтгэл зовно. Рон, Гермиона

хоёр шидэт шатар тоглож байлаа. Харрийн урвагар байхыг харснаа Гермиона морио алдчихав. Роны тэмээ түүнийг хөлөг дээрээс зайлуулжээ.

- Харри чи үнэхээр санаа зовоод байгаа юм бол Жастиныг эрж олоод ярилцаач дээ гэж охин хэлэв.

Харри хатагтайн хөрөгтэй нүхээр гарч Финч-Флетчлийг олохоор явлаа.

Гадаах шуурганаас болоод шилтгээнд урьдынхаасаа харанхуй байв. Хүйтэнд даарсан хүү ангиудын дэргэдүүр өнгөрөхдөө хаалганы цаадах чимээг сонсож явлаа. Профессор МакГонагалл сахилгагүйтсэн нэгнийг зэмлэх ажээ. Тэд дүрсгүйтэхдээ нэгнийгээ дорго болгоод хувиргачихсан юм байж. Харри анги руу шагаймаар санагдсан ч дэргэдүүр нь өнгөрлөө. Хичээл ороогүй юм чинь Жастин номын санд байгаа юм болов уу?

Үнэндээ ч пуффендуйн хэд хэдэн хүүхэд танхимын цаад үзүүрт өндөр тавиуруудын хооронд сууж байлаа. Гэхдээ тэд ургамал судлалын тухай ярилцаагүй бололтой. Тэд толгойгоо ойртуулан нэгэн чухал юм ярилцах аж. Тэдний дунд Жастин байгаа эсэхийг Харри мэдээгүй блохоор ойртон очоод юун тухай ярьж байгааг нь сонсмогцоо эргэж хажуугийн үл үзэгдэх хэсэгт орлоо.

- Тийм ч байж магадгүй, үгүй ч байж магадгүй. Гэхдээ би Жастиныг манай унтлагын өрөөнд нуугд гэж зөвлөсөн юм. Хэрэв үнэхээр Поттер түүнийг хөнөөх гэж шийдсэн бол одоохондоо гадагш цухуйхгүй байвал дээр. Жастин ийм юм болно гэдгийг мэдэж байсан юм. Поттер түүнийг маглуудаас гаралтай гэдгийг саяхан мэдсэн. Өөрөө л Итонед суралцах ёстой байсан гэж чалчсан гэсэн. Үүнийгээ очиж очиж Слизериний залгамжлагчид хэлэх ч гэж дээ! хэмээн нэгэн бүдүүн хүүхэд ярьж байв.

- Энри чи Харри Поттерыг ингэсэн гэж бодож байна уу? хэмээн цайвар үстэй охин боосон гэзгээ оролдон асуулаа.

- Ханна, тэр чинь могойн хэлтэй шидтэн. Энэ бол хар шидийн шинж тэмдэг байхгүй юу. Сайн шидтэн могойн хэлээр ярилаа гэж чи хэзээ нэгэн цагт соссон уу? Слизеринийг л могойн хэлт гэдэг байсан юм! гэж бүдүүн хүү багш лугаа адил ярина.

Тэд хэсэг зуур шивнэлдсэнээ Энри:

- Ханан дээрх үгийг санаж байна уу? «Үе залгамжлагчдын дайснууд чичирцгээ!» Поттер Филчтэй таардаггүй байсан болохоор муур нь хөшчихсэн. Сүүлчийн тэмцээн дээр Кривид уурласан юм. Тэр хүү Харри Поттерыг шавхайд хэвтэж байхад нь зураг авах гэж л дээ. Ингээд л Криви баримал болчихсон гэлээ.

- Гэхдээ тэр чинь тун сайн хүүхэд! Түүний ачаар л Хэцүү нэрт алга болсон.

Тэгэхлээр түүнд сайн юм байгаа гэсэн үгэ хэмээн Ханна хулчгардуухан татгалзана.

Энри хариу хэлэхдээ бүр шивнэж байлаа. Пуффендуйнхан толгойгоо бүр ойртуулсан болохоор Харрид ойртохоос өөр арга байсангүй.

- Тэрхүү тулаанд яаж амьд үлдсэнийг нь хэн ч мэдэхгүй. Тэр үед бүр жаахан байсан юм чинь. Хэцүү нэрт хэдийгээр бүх гэр бүлийнхэнд нь аймшигт хараал хийсэн авч бараагүй юм. Гагцхүү жинхэнэ хар шидтэн л амьд үлдэж чадах байжээ. Тийм болохоор л хар ноёнтон түүнийг хөнөөх гэсэн юм байлгүй. Түүнд өрсөлдөгч ямар хэрэгтэй юм бэ? Би Харри Поттероос илүү хүчтэй хар шидтэн байхгүй гэж бодож байна! хэмээн нөгөө бүдүүн хүү шивнэнэ.

Энэ ч арай дэндлээ! Харри тэссэнгүй нуугдсан газраасаа гарав. Хэрэв тэр уурлаагүйсэн бол хуйвалдагчдийн дүр төрхийг хараад инээд алдахаар байлаа. Тэдэнд хөшөө шившлэг уншсан юм шиг харагдана. Эрни яг л шохой шиг цагаан болжээ.

- Сайн уу, Жастиныг хараагүй биз? хэмээн Харри юу ч болоогүй юм шиг мэндлэв.

Пуффендуйхны айж байсан талаар өнгөрсөнгүй боллолтой! Тэд цөм Эрнийг айсан байдалтай харна.

- Чамд ямар хэрэгтэй юм бэ? гэж Эрни чичирсэн хоолойгоор асуув.

- Халз тулааны клубт үнэн хэрэгтээ юу болсныг түүнд тайлбарлах гэсэн юм.

- Бид бүгдээрээ тэнд байсан, бүгд л харцгаасан.

- Намайг үг хэлэхэд могой ухарсныг та нар харсан юм байна.

- Чамайг могойн хэлээр ярихыг чинь л сонссон. Энэ бол хар хүчний хэл. Чи могойд Жастиныг залги гэж тушаасан байлгүй гэж Эрни зөрүүдлэнэ.

- Тийм юм болоогүй ээ! Та нар эндүүрчээ! Би түүнийг аварсан! гэж Харри уурласандаа жингэнэсэн дуугаар хэлэв.

- Тийм ч байж магадгүй, үгүй ч байж магадгүй. Ямар ч байсан би бол арав дахь үеийн цэвэр цусны шидтэн гэдгээ хэлмээр байна.

- Чиний шидтэн, шидтэн бус гэдэг надад хамаагүй. Би хувьдаа маглуудын эсрэг юу ч хийдэггүй.

- Гэхдээ би чамайг хамт амьдардаг маглуудаа үзэн яддаг гэж сонссон юм байна.

- Чи тэдэнтэй ядахдаа нэг сар байсан ч болоосой. Тэгвэл бүр ч илүү үзэн ядах байсан юм.

Харри ингэж хэлээд өсгий дээрээ эргэн номын сангаас сум шиг дүүлэн одлоо. Энэ үед хуучин судрын алтан хавтсыг зүлгэж байсан хатагтай Пинс номын сан дотуур дүүлэх Харрийг таагүй харцаар ширтэж байв.

Харри чухам хаашаа явж байгаагаа ч мэдсэнгүй. Урдах юмаа огт харахгүй явсан тэрбээр хэн нэгэн том хүнийг мөргөөд арагш унажээ. Өөр хэн хонгилын нэг хананаас нөгөөг хүртэл халхалж чадах билээ дээ! Тэрбээр сохор номингийн арьсаар хийсэн

дээл, зөвхөн нүдээ ил гаргасан дуулга шиг сүлжмэл малгай, зузаан бээлий өмсчээ. Том гартаа үхсэн тахиа барьсан байв.

- Сайн уу, Хагрид аа!
- Чи яагаад хичээлдээ суугаагүй юм бэ? гэж Хагрид асуугаад малгайгаа авлаа.
- Хичээл цонхолсон. Чи энд юу хийж байгаа юм бэ? гэж Харри шалан дээрээс босох зуураа асуув.
- Хагас жилд хоёр дахь тахиагаа алдлаа. Үнэг ирээд байна уу, эсвэл гайтай албин ирэв үү? бүү мэд. Дамблдор хэлж тахианы байраа аргалуулдаг юм билүү гэж явна. Чи зүгээр биз дээ? Яагаад ингэтлээ улайчихаав? гэж цас болсон өтгөн хөмсөгөө өргөн Хагрид асуув.

Харри дөнгөж сая сонссон яриагаа хэлэх гэтэл ам нь эвлэсэнгүй.

- За тийм байж. Би явлаа. Одоо хувиргалын хичээл орох болохоор номоо авах хэрэгтэй гэж хэлээд Харри цааш гүйлээ. Түүний толгойд: «Жастин ийм юм болно гэж мэдэж бйсан юм. Поттер түүнийг маглуудаас гаралтай гэдэгт саяхан мэдсэн» гэх Эрнийн үг эргэлдэж байв.

Харри шатаар өгсөж харанхуй хонгил руу эргэтэл салхинд цонх нээгдэн, бамбар унтарчээ. Тэрбээр хонгилын дагуу ухаан малгайгүй гүйж байтал нэг юманд таварцаглав. Тонгойгоод харсан чинь Жастин айсандаа гөлийсөн нүдээрээ адар ширтэн хөдөлгөөнгүй хэвтэж байлаа. Харри тун ч их айлаа. Бас хажууд нь толгойгүй Ник байгаа нь хачирхалтай. Түүний бие сүүмгэрдүү тунгалаг бус хөө түрхсэн юм шиг харагдана.

Харрийн амьсгал давхцан дээш болоход зүрх нь хүчтэй булгилж байв. Тэрбээр толгойгоо эргүүлэн харахад хонгилд хэн ч байсангүй. Зөвхөн тэр хоёрын биенээс баахан аалз цувран гарч гүйлдэх агаад хаалттай хаалганы цаанаас багш нарын дуу бөглүү сонсогдоно.

Эндээс хурдхан зугт Харри минь! Энд байсан, тэднийг анхалж харсан гэдгийг хэн ч мэдэх ёсгүй. Гэхдээ тэднийг ингээд үлдээж болно гэж үү? Тусламж дуудах хэрэгтэй. Харин үүнийг тэр хийгээгүй гэдэгт хэн итгэх билээ!

Харри шаланд зоогдчихсон мэт зогсоно. Гэтэл нэг үүд чахран нээгдээд Пивз хонгилд нисэн орж ирлээ.

- Аа, Поттер хөлөрчихсөн байх шив! Энд юу хийж байнаа? Хэнээс нуугдсан юм? гэж хэлээд дэргэдүүр нь нисэхдээ Харрийн нүдний шилийг шүргэж хамар дээр нь тохчихлоо.

Харуул дээш доош тонгорцоглон толгойгоо уруу харуулан тогтлоо. Тэрбээр гэмтэн хэвтэж буй Жастин, бараг толгойгүй Ник хоёрыг харна. Пивз эргэн гүнзгий санаа алдсанаа Харрийг үг хэлэхийн зуургүй байдаг чадлаараа:

- Довтолгоо. Ахиад л довтолжээ! Хүмүүс минь амиа бодоорой! Амь амиа бодоорой! гэж хашгилаа.

Тар! Түр! Тар! Үүднүүд ээлж дараалан нээгдлээ. Сурагчид хонгилд гарч ирцгээв. Тэд Жастиныг гишгэхээ шахаж, Харрийг хананд шахаад Никийн дээгүүр хий хоосонд явж буй мэт холхино. Багш нар түгшсэн хүүхдүүдийг арайхийн чимээгүй болголоо. Профессор МакГонагалл ангийнхныгаа дагуулан иржээ. (Нэг хүүхдийн толгойтой үс алаг тахийнх шиг хар, цагаан судалтай хэвээр байв). Тэрбээр шидэт саваагаа тасхийтэл дуугарган хүүхдүүдийг чимээгүй болгоод анги ангидаа ор гэлээ. Энэ агшинд нөгөө номын санд байсан Эрни цусгүй цонхигор царайлсаар хүүхдүүдийн дундуур зүтгэлэн хүрч ирээд:

- Баригдлаа! гэж хэлэн Харрийг хуруугаараа заав.

- МакМиллан чи дуугүй бол гэж хувиргалын багш професоор зандарлаа.

Болж буй бүхнийг харан адар доогуур нисэх Пивз инээмсэглэнэ. Тэрбээр элдэв үймээн бужигнаанд хэдийний дуртай билээ. Багш нар хөдөлгөөнгүй хэвтэх биеийн дээрээс тонгойн харна. Тэгтэл Пивз:

Харри Поттер харгис амьтан

Хамаг хүмүүсийн хар алуурчин! гэж зохион дууллаа.

- Пивз, болиорой гэж профессор түүнд хашгиран хэлэв. Пивз холдон нисэх зуураа Харри руу хэлээ гаргажээ.

Профессор Флитвик одон орны тэнхимийн профессор Синистра хоёр Жастиныг болгоомжтой өргөн эмнэлэг рүү авч явлаа. Харин бараг толгойгүй Никийг яаж ч болсонгүй. Хий үзэгдлийг яаж авч явах вэ? Үүнийг МакГонагалл шийдэж чадлаа. Тэрбээр ид шидийн арга хэрэглэн том дэвүүр бүтээгээд Эрнид өгч яаж ажиллуулахыг тайлбарласан юм. Бахархаж бардамнасан Эрни дэвүүрээ дэвэхэд хий үзэгдэл яг л агаарын хөлөг шиг дээш хөөрчээ. Хонгилд зөвхөн Харри профессор МакГонагалл хоёр үлдэв.

- Явъя, Поттер оо гэж тэрбээр хэллээ.

- Профессор оо, би ингээгүй.

- Үүнийг би мэдэхгүй.

Тэд хонгилоор чимээгүй явж булан тойроод том зургийн өмнө зогслоо.

- Нимбэгийн ундаа! гэдэг шидэт нууц үгийг МакГонагалл багш хэлэв.

Зурагтай хана нээгдэн тэднийг нэвтрүүллээ. Харрийн дотор зүрх айсандаа чичирч байв. Гэвч нэг юм хараад чичрэхээ больжээ. Түүний өмнө дугуйрсан шат дээшээ урсаж байх юм. Тэр хоёр гишгүүр дээр гишгэхэд ардах хана хаагдлаа. Шат нилээд хурдан дээшлэх агаад Харрийн толгой ялимгүй эргэж байв. Төдхөн тэд дэргэд нь сийлбэр мэт гуулин алх дүүжилсэн хүнд хаалганы өмнө зогсож байлаа. Энд Дамблдор суудаг гэдгийг Харри шууд л ойлгожээ.

БҮЛЭГ 12: ХУВИРГАХ УУСМАЛ

Профессор МакГонагалл үүдийг аяархан тогшив. Үүд ч чимээгүй онгойн тэд дотогш орлоо. Профессор МакГонагалл Харийг хүлээж бай гээд ганцааранг нь үлдээв.

Харри эргэн тойрноо харлаа. Бүх танхимаас Дамблдорын танхим л хамгийн сонирхолтой ажээ. Харри уул нь энэ жил олон ч танхим харсан даа. Хэрвээ тэрбээр болсон явдлаас айж ичээгүйсэн бол хөөр баяраар дүүрэн байх биз.

Энэ бол дөнгөж сонсогдохуйц чимээ гарах том дугуй тасалгаа байв. Эргэдэг ширээн дээрх олон янзын мөнгөлөг хэрэгслүүд яльгүй утаа баагиулан жингэнэнэ. Хананд түрүүчийн захирлуудын сайхан жаазтай зурагнууд тайван үүрэглэж байлаа. Танхимын голд хумс бүхий хөлтэй бичгийн том ширээ, түүний цаадах тавиур дээр үнгэгдэж үрчийсэн шидэт бүрх харагдана.

Харри гэнэтхэн энэ бүрхийг дахин өмсөж юу хэлэхийг нь сонсвол яадаг бол? гэж бодлоо. Тэрбээр хананд өлгөөстэй зүүрмэглэх ид шидтэнгүүдийг болгоомжлон харав. Ахин аз сориод үзвэл гай түйтгэр болох юм биш байгаа? Зүгээр л орох ёстой тэнхим мөн байсан эсэхийг мэдэх хэрэгтэй юм.

Тэрбээр ширээг сэмхэн тойрч гараад бүрх малгайг тавиур дээрээс авч толгойдоо алгуурхан углалаа. Малгай томдож ноднин жилийнх шиг нүдийг нь халхлаж аж. Харри юу болохыг хүлээн чимээгүй байтал түүний чихэнд аяархан дуугаар:

- Юу хийж байгаагаа мэдэж буй биз, Поттер минь? гэлээ.

- Т-тийм ээ. Түвэг удсаныг минь өршөөгөөрэй, би нэг юм асуух сан ... гэж

Харри бувтнав.

- ...Өөр тэнхимд оруулсан уу гэх гээ юу? Тийм ээ ... Чамайг хуваарилахад амаргүй байсан даа. Гэхдээ би одоо урьд хэлснээ л баримтлана. Чи Слизеринд орсон бол сайн сурах байсан даа ... гэж бүрх малгайг хэлэхэд Харрийн зүрх түгшин догдолжээ.

Хөл доорх шат хөвөн одох шиг санагдана. Тэгээд бүрхний ирмэгээс барин толгойноосоо авлаа. Гундаж бохирдсон малгай гарт нь санжигнана. Харри малгайг тавихдаа дотор сэтгэл нь үймрэн эсэргүүцэж байгаагаа мэдрэв.

- Чи худал ярьж байна гэж чимээгүй хөдөлгөөнгүй байгаа малгайд чанга хэлсэн авч бүрх хөдөлсөнгүй. Харри малгайг харсаар ар тийш ухартал ард нь хачин чимээ гарахад эргэж харлаа.

Ганцаархнаа байгаагүй бололтой. Хаалганы хажуугийн алтан хөндлөвч дээр харахад хөгшин үсийг нь дутуу зумласан цацагт хяруултай төстэй гэмээр нэгэн шувуу сууж байв. Нүд нь бүүдийж сүүмийснийг үзвэл ямар нэг өвчин туссан бололтой. Харри түүнийг харж зогсох хооронд шувууны сүүлнээс хоёр гурван од унажээ.

Харри гунигтайгаар толгой сэгсрэв. Өрөөнд хоёулхнаа байх үе Дамблдорын шувуу түүний нүдэн дээр үхэх нь дутаад байж гэнэ дээ. Яг энэ агшинд шувууны өдөн дээгүүр гал гарснаа, бүр дөл бадран шатлаа.

Харри уулга алдаад, хаа нэгтээ ядахдаа ганц аяга ус байна уу гэж эргэн тойрноо харсан авч юу ч байсангүй. Энэ зуур шувуу галт бөмбөлөг болон хувирч чанга хашгирч байснаа хэдхэн агшны дараа түүнээс ердөө л утаа савссан атга үнснээс өөр юу ч үлдсэнгүй.

Өрөөний үүд нээгдэж ууртай ч гэмээр, баргар ч гэмээр царайлсан Дамблдор орж ирлээ.

- Профессор оо ... Таны шувуу ... Би яаж ч чадсангүй ... Шувуу ... Шатчихсан ... гэж Харри түгшсэндээ болоод арайхийн хэлэв.

Дамблдорыг тоохгүй инээмсэглэхэд Харри тун их гайхлаа.

- Цаг нь болсон доо. Сүүлийн хэдэн өдөр их муу байсан юм. Ийм байдлар удахгүй гэж би түүнд хэлж л байсан.

Харрийн гайхсан царайг хараад тэрбээр сэргэж:

- Энэ чинь Фоукс гэдэг галт шувуу, Харри минь. Галт шувуу үхэхээ болохоор үнснээсээ дахин төрөхийн тулд шатдаг юм. Чи түүнийг хар даа ... гэв.

Харри яг цагийг нь олж харжээ. Үнснээс жижигхэн өрвийсөн дэгдээхэй толгойгоо цухуйлгаж байлаа. Тэр шувуу урьдынх шигээ сүлд сүргүй юм.

- Чи түүнийг шатах өдөр харсан нь харамсалтай. Амьдралынхаа ихэнх үед энэ шувуу сайхан өнгө зүстэй байдаг юм. Гайхалтай сайхан улаан алтан өднүүдтэй гээч. Галт шувуу ч гайхалтай амьтан даа. Тэд том оврын ачаа тээж чаддагаас гадна нулимс нь эмчлэх чадвартай, бас хамгийн үнэнч нөхөр гэж Дамблдор хэлээд ширээнийхээ ард суулаа.

Өөрөө шатах шувууг харж гайхсан Харри яах гэж ирснээ мартсан байсан авч Дамблдорыг өндөр түшлэгтэй сандалд сууж, түүнийг цэнхэр нүдээрээ нэвт ширтэх үед бүгдийг санажээ.

Гэвч захирлыг үг хэлж амжаагүй байтал өрөөний үүд тар нярхийн нээгдэж Хагрид орж ирлээ. Харц нь ширүүн, сүлжмэл малгайгаа тал дээрээ тавьсан хар үс нь сэгсийсэн гартаа нөгөө үхсэн тахиагаа барьсан хэвээр аж.

- Профессор Дамблдор гуай, энэ хэргийн эзэн Харри биш! Би түүнтэй ... за байз ... энэ дэгдээхэйг олохоос ... хэдхэн агшны өмнө ... ярилцаж байсан юм! Ноёнтоон, түүнд ингэх завдал байгаагүй ... гэж омогдуухан хэллээ.

Дамблдор ямар нэг юм хэлэх гэсэн авч Хагридын үгийг таслах аргагүйн дээр мань хүн яриандаа болоод нөгөө тахианыхаа өд сөдийг бутартал савчиж байлаа.

- Тэр тийм юм хийж чадахгүй ээ! Би түүнийг ... За байз ... Ид шидтэний Яамны өмнө ч тангараглаж чадна ...

- Хагрид аа, би ...

- Та ... өөр хүн барьчихжээ, ноёнтоон! Би мэдэж байна ... Харри хэзээ ч ...

- Хагрид! Тэр хоёр луу Харри довтлоогүй гэдэгт би итгэлтэй байна гэж

Дамблдор чанга дуугаар хэлэв. Хагрид:

- Уф! гэж гүнзгий амьсгалахад гарт байгаа тахиа нь санжиганана.

- Тэгээд Хагрид чанга чанга дэвсэлсээр гарч одлоо.

- Та үнэхээр намайг тэгээгүй гэдэгт итгэж байна уу? гэж Харри найдангуй асуув. Дамблдор ширээн дээрээ унасан өд сөдийг унагах зуураа:

- Тийм ээ, Харри чи биш. Гэхдээ л надад чамтай ярих юм байна гэж Дамблдор хэлэхдээ царай нь ахиад барайжээ.

Дамблдор гараа салаавчлан юм бодох зуур Харри айсан янзтай хүлээж байв.

- Харри, чи надад ямар нэг юм хэлэх гэсэн үү гэдгийг би чамаас асуух ёстой.

Юу ч байж болно гэж захирал алгуурхан хэллээ.

Харри юу хэлэхээ мэдсэнгүй. Тэрбээр: «Эрлийз та нар дараачийнх нь!» гэж Малфой хашгирсан тухай уйланхай Миртлийн жорлонд буцлаж буй уусмалын тухай бодлоо. Бас түүнд хоёр ч удаа үг хэлсэн нууцлаг дуу хоолой, «Хэн ч сонсоогүй дууг сонсон гэдэг бүр ид шидийн ертөнцөд хүртэл муу байдаг» гэж хэлсэн Роны үгийг эргэн санах. Мөн түүний тухай тарсан цуу яриа Слазар Слизеринтэй ямар нэг холбоотой байж магадгүй хэмээн өөрийгөө хардаж сэрдсэн тухайгаа бодож байлаа ...

- Надад хэлэх юм байхгүй профессор оо гэж Харри түгдрэн хэлжээ.

Жастин, бараг толгойгүй Ник хоёрыг довтолсон явдал бүгдийг айлган цочоожээ. Бараг толгойгүй Никийг хорлосонд сургууль даяараа түгшиж багаа нь хамгийн хачирхалтай. Хөөрхий хий үзэгдлийг дөнгөхөөр хэн зориглов, аль дээр үхсэн хүнийг дийлэх ямар аймшигтай хүч байв? гэх зэрэг асуултыг хүүхдүүд бие биедээ тавина. Шинэ жилийн өмнө явах Хогвартс-Лондонгийн буухиа галт тэрэгний тийз агшин зуур дуусчээ. Хүүхдүүд сургуулиас бөөн бөөнөөрөө явж байв.

- Зөвхөн бид л үлдэх юм байна. Бас Слизериний Малфой, Крэбб, Гойл гурав.

Ингээд л үлдэх хүүхдүүд гүйцлээ. Хөгжилтэй амралт болно доо гэж Рон байдлыг үнэлж цэгнэн Харри Гермиона хоёрт ярьжээ.

Крэбб Гойл хоёр Малфойг яг ямагт бүх талаар дуурайж байдаг болохоор хамт амрах гэж үлдсэн юмсанж. Харрийн хувьд бол бараг бүх хүүхэд явж байгаад баяртай байлаа. Түүнийг хонгилоор явахад нь араа соёотой юм шиг, эсвэл хороор тургидаг юм шиг бүгд л бутран зугтдагт бүр залхаж гүйцжээ. Бас ард нь яваа хүүхдүүд шивнэлдэж зааж дохиж байдагт залхсан аж.

Харин Фред, Жорж хоёр л тэрхүү айж цочсон байдлыг тоглоом наадам болгоно. Тэд

Харрийг хармагцаа бүх юмаа хаяад урд нь орон алхахдаа чанга дуугаар:

«Слизериний үе залгамжлагчид зам тавьцгаа! Хамгийн агуу шидтэн явж байхад сөхөрцгөө ...» гэж хашгирдаг байв.

Перси тэднийг эрс шүүмжлэх бүлгээ.

- Ингэж тоглодоггүй юм гэж хүйтнээр хэлнэ.

- Перси чи ч замаас зайлбал дээр. Харри яарч байгааг харахгүй байна уу ... гэж

Фред дөнгөнө.

- Түүнийг нууц өрөөнд аяга цай бас соёт зарцтай уулзах таатай уулзалт хүлээж байгаа гэж Жорж хөгжилтэй инээн марзганадаг байлаа.

Жинни энэ байдлыг хараад огт инээдэггүй байв. Өөр хэнийг хөнөөх гэж байна гэж Фредийг Харригаас чангаар асуухад юм уу, эсвэл Жоржыг ид шидээс хамгаалах гэж буй мэт дүр үзүүлэн сармисны том хумс үзүүлэх болгонд Жинни:

- Болиоч дээ, та нар гэж гуйдаг байв.

Харри энэ бүхнийг нэг их тоодоггүй байсан ч Фред Жорж хоёр төдхөн энэ тоглоом наадмаасаа залхжээ. Тэд Харрийг Слизериний үе залгамжлагч гэдэг нь шал дэмий гэж үзсэн учир Харрийн сэтгэл ч амрав.

Харин тэдний энэ тоглоом наадам Драко Малфойн уурыг хүргэдэг байлаа. Тэднийг хармагцаа уурласандаа дэлбэрэх шахна.

- Түүнийг жинхэнэ шидтэн гэдэггүй болохоор л тэгэж байгаа юм. Өөрөөс нь илүү хүнийг үзэн яддаг гэж чи мэднэ шүү дээ. Гэтэл алдар хүнд чам дээр, ажил төрөл түүн дээр бууж байна гэж Рон өөрийнхөө бодлыг тайлбарлажээ.

- Мөдхөн энэ бүх явдал дуусгавар болно. Хувиргах шингэн бараг бэлэн болж байна. Одоо долоо хоноход л бид үнэнийг мэдэх юм чинь гэж Гермiona итгэл төгс хэлэв.

Ингээд хичээл дуусаж тал дахь цас шиг гүн гүнзгий нам гүм байдал шилтгээнд ноёрхох болжээ. Харри нам гүмд сэтгэлээр унасангүй харин ч Хогвартст үлдсэн болгонд Гриффиндорын удирдлагаас бэлэглэсэн эрх чөлөө, амар амгаланд хөөрөн баясаж байлаа. Хэнийг ч уурлуулалгүй, хэнийг ч айлгалгүй галт бамбар асааж, шидэт саваагаар халз тулааны дасгал хийж болох юм. Фред, Жорж, Жинни гурав амралтаараа бас сургуульдаа үлдэхийг дээр гэж үзжээ. Хэрэв тэднийг гэртээ очвол эцэг эх нь Египетэд байдаг Билл рүү хамт явна гэсэн аж. «Хүүхдийн тоглоом» хүртэл доош ордоггүй Перси их танхимд ховорхон орж ирэх агаад тайван бус үед багш нартаа туслах нь ахлагч нарын үүрэг гэж үзсэн учраас л амралтаараа энд үлдэж байна гэж албархуу хэлсэн юм.

Шинэ жилийн өглөө хүйтэн цасан цагаан байлаа. Унтлагын өрөөндөө хоёулхнаа үлдсэн Рон, Харри хоёрыг хар өглөөгүүр Гермiona сэрээжээ. Тэрбээр хувцасаа өмсчихсөн, тэр хоёрт бэлэг сэлт авчирсан юм.

- Босоод! гэж захираад охин цонхны хөшгийг нээв.

- Гермiona, чи ийшээ орох ёсгүй шүү дээ гэж Рон нүдээ гэрлээс халхлан үглэнэ.

- Чамд шинэ жилийн мэнд хүргэе. Би босоод цаг болж байна. Уусмалд алтан нүдэн цэцэг хийгээд бэлэн болгочихсон гэж хэлээд Гермiona түүнд бэлэг өглөө.

Харри сэрмэгцээ босож суугаад:

- Чи итгэлтэй байна уу? гэв.

- Бүрэн дүүрэн гэж Гермiona хэлээд эцэс төгсгөлгүй унтах Коростаг зайлуулан орны ирмэг дээр сууснаа:

- Бид үнэхээр л ямар нэг зүйл хийх гэж байгаа юм бол өнөө оройноос өөр сайхан цаг олдохгүй гэлээ.

Энэ үед хошуундаа бяцхан боодолтой юм зуусан Хэдвиг ууль өрөөнд нисэн орж ирээд Харрийн орон дээр суув.

- Сайн уу! Бид андууд хэвээр биз дээ? гэж Харри түүнийг баярлан угтлаа. Хэдвиг талархлын тэмдэг болгон түүний чихийг нөхөрсгөөр тоншиход энэ нь түүний авчирсан бэлгээс хамаагүй илүү санагджээ.

Дурслийхний илгээсэн тэрхүү боодолтой юманд шүдний сойз товчхон захиа байлаа. Захиандаа тэд Харрийг зуныхаа амралтаар сургуульдаа үлдэж болох эсэхийг сонирхсон байв.

Шинэ жилийн бусад бэлгүүд түүнээс хавьгүй илүү ажээ. Хагрид идэхээсээ өмнө гал дээр халаадаг том лаазтай хар чавганы тос явуулжээ гэдгийг Харри мэдлээ. Рон өөрийнхөө хайртай «Педдлийн их буунууд» багийн тухай олон сонирхолтой зүйл бичсэн «Их бууны сум» гэдэг номыг бэлэглэсэн байв. Гермiona юм бичих зориулалттай бүргэдийн гоёмсог өд бэлэглэжээ. Харри сүүлчийн боодолтой юмаа задлахад гараар сүлжсэн шинэ цамц, үзэмтэй том амттай бялууг Уизли авхай явуулсан байлаа. Түүний баяр хүргэсэн ил захидлыг гартаа авч үзээд Харрийн сэтгэл ахиад шаналж эхлэв. Шажигнуур удны дэргэд болсон ослоос хойш хэн ч хараагүй ноён Уизлийн форд машин түүнд санагджээ.

Галзуурсан модтой хийсэн шөнийн тэмцлийн дүр зураг, Рон тэр хоёр ахиад л сургуулийн дүрэм журам зөрчих болсон шалтгаан түүний ой ухаанд эргэлдэнэ.

Хогвартет болсон оройн зоог үнэхээр гайхамшигтай байсныг хэлэхгүй байхын аргагүй. Эртний судраас авсан жороор найруулсан аюултай уусмалыг уух болсондоо сэтгэл түгшин айж байсан хүүхдүүд маань ч энэхүү зоогийг ихэд үнэлсэн билээ.

Их танхим тун гайхамшигтай харагдана. Тэнд цан хүүргээр хучигдсан сүлд мод, хурц навчит ороомгоор хийсэн алаг эрээн хэлхээ байсан төдийгүй хуурай дулаахан шидэт цэс адраас лавсан орж байлаа. Тэнд цугларагсад Дамблдорын удирдлага дор түүний дуртай шинэ жилийн сүлд дууллыг дууллаа. Хагрид бусдаас чанга дуулж байсан төдийгүй түүний хоолой хундагатай өндөгний коктейль уух болгоны дараа улам чангарч байв. Ахлагчийн тэмдгийг нь Фред хэрхэн илбэдсэнийг Перси ажигласангүй. Тэмдэгэн дээрх «Маанаг» гэсэн бичгийг харсан хүүхдүүд гайхан

инээлдэхэд Перси чухам яагаад гэдгийн учрыг олохгүй байлаа. Харри шинэ цамцаа өмсөн баярт ирсэн юм. Слизеринийхний ширээний ард суугаа Драко Малфой шинэ гоёлыг нь хараад шоолонгуй инээж байсан ч Харри огт тоосонгүй. Тэгж л байг. Бүх юм ёсоороо болоох аваас хоёр гурван цагийн дараа Малфой таарах шангаа хүртэх юм чинь.

Рон Харри хоёрыг шинэ жилийн гурав дахь зүсэм чунзаа идэж дуусахыг хүлээж байсан Гермiona үдшийн ажиллагааныхаа дэлгэрэнгүй төлөвлөгөө зохиохын тулд тэднийг дагуулан танхимаас гарав.

- Бид одоо дүрд нь хувилах хүнийхээ үс, хумс зэрэг ямар нэг өчүүхэн зүйл олж авах хэрэгтэй байна гэж тэрбээр ердөө л хажуугийн мухлагаас саван авах тухай ярьж байгаа юм шиг хайхрамжгүй өнгөөр хэллээ. Тэгснээ:

- Үүнд Малфойн дотны анд Крэбб Гойл хоёр л илүү таарна. Тэд бүх нууцаа хуваалцдаг юм чинь. Бас Дракотой ярилцаж байх үедээ жинхэнэ Крэбб Гойл хоёрыг нэг тийш нь зайлуулах хэрэгтэй байдаг. Тэгэхгүй аваас хамгийн тааламжгүй үед ороод ирж мэднэ. Гэхдээ би бүгдийг тооцоолсон гэж ярихдаа Гермiona нөхдийнхөө гайхсан царай аннзаараагүй дүр эсгэнэ. Тэрбээр нөгөө хоёртоо том шоколадан бялуу хоёрыг үзүүлээд:

- Энд жаахан нойсруулсах эм шахчихсан юм. Зүгээр л Крэбб, Гойл хоёрт харагдахаар газар тавих хэрэгтэй. Тэдний ховдог гэдгийг та нар мэдэхгүй биш. Харах л юм бол идэж таарна. Тэгээд л унтчихна. Тэр хоёрыг шал угаах мод байдаг пинд нуучихаад хэн хэнээс нь хэдэн үс зулгаагаад авчих гэв.

Рон Харри хоёр бие биенээ гайхшран харлаа.

- Гермiona, миний бодлоор бол ...

- Энэ чинь муугаар төгсөж болзошгүй ...

Гэвч Гермionaгийн нүд яг л профессор МакГонагаллын нүд хааяа ширүүн гялалздаг шиг гялтганаж:

- Крэбб Гойл хоёрын үсгүйгээр уусмал үйлчлэхгүй. Та нар Малфойтой ярилцмаар байна уу, үгүй юу? хэмээн шулуухан асуулаа.

- За, за. Харин чи яах юм бэ? Хэний үсийг авах вэ? гэж Харри өгүүлэв.

- Би аль хэдийн олоод авчихсаан! Милисентийг санаж байна уу? Халз тулааны бэлтгэл хийхэд бид хоёр тулалдсан шүү дээ. Тэр чинь намайг боох санаатай байсан юм. Энэ үед үс миний жанч дээр үлдсэн байлаа. Шинэ жилийн амралтаар тэр гэр лүүгээ явчихсан боловч би буцаж ирмээр санагдаад гэж Слизеринийхэнд ярина гэж Гермiona хэлээд халааснаасаа жижигхэн шил гаргаж ирэв. Тэрхүү шилэнд цорын ганц богинохон хялгас байлаа.

Ингээд Гермiona нөгөө олон найрлагатай уусмалаа яаж байгааг харахаар явав. Рон яг л шүүхийн өмнө байгаа мэт царайлан Харрийг хараад:

- Сургуулийн дүрэм журмыг нэг дор ийм олон удаа зөрчих төлөвлөгөөг чи урьд өмнө үзсэн үү? гэж асуулаа.

Гэхдээ үйл ажиллагааны эхний хэсэг яг л төлөвлөгөөний дагуу өчүүхэн ч гажуудалгүй болж өнгөрсөнд Рон Харри хоёр багагүй гайхжээ. Шинэ жилийн цайллагын дараа тэр хоёр Крэбб Гойл нарыг хүлээж хоосон хонгилд нуугдлаа. Харин нөгөө хоёр нь Слизеринийхний ширээний ард хоёулхнаа үлдээд цөцгийн тос бүхий дөрөвдөх амттай боовоо чихэж суулаа. Шоколадан бялуугаа Харри хонгилд ил

харагдахаар газар тавьжээ. Крэбб Гойл хоёрыг их танхимаас гарахыг хармагцаа андууд маань орох хаалганы дэргэдэх баатрын баримлын араар хурдхан нуугдав.

- Чи ч улам бүдүүрнэ дээ! гэж Рон хүү нөгөө бялууг заан Гойлыг тохойгоороо нудрах Крэббийг харан шивнэлээ. Нөгөө хоёр бялууг шүүрэн авмагцаа том ам руугаа чихэж амтархан идэж гэнэ. Хором хэртэй тэд ховдоглон зажилж байснаа тэр дороо л унтаад өгчээ.

Хамгийн хэцүү нь тэр хоёрыг хонгилоор чирэн агуулах руу аваачих явдал байлаа. Андууд маань нөгөөдүүлээ хувин шал угаах модны хооронд хэвтүүлээд дараагийнхаа ажилд оржээ. Харри хоёр ширхэг үс Гойлын толгойноос авахад Рон ч мөн Крэббийн арзгар үснээс хоёрыг авчээ. Бас тэр хоёрын шаахайг авах хэрэг гарлаа. Тэр хоёрын шаахайд Крэбб Гойл хоёрын хөл багтахгүй нь мэдээж. Үүнийгээ амжуулчихаад андууд маань бас л түгшсэн хэвээр уйланхай Миртлийн жорлон руу явлаа.

Гермионагийн уусмалаа янзалж буй өрөөнөөс өтгөн утаа баагина. Жанчаараа нүүрээ халхалсан Харри Рон хоёр хаалгыг аяархан тогшоод:

- Гермиона! гэлээ.

Түгжээ дуугарах дуулдаад царай нь улайж догдолсон Гермиона гарч ирлээ. Түүний ард нөгөө уусмал пор порхийн буцлана. Жорлонгийн суудал дээр гурван шилэн аяга бэлэн байх ажээ.

- Олж ирэв үү? гэж охин шивнэн асуулаа. Харри түүнд Гойлын үсийг үзүүллээ.

- Сайн байна. Би угаалгын өрөөнөөс жанч аваад ирсэн. Та хоёр Крэбб Гойл хоёр болоход том жанч хэрэг болно гэж хэлээд Гермиона том боодолтой зүйл харуулжээ.

Тэд тогоотой юмаа харлаа. Уусмал яг л буцлан байгаа өтгөн хар шавар шиг юм.

- Ямар ч алдаа гараагүй гэж найдаж байна гээд Гермиона «Хүчтэй үйлчлэгч уусмал» гэдэг толбо болсон номынхоо хуудсыг эргүүлэн шалгаад:

- Яг л номонд бичсэн шиг харагдаж байна. Бид үүнийг уусныхаа дараа нэг цаг болоод урьдынхаа төрхөнд хувирах юм гэлээ.

- Одоо тэгээд яах вэ? гэж Рон дуугаа намсган асуув.

- Аяганууддаа хувааж хийгээд үсээ нэмцгээе.

Гермиона нөгөө тусгүй ундаанаас аяга бүрт ахиухан хийлээ. Тэгээд нөгөө шилэнд байсан үсээ эхний аяганд чичирсэн гараараа сэгсрэн унагав.

Уусмал буцалж буй данхтай цай шиг шуугиж байснаа хөөсөрлөө. Тэгээд агшин зуур шар ногоон өнгөтэй болов.

- Үгүй ер! Энэ чинь Милисента Булстроудын үнэн төрх байна. Амт нь ч бас тийм муухай гэж бооцоо тавья гэж Рон уулга алдлаа.

- Одоо та хоёр нөгөө үсээ хий гэж Гермiona тушаав.

Харри Рон хоёр аягандаа нэг нэг ширхэг үс хийлээ. Уусмал шуугин хөөсрөхдөө Гойлынх хүрэн ногоон, Крэббийнх хар хүрэн өнгөтэй болжээ. Рон Гермiona хоёр аяга руугаа гараа сунгатал Харри тэднийг зогсоож:

- Байзаарай. Бүгд зэрэг ууж болохгүй. Крэбб Гойл болон хувирсныхаа дараа бид энд багтахгүй. Милисента ч бас лусын дагина биш гэв.

- Зүйтэй санаа байна. Өөр өөр өрөөнд орцгооё гэж Рон хэлээд үүд нээлээ.

Үнэт уусмалаасаа нэг ч дусал цалгиахгүйг хичээн Харри хажуугийнхаа өрөөнд оров.

- Бэлэн үү? гэж тэрбээр асуулаа.

- Бэлэн! гэх Рон, Гермiona хоёрын дуу сонсогдов.

- Нэг ... хоёр ... гурав!

Харри хамраа чимхэн байж уусмалыг хоёр том балгаад хоосолчихлоо. Амт нь яг л ялзарсан байцаа шиг юм.

Тэгтэл олон арван амьд могой залгичихсан юм шиг дотор гэдэс нь арзаганаж гарлаа. Гэдэс хуруу хөл гар нь жирвэгнэнэ. Ямар нэг аймшигтай өвчин тусчихсан байвал яанаа? Харри эвхрэн тонгойж амьсгаадаж өвдөг дээрээ уналаа. Тэсэхийн аргагүй жирвэгнэх ажээ. Арьс нь халуу оргиж, халуун лав шиг хайлж байна уу даа гэмээр. Тэгтэл бүр гайхалтай юм боллоо! Харсаар байтал гар нь уртсаж хуруу нь бүдүүрч хумс нь өргөсөж хурууны үеүд нь боолтны толгой шиг бондойн томорлоо. Бас үс хөмсөг рүү нь буун уртсаж, мөр цээж нь эмзэглэмээр өвдөн өргөсөхөд жанч тэсэлгүй яг л хөөж буй орхны бүслүүр шиг пидхийн урагджээ. Шаахайд хөл нь багтахаа болилоо. Дөрвөн хэмжээсээр бага юм чинь аргагүй ээ.

Хувирах үйлдэл эхэлсэн шигээн гэнэтхэн дуусчээ. Харри нүүрээ хүйтэн чулуунд наан хэвтэхдээ жорлонгийн цаад өрөөнд Миртл ямар нэг юманд дургүйцэн бувтнаж байхыг сонслоо.

Тэрбээр шаахайгаа арайхийн тайлаад босов. Ямар ч атугай Гойл болон хувирчээ. Хэдийгээр чичрэн байгаа ч мангар том гараараа Харри өсгийнөөсөө дээш хагас метр шахам богинодсон жанчаа тайлаад Гермionaгийн авчирсан жанчыг өмсөж, Гойлын завь шиг шаахайг углаж үзлээ. Үсээ хойш хаях гэсэн боловч гарт нь ширүүн,

богинохон үс тааралджээ. Нүдний шилтэй болохоор бүх юм мананд байгаа юм шиг харагдана. Гойл шил зүүдэггүй байж л дээ. Харри шилээ хурдхан авлаа.

- Хөөе, та хоёр яаж байнаа? гэж асуусан чинь яг л Гойлын нарийхан сөөнгө дуу гарч байна.

- Зүгээр гэх Крэббийн дуу баруун талд нь гарав.

Харри үүдээ нээж цав суусан толь руу ойртлоо. Түүнийг Гойлын маанагдуу хөнхөр нүд харах ажээ. Харри чихээ маажихад Гойл ч мөн адил.

Роны өрөөний үүд нээгдэв. Тэр хоёр бие биеэ харлаа. Яльгүй цонхигор, арай маанаг төрхийг эс тоцвол Роныг Крэббээс ялгах арга алга. «Хөтөвч» лугаа засуулсан үс сармагчных шиг урт гар нь хүртэл адилхан юмаа.

- Хачин юм даа. Үнэхээр гайхалтай! гэж Рон толь руу очоод Крэббийн шантгардуу хамрыг заан харангаа үглэнэ.

- Хурдхан явцгаая. Бид бас Слизеринийхний зочны өрөөг эрж олох хэрэгтэй.

Замдаа тааралдсан хүүхдийг дагаж явахаас ... гэж Гойлын бадриун бугуйд шигдсэн цагныхаа оосрыг сулруулах зуураа Харри хэллээ.

Рон Харрийг нүд салгалгүй ширтэж байснаа:

- Юм бодож байгаа Гойлыг харахад хачирхалтай байна шүү ... гэлээ. Тэрбээр Гермionaгийн үүдийг тогшоод:

- Чи юунд бүгээд байнаа? Явах боллоо ... гэв. Тэгтэл чанга хахирган дуу гарч:

- Би ... Би явахгүй ээ. Та хоёр л яв гэлээ.

- Гермiona минь, бил Милисента Булстроудыг царай муутай гэдгийг мэднээ.

Чамайг гэж хэн ч бодохгүй.

- Үгүй ээ ... Үнэн хэрэгтээ ... Би явахгүй байсан нь дээр. Та хоёр цаг алдалгүй явж үз.

Харри Роныг гайхан харлаа.

- Одоо л чи Гойлтой илүү адилхан байна. Багшийг юм асуухад яг ингэж хардаг юм гэж Рон хэлэв.

- Гермiona чи зүгээр биз? гэж Харри хаалганы завсраар асуулаа.

- Зүгээр ээ ... Яг номоороо ... Та нар явцгаа.

Харри цагаа харлаа. Үнэт жаран хормын тав нь өнгөрчихсөн байв.

- Биднийг буцаад ирэхэд учир явдлаа яриарай гэж Харри хэллээ.

Рон Харри хоёр үүдийг болгоомжтой нээгээд зам чөлөөтэй байхыг хармагцаа явцгаалаа.

- Гараа бүү хаялаад бай гэж Харри аяархан хэлэв.

- Юу гэнээ?

- Крэббийн гар биедээ наалдчихсан юм шиг явдаг юм.
- Ингэвэл болох уу?
- Арай дээр байна.

Тэд гантиг шатаар газар доорх байр луу буулаа. Эргэн тойронд ганц ч хүн амьтан алга. Слизеринийхэн хаачсан юм болоо? Тэднийг үгүйд Малфой руу очно гэж байхгүй.

- Одоо яах вэ? гэж Харри аяархан асуув.
- Слизеринийхэн өглөөний цайндаа тэндээс дандаа ирдэг юм гээд Рон газар доорх үүд рүү толгой дохилоо. Түүнийг үгээ дөнгөж дуусгамагц урт буржгар үстэй нэг охин үүдээр гарч харагдав. Рон түүний зүг яаран очоод:
- Уучлаарай, бид зочны өрөөнд яаж очдогоо мартчихаж ... гэлээ. Охин түүнийг таагүй байдлаар хараад:
- Өршөөгөөрэй, бид өөр өөр өрөөтэй шүү дээ. Би Когтевраных гэлээ. Тэгснээ тэднийг сэжиглэнгүй харсаар гүйж одов.

Ямар ч арга алга. Харри Рон хоёр чулуун шатаар бууж харанхуйд орлоо. Шалан дээгүүр явахад Крэбб Гойл хоёрын том гутал ихээхэн цуурайтай чимээ гаргах аж. Санаснаас хавьгүй ээдрээтэй болж байгааг тэд мэдэрч байлаа.

Газар доорх дамжих өрөөнүүд хов хоосон. Хөвгүүд ямар хугацаа үлдэж байгааг байнга шалгасаар улам бүр уруудаж байв. Арван таван хормын дараа тэд бүр аргаа барж байтал урд нь ямар нэг юм хөдөлж харагдлаа.

- Ай даа! Тэдний нэг явж байх шиг! гэж Рон баясан хэлэв.

Хажуугийн хаалгаар нэг хүүхэд гарч ирлээ. Тэд ойртохоор яарах үед зүрх нь түгшиж байв. Гэтэл энэ нь Слизеринийхний хүүхэд биш Перси байжээ.

- Чи энд юу хийж байгаа юм бэ? гэж Рон гайхан асуулаа. Персийн царай уурласан байртай харагдана.
- Энэ та нарт хамаагүй. Би буруу хэлээгүй биз, Крэбб ээ? гэж тэрбээр хариулав.
- Зам ... тийм дээ гэж Рон хэллээ.
- Өрөө рүүгээ очицгоо. Ийм өдөр харанхуй хонгилоор тэнэх аюултай шүү гэж Перси эрсхэн өгүүлэв.
- Чи төөрсөн юм байна гэж Рон эсэргүүцлээ.
- Би ахлагч. Хэн ч над руу дайрч зүрхлэхгүй хэмээн Перси цээжээ цэхлэн хэллээ.

Гэнэтхэн тэдний ард хэн нэгний дуу гарлаа. Тэдний зүг Драко Малфой яаран явах ажээ. Түүнийг хараад Харри амьдралдаа анх удаа баярласан юм.

- Та нар энд байгаа юм уу? Их танхимд унтчихсан юм биш биз дээ? Би та нарт нэг сонин юм үзүүлэх санаатай эрж байлаа гэж Малфой нөгөө хуучнөөрөө үгээ сунжруулан хэлэв.

Малфой Персийг тун ч таагүй харцаар ширтэнэ.

- Уизли чи энэ дор юу хийж яваа юм бэ? гэж тэрбээр шоолонгуй инээмсэглэн асуулаа.

Перси дургүй нь хүрсэн бололтой:

- Ахлагчийг аль болохоор хүндэтгэх хэрэгтэй. Таны харьцаа таалагдахгүй байна! гэлээ.

Малфой ахин жуумалзаад Рон Харри хоёрыг араасаа дага гэж зангав. Харри Персигээс уучлал гуйх гэснээ тэр дорхноо ухаарчээ. Рон тэр хоёр дараагийн хонгил руу эргэж амжсан Малфойн араас дагаж явтал:

- Энэ Питер Уизли хэтэрхий биеэ тоожээ гэж Малфой хэлэв.

- Перси гэгч хэмээн Рон санамсаргүй залрууллаа.

- Ямар ялгаа байх вэ дээ. Түүнийг шөнө дөлөөр ч энд явж байхыг би харсан.

Слизериний залгамжлагчийг барина гэж л бодоод байгаа юм гээд Малфой пархийтэл инээв.

Рон Харри хоёр бие биеэ харлаа.

Малфой чийгэнд норсон нүцгэн хананы дэргэд зогсоод:

- Шинэ нууц үг маань юу билээ? гэж Харригаас асуув.

- Ээ ... мм ... гэж Харри гүнгэнэнэ.

- Өө, саналаа. «Цэвэр цус!».

Хананы хэсэг хажуу тийш болж зай гаргав. Малфой дотогш итгэлтэй алхахад Харри

Рон хоёр түүнийг дагав.

Слизериний их танхим чулуун ханатай урт намхан өрөө агаад ногоондуу дэнлүүнүүд адраас дүүжилжээ. Сайхан хээгээр чимэглэсэн ханан зууханд гал шажигнан асаж эргэн тойронд буй силийбэртэй сандал дээр Слизериний хүүхдүүд суусан харагдана.

- Энд хүлээж бай. Би яваад өнөөдөр аавын явуулсан юмыг аваад ирье гэж Малфой тушаагаад ханан зуухнаас алсхан байгаа хоёр сул сандлыг гараараа заажээ.

Андууд Малфой чухам юу үзүүлэхийг сониучирхан сандалд суугаад яг л өөрсдийнхөө өрөөнд байгаа мэт дүр үзүүлнэ.

Хормын дараа Малфой гартаа сонины хайчилбар барьсаар хүрч ирлээ.

- Уншаад инээцгээ! гэж хэлээд тэрбээр сонингоо Роны хамарт тулган барив.

Рон гайхсандаа нүдээ бүлтийлгэжээ. Хайчилбарыг хурдхан уншаад инээсэн дүр үзүүлэн Харрид өглөө.

«Өдөр тутмын номлогч» сонины тэмдэглэлд:

«Ид шидтэний яаманд мөрдөн байцаалт явууллаа. Маглуудын зохион бүтээсэн зүйлийг хууль бусаар ашиглахтай тэмцэх хэлтсийн эрхлэгч Артур Уизлийг өнөөдөр маглуудын машиныг ид шидийн хүчээр өөрчилсний нь төлөө тавин галлеоноор торгожээ. Энэхүү илбэдүүлсэн машины энэ жил эвдэрсэн газар болох ид шидтэний

«Хогвартс» сургуулийн ивээн тэтгэх зөвлөлийн дарга ноён Люциус Малфой өнөөдөр ноён Уизлийг огцор гэж шаардсан байна.

- Уизли Яамны нэр хүндийг гутаалаа. Түүнийг ямар нэгэн хууль гаргахад оролцуулж болохгүй нь эргэлзээгүй бөгөөд маглуудыг хамгаалах тухай түүний гаргасан инээдэмтэй журмыг нэн даруй хүчингүй болгох хэрэгтэй гэж ноён Малфой манай сурвалжлагчид ярьсан байна.

Ноён Уизли тайлбар өгөхөөс татгалзсан бөгөөд түүний гэргий сурвалжлагчдыг гарахгүй бол гэрийнхээ ороолонг тавина хэмээн заналхийлжээ» гэсэн байлаа.

- За ямар байна? Инээж үхмээр байгаа биз! гэж Малфой сонинг Харрийн гараас авахдаа хэллээ. Харри:

- Хар-ха-ха гэж доройхон инээв.

- Артур Уизли маглуудыг хүндэтгэдэг төдийгүй тэдний бүх юмыг дуурайх гэж шидэт саваагаа ч хугалахад бэлэн байдаг юм. Уизлийнхныг хараад байхад цэвэр цустай гэж огт хэлмээргүй! хэмээн Малфой хардангуй өгүүлнэ.

Рон, өөрөөр хэлбэл Крэбб галзуурах шахам үрчийжээ.

- Крэбб чи яагаад байнаа? гэж Малфой түүнийг ууртай харан хэллээ.

- Гэдэс мушгираад гэж Рон бувтнана.

- Эмнэлэг рүү очоодд тэнд байгаа эрлийзчүүдийг миний өмнөөс балбаарай гэж

Малфой хэлснээ:

- «Өдөр тутмын номлогч» сургуульд болсон дайралтын тухай сурвалжлага нийтлээгүй нь хачирхалтай. Дамблдор энэ явдлыг нуух гэсэн байлгүй. Хэрэв иймэрхүү дайралт ойрын үед зогсохгүй бол түүнийг ус уухаас ч амархан хусна

даа. Дамблдор бол хамгийн гайтай амьтан гэж аав дандаа ярьдаг юм. Тэр чинь эрлийзчүүдэд хайртай. Жинхэнэ захирал бол Криви мэтийн амьтдыг сургуульдаа хэзээ ч авахгүй байсандаа гэж үргэлжлүүлэв.

Малфой зураг авч буй дүр үзүүлэхдээ Колиныг тун ч чадмаг дуурайх ажээ. Тэрбээр:

- Поттер би чиний зургийг авч болох уу? Надад гарынхаа үсгийг өгч хайрлаач.

Поттер би чиний гутлын улыг долоох уу? хэмээн элэглэснээ:

- Өнөөдөр та хоёр чинь юу болоод байна? гэж тэднийг хараад асуулаа.

Хэдийгээр хожимдсон ч гэлээ Харри, Рон хоёр нэг муу инээхчээн аядав. Гэхдээ

Крэбб Гойл хоёр сэтгэхдээ удаан болохоор Малфойн сэтгэл ханажээ.

- Ариун Поттер бол эрлийзүүдийн анд даа. Саваагүйгээр юу ч хийж чадахгүй шүү дээ. Баярлаж бахархах мэдрэмжгүй амьтан. Жинхэнэ шидтэн байсан бол хий хоосон цээжлэгч, эрлийз Гермionatoй хэзээ ч үерхэхгүйсэн. Түүнийг Слизериний үе залгамжлагч гэлцээд байгаа шүү! хэмээн урсгалаа.

Рон Харри хоёр одоо л түүнийг нууцаа илчлэх байх гэж амьсгал даран сонсож байв. Гэвч Малфой дууныхаа өнгийг өөрчилж:

- Үе залгамжлагч чухам хэн гэдгийг мэдэх сэн. Би түүнд тусламаар байна ... гэлээ.

Малфой үүнийг мэдэхгүй гэдэг нь илт байв. Рон доод эрүүгээ унжуулан суусан нь Крэббийг улам маанаг харагдуулна. Малфой сэжигтэй юм юу ч ажиглаагүй болохоор Харри чухам юу хэлэхээ агшин зуур сэтгэжээ.

- Гэхдээ чи үүний ард хэн байгааг тааварласан биз дээ? гэв.

- Би юу ч мэдэхгүй гэж чамд хичнээн удаа хэлэх юм бэ, Гойл минь! Аав юу ч ярьдаггүй юм. Өрөөг сүүлчийн удаа тавин жилийн тэртээ түүнийг энд суралцахаас ч өмнө онгойлгосон гэлцдэг. Гэхдээ тэр бүгдийг мэдэж байгаа. Энэ бол маш том нууц. Намайг их юм мэдэх аваас санамсаргүй чалчина гэж аав минь айдаг юм. Гэхдээ би нэг юм мэднэ. Өрөөг сүүлчийн удаа онгойлгоход эрлийзүүдийн хэн нэг нь алагдсан гэдэг юм. Энэ удаа хэн нэгний бодийг хөтлөх бол дэмий чалчигч Грэйнджер таараасай! гэж харгис дүртэй хэллээ.

Рон Крэббийн мундаг том нударгыг зангиджээ. Хэрэв одоо Малфойг өшиглөж орхивол бүх төлөвлөгөө нурах болно. Иймд Харри түүнийг сануулах янзтай харж байв.

- Өрөөг онгойлгосон хүнийг барьсан эсэхийг чи мэдэх үү? гэж Харри Малфойгоос асуулаа.

- Тэгэлгүй яахав ... Түүнийг хөөчихсөн. Одоо болтол Азкабанд байгаа байлгүй.

- Азкабанд гэнээ? Харри учрыг ойлголгүй лавлав.
- Азкабан бол шидтэнгүүдэд зориулсан шорон. Чи ч мөн мунхаг юм аа.

Үнэнийг хэлэхэд үүнээс ч мунхаг байсан байж магадгүй. Гэхдээ чи өнөөдөр бүх дээд амжилтыг эвдлээ.

Малфой суудалдаа тух муутайхан сууна.

- Аав маань намайг үүнтэй бүү орооцолд гэсэн. Үе залгамжлагч нь хийх ажлаа хийвэл барав. Энэ бүх муухай зүйлийг сургуулиас зайлуулах цаг аль хэдийн болжээ. Гэхдээ бид зайгаа барих хэрэгтэй. Аавд ч одоо олигтой юм болохгүй. Өнгөрсөн долоо хоногт Ид шидтэний яам манай шилтгээнд нэгжлэг хийснийг та хоёр мэдэж байгаа.

Харри Гойлын маанаг царайд харууссан дүр тодруулахыг хичээнэ.

- Олигтой юм олоогүй л дээ. Аавд маань хар шидийн ёслолын мөргөлд зориулсан маш үнэтэй эдлэлүүд бий. Зочны том өрөөний шалан дор хадгалдаг юм.
- Ёстой сайхан! гэж Рон уулга алдлаа.

Малфой түүнийг эгцлэн ширтэхэд Харри ч бас дуурайв. Роны царай улайж, үс нь хүртэл шаргалтаж, хамар нь аажим аажмаар сунаж байв. Тэдэнд оногдсон хугацаа дуусч байгаа нь тэр. Рон буцаад хуучин төрхөндөө орж байгаагаа Харрийг хараад л мэдэж авлаа.

Тэр хоёр зэрэг ухасхийн бослоо.

- Хурдхан явж гэдэсний эм олж ирье! гэж Рон хашгираад анд хоёр Малфойг анзаараагүй байх гэж итгэн тэрхүү өрөөнөөс гүйн гарлаа.

Харри биеэ жижгэрч байгааг мэдэв. Том шаахай дотор хөл нь холхиндог оргин, жанчныхаа хормойг өргөж явахаас өөр аргагүй байлаа. Тэр хоёр чанга чанга дэвслэн шатаар өгсөж харанхуй хонгил руу очиход Крэбб Гойл хоёрыг түгжиж орхисон өрөөнөөс ямар нэг юм цохих чимээ гарна. Тэдний шаахайг өрөөний үүдэнд чулуудчихаад андууд маань дан оймстойгоо гантиг шатаар уйланхай Миртлийн өрөө рүү гүйлдлээ.

- Ерөнхийдөө бид цагаа дэмий үрсэнгүй шүү. Бид хэн дайралт хийгээд байгааг мэдэж чадсангүй ч маргааш аавд захиа бична. Малфой зочны өрөөнийхөө шалан дор юу нугаад байгааг шалгуулах биз гэж Рон хаалгаа дөнгөж хаамагцаа амьсгаадан хэлэв.

Харри цав суусан толинд өөрийгөө анхааралтай харлаа. Ахиад л хуучин хэвдээ оржээ. Тэрбээр сэтгэл амарсан янзтай санаа алдаад нүднийхээ шилийг зүүхэд Рон Гермionaгийн байгаа бүхээгний үүдийг тогшиж байв.

- Гермiona, хурдхан гараад ир. Бид чамд баахан юм яримаар байна.

- Та нар явцгаа! гэж Гермiona хаалганы цаанаас хашгирав. Харри Рон хоёр бие биеэ харлаа.

- Юу болсон юм бэ? Чи буцаад хэвдээ орчихоо биз дээ? Харри бид хоёрын бүх юм номоороо гэж Рон асуув.

Тэгтэл уйланхай Миртл гэнэтхэн бүхээгний хаалганы завсраар гараад иржээ. Түүний ийм баяртай байхыг Харри хэзээ ч харсангүй.

- Ай даа! Одоо л та нар харна даа! Аймаар юм! гэж хэлэхдээ түүний тунгалаг дүгэрэг царайд хөөр баяр гэрэлтэж байв.

Үүдний түгжээ дуугараад Гермiona жанчаар нүүрээ бүтээчихсэн уйлсаар гарч ирлээ.

- Юу болсон бэ, Гермiona? Милисентийн муухай хамар хэвээрээ үлдчихсэн үү? гэж Рон түгшин асуув.

Герминаг жанчаа авахад Рон ар тийш ухрахдаа суултуурт суучихжээ.

Түүний нүүрэнд дүүрэн хар үс ургасан байв. Нүдэнд нь шар өнгө туяарч, толгойд нь хоёр шовх чих соотойно.

- Энэ чинь муурын үс байжээ! Милисент Булстроуд гэртээ муур тэжээдэг болж таарлаа! Харин уусмал маань амьтныг буцааж хүн болгодоггүй юм.

- Тийм үү ... хэмээн Рон арайхийн дуугарав.

- Чамд тохирсон аятайхан хоч өгөх байлгүй гэж Миртл баярлана.

- Санаа зовох хэрэггүй ээ, Гермiona. Одоохон эмнэлэг рүү очигцооё. Хатагтай Помфри хэзээ ч илүү дутуу юм асуудаггүй ... гэж Харри яаран ярианд оролцлоо.

Андууд Гермionaг жорлонгоо орхи гэж удаан ятгажээ. Эцсийн эцэст өөр аргагүй болохоор Гермiona ч зөвшөөрлөө. Уйланхай Миртл тэдний араас цангинатал инээж:

- Байзаарай, ардаа сүүлтэйгээ мэдэгдэх хэрэгтэй шүү! гэж хашгирна. Уйланхай Миртл хөөрсөндөө тэнгэрт гарах нь холгүй байлаа.

БҮЛЭГ 13: ШИДЭТ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ

Гермиона эмнэлэгт хэдэн долоо хоног хэвтжээ. Шинэ жилийн амралт дуусах дөхөж хүүхдүүд бөөн бөөнөөрөө ирж байсан болохоор Гермионаг алга болсон тухай элдэв цуурхал дэгдэж байлаа. Түүнийг дайралтанд өртсөн гэж зарим нь бүр итгэжээ. Түүнийг эргэх гэсэн хүүхдүүд тоймгүй байсан болохоор хатагтай Помфри орыг нь тойруулан хөшиг татсан юм. Учир нь түүний нүүр муурын төрхтэй хэвээр байлаа. Яаж тийм байдалтай хүүхдүүдэд харагдах билээ! Тэгвэл охин тэсэхгүй шүү дээ.

Рон Харри хоёр түүнийг орой болгон эргэнэ. Харин хичээл эхлэхэд тэд бүх гэрийн даалгавраа түүнд авчирч өгдөг боллоо.

- Хэрэв надад сахал юм уу, арслангийн зогдор ургасан бол би бүхэл бүтэн амралтын хугацаанд хэвтэх байж дээ гэж Рон тэр үдэш хэлээд Гермионагийн орны ойролцоох ширээн дээр баахан ном тавьжээ.

- Рон минь, бүү тэнэг юм ярь. Чи ангийхнаасаа хоцорно гэж Гермиона хөгжилтэй хэллээ. Түүний нүүрэнд ургасан хар үс алга болж, нүд нь ахин хар өнгөө олж, түүний сэтгэл санаа өөдрөг болжээ.

- Та нараар сонин юм алга уу? гэж хатагтай Помфрид дуулдахааргүй шивнэн асуув.

- Юу ч алга гэж Харри уруу царайлан хэллээ.

- Би Малфой тэгсэн байх гэж итгэж байсан юм даа хэмээн Рон зуу дахь удаагаа давтжээ.

- Энэ чинь юу вэ? гэж Харри түүний дэрэн доороос цухуйх алтан хүрээтэй зургийг хараад асуулаа.

- Зүгээр л баярын мэндчилгээ гэж Гермиона яаран хариулаад ил захидлыг лавхан шургуулах гэсэн авч Рон илүү шалмаг байжээ.

Тэрбээр ил захидлыг дэрэн доороос суга татаж аваад дэлгэж:

- Хатагтай Грэйнджер танд гүн харамсал илэрхийлж, түргэн эдгэрэхийг хүсэн ерөөж Мерлиний гуравдугаар зэргийн одонт, хар хүчнээс хамгаалах байгууллагын хүндэт гишүүн, хамгийн сайхан инээмсэглэлтэй хүнийг шалгаруулах «Шидэт долоо хоног» сэтгүүлийн уралдааны таван удаагийн ялагч, профессор Алтан хонгиот Туг үс мэндчилэв гэж чангаар уншаад Гермионаг зэмлэнгүй харснаа:

- Чи үүнийг дэрэн доороо хадгалж байдаг хэрэг үү? гэж асуулаа.

Энэхүү таагүй ярианаас Гермионад оройн эм авчирсан хатагтай Помфри чөлөөлжээ.

- Огт ойлгохгүй юм. Туг үс хамгийн ухаантай нь болж таарч байна уу? гэж Рон Гриффиндорын шилтгээн рүү явах замдаа ярина.

Хичээлээ хийх цаг болжээ. Снег багш тэдэнд зургадугаар дамжаандаа л барж магадгүй их даалгавар өгсөн аж. Үс арзайлгагч уусмалд хархын хэдэн сүүл хийх ёстойг Гермионагаас асуудаг байжээ гэж Рон чангаар үглэнэ. Гэнэтхэн гуравдугаар давхарт уурсан хашгирах дуу гарлаа.

- Филч байна гэж Харри дууг нь таниад хэлэв. Андууд чимээ сайтар сонсон шатаар дээш гүйлдлээ.

- Бас хэн нэгнийг довтолсон юм болов уу? гэж Рон замын хагаст зогсоод айсан байдалтай асуув.

Харин Филч:

- ... Ахиад л ажил гарлаа! Шөнөжингөө цэвэрлэх болох нь ээ! Бүх юманд эцэс төгсгөл гэж байдаг сан. Одоохон Дамблдор луу очье байз! хэмээн хашгичсаар.

- Түүний алхах чимээ намдаж, хаа нэгтээ хаалга дуугарах сонсдоно.

Андууд булан тойрлоо. Филч дөнгөж сая ажиглах байраа орхисон бололтой. Ноён Норрис муур луу хэн нэгэн хүн довтолсон тэр газарт тэд ахин зогсож байлаа. Хөөрхий сангасваа чухам яагаад тэгж дуу болсныг андууд шууд ойлгожээ. Хонгилд жинхэнэ үер болж, ус улам нэмэгдсээр байгаа бололтой. Ус уйланхай Миртлийн жорлонгийн хаалган дороос урсах ажээ. Филчийн орилох дуу дарагдахад Миртлийн уйлах дуу чулуун хананд цуурайтана.

- Тэр бас яачихваа? гэж Рон санаа алдав.

- Явж үзье гэж Харри хэллээ.

Тэд жанчныхаа хормойг шагайнаасаа дээш өргөөд «Жорлон ажиллахгүй» гэсэн бичигтэй үүд чиглэн ус туучсаар очоод урьдын адил бичгийг тоолгүй дотогш орцгоов.

Уйланхай Миртл урьдынхаасаа ч чангаар цурхиран уйлна. Хана шалаар урсах ус лааг унтраасан болохоор жорлонд хав харанхуй.

- Юу болсон бэ, Миртл ээ?

- Тэнд хэн байна вэ? Намайг бас өөр юмаар шидэх гэж ирээ юу? хэмээн золгүй

Миртл дуугарав.

Харри нимгэн хэсгийг даган түүний бүхээгт хүрч очлоо.

- Би яагаад чам руу юм чулуудах ёстой билээ? гэж Харри асуув.

- Би яаж мэдэх юм! гэж Миртл хашгираад усны савнаас шал руу асгарах давалгаанаар гарч ирэв. Тэгснээ:

- Би тэнд суугаад юухан хээхэн хийж хэнд ч саад болдоггүй билээ. Тэгтэл намайг номоор шидээд эхлэх юм! гэлээ.

- Гэхдээ чамайг яах ч үгүй. Ном чамайг нэвтрээд л гарах болно гэж Харри татгалзан өгүүлэв.

Ингэж хэлмэгцээ Харри тун ч гэмшжээ. Миртл дээш хөөрснөө чанга дуугаар:

- Тэгэхээр хөөрхий Миртлийг шидээд байж болох нь ээ? Тэр юу ч мэдэхгүй юм чинь гэж үү? Түүний гэдсийг оновол арван оноо авна! Толгойг нь оновол тавин оноо! Сайхан тоглоом байна даа! Гэхдээ надаар тоглоод байж болохгүй шүү дээ! гэж хашгирав.

- Тэгээд хэн чамайг шидсэн юм бэ? гэж Харри асуулаа.

- Бүү мэд. Би шахуургын залгаасан дээр суугаад үхлийнхээ тухай бодож байтал нэг юм толгойг минь нэвтлэн өнгөрлөө. Одоо тэр зүйл угаалтуурын дор хэвтэж байна гэж Миртл хэлээд андуудыг ууртай харна.

Рон Харри хоёр тонгойгоод хартал жижигхэн нимгэхэн ном хэвтэж байв. Үнгэгдсэн хар хавтастай агаад жорлонд байгаа бүх зүйлийн адил нэвт норсон байжээ. Харри түүнийг авах гэтэл Рон гараас нь шүүрэн авч:

- Чи солиороо юу? Аюултай шүү дээ гэлээ.

- Аюултай гэнээ? Юу нь аюултай байдаг юм? гэж Харри гайхав.

- Асуух л дутаж гэнэ. Тэр ч байтугай яамнаас хураан авдаг ном байдаг гэж аав хэлсэн гэж яриад Рон нөгөө зүйлийг айсан байдалтай харна. Тэгснээ:

- Жишээ нь: нэг ном хүмүүсийн нүдийг түлдэг байсан юм. Бас «Шидийн цэцгэн эрхи» гэдэг ном байжээ. Түүнийг уншсан хүн үхэн үхтлээ шүлэглэн ярих хэрэг гарна. Батад байдаг хөгшин шулмасынхаас ямар ном гарсан гээч. Нэг л нээх

юм бол амьдралынхаа турш уншдаг гэсэн. Явж байсан ч хооллож байсан ч уншаад л байна. Нэг гартаа номоо бариастай нөгөө гараараа юмаа хийнэ гэж ярилаа.

- Үгүй ер гэж Харри хайхрамжгүй хэлжээ.

Шалан дээр хэвтэх нойтон ном өөрийн эрхгүй сонирхол татна. Харри Роныг тойрон гараад:

- Энэ номыг сөхөөд үзвэл бүх нууцыг мэдэж болмоор совин төрөөд байна гэж хэлээд номыг авлаа.

Хавтсан дээрх хагас жилийн тэртээ бичсэн он сарыг хараад Харри энэ бол өдрийн тэмдэглэл гэж шууд мэджээ. Чичирсэн гараар түүнийг нээв. Эхний хуудсан дээр бэхээр бичсэн Т. Н. Реддл гэдэг нэр уншиж болохуйц ажээ.

- Байзаарай. Би энэ нэрийг мэдэх юм байна.

... Тавин жилийн тэртээ Т. Н. Реддл сургуульд онцгой гавъяа байгуулсны төлөө шагнуулж байсан гэж Рон Харрийн мөрөн дээгүүр харснаа хэлэв.

- Чи хаанаас мэдсэн юм бэ?

- Филч намайг бүтэн цаг дурсгалын самбар арчуулах үед. Тэгэхэд би нялцгай хорхойгоор бөөлжсөн шүү дээ. Чи ч гэсэн хэн нэгний нэртэй самбар тийм удаан арчсан бол бас л тогтоох байсан даа.

Харри тэр үед усанд норж пэмбийсэн хуудсуудыг эргүүлж байв. Тэдгээр хуудаснууд цэв цэвэр ажээ. Хаана нь ч «Мэйбл авгын төрсөн өдөр», «Шүдний эмчид 15.30-д» гэх мэтийн нэг ч тэмдэглэл, нэг ч үг үсэг алга байлаа.

- Тэр хүн хэзээ ч юу ч бичээгүй юм байна гэж Харри гоморхон хэлэв.

- Гэхдээ үүнийг хэн яагаад шидсэн юм бол? гэж Рон шилээ маажина.

Харри хар хавтсыг эргүүлтэл дотор талд нь Лондоны Воксхолл-Роудод байдаг дэлгүүрийн хаяг байлаа.

- Дэвтрийн эзэн магл байсан байхаа. Тэгэхгүй бол энэ дэвтрийг тэндээс худалдан авч чадахгүй байсан гэж Харри бодлогоширон хэлэв.

- Энэ ч чинь ямар ч тус болохгүй. Уйланхай Миртлийн хамрыг онох юм бол чамд тавин оноо өгөх байлгүй гэж Рон мөрөө хавчин дугаа аяарсан хэллээ.

Харри ямар ч атугай өдрийн тэмдэглэлийг халаасандаа хийв.

Гермиона хоёрдугаар сарын эх гэхэд сахалгүй хар үсгүй сүүлгүй болоод эмнэлгээс гарчээ. Түүнийг буцаж ирсэн анхны үдэш Харри өдрийн тэмдэглэлээ үзүүлж яаж олсноо ярив.

- Үүнд ямар нэг юм нууцлагдсан байж магадгүй гэж Гермiona өдрийн тэмдэглэлийг анхааралтай хараад хэллээ.

- Хэрэв нууцлагдсан бол тун ч найдвартай байж таарна. Айж ичихээр ч юм байж магадгүй. Харри чи яагаад үүнийг орхиогүй юм бэ? гэж Рон асуув.

- Яагаад түүнийг хаясан тухай мэдмээр санагдсан юм. Бас Реддл ямар онцгой гавъяа байгуулаад шагнагдсан юм бол гэж Харри хэллээ.

- Шагнуулахад амархаа. Гучин СНТ авсан ч юм уу, эсвэл профессорыг аварга наймаалжнаас аварсан ч юм уу ... Миртлийг алсан ч байж блно. Энэ бүхэн алдар хүнд авчирдаг юм чинь ... гэж хэлээд Рон дээш харав.

Гермиона анхаарлаа төвлөрүүлсэн байхыг хараад Харри надтай адил зүйл бодож байгаа юм байж хэмээн ойлголоо.

- Чи ямар нэг бодож олов уу? гэж Рон сониучирхав. Харин Харри түүнд:

- Тэгээд ... гэж Рон лавлана.

- Энэ өдрийн тэмдэглэл ч тавин жил болсон гэж Гермiona сэтгэл догдлон хэлээд хар хавтсыг тогшлоо.

- Тэгээд юу гэж?

- Рон чи ухаарч үзээч! Бид бас нууц өрөөг онгойлгосон хүн тавин жилийн тэртээ сургуулиас хөөгдсөн гэдгийг мэднэ. Т. Н. Реддл бас тавин жилийн тэртээ онцгой гавъяа байгуулагаад шагнагдсан байдаг. Хэрэв тэр Слизериний залгамжлагчийг барьсны төлөө шагнуулсан байвал яана? Энэ өдрийн

тэмдэглэлд нууц өрөө хаана байдаг түүнийг хэрхэн нээдэг ямар юм тэнд байдаг тухай бүгдийг бичсэн байж болох л юм. Харин одоо довтлоод байгаа хүн бол энэ бүхнийг мэдэгдэхийг хүсэхгүй байгаа нь тодорхой, тийм үү? гэж Гермiona дуу алдлаа.

- Гайхалтай санаа байна, Гермiona. Гэхдээ нэг учир байна. Өдрийн тэмдэглэлд юу ч бичигдээгүй гэж Рон зөвшөөрчээ.

Гэтэл Гермiona цүнхнээсээ шидэт саваагаа гаргаж ирээд:

- Үл үзэгдэгч бэх байдаг юм гэж шивнэснээ тэмдэглэлийн дэвтрийг саваагаараа гурван удаа тогшоод:

- Нууц өрөө тавин жилийн тэртээ нээгдсэн гэдэг биз дээ? Малфой ингэж хэлсэн гэлээ.

- Апарекиум! гэв.

Юу ч болсонгүй. Бүтэлгүй болсонд гайхаш тасарсан Гермiona дахин цүнхээ ухаж тод улаан өнгийн даавуу шиг юм гаргаж ирээ:

- Энэ бол илрүүлэгч. Би Тахир гудамжнаас худалдаж авсан юм гэлээ.

Гермиона «Нэгдүгээр сарын нэгэн» гэсэн хуудсыг байдаг чадлаараа үрэвч нэмэр болсонгүй.

- Энд эрээд байх юм алгаа гэж би хэлээд байна шүү дээ. Реддл энэ дэвтрийг шинэ жилийн бэлгэнд аваад юм тэмдэглэхээсээ залхуурсан хэрэг гэж Рон өгүүлэв.

Харри чухам яагаад Реддлийн өдрийн тэмдэглэлийг хаяагүйгээ өөрөө тайлбарлаж чадахгүй байлаа. Хэрэв өдрийн тэмдэглэлийг хоосон гэдгийг мэдсэн ч гэлээ түүнийг авч, хуудсыг нь эргүүлж үзэх л байсан дээ. Өдрийн тэмдэглэл дээр үеийнх болохоор түүний тайлах гэж оролдож буй элдэв явдалтай холбоотой байж болох юм. Хэдийгээр Харри амьдралдаа Т. Н. Реддл гэдэг нэрийг сонсоогүй гэдгээ сайн мэдэж байсан ч түүнтэй ямар нэг холбоотой юм шиг, энэ Реддл гэгч хүүхэд ахуй цагийн нь мартагдах шахсан анд байсан юм иг санагдах бүлгээ ... Гэхдээ энэ бол дэмий хэрэг. Хогвартст орох хүртэл Дурслийхны ачаар хэзээ ч андтай байж үзээгүй юм.

Тэмдэглэл тэр хэвээрээ хоцорлоо. Харри одоохондоо Т. Н. Реддлийн тухай аль болох их зүйл мэдэж авахаар шийдэв. Маргааш нь тэрбээр өдрийн хоолны завсарлагаар Реддлийн шагналын тухай дэлгэрэнгүй зүйл байгаа эсэхийг үзэх санаатай хүндэт танхим руу явлаа. Түүнтэй хамт итгэл муутай Рон, өөрийнхөө бодлыг үнэн гэдэгт итгэсэн Гермиона хоёр цуг очсон юм. Рон болохоор хүндэт танхимаас залхаж гүйцсэн гэж андууддаа хэлээд зүгээр л хамт явсан аж.

Реддлийн нэр бүхий алтан жааз булангийн шүүгээнд байв. Тэрхүү жаазанд Реддлийн шагналын тухай юу ч дурдсангүй.

- Энэ чинь сайн хэрэг. Хэрэв шагналын тухай бичсэн бол жааз арав дахин том байх сан. Тэгвэл одоо болтол зүлгэж суух байсан байлгүй гэж Рон наргиа болгон хэллээ.

Гэхдээ андууд «Ид шидийн гавъяа» гэдэг хуучин медаль дээр, бас сүүлийн зуун жил сургуулийн ахлагч байсан хүмүүсийн жагсаалтан дотроос түүний нэрийг олж үзжээ.

- Перситэй адилхан юм. Тэнхимийн ахлагч. Сургуулийн ахлагч юм чинь ... бүх хичээлдээ бусдаас илүү суралцдаг байсан биз гэж Рон хэлээд хамраа шантайлгав.

- Чи үүнийг муу юм шиг яриад байх юм гэж Гермиона яльгүй гомдсон өнгөөр хэлжээ.

Хогвартсынхан ахиад л нараа үзэн баярлах болов. Дахиж дайралт, довтолгоо гарсангүй бүгд л хөөр хөгжөөнтэй болж хуралдан байсан үүлс ашгүй нэг өнгөрлөө гэх найдлага зүрх сэтгэлийг баясгаж байлаа. Хатагтай Помфри мандрагорууд сэтгэлийн хөдөлгөөнтэй, түгжигдмэл болж байна гэж баяртайгаар мэдэгдсэн бөгөөд энэ бол шилжилтийн насандаа орсон хэрэг ажээ.

Хатагтай Филчтэй уулзан сонин сайхныг хэлэлцэн байхдаа:

- Одоо тэдний батга мөдхөн арилахад нь бид шилжүүлэн суулгана. Дараа нь зүсэж хэрчээд ханд бэлтгэнэ. Тэгээд л мөдхөн ноён Норрис муур дахин тантай хамт байх болно ... гэж ярихыг Харри санамсаргүй сонсчээ.

Слизериний залгамжлагч хэн ч байлаа гэсэн шийдвэрээсээ няцсан юм байлгүй гэж Харрид бодогдох болов. Сургууль даяараа сэрэмжилж байсан юм чинь нууц өрөөг дахин онгойлгоно гэдэг илүү аюултай болсон байлгүй дээ. Нөгөө гайхал амьтан ахиад тавин жил ичээндээ унтахаар шийдсэн байж ч болох юм.

Гагцхан Пуффендуйн Эрни МакМиллан бусадтайгаа адилгүй байлаа. Тэрбээр урьдын адил Харрийг буруутай халз тулааны клубын нээлтийн үеэр өөрөө өөрийгөө илчилсэн гэдэгт итгэлтэй хэвээр байсан юм. Бас Пивз олон хүнтэй хонгилоор нисэж, өөрийнхөө зохиосон:

Харри Поттер, харгис амьтан

Хамаг хүмүүсийн хар алуурчин!

гэдэг дуугаа хоолой мэдэн хашгирна.

Алтан хонгиот Туг үс довтолгоог зогсоох нь өөрийн үүрэг гэж үзсэн бололтой. Харри нэг удаа түүнийг өөрийн байгуулсан гавъяаныхаа тухай ярьж байхыг сэмхэн сонссон юм. МакГонагалл багш Гриффиндорынхонд хувиргалын хичээл заахаар ирж байхад Туг үс хажууд нь явж байлаа.

- Минерва МакГонагалл минь, хохирол дахин гарахгүй гэж бодож байна. Өрөөг энэ удаа бүрмөсөн хаасан байлгүй. Гэмт хэрэгтэн намайг өөрийгөө илчлэнэ гэдгийг ухаарчээ. Энэ бол цаг хугацааны л ажил юм чинь. Намайг тухтайхан хөөцөлдөөгүй дээр муу үйлээ зогсооно гэдэг түүний талаас их л ухаалаг

хэрэг. Дашрамд хэлэхэд хүүхдүүдийн сэтгэл санааг өргөх ямар нэг баяр сургууль даяараа тэмдэглэвэл хэрэгтэй гэдгийг та бас мэдэж байгаа. Өнгөрөгч улирлын гай зовлонгийн тухай дургалыг үлдэн хөөх хэрэгтэй! Өөр олон юм ярьж чадахгүй нь. Зөвхөн ямар замаар явах хэрэгтэйг мэднэ гэдгээ л нэмж хэлье ... гэж Туг үс нүдээ ирмэн, хуруугаараа хамраа тогшин ярьж явсан юм.

Тэгснээ хамраа дахин нэг тогшоноо цааш оджээ.

Туг үсийн баярын тухай яриа хоёрдугаар сарын арван дөрөвний Валентины өдрөөр биелэлээ олсон юм. Баярын бэлтгэл шөнө дөл болтол үргэлжилсэн агаад Харри өглөөний цайндаа ялимгүй хожимдон их танхимд орж ирлээ. Эхлээд түүнд хаалга андуурсан юм шиг санагджээ.

Ханыг бүхэлд нь ягаан сарнай цэцгээр бүрж, цайруу цэнхэр адраас зүрхэн хэлбэртэй унжлага зүүсэн байв. Харрийг ширээ рүүгээ очих үед Гермiona байн байн инээд алдаж байснаас болоод Роны дотор эвгүйрхсэн мэт царайтай сууж байлаа.

- Энд юу болоод байнаа? гэж Харри асуугаад ширээний ард сууж шарсан зүрхэн хэлбэртэй гахайн утсан мах идэж эхлэв.

Рон чимээгүйхэн багш нарын ширээ лүү заалаа. Тэрбээр дургүй нь хүрсэндээ ярьж ч чадахгүй байв. Цэцэг бүхий тод ягаан жанч өмссөн Туг үс чимээгүй болохыг анхааруулан дохино. Түүний хоёр талын ширээнд багш нар хүрэл царайлан сууцгааж байлаа. Профессор МакГонагаллын хамар татвалзан байхыг Харри суудлаасаа харжээ. Снегт багш бүхэл бүтэн аяга «Яс бороолуулагч» уулгахаар тулгуулсан мэт харагдана.

- Гэгээн Валентины өдрийн баярын мэнд хүргэе! Эхлээд энэ өдөр надад баярын мэндчилгээ илгээсэн дөчих зургаан хүнд талархал илэрхийлэхийг зөвшөөрнө үү! Би та бүхэнд энэхүү бяцхан бэлэг бэлтгэхээр зориулсан юм. Гэхдээ дуусаагүй шүү! гэж Туг үс зарлалаа.

Туг үсийг алга ташихад танхимд баргар царайлсан баахан анахай орж ирэв. Тэд үнэндээ ердийн анахайтай адилгүй ажээ. Анахай бүр гартаа босоо ятга барьсан байхаас гадна ар нуруундаа алтан жигүүртэй юм.

- Би та бүхэнд өөрийн өхөөрдөм захидал хүргэгчдийг танилцуулъя! Өнөөдөр эд нар сургуулиар явж валентины илгээмжийг тараах юм. Хөгжил цэнгэл дөнгөж эхлэлээ! Манай баярт хамтран зүтгэгчид маань бас хувь нэмрээ оруулна гэдэгт би итгэлтэй байна! Профессор Снегтийг бидэнд дурлалын ундаа яаж бэлтгэдгийг үзүүлэхийг хүсье! Харин профессор Флитвик зүрх бадамлан бадрах энэ баяраар дурлуулах бодисын талаар зарим зүйл ярьж өгөх байлгүй дээ. Ямар ч шидтэнээс илүү хашир эр энэ тухай мэддэг юм! гэж Туг үс яралзтал инээмсэглэн ярилаа.

Профессор Флитвик нүүрээ алгаараа таглажээ. Харин Снегт багшийг харахад дурлалын ундаа авахаар ирсэн анхны хүнд аяга хор хүчээр өгөхөд бэлэн мэт байлаа.

- Гермiona тэр дөчин зургаа дотор чи байхгүй биз дээ? гэж хичээлдээ явах зуур Рон асуужээ. Гэвч Гермiona цүнхнээсээ хичээлийн хуваарь хайгаад юу ч хэлсэнгүй.

Нөгөө анахайнууд бүхэл өдрийн турш ангиас анги руу гүйлдэж багш нарыг уурлуулсаар валентины илгээмжийг түгээж байлаа. Үдийн хоолны дараа шившлэгийн танхимын үүдэн дээр тэдний нэг муухай царайтай анахай Харрийг барьж авчээ.

- Хөөе, Хайн Поттей! гэж хашгирсаар сурагчдыг түлхэн хүрч ирэв.

Харрийн нүүр халуу шатлаа. Энэ заваан амьтдын дунд валентины илгээмж авах л дутаж гэнэ. Ядахдаа Жиннийг тэнд байхад шүү. Тэрбээр мултархыг оролдсон авч чадсангүй. Анахай замдаа тааралдсан хүүхдүүдийн хөл дээр гишгэлэн түүний араас зүтгэн гүйцэж очоод цүнхнээс нь чанга зуурчээ.

- Хайн Поттей чамд хөгжмөөр мэндчилгээ дэвшүүлье гэж анахай хэлээд босоо ятгаа дон дон хийлгэв.

- Энд болохгүй ээ! гэж хэлээд Харри зүтгэнэ.
- Зүгээл байгаалай! гэж анахай тультчих хэлээд түүнийг өөр лүүгээ татав.
- Намайг тавь! гэж Харри уурсан хэлээд цүнхээ угз татгал буу тасхийх шиг чимээ гаран цүнх урагдаж ном дэвтэр, шидэт саваа, үзэг цаас гээд бүх зүйл асгарч эцэст нь бэхийн сав унан хагарчээ.

Харри асгаран унасан юмнуудаа татаж авахаар шамдав. Анахайг дуулж эхлэхээс өмнө л амжих юм шүү!

- Энд юу болоод байнаа? гэж Малфой нөгөө л янзаараа үгээ сунжруулан шоолонгуй асуув.

Харри урагдсан цүнхэндээ цуглуулсан зүйлээ яаран чихнэ. Хаанаас ч юм илгээсэн валентины илгээмжийн тухай Малфой бүү мэдээсэй.

- Юунд шуугилдаад байна вэ? гэсэн танил дуу гарахад харвал Перси Уизли ирсэн байлаа.

Ахиад л бөөн гай! Харри бүх зүйлээ хаяад явахаар шийдсэн авч анахай түүний өвдгөөр тэврэн шалан дээр унагав. Анахай өвдөг дээрээ сөхрөн суугаад:

- За одоо сонсоолой гэв. Тэгээд:

Үнэндээ нүд нь таалуухан халдаг ч

Өнгө нь юутай ногоохон билээ Үс нь болохоол тас хал Өлгөөтэй самбалаас ч илүү хал Хал Лолдыг дийлсэн баатал

Хайлаа надад өгөөсэй, Булхан минь! гэж тультраадан дууллаа.

Харри газар доогуур орохын тулд «Гринготтс» банкинд байгаа бүх юмаа өгөхөд ч бэлэн байв. Одоо бусдын адил инээх л хамгийн сайн арга байлаа. Тэрбээр инээхийг хичээн хөл дээрээ босоход хөл нь хүнд анахайд даруулан хөшсөн байж билээ. Нэгдүгээр дамжааны зарим хүүхэд байдгаараа инээлдэн Перси эмх журамтай байлгахаар мэрийнэ.

- Тарцгаа тарцгаа таван хормын өмнө хонх дуугарсан шүү. Малфой чамд ч энэ бас хамаатай! гэж хэлээд Перси сурагчдыг ангийн нь үүд рүү түлхэж байлаа.

Харрийг эргэж харахад Малфой тонгойн ямар нэг юм газраас аван тэрхүү зүйлээ өөрийн үнэнч дагуул Крэбб Гойл хоёрт инээмсэглэн үзүүлж байлаа. Энэ бол Реддлийн өдрийн тэмдэглэл ажээ.

- Буцааж өг гэж Харри аятайхан хэлэв.

Поттер энэхүү дэвтэрт юу бичдэг нь сонирхолтой биз дээ? гэж Малфой даажигнана. Тэрбээр хавтсан дээрх он сарыг хараагүй болохоор Харрийн өдрийн тэмдэглэл гарт нь орсон гэж бодож байлаа.

Тэд чимээгүй болжээ. Жинни охин өдрийн тэмдэглэл, Харри хоёрыг ээлжлэн харах агаад тун ч аягүй царайтай байлаа.

- Малфой, буцааж өг гэж Перси эрс шулуун хэлэв.
- Эхлээд үзээдэхье ... гэж Малфой хорсолтой хяхтнаад өдрийн тэмдэглэлийг

Харрийн хамрын өмнүүр даллаж байлаа.

Перси: «Тэнхимийн ахлагчын хувьд ...» гэж нөгөө л үгээ давтсан авч Харри биеэ барьж чадсангүй. Шидэт саваагаа шүүрэн аваад: «Экспеллиармус!» гэж хэллээ. Снегг багш клубт хичээл орохдоо өрсөлдөгчөө зэвсэггүй болгох аргыг халз тулалдагч нарт үзүүлсэн болохоор өдрийн тэмдэглэл Малфойн гараас сум шиг сугаран нисчээ. Рон түүнийг овсгоотой шүүрэн авлаа.

- Харри! Хонгилд ид шид хэрэглэж болдоггүйг чи мэднэ! Энэ тухай илтгэхээс өөр аргагүй! гэж Перси чангаар зандарлаа.

Гэхдээ Харри огт тоосонгүй. Малфойгоос салахад Гриффиндор тэнхим таван оноо алдах ч яамай хэрэг. Малфой их уурлажээ. Хичээлдээ яарч яваа Жиннийг хараад Малфой араас нь:

- Поттерг чиний илгээмж таалагдсан гэж бодохгүй байна! хэмээн бах нь ханасан байдалтай хашгирав.

Жинни уйлсаар анги руугаа гүйн оржээ. Уур нь хүрсэн Рон шидэт саваагаа шүүрэн авсан ч Харри түүнийг зогсоолоо. Шившлэгийн хичээл дуустал нялцгай хорхойгоор бөөлжих хэрэг гарвал яана.

Профессор Флитвикийн хичээл дээр сууж байхдаа л Харри өдрийн тэмдэглэлийн нэг хачирхалтай онцлогийг анзаарсан юм. Бүх ном улаан бэхээр будагдсан байхад өдрийн тэмдэглэл бэх огт хүрээгүй мэт цэв цэвэр ажээ. Харри түүнийгээ Ронд харуулах гэтэл түүний шидэт саваа бас л болж өгөхгүй байв. Нэг үзүүрээс нь ягаан хөөс гарч байсан болохоор Рон өөр юм анхаарахтай мантай харагдана.

- ... Тэр орой Харри бусдаас түрүүнд унтахаар явжээ. Учир нь Фред Жорж хоёрын дуулах Валентины хөгжмийн мэндчилгээг сонсох дургүйн дээр хэдийгээр Рон цаг дэмий үрэхийн нэмэр гэж үзэж байсан ч Реддлийн өдрийн тэмдэглэл дээр нэг туршилт хийж үзмээр санагдаад болохгүй байв.

Харри орон дээрээ суугаад цэвэр хуудсуудыг эргүүлж үзлээ. Хаана ч улаан бэхний ул мөр байсангүй. Тэгэхээр нь орныхоо толгойн шүүгээнээс шинэ бэхтэй сав аваад үзгээ дүрэн эхний хуудсан дээр дусааж үзлээ.

Бэх цагаан хуудсан дээр хэсэг зуур тогтсоноо цаасанд сорогдох мэт алга боллоо. Харри тоглоом ч үгүй догдлон үзгээ дахин дүрсэнээ: «Намайг Харри Поттер гэдэг» гэж бичив. Үгс түр зуур тодхон харагдаж байснаа бас л алга боллоо. Ямар нэг юм болж байгаа нь тодорхой.

Түүний бичсэн бэх цааснаас урсан гарах мэт болж Харрийн хэзээ ч бичиж байгаагүй үгс болон тодорлоо. Үүнд:

«Сайн уу, Харри Поттер. Намайг Том Реддл гэдэг. Чи миний өдрийн тэмдэглэлийг яаж олсон юм бэ?» гэжээ.

Энэ бичиг бас алга болсон ч Харри түүнээс өрсөн:

«Хэн ч юм түүнийг суултуурт хаясан байсан» гэж яаран бичиж амжлаа. Реддлийн шинэ хариу тэр дорхноо гарч иржээ.

«Би дурсамжаа бэхээр бус илүү найдвартай аргаар бичсэн маань оножээ. Миний тэмдэглэлийг хүмүүс бүү уншаасай гэж хүсэх хүн бий гэдгийг мэдэж байсан юм».

«Энэ чинь юу гэсэн үг вэ?» гэж бичихдээ Харри сэтгэл догдлон үзгээ чичрүүлэн бэх дусааж орхив.

«Энэ өдрийн тэмдэглэлд нууцын хөшгөөр халхлагдсан аймшигт үйл явдлын тухай мэдээлэл байгаа. Энэ явдал олон жилийн тэртээ ид шидтэний «Хогвартс» сургуульд болсон юм».

«Би яг одоо энд байна. Хогвартст ахиад л аймшигт явдал болж байна. Чи нууц өрөөний талаар ямар нэг юм мэдэх үү?» гэж Харри яаран бичлээ.

Түүний зүрх түргэн түргэн булиглана. Реддл түргэн зуур хариулах агаад бодол санаагаа хэлэх гэж яарсан бололтой бичгийн хэв загвар нь хамаагүй боллоо.

«Мэдэлгүй яахав. Тэр үед энэ бол домог тийм өрөө байхгүй гэж бидэнд хэлдэг байсан ч худал үг байсан юм. Намайг тав дахь жилдээ сурч байхад өрөөг нээж савдгийг сулласан агаад савдаг сурагчид руу довтлон нэгийг нь хөнөөсөн юм. Би өрөө нээсэн хүнийг барьсан бөгөөд түүнийг хөөсөн билээ. Хогвартст ийм явдал болсны төлөө сургуулийн захирал, профессор Диппет маш их ичиж зовж, намайг энэ тухай үнэнийг бүү ярь гэж хориглосон доо. Охиныг золгүй явдлаар нас барсан мэтээр

ойлгуулсан юм. Намайг сийлбэр бүхий гоё самбараар шагнаж амаа хамхиж байхыг тушаасан билээ. Гэхдээ би энэ явдал давтагдаж магадгүй гэж мэдэж байсан юм. Савдаг амьд байгаагаар барахгүй түүнийг суллаж чадах хүн ч урьдын адил эрх чөлөөтэй яваа шүү дээ».

Харри хариу бичих гэж яарсандаа бэхтэй саваа эгээ л унагачихсангүй.

«Энэ явдал давтагдаж байна. Гурав дахиа довтолсон авч гол буруутанг олоогүй хэвээр. Түүрүүнд нь хэн буруутай байсан юм бэ?»

«Хэрэв хүсвэл би чамд түүнийг үзүүлж болно. Ганцхан миний үг хангалтгүй л дээ. Гэхдээ би чамайг түүнийг барьсан шөнийхөө дурсамж руу оруулж чадна».

Харри бүр эргэлзэж хоцров. Өдрийн тэмдэглэл дээр үзгээ барьсан хэвээр хөшчихлөө. Реддл юу гэчих вээ? Хэн нэгний дурсамжид яаж орж болдог байна вэ? Тэрбээр унтлагын өрөөний үүд рүү түгшин харлаа. Өрөөнд улам харанхуй болжээ. Дахиад л өдрийнхөө тэмдэглэл рүү анхаарав. Тэнд:

«Чамайг өөрийнхөө дурсамжид оруулахыг зөвшөөрөөч» гэж бичжээ. Харри эгшин зуур бодолхийлснээ:

«За» гэдэг хоёрхон үсэг бичлээ.

Өдрийн тэмдэглэлийн хуудас хүчтэй салхинд өртсөн мэт дэрвэлзэн хийссэнээ зургадугаар сарын дунд үе хүрээд зогсов. Зургадугаар сарын арван гуравны өдрийн хуудас жижигхэн зурагтын дэлгэц болон хувирахыг хараад Харри амаа ангайжээ. Тэрбээр чичирсэн гараараа өдрийн тэмдэглэлийг нүдэндээ ойртуултал жижигхэн цонх гэнэт өргөсөн тэлж түүнийг татахуй Харри орноосоо хөндийрч толгойгоо урагш сунгаж будаг сүүдэр болсон нээлттэй хуудсаар нэвтрэн орж байгаагаа мэдэрлээ.

Хөл нь хатуу газар хүрэхэд гуйвсан авч уначихалгүй тогтов. Эргэн тойрны байдал тодрон үзэгдэнэ.

Харри хаа байгаагаа шууд л мэдлээ. Ханан дээр үүрэглэх хүмүүсийг хөрөг бүхий дугуй танхим бол Дамблдорынх. Гэхдээ танил ширээний ард Дамблдор байсангүй. Өвчтэй байрын туранхай биетэй хэдхэн туг буурал үсийг нь эс тооцвоос халзан гэмээр шидтэн лааны гэрэлд захидал уншиж суулаа. Харри энэ хүнийг урьд нь хэзээ ч хараагүй билээ.

- Өршөөгөөрэй. Би ингээд ород ирье гэж бодоогүй юм ... хэмээн Харри итгэлгүйхэн дуугарав.

Гэвч шидтэн харцаа дээшлүүлсэнгүй. Тэрбээр хөмсгөө зангидан үргэлжлүүлэн унших аж. Харри ширээ рүү дөхөж очоод түгдрэн байж:

- Хм ... Би явах уу даа? гэлээ.

Шидтэн урьдын адил түүнийг хайхарсангүй. Юу ч сонсоогүй бололтой. Харри түүнийг дүлийн юм байна гэж бодоод дуугаа өндөрсгөн:

- Түвэг удсанд уучлаарай, би явъя даа! гэв.

Шидтэн санаа алдан захидлаа эвхээд босож Харрийн хажуугаар өнгөрөн цонхны хөшиг татлаа.

Цонхны цааны тэнгэр улайран харагдах нь нар жаргах дөхсөний тэмдэг. Шидтэн ширээ рүүгээ буцаж ирээд сууж, хуруугаа салаавчлаад эрхий хуруугаа эргэлдүүлэн үүд рүү харах ажээ.

Харри эргэн тойрноо харав. Хангинан жингэнэх мөнгөлөг зүйлс байхгүйн адил галт шувуу ч алга. Энэ бол Реддлийн мэддэг Хогвартс болохоор энэ танихгүй шидтэн

захирал нь байж таарлаа. Харин Харри өөрөө тавин жилийн тэртээ амьдарч байсан хүмүүст үл үзэгдэх хүн болжээ.

Үүд тогшлоо.

- Ор гэж өвгөн сулхан дуугаар хэлэв.

Шовгор оройтой бүрхээ авсаар арван зургаа орчим насны хүү орж ирлээ. Түүний энгэрт ахлагчийн мөнгөн тэмдэг гялалзана. Тэрбээр Харригаас нилээд өндөр авч үс нь яг л түүнийх шиг гялалзсан хар юм.

- Аа, Реддл гэж захирал хэлэв.

- Профессор Диппет та надтай уулзах гээ юу? хэмээн асуухдаа Реддлийн сэтгэл уймрах ажээ.

- Суу. Би дөнгөж сая захидлыг чинь уншлаа гэж Диппет хэлэв. Реддл санаа алдан суугаад гараа чанга атгалаа.

- Эрхэм хүндэт хүү минь, энэ зун чамайг сургуульд үлдэхийг би зөвшөөрч чадахгүй нь ээ. Чи зуны амралтаараа гэртээ байхсан гэж байгаа биз дээ? гэж Диппет эелдэг хэллээ.

- Үгүй ээ, би тэдэн рүү ... тэдэн рүү очсоноос Хогвартст үлдвэл дээр гэж Реддл шуудхан хариулав.

- Миний мэдэж байгаагаар чи амралтаа дандаа маглуудын өнчний асрах газарт өнгөрүүлдэг биз дээ? гэж Диппет үнэн голоосоо сонирхон асуулаа.

- Тийм ээ, ноёнтоон гэж хэлээд Реддл ялимгүй улайжээ.

- Чи төрөлхийн магл уу?

- Холимог цустай, ноёнтоон. Аав магл ээж шидтэн.

- Тэгээд эх чинь яасан юм бэ?

- Ээж минь намайг төрүүлээд нас барсан юм, ноёнтоон. Надад дөнгөж л нэр өгч амжсан гэгцгээдэг юм. Аавын дурсгалыг хүндэтгэн Том, өвөөг хүндэтгэн Марвало гэдэг нэр өгсөн.

Диппет өрөвдөн санаа алдлаа.

- Онцгой байдлыг анхаарч үзээд чиний хүссэнээр болгоё гэсэн ч сургууль дээр байдал иймэрхүү байхад ...

- Та довтолгооныг хэлж байна уу, ноёнтоон? гэж Реддлийг асуухад Харрийн зүрх улам булиглаж, тэрбээр юм сонсолгүй хоцорчих вий гэж айсандаа улам ойртлоо.

- Чухам тийм. Хонгор хүү минь, хичээл дууссаны дараа ялангуяа энэ эмгэнэлт явдал ... энэ золгүй охиныг нас барсны дараа чамайг шилтгээнд үлдээхийг зөвшөөрнө гэдэг тун ч бодлогогүй явдал гэдгийг чи ойлгох ёстой. Чи эндээс хол, тэр асрамжийн газартаа байвал аюулгүй шүү дээ. Ид шидтэний яаманд сургуулийг хаах тухай яригдаж байна. Бид энэ золгүй явдлын шалтгааныг тайлбарлах гээд ... ердөө ч чадахгүй байгаа юм ...

Реддлийн нүд том боллоо.

- Ноёнтоон ... Хэрэв энэ хүн баригдвал ... Хэрэв энэ бүхэн зогсвол ...

- Чи юу гэх гээд байна? Реддл чи энэхүү довтолгооны тухай ямар нэг юм мэдэх үү? гэж Диппет огцом дуугаар асуугаад суудлаасаа үсрэн босов.

- Үгүй, ноёнтоон гэж Реддл яаран хариуллаа.

Гэхдээ энэ «үгүй» гэдэг үг бол түүний Дамблдор хэлсэн үгтэй чанар нэгтэй гэдэг нь Харрид тодорхой байв.

Яльгүй цөхөрсөн Диппед ахин сандалдаа суугаад:

- Том минь, явж болно ... гэлээ.

Реддл өндөр сандлаас гулсан буугаад өрөөнөөс гарав. Харри араас нь дагалаа. Тэд махирласан шатаар уруудаж бүдэг хонгилд оржээ. Реддл зогсоод уруулаа хазлан, духаа үрчийлгэн байх нь ямар нэг юмны тухай сүрхий бодлогошрон байгаа бололтой.

Тэгээд Реддл ямар нэг юм шийдсэн юм байлгүй өөр тийш явлаа. Харри араас нь чимээгүйхэн дагасаар. Тэдний замд нэг ч хүн таараагүй агаад зөвхөн танхимд орох үед бөөгнөрсөн шаргал үс сахалтай биерхүү шидтэн гантиг шатан дээрээс Реддлийг дуудаад:

- Том, ийм орой болсон хойно чи юунд тэнээд байна? гэж асуув.

Харри түүнийг сайтар харлаа. Түүний өмнө өөр хэн ч биш, тавин насаар залуу Дамблдор зогсож байв.

- Ноёнтоон, би захирал дээр байж байгаад ирлээ гэж Реддл хэллээ.

- За яахав, хурдхан явж унт. Одоо хонгилоор зугаалахгүй байвал зүгээр дээ. Тэр явдлаас хойш ... гэж хэлээд Дамблдор нөгөө л Харрид танил болсон хурц ширүүн харцаар Реддлийг харжээ.

Дамблдор хүндээр санаа алдаад Реддлд тавтай нойрсохыг ерөөгөөд цааш явлаа. Том түүний далд орохыг хүлээж байснаа байдаг хурдаараа доош яаран чулуун шатаар газар доорх байр луу буув. Харри ч араас нь дагасаар.

Өө, хөөрхий! Реддл түүнийг ямар нэг овжин далдалсан хонгил буюу нууц өрөө рүү биш харин уусмал бэлтгэх хичээл ордог Снеггийн танхим руу дагуулан авчирчээ. Бамбарууд асаагүй байв. Том жижигхэн завсар үлдээн үүдийг хаасан болохоор Харри хонгилд болж буй зүйлийг ажиглан хаалганд наалдаж зогссон түүнийг л харж байлаа.

Тиймэрхүү байдлаар бараг нэг цаг зогсох шиг Харрид санагджээ. Том Реддл чулуун хөшөө шиг зогсон нарийхан завсраар харсан хэвээр. Тэгээд Харри бүр цөхрөнгөө барж бодит байдал руугаа буцах боломж хайхын даваан дээр хаалганы нөгөө талд хүний хөлийн чимээ гарлаа.

Тэдний зогсож буй хаалганы дэргэдүүр тэр хүн явж өнгөрөхийг Харри тодхон сонсчээ. Реддл сүүдэр мэт чимээгүй гэтэн хонгилд гараад түүний араас явлаа. Харри түүний чимээг сонсохгүй гэдгийг ч мартан өлмий дээрээ явсаар түүнийг дагав.

Тэр таван хором хэртэй тэрхүү нууцлаг хүнийг дагаснаа Реддл гэнэтхэн зогсоод бас нэг чимээ гарсан зүг рүү толгойгоо эргүүлжээ. Бараг хажууханд нь булангийн цаана хаа нэгтээ үүд нээгдэх дуулдсанаа хэн нэгэн хүн сөөнгө дуугаар:

- Алив хүрээд ир ... Над руу хүрээд ир ... Яг тэгээд ... Одоо хайрцагт ор гэх сонсогдов.

Тун ч танил дуу байлаа.

Реддл булангийн цаанаас гэнэтхэн гарч ирэв. Харри ч бас хоёр гурав алхаад ард нь зогсов. Нээлттэй хаалганы эсрэг талд хажуудаа том хайрцаг тавьсан биерхүү залуугийн дүрс түүнд харагджээ.

- Үдшийн мэнд, Рубеус гэж Реддл чангаар хэлэв. Нүсэр биет тагийг хаагаад бослоо.

- Чи энэ дор юу хийж явсан юм бэ, Том оо? Реддл ойртож очоод:

- Бүх юм дууссан, Рубеус минь. Би чиний тухай бүгдийг ярьв. Хэрэв довтолгоон зогсохгүй бол сургуулийг хаах юм байна.

- Чи чинь тэгээд ...

- Чамайг хэнийг ч алах гээгүй гэж би бодож байна. Гэхдээ аймшигт амьтныг гэрийн номхон амьтан болгохгүй шүү дээ. Чи түүнийг жаахан дураараа яваг гэсэндээ л сулласан юм чинь ...

- Тэр ч, хэнийг ч хөнөөгөөгүй! гэж өндөр залуу хашгираад нуруугаараа тагийг налан зогслоо. Тагны цаанаас нэг л хачирхалтай шар шур, шажиг шужиг хийх чимээ гарах ажээ.

- Рубеус минь, сонсооч. Нас барсан охины эцэг, эх маргааш ирнэ. Хогвартсын тэдний төлөө хийж чадах хамгийн гол зүйл бол охиныг хөнөөсөн амьтныг устгасан гэж тэдэнд итгүүлэх явдал ...

- Энэ хөнөөгөөгүй юм аа! Энэ ... үгүй шүү, энэ хэзээ ч ... тэгж чадахгүй! гэж залуу нүргэлүүлэн хэллээ. Түүний дуу харанхуй хонгилоор чанга цуурайтав.

- Хажуу тийшээ зайл гэж Реддл тушаагаад шидэт саваагаа авлаа.

Шившлэг газар доорх хонгилыг хурц гэрлээр гийгүүлэв. Аварга хүний ардах үүд хүчтэй нээгдэхэд тэрбээр нөгөө хана руу шидэгджээ. Тэгтэл Харрийн нүдэнд аймаар амьтан үзэгдэхэд Харри дуу алдсан ч азаар сонсохгүй юм чинь.

Сэгсгэр том биетэй, тоолохын аргагүй олон хар хөлтэй, бас олон гялалзсан нүдтэй, сахлын хутга шиг хурц хоёр зажлууртай хилэнцэт хорхой ч гэмээр, аварга аалз ч гэмээр амьтан харагдлаа. Реддл шидэт саваагаа дахин өргөсөн боловч хожимджээ. Аврагдахаар зугатахдаа нөгөө гайхал түүний дээгүүр гарч, хонгилоор харайлган бараа тасрав. Реддл арайхийн хөл дээрээ босоод түүний араас харснаа ахиад л саваагаа авсан ч гэлээ нөгөө аварга биет түүний зүг харайн очоод савааг нь булааж аваад Реддлийг шалан дээр чулуудсанаа «Болохгүй ээ-ээ!» гэж зэрлэгээр хашгирлаа.

Болсон үйл явдлууд Харрийн нүдэнд эрээлжлэхүй харанхуй болж, Харри хаашаа ч юм ниссэнээ Гриффиндор шилтгээнийхээ унтлагын өрөөний орон дээрээ пидхийн унажээ.

Реддлийн өдрийн тэмдэглэл дэлгээтэй хэвээр, юу ч болоогүй юм шиг гэдсэн дээр нь хэвтэнэ.

Харрийн амьсгаа авч амжаагүй шахам байтал унтлагын өрөөний үүд нээгдэн Рон орж ирлээ.

- Энд байгаа юм уу? гэж Рон хэлэв.

Харри орон дээрээ өндийн суулаа. Тэрбээр дагжин чичирч, бүх бие нь хөлөрчээ. Рон сэтгэл зовнин ойртож ирсэнээ:

- Чи юу болов оо? гэлээ.

Тэр чинь Хагрид байжээ, Рон оо. Тавин жилийн тэртээ нууц өрөөг Хагрид нээсэн юм байна.

БҮЛЭГ 14: КОРНЕЛИУС ФАЖ

Хагридыг элдэв хачин амьтанд дуртайг Рон, Харри, Гермиона гурав эртнээс мэдэх билээ. Тэднийг Хогвартст байсан эхний жил тэрбээр ой дахь өөрийнхөө жижиг оромжинд луу тэжээх гэж үзсэн бөгөөд харин түүний Пушок гэж нэрлэсэн гурван толгойтой том нохойг тэд тийм ч амар мартахгүй нь мэдээж. Хэрэв Хагрид хүүхэд байхдаа шилтгээнд байдаг гайхалтай амьтны тухай домог сонссон аваас түүнийг хальт ч атугай харахын тулд огт айлгүй тийшээ мөлхөх байсан гэдэгт Харри итгэлтэй байлаа. Тэгээд цаашдаа ... Тэрбээр амьтныг торонд байлгахаасаа өрөвдөөд тоо тоомшгүй хөлөө тэнийлгэх боломж олгохоор түүнийг гаргах гэж шийдсэн байж болох юм ... Тэр ч байтугай Харри арван гурван настай Хагрид тэрхүү амьтныг хүзүүгээр нь оосорлоод хөтлөж яваагаар төсөөлж үзлээ. Гэхдээ нэг юм түүнд тодорхой байв. Хагрид хэзээ ч ямар ч тохиолдолд хэнийг ч хорлож чадахгүй билээ. Харри өдрийн тэмдэглэлийн нууцад нэвтэрсэндээ бараг харамсаж байв. Рон Гермиона хоёр Реддлийн дурсамжаар аялсан тухай дэлгэрэнгүй ярихыг байн байн шаардана. Харри энэхүү үйл явдлуудыг эцэс төгсгөлгүй ярьсаар залхаж гүйцжээ.

- Реддл өөр хүнийг барьж болох л байсан. Хүн рүү довтолдог өөр савдаг байсан байж магадгүй гэж Гермиона батлана.

- Чинийхээр бол тэнд хэдэн савдаг байсан юм бэ? гэж Рон баргар царайлан асуув.

- Хагридыг аль дээр сургуулиас хөөсөн гэдгийг бид мэднэ. Үүний дараа довтолгоо зогссон. Тэгээгүй бол Реддл онцгой шагнал хүртэхгүй байсан ... гэж Харри гунигтайа өгүүлэв.

Рон энэ хэрэгт өөр талаас нь хандаж:

- Реддл тэр үед Перси шиг л байжээ. Түүнийг хэн нэг нь Хагридыг матаж бичээч гэж шахсан ч юм билүү? гэв.

- Гэхдээ тэр амьтан хэн нэгнийг хөнөөсөн шүү дээ гэж Гермиона татгалзлаа.

- Сургуулийг хаах гээд байсан юм. Реддл маглууд руу нөгөө аймшигт асрамжийн газар луу явах хэрэг гарах байсан даа. Сургуулийг аврах гэсэн ганцхан шалтгаанаар л түүнийг зөвтгөж болох юм гэж Харри нэмж хэлэв.

Рон уруулаа имрэн байснаа:

- Чи Догшин гудамжинд Хагридтай тааралдсан биз дээ? гэж асуулаа.

- Тэр чинь ургамлын хортонтой тэмцэх хор худалдан авч байсан юм гэж Харри яаран хариулав.

Тэд гурвуулаа дуугүй суулаа. Удаа дуугүй сууцгаав. Эцэст нь Гермiona түгдчин байж яг одоо бүгдээрээ бодож байгаа зүйлийн тухай:

- Бид Хагридын очиж, өөртэй нь яривал яасан юм бэ? гэж асуулаа.

- Сайхан уулзалт болох байх даа. Сайн уу, Хагрид. Чи сүүлийн үед сургууль руу ямар нэг аймшигтай үстэй амьтан тавиагүй биз? гэж асуух юм уу гэж Рон бувтнана.

Хэрэв ахин дайралт болохгүй бол Хагридад юу ч ярихгүй байхаар шийджээ. Нөгөө учир битүүлэг, бие хаагүй дуу хоолой сонсогдохгүй удах тутам Хагридыг яагаад сургуулиас хөөгдсөн тухай асуух хэрэг гарахгүй юм байна гэх итгэл илүү их төрөх бүлгээ.

Жастин, бараг толгойгүй Ник хоёр хөшсөнөөс хойш бараг дөрвөн сар өнгөрөхөд ямар ч байсан нөгөө харгис амьтан бүр алга болж Хогвартст дахин хэзээ ч ирэхгүй гэж бараг бүгдээрээ бодоцгоох болов. Пивз: «Харри Поттер харгис амьтан» гэдэг дуугаа дуулахаасаа залхаж, Эрни МакМиллан бүр зөөлөрч тэр ч байтугай бүр ургамал судлалын хичээл дээр Харригаас үсрэгч мөөгтэй сагс авч өгөхийг эелдэгээр гуйсан билээ. Гуравдугаар сард хэд хэдэн мандрагор гуравдугаар хүлэмждээ шуугилдан ер бусын байдлаар үдшийг өнгөрөөхөд професоор Стебль маш их баярлажээ.

- Тэд саванд байхдаа бие бие рүүгээ тэмүүлж байгаа бол бие гүйцсэн хэрэг. Бид мөдхөн эмнэлэгт хэвтэж буй золгүй хүмүүсийг буцаан амьдруулж чадна гэж тэрбээр Харрид тайлбарлаж өглөө.

Хаврын амралтаар хоёрдугаар дамжааныхан бодох юмтай болжээ. Сургалтын гурав дахь жилд судлах хичээлээ сонгож авах хэрэгтэй байлаа. Үүнд Гермiona тун ч хариуцлагатай хандаж байв.

- Үүнээс л бидний ирээдүй шалтгаална гэж тэрбээр Рон Харри хоёрт хэлээд шинэ хичээлийн жагсаалтыг гурвуулаа үзэн тэмдэгтэвч байлаа.

- Би ч уусмалын хичээлээс татгалзмаар байна гэж Харри хэлэв.

- Болохгүй ээ. Бүх хуучин хичээлүүд хэвээрээ байна. Хэрэв ямар нэг хичээл үлдээж болдогсон бол би хар урлагийн хичээлийг үлдээх сэн гэж Рон баргар царайлан ярина.

- Энэ чинь маш чухал хичээл шүү дээ! гэж Гермiona дургүйцэв.

- Хэрэв Туг үс заадаггүйсэн бол ч чухал л даа. Би түүнээс юу ч сурсангүй. Үгүй ээ, корнуэлийн шунгинуурыг дураар нь тавибал яадгийг сурсан юм байна гэж Рон зөрүүдлэнэ.

Невилл Долгопупс ид шидэт хамаатан садныхаа ямар хичээл амьдралд хамгийн их хэрэгтэй тухай чухалчлан бичсэн янз бүрийн санал бүхий захианд даруулжээ. Самгардаж гүйцсэн тэрбээр хэлээ бултгануулан байж хичээлийн жагсаалтыг уншин талхидлага, эртний дайрлага хоёрын аль нь хүнд бол гэж хавь ойрныхоосоо ичингүйрэн асууна. Харритай адил маглуудын дунд өссөн Динд Томас асуудлыг маш амархан шийджээ. Тэрбээр нүдээ дараад шидэт саваагаараа жагсаалт руу дохин, саваанд таарсан хичээлүүдийг сонгон тэмдэглэсэн юм. Гермiona хэний ч зөвлөгөөг сонссонгүй, жагсаалтыг авмагцаа бүх л шинэ хичээлийг шууд тэмдэглээд өгчихлөө.

Хэрэв нагац Вернон ах, Петунья эгчтэйгээ ид шидтэний ирээдүйн тухай ярилцсан аваас юу гэх байсан бол хэмээн бодоод Харри тоомсоргүй мушийжээ. Гэхдээ хэн ч түүнд зөвлөөгүй гэж хэлж болохгүй л дээ. Перси Уизли амьдралынхаа туршлагаас хэнтэй ч хуваалцахад бэлэн байв.

- Харри минь, хамгийн гол нь чи өөрөө юу хүсэж байгаагаа ойлгох хэрэгтэй.

Ирээдүйнхээ тухай аль болохоор эрт бодох нь зүгээр. Тийм болохоор би чамд мэргэ төлөг сур гэж хэлмээр байна. Маглуудын үздэг хичээл хэтэрхий хөнгөн гэлцдэг ч ид шидтэнгүүд нийгмийн эгэл хэсгийн тухай тодорхой төсөөлөлтэй байх ёстой гэж би үздэг юм. Ялангуяа маглуудтай нягт хамтран ажиллах үед тун хэрэг болно. Аавыг бодоод үз л дээ. Аав маань маглуудтай, тэдний үйл ажил, үйлс бүтээмжтэй байнга хамт байдаг юм. Манай ах Чарли цэвэр агаарт ажиллах дуртай болохоор ид шидэт зүйлүүдийг харж хандах ажил сонгож авсан билээ. Өөрийнхөө давуу талыг ашиглах хэрэгтэй, Харри. Бас дур сонирхолоо дагах хэрэгтэй шүү гэж Перси ярьжээ.

Гэхдээ Харрийн сэтгэлд хоногшсон ганцхан зүйл бол квиддич байлаа. Тэгээд унаж боссон ч хамтдаа гэж бодоод Роны сонгосон хичээлүүдийг сонгон авсан аж.

Ээлжит тэмцээнд Гриффиндорынхон, Пуффендуйхантай тоглолоо. Вуд орой болгон багаа талбай руу хөөн аваачдаг байсан болохоор Харри квиддич тоглох гэрийн даалгавраа хийхээс өөр зүйлд цаг зав гаргаж чадахгүй байлаа. Бэлтгэл сургууль сайн байсан уу, цаг агаар сайхан болсон уу, ямар ч атугай бямба гаригын уулзалтын өмнө Харри унтлагынхаа өрөөнд ирэхдээ Гриффиндорх багийхан энэ жил сургуулийн цомыг заавал авна гэсэн итгэл дүүрэн байлаа.

Гэхдээ баяр хөөрөөр удаан бялхсангүй. Унтлагын өрөөний үүдний дэргэд Харри царай алдаж гүйцсэн Невилл Долгопупстай тааралджээ.

- Харри, хэн ингэснийг би мэдэхгүй юм ... Ороод харсан чинь ... Тэрбээр Харрийг цөхрөнгөө барсан харцаар харснаа үүд нээлээ.

Харрийн чемоданд байсан бүх юмыг өрөөгөөр нэг тараан хаяжээ. Шалан дээр уранхай жанч, орны цагаан даавуу, бүтээлэг хөглөрөх агаад шургуулганы нүдийг татаж, дотор нь байсан бүх зүйлийг гудсан дээр гаргаж хаясан байлаа.

Харри юу болсныг огт ойлголгүй «Савдгийн жимээр» гэдэг номон дээгүүр гишгэлэн ор луугаа очив. Тэгээд Невиллийн хамт ороо засаж байтал Дин, Симус, Рон гурав орж иржээ.

- Хэн ингэж замбараагүй болгочих воо? гэж Дин уурсан хэллээ.

- Мэдэх юм алга ... гэж Харри учраа олохгүй үглэнэ. Рон түүний жанчыг үзтэл бүх халаасыг нь эргүүлсэн байлаа.

- Хэн нэгэн хүн ямар нэгэн юм эржээ ... юу алга болсныг үзэхгүй юу?

Харри эд зүйлээ цуглуулан чемодандаа хийж дуусаад хамгийн сүүлд Туг үсийн номыг хийхдээ алдагдсан зүйлийг мэдлээ.

- Реддлийн өдрийн тэмдэглэл алга болчихжээ гэж Рон руу эргэн хараад дорой дуугаар хэлэв.

- Юу гэнээ?!

Харри үүд рүү дохиж, Рон тэр хоёр гарлаа. Тэд одоо бараг хоосон байгаа Гриффиндорын танхимд очоод цор ганцаараа «Эртний дайрлагын тайлбар» номыг уншин суух Гермионаг олж авав.

Энэхүү мэдээ түүнийг цочирдуулжээ.

- Түүнийг чинь зөвхөн Гриффиндорын хүүхэд л хулгайлж чадна. Өөр хэн ч нууц үгийг мэдэхгүй ...

- Яг үнэн гэж хэлээд Харри санаа алдлаа.

Маргааш өглөөгүүр тэднийг босоход наран хурцаар гийгүүлж, сэвшээ салхи сэвэлзэж байв.

- Квиддич тоглоход сайхан өдөр байна! гэж хэлээд Вуд Гриффиндорын ширээний дэргэд зогсон, цог золбоо дүүрэн байх агаад багийнхныхаа тавганд өндөг жаврай нэмж хийн:

- Харри, чи хурдхан хүрээд ир. Чи сайн идэж эрч хүч авах хэрэгтэй! гэв.

Харри бараг сул суудалгүй ширээг тойруулан харснаа, нөгөө өдрийн тэмдэглэлийг авсан хүн энд сууж байгаа болов уу? гэж өөрөө өөрөөсөө асуулаа. Гермиона хулгайн тухай мэдэгдэх хэрэгтэй гэж шаардсан ч Харри зөвшөөрөөгүй юм. Тэгэх аваас өдрийн тэмдэглэлийн тухай бүгдийг ярих хэрэг гарна. Тэгтэл тавин жилийн тэртээ

Хагридыг яагаад хөөснийг хүн бараг мэдэхгүй шүү дээ. Харин тэрбээр энэ түүхийг дэлгэмээргүй байлаа. Бас хамгийн түрүүнд шүү!

Андууд их танхимаасаа гараад тэмцээнд орон хэрэгслүүдээ авахаар шилтгээн рүү явсан авч өсөн нэмэгдсээр блайгаа нөгөө таагүй зүйлийн жагсаалтад бас нэг нилээн жинтэй түгшүүрийн дохио нэмэгджээ. Харрийг гантиг шалан дээр хөлөө тавьж амжив уу, үгүй юу:

- Энэ удаа ал ... Намайг тавь, би хэдэн хэсэг болгоод орхиё ... Би өөрөө хэдэн хэсэг болгоё! гэх дуу дуулдлаа.

Харри уулга алдахад Рон, Гермiona хоёр түүний зүг ухасхийв.

- Нөгөө дуу хоолой! Би сая түүнийг дахин сонслоо! Та хоёр сонсов уу? гэж

Харри дуу алдаад эргэн тойрноо харлаа.

Рон нүдээ бүлтийлгэн толгой сэгсрэхэд Гермiona гэнэт духаа алгадаж:

- Харри, би мэдчих шиг боллоо! Одоохон номын сан руу очьё! гэлээ.

Тэгээд шатаар дээш гүйлээ.

- Тэр юу мэдсэн юм бол? гэж Харри гайхан асуугаад эргэн тойрноо дахин харав. Дуу ахиад сонсогдвол хаанаас гараад буйг нь мэдэж болох юм.

- Ойлгох юм алга гэж Рон хэлээд дээш харлаа.

- Яагаад гэнэтхэн номын сан руу очих хэрэг гардаг байнаа?

- Энэ чинь Гермiona. Хэрэв юм ойлгоогүй бол тийшээ явж түүнээс асуу гэж

Рон мөрөө хавчин хэлэв.

Харри шийдэж чадалгүй зогсож байлаа. Тэрбээр нөгөө дууг сонсох гэж хичээсэн авч их танхимаас хүүхдүүд гарч ирэн хоорондоо чанга чанга ярилцсаар цэнгэлдэх хүрээлэн рүү яарцгаах аж. Харри дахин юу ч сонссонгүй.

- Алив яараач. Бараг арван нэг болчихоод байна. Тэмцээнтэй гэдгээ мартчихсан байх шив! гэж хэлээд Ронт үүнийг түлхжээ.

Харри ахин хэсэг зуур азнаснаа гараа зангаад Гриффиндорын шилтгээн рүү гүйлээ.

«Нисдэг лус-2000»-аа аваад нуга дундуур цэнгэлдэх рүү явцгаах хүүхдүүдийн дунд оржээ. Гэхдээ түүний ухаан санаа шилтгээндээ нөгөө учир битүүлэг дууг сонссон хэвээр байлаа. Тэгээд хувцасны өрөөнд улаан жанчаа өмсөж байх зуураа, шилтгээнд одоо хэн ч байхгүй, бүгд энд тэмцээн үзэхээр ирсэн гэж бодоод тайтгарчээ.

Багууд чангаар алга таших чимээн дор талбайд гарч ирлээ. Оливер Вуд онооны цагаригыг урьдчилан үзэхээр агаарт хөөрчээ. Хатагтай Нугарагч бөмбөгийг гаргалаа.

Шар хувцас өмссөн Пуффендуй багийнхан бөөгнөрөн зогсоод тоглоомын тухай ярилцах аж.

Харри шүүртэйгээ ухасхийтэл профессор МакГонагалл гэнэтхэн гарч ирээд гартаа том яагаан чанга баригч барьсаар талбай дундуур гүйж явлаа.

Харрийн зүрх ёгхийжээ.

- Тэмцээн хойшлогдлоо! гэж чанга яригчаар хашгирахад үзэгчдийн суудалд дүүрэн суусан хүүхдүүд чангаар хашгирч шүгэлдэн шуугилдаж гарлаа.

Оливер Вуд яаран газардсанаа, гартаа шүүрээ барьсан хэвээр профессор

МакГонагаллын зүг мэл гайхан явлаа. Тэрбээр:

- Профессор оо! Бид тоглох хэрэгтэй ... Цомыг ... Гриффиндорынхон ... гэж хашгирав.

Профессор МакГонагалл түүнийг огт тоолгүй чанга яригчаар:

- Бүх сурагчид өрөөндөө буцаж очицгоо. Тэнд очоод цааш яахаа мэдэх болно.

Хурдан бол сайн шүү! гэж хашгирна.

Тэгснээ профессор чанга яригчаа буулгаад Харрийг дохин дуудаж:

- Поттер чи надтай явбал дээр гэлээ.

Өнөөдөр түүнийг юунд сэжиглэж байгааг огт ойлгоогүй Харри орлилдон байгаа хүүхдүүдээс сондгойрон зогссон Роныг харав.

Рон тэднийг шилтгээн орох замд гүйцэж очлоо. Гэхдээ Роныг ирэхэд профессор

МакГонагалл төвөгшөөлгүй:

- Уизли чи ч бидэнтэй хамт яв гэсэн учир Харри их л гайхав.

Алсад яваа сурагчид тэмцээн хойшлогдох болсныг дургүйцэн шуугилдаж зарим нь түгшсэн харагдана. Рон Харри хоёр профессорыг даган гантиг шатаар өгслөө. Энэ удаа профессор тэднийг танхим руугаа биш эмнэлэг рүү дагуулж иржээ.

- Үүнийг дуулаад та нар цөхрөх л байх. Ахин нэг дайралт боллоо ... Хоёр хүнийг шүү ... гэж профессор МакГонагалл ер бусын аядуун өгүүлээд эмнэлгийн үүдэнд дөхөж очлоо.

Харрийн дотор хүйт оргив. Профессор МакГонагалл үүдийг түлхэн нээж, тэд дотогш оржээ.

Хатагтай Помфри тавдугаар дамжааны нэг охины дээрээс тонгойно. Энэ бол Харри Рон хоёр шинэ жилийн үеэр Слизериний өрөөнд очих замаа асуух гээд бүтээгүй Когтевраны нөгөө охин байв.

Харин хажуугийн орон дээр нь ...

- Гермиона! гэж Рон уулга алдлаа.

Гермиона огт хөдөлгөөнгүй хэвтэх агаад нээсэн нүд нь шил шиг гөлийжээ.

- Эднийг номын сангийн үүднээс олсон юм. Яагаад гэдгийг та нар бас л мэдэхгүй биз дээ? гэж профессор МакГонагалл хэлээд жижигхэн дугариг толь тэдэнд үзүүлж:

- Энэ толь тэдний дэргэд шалан дээр байсан юм гэлээ. Рон, Харри хоёр Гермионагаас харц үл салган толгой сэгсрэв.

- Би та нарыг Гриффиндорын шилтгээнд хүргэж өгнө. Би сурагчидтай ярилцах учиртай гэж хэлээд профессор МакГонагалл хүндээр санаа алдлаа.

Бүх хүүхдүүдийг цугласан хойно профессор:

- Бүх сурагчид оройн зургаан цагаас өмнө өөр өөрийнхөө тэнхимийн өрөөнд эргэж очоод тэндээс гарахгүй байх ёстой. Багш нар хичээлд чинь хүргэж өгнө. Дагалдагч хүнгүйгээр хэн ч бие засах газарт очиж болохгүй. Бүх тэмцээн, бэлтгэл түр зуур хойшлогдлоо. Үдэш орой хаашаа ч явж болохгүй гэж хэллээ.

Гриффиндорын шилтгээнд дүүрэн байгаа хүүхдүүд энэхүү хатуухан сануулгыг нэг ч үг гээлгүй сонсоцгоов. Профессор юм уншсан цаасаа хуйлж аваад:

- Би ингэж цөхөрч үзсэнгүй удсан гэдгээ хэлмээр байна. Хэрэв гэмт этгээдийг барьж чадахгүй аваас сургууль маань хаагдах байлгүй дээ. Хэн нэгэнд ямар

нэг ажиг сэжиг байвал над руу хүрч ирээд мэддэг бүхнээ ярихыг хичээнгүйлэн хүсье гэж нэмж хэллээ.

Профессор МакГонагалл бүдүүн хатагтай бүхий завсраар гарч одохуй, завсар дорхноо хаагджээ.

- Хараач хөөе, хий үзэгдэл, Пуффендуйн нэг сурагч, Когтевраны нэг сурагчийг эс тооцох юм бол Гриффиндорын хоёр хүүхдэд хараал хийжээ хэмээн ихэр Уизлийнхны дотны анд Ли Жордан хуруу даран тоолоод:

- Слизерины сурагчид бүгд эрүүл саруул энх тунх байгааг багш нарын нэг нь ч анзаардаггүй юм байх даа? Энэ бүхэн Слизеринээс гараад байгаа нь тодорхойгүй байна гэж үү? Слизериний үе залгамжлагч бол Слизериний гайхал амьтан ... Эндээс Слизериний бүх сурагчдыг барьж аваад явуулчихаж яагаад болдоггүй юм бол? гэж түүнийг ярихад хүүхдүүд дэмжин толгой дохиж цувран алга ташицгаалаа.

Перси өөрөө Лигийн ард сууж байсан авч энэ дудаа өөрийнхөө үзэл бодлыг зарлах гэж яарсангүй. Харин ч бүр аргаа барсан дорой буурай харагдаж байв.

- Перси бүр гутарч гүйцжээ. Пенелон Кристалл гэдэг Когтевраны тэр охин чинь бас ахлагч юм. Гайхал амьтан ахлагч руу довтолж болно гэж түүний ухаан санаанд огт ороогүй дээ гэж Жорж Харрид шивнэлээ.

Гэвч Харри түүний хэлэхийг сонссонгүй. Түүний нүдэнд эмнэлгийн оронд дээр гантиг хөшөө мэт хөдлөхгүй хэвтэх Гермiona харагдсан хэвээр. Одоо гэмт хэрэгтэнг барьж чадахгүй бол яанаа? Тэгвэл Дурслийхантай амьдрах тухайгаа бодох хэрэг гарна даа. Том Реддл маглуудын асрамжийн газарт очихгүйн тулд Хагридыг барьж өгсөн шүү дээ. Харри одоо түүнийг сайн ойлгож байлаа.

- Бид одоо яах вэ? Хагридыг сэжиглэж байгаа байх даа? гэж Рон түүний чихэнд шивнэв.

- Явж түүнтэй ярилцах хэрэгтэй байна. Түүнийг тэгсэн гэдэгт би огт итгэхгүй.

Гэхдээ тэр үед гайхал амьтныг чухам Хагрид сулласан болохоор тэр нууц өрөөг хаана байдгийг мэдэх учиртэй. Үүнээс л яриагаа эхлэх юм шүү гэж Харри бодлогошрон хэллээ.

- Гэхдээ МакГонагалл багш шилтгээнээс зөвхөн багш нарын хамт хичээлийн үеэр л гарч болно гэсэн.

- Тэгэхээр аавын хуучин нөмрөг дахин хэрэг болох нь ээ.

Харри ааваасаа өвлөн авсан цорын ганц зүйл бол урт, мөнгөлөг өнгийн далдын хар нөмрөг байлаа. Түүнгүйгээр сургуулиас гарах аргагүй. Учир нь тэд хэнд ч харагдалгүй Хагридтай уулзах ёстой. Андууд хэвтдэг л цагтаа хэвтээд Невилл, Дин, Симус нарыг ярьж дуусаад унтахыг хүлээж байснаа босоод хувцаслан том нөмрөгөө нөмөрлөө.

Шилтгээний харанхуй хонгилоор явна гэдэг тийм ч таатай бус. Шөнийн цагаар шилтгээнд тэнэж байсан Харри ийм орой болсон хойно ийм их хөл хөдөлгөөнтэй

байхыг урьд өмнө үзээгүй юм. Багш, ахлагч, хий үзэгдлүүд ямар нэг аюултай юм үзэгдэж магадгүй гэсэн бололтой эргэж харан хос хосоороо явцгаана. Харамсалтай нь далдын хар нөмрөг чимээ дарж чадахгүй ажээ. Жижүүрлэхээр гарсан Снеггээс ердөө л алхамын төдий зайтай байтал Рон ямар нэг гишгичихээд чанга хараатал, яг тэр үед Снегг агш найтаалгах таарч бүх юм аятайхан өнгөрчээ. Андууд хаалга руу дөхөж очоод санаа алдан хүнд царсан үүдийг нээлээ.

Одод түгсэн саруулхан шөнө байлаа. Хориотой ойн моддын дундуур ойн харуулын бяцхан байшингийн цонх гэрэлтэн харагдана. Хүүхдүүд бүр хаалганд тулж очсон хойноо нөгөө авралт нөмрөгөө тайлцгаав.

Үүд тогшоноо гартаа нум барин онилсон Хагридыг харлаа. Түүний ард чонын ангуучин Соёт чанга хуцна.

- Энэ чинь хэн бэ! Ийм шөнө ойгоор яах гэж яваа юм? гэж Хагрид зэвсгээ буулган тэднийг гайхан харсаар асуув.

Тэд хамтдаа гэрт орох үед Харри нумыг заагаад:

- Үүгээр яах нь вэ? гэж асуулаа.

- Зүгээр л ... Яах ч үгүй ... Би ... хүн ... хүлээж байсан юм ... Сууцгаа цай ууцгаая

... гэж Хагрид түгдчинэ.

Тэрбээр юу хийж байгаагаа сайн мэдэхгүй байгаа бололтой. Усаа цалгилуулж галаа унтраах шахсанаа ханд хийдэг гүцнийхээ бариулыг хамаагүй татаад мулталчихав.

- Хагрид чи юу болоод байна? Гермionaгийн тухай дуулаа биз дээ?

- Тиймээ, дуулалгүй яахав ...

Хагридын дуу хоолой хэзээ ч ийм байгаагүй билээ.

Тэрбээр цонх руу түгшингүй харснаа ханд хийхээ мартан цай аягалаад самартай том бялуу зүсэж байтал гэнэт үүд чанга тогшлоо.

Бялуу шалан дээр унажээ. Рон Харри хоёр бие биеэ айсан харцаар харснаа далдын хар нөмрөгөө нөмрөөд алсын буланд очиж зогсов. Хагрид тэднийг харагдахгүй байгааг үзэж итгээд нумаа аван үүдийг нээлээ.

- Үдшийн мэнд, Хагрид аа.

Оромжинд Дамблдор орж ирэв. Тэрбээр хөмсөг зангидан баргар царайлжээ. Түүний араас бас нэг хүн орж ирлээ. Дамблдорын дагуулсан хүн тун ч хачин төрхтэй ажээ.

Үл таних тэр хүн намхан авч бадриун ороолдсон буурал үстэй сэтгэл зовсон ядрангуй царайтай юм. Тэрбээр ер бусын хувцас алаглуулан өмсчээ. Судалтай костюм ягаан зангиа, хар жанч, шөвгөр хоншоортой улаан шаахай өмсөж сугандаа цайвар ногоон тогоо хавчуулсан байв.

- Энэ чинь аавын дарга. Ид шидтэний яамны сайд Корнелиус Фаж байна! гэж

Рон сэмхэн шивнэлээ.

Харри Роныг чимээгүй бол гэж дохин тохойгоороо нудрав.

Хагридын царай цонхийж, духан дээр нь хөлс бурзайжээ. Тэрбээр Корнелиус Фаж, Дамблдор хоёрыг гайхан харсаар нэгэн сандалд суулаа.

- Тусгүй ажил боллоо, Хагрид минь! Тун ч тусгүй. Ямар нэг юм бодож олох хэрэгтэй. Холимог цустай дөрвөн хүүхэд дайралтанд өртлөө. Энэ явдал арай дэндэж байна. Яам арга хэмжээ авах ёстой гэж Фаж товчхон ярьж эхлэв.

- Би ... үүнийг ... хэзээ ч ... Намайг биш гэж та бүхэн ... мэднэ дээ ... Би хэзээ ч ... профессор Дамблдор гуай ... гэж Хагрид хэлээд Дамблдорыг царайчлангуй харна.

- Корнелиус минь, би зарим зүйлийг тодруулж өгмөөр байна. Хагридад би бүрэн итгэдэг. Түүнийг хардахгүй байгаа гэж Дамблдор хөмсгөө улам зангидан эрс тэс хэллээ.

Фаж тун эвгүй байдалд орсон ч:

- Альбус та сонсож байгаач. Хагридын урьд хийсэн ажил түүнийг буруутгаад байгаа юм. Яам өөр яах ч арга алга. Арга хэмжээ авахагүй бол болохгүй. Ивээн тэтгэх зөвлөл бүх юмыг мэдэж байгаа гэлээ.

- Хагридыг холдуулснаар энэ явдлыг зогсоохгүй гэдгийг би танд дахин хэлмээр байгаа гэж ярихдаа Дамблдорын цэнхэр нүд гялалзаж байлаа. Харри ийм байхыг нь хэзээ ч үзээгүй юм.

Фажын сэтгэл хямран гартаа тогоогоо эргүүлнэ.

- Болсон явдлыг миний байр сууринаас аваад үз дээ, Альбус минь. Намайг бас шахаад байна. Юм хий гэж шаардаад байна. Хэрэв Хагридыг буруугүй гэж нотлох аваас бид буцаагаад л аваад ирнэ. Тэгэхэд муу юм ярих хүн гарахгүй гэдэгт итгээрэй. Харин одоо би Хагридыг авч явах хэрэгтэй. Тэгэх шаардлагатай юм. Энэ бол миний үүрэг.

- Намайг авч явна гэнээ? Хаашаа? гэж Хагрид асуугаад чичирч байв.

- Удахгүй ээ. Энэ бол шийтгэл биш шүү, Хагрид аа. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ. Жинхэнэ гэмт хэрэгтнийг барьсан хойноо танаас уучлал гуйгаад явуулах болно ... гэж хэлэхдээ Фаж Хагридаас харцаа бууруулж байлаа.

- Азкабан руу аваачих уу? гэж Хагрид сөөнгө дуугаар асуув. Фажыг хариу хэлж амжаагүй байтал үүд ахиад тогшлоо.

Дамблдорыг үүд нээхэд орж ирсэн хүнийг хараад Харри өөрийн эрхгүй дуу алдахад

Рон түүний хажуу руу тохойгоороо нударчээ.

Аян замын урт хар жанч нөмөрсөн, сэтгэл хангалуун хүйтэн инээмсэглэл нүүрэндээ тодруулсан Люциус Малфой түргэн түргэн алхалсаар орж ирлээ. Соёот уурсан архирна.

- Фаж та хүрээд иржээ. Сайн байна! гэж Малфой хэлэв.

- Та ... Танд ... юу хэрэгтэй юм бэ? Явж үз! Өөрөөр хэлбэл ... миний байшингаас тонил! гэж Хагрид уурсан хашгирлаа.

- Хонгор минь, үүнийг чинь байшин гэж хэлдэг юм бол энд чинь байхад тийм ч сайхан биш байна. Би захирлыг эрж сургууль руу утасдахад түүнийг энд байгаа гэсэн

юм хэмээн хэлэхдээ Малфой ойн харуулын тааруухан оромжийг тун ч сэжиглэнгүй харж байв.

- Та надаар яах гэсэн юм бэ, Люциус минь? гэж Дамблдор асуулаа. Хэдийгээр эелдэг асуусан ч нүдэнд нь таагүй оч гялалзана.

- Аймшигтай мэдээ дуулганаа. Ивээн тэтгэгч нар таныг захирлын тушаалаас халахаар шийдсэн юм. Энэ таныг халах тушаал байна. Тушаал дээр арван хоёр хүний гарын үсэг бүгд бий. Та болж байгаа явдлыг зогсоож чадахгүй байгаа болохоор айж байна. Хичнээн ч хохирол гарав даа? Өнөөдөр бас хоёр биз дээ? Хэрэв гэмт хэрэгтнийг зогсоож чадахгүй аваас мөдхөн Хогвартст нэг ч холимог цустан үлдэхгүй нь. Энэ бүхэн ямар муухай уршиг тарихыг бид сайн мэдэж байгаа хэмээн Малфой жүжигчин лугаа үгээ сунжруулан хэлж, гаргасан цаасаа үзүүлэв.

- Дамблдорыг хална гэнээ? Ингэж болохгүй! Энэ чинь эцсийн арга хэмжээ байх ёстой ... Люциус минь, сонсооч ... гэж Фаж дүрсхийлээ.

- Захирлыг томилох, халах нь ивээн тэтгэх зөвлөлийн бүрэн эрхийн асуудал.

Дамблдор гараад байгаа гэмт хэргийг зогсоож чадахгүй болохоор ... гэж

Малфой нэгэн хэмийн аялгуугаар ярина.

- Дамблдор чадахгүй гэнээ? Тэгвэл хэн чадах юм? гэж Фаж догдлон асуухад дээд уруулд нь хөлс бөнжигнөж байв.

- Үүнийг бид мөдхөн мэдэх болно. Арван хоёр хүн бүгд санал нэгтэй байгааг анхаарах хэрэгтэй дээ ... гэж Малфой жудаггүй байдалтай ярзайн хэллээ.

Хагрид үсрэн босоход түүний сэгсгэр хар толгой адар шүргэнэ.

- Аа-аа! Та нар хэдийг ... хэдийг та нар ... шахаж ... айлгасан бол доо ... Тэгээд л зөвшөөрсөн хэрэг гэж Хагрид орилов.

- Хонгор минь, муухай зангаасаа болоод балрах вий дээ. Азкабаны харгалзагч нарыг ингэж загнаж болохгүй гэж зөвлөмөөр байна. Ингэхэд тэд дургүй байдаг юм ... гэж Малфой харууссан дүр эсгэн өгүүлэх ажээ.

- Дамблдорыг хөөнө гэнээ! Хөөгөөд үз л дээ. Холимог цустнуудад тэртээ тэргүй аврал байхгүй! Тийм ээ, аврал байхгүй! Бүгдийг цааш харуулах байлгүй гэж Хагридыг оволзоход Соёт өрөвдөн ульж байлаа.

- Хагрид минь тайвшир. Нэгэнт л ивээн тэтгэх зөвлөл шийдсэн хойно би яахав, Люциус ээ гэж Дамблдор хэлээд Малфойг харав.

- Гэхдээ ... хэмээн Фажыг түгдрэхэд:

- Үгүй ээ! гэж Хагрид нүргэлүүлэн хэллээ.

Дамблдорын цэнхэр нүд Малфойн хүйтэн харцтай тулгарчээ.

- Гэхдээ нэг зүйлийг мэдэх хэрэгтэй. Сургуульд намайг итгэн дагах нэг хүн үлдэх хүртэл би сургуулиа орхихгүй ээ. Бас тусламж хүссэн хүн бүр Хогвартсаас ямагт туслалцаа авдаг байсныг санаарай гэж Дамблдор удаан тод хэллээ. Тэрбээр нэг ч үгээ тэдэнд сонсголгүй үлдээхийг тэвчихгүй байсан юм.

Дамблдор ингэж хэлэхдээ Рон тэр хоёрын нуугдсан буланг нэвт шувт харсан гэж

Харри тангараглахад бэлэн байлаа.

- Бахархмаар санаа байна. Таны удирдагчийн үүргийг хэрхэн ... ойлгодог чинь ... өө-өө ... бүхэнд хүртээлгүй байх л даа. Таны дараагийн хүн журамлаж дөнгөнө гэж найдахаас өөр арга бидэнд алга. Тэгвэл холимог цустнуудыг ... өө-өө ... «цааш харуулахаа» болих биз хэмээн хэлээ Малфой тонгойн ёслов.

Тэрбээр оромжны үүд рүү очиж нээгээд дахин даажинтай тонголзон Дамблдорыг үдлээ. Фаж гуайн Хагридыг хүлээн гартаа тогоогоо эргүүлсээр байсан ч ой хамгаалагч маань огт яарсангүй гүнзгий амьсгал аваад үг бүрээ цэгнэн байж:

- Ямар нэгэн юм эрж байгаа бол аалзыг л дагах хэрэгтэй. Би аалзыг гэж байна.

Тэд л хэрэгтэй газарт аваачдаг юм. Миний хэлэх юм гүйцлээ гэв. Фаж түүнийг гайхан ширтэнэ.

- Би одоо явъя даа гэж Хагрид түүнийг тайтгаруулаад сохор номингийн арьсан дээлээ хөдөрлөө. Тэгээд Фажын араар гарах зуураа үүдний дэргэд саатаад:

- Хоолны хувьд бол ... Соёотыг хооллох хэрэгтэй дээ. За баяртай ... Өөрөөр хэлбэл эргэж иртэл баяртай гэж чангаар хэллээ.

Үүд чанга хаагдахад Рон далдын хар нөмрөгийг авч чулуудаад:

- Бид ингээд Дамблдоргүй үлдэх шив. Одоо өдөрт гурван удаа довтлох байлгүй дээ. Сургуулийг хэзээ ч хааж болох нь гэж дорой дуугаар хэлэв.

Соёот үүд рүү дөхөж очсоноо гэнэтхэн ульж, тэгснээ том савраараа түүнийг маажин малтаж байлаа.

БҮЛЭГ 15: АРАГОГ ААЛЗ

Шилтгээний эргэн тойрны нугад нэг л мэдэхэд зун болжээ. Тэнгэр, нуур хонин нүдэн цэцэгтэй өнгө булаалдан цэнхэрлэж, хүлэмжийн цэцгүүд өнгө хоршин алаглана. Гэхдээ Харрийн хувьд байгалийн гайхамшигтай хослох нэг л зүйл дутаад байв. Хавь орчныг аварга алхаагаараа хэмжин явах ойн харуул Хагрид, түүний мөнхийн дагуул чоноч нохой Соёт хоёр алгаа. Шилтгээнүүд ч бас төдийлөн сайхан байсангүй.

Рон, Харри хоёр Гермионаг эргэх гэсэн авч эмнэлэгт эргэлтийн хүн оруулахгүй байлаа.

- Өршөөгөөрэй, бид гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлагдсан. Ингэвэл манай өвчтөнүүдийг дахин дайрахгүй байлгүй дээ. Гэмт этгээд хэзээ ч гараад ирж болох юм ... гэж хатагтай Помфри үүдээ яльгүй онгойж завсраар нь тэдэнд хэлжээ.

Дамблдорыг явсны дараа хүн бүхний сэтгэлд айдас хургажээ. Шилтгээнийг гийгүүлэх наран хүртэл зарим цонхны шилийг нэвтлэхгүй байгаа мэт санагдана. Сургууль даяар амгалан тайван царай нэг ч үл үзэгдэх агаад хонгилд хааяа нэг гарах инээд хөөр хуурамч, зориуд юм шиг санагдан дорхноо дуугүй болох бүлгээ.

Өөртнь итгэх цорын ганц хүн үлдэх хүртэл сургуулийг орхихгүй. Хогвартет байдаг хэн ч «тусламж хүсэх аваас ямагт авдаг байсан» хэмээх Дамблдорын сүүлчийн үгийг Харри өөртөө байнга давтдаг байлаа. Гэхдээ энэ чинь юу гэсэн үг вэ? Одоо хэнээс тусламж хүсэх вэ? Эргэн тойрны бүх хүмүүс яг л өөр шиг нь айн ширвээтсэн байгаа юм чинь.

Аалзны талаар Хагридын өгсөн зөвлөгөө ойлгомжтой, тодорхой байсан ч шилтгээнд нэг ч аалз үлдээгүй мэт харагдах болохоор юугаа ч мөрдөх билээ. Аалзнаас үхтлээ айдаг Роныг бодвол Харри аалзнуудыг хянамгай гэгч эрж байлаа. Эрэл хийхэд багш наргүйгээр шилтгээн дотуур ганцаар явахыг хориглосон хорио цээр түвэг учруулна.

Харрийн нэг ангийхан хамгаалуулахыг эсэргүүцдэггүй ч Харрид энэ нь бишгүй түвэгтэй аж.

Сургуульд айдас хүйдэс, ажиг сэжиг дүүрэн авч сэтгэл хангалуун явах цорын ганцхан сурагч байлаа. Драко Малфой дөнгөж саяхан ахлагч болсон мэт бардам түрэмгий дүртэй сургууль дотуур холхино. Малфой чухам юунд баярлаад байгааг Харри ойлгохгүй уджээ. Гэтэл Дамблдор явж, Хагрид баригдсанаас хоёр долоо хоногийн дараа Харри уусмал бэлтгэх хичээл дээр Малфойн ард суух учрал тохиожээ. Тэгээд түүнийг Крэбб Гойл хоёртой ярилцахыг сэмхэн сонссон билээ.

- Дамблдорыг зайлуулж чадах цорын ганц хүн бол аав гэдгийг би үргэлж мэддэг байсан юм аа. Аав түүнийг үнэхээр бүтэхгүй захирал гэж хэлдгийг би та нарт ярьж байсан даа. Одоо л бид жинхэнэ захиралтай болж магадгүй. Тэгвэл нууц өрөөнөөс айхгүй түүнийг хаахгүй болно. МакГонагалл багш зүгээр л орлож байгаа болохоор удахгүй л дээ ... гэж Драко дуугаа аяарсан шивнэжээ.

Снег багш Гермionaгийн хоосон суудал тогоог хальт харсан боловч түүний байхгүй талаар ганц ч үг дуугарсангүй.

- Ноёнтоон та захирал болох саналаа яагаад өгч болдоггүй юм бэ? гэж Драко түүнээс чангаар асуулаа.

- Малфой, энэ чиний ухаан хүрэх асуудал биш. Профессор Дамблдорыг ивээн тэтгэгчид түр зуур л холдуулсан юм. Түүнийг мөдхөн ахиад бидэнтэй хамт байна гэж би зориглон батлаж чадна гэж Снег багш хэдийгээр жимбэгэр уруулд нь үл ялиг инээмсэглэл тодорсон ч эрс шулуун хэлэв.

- Яалаа гэж дээ! Таныг нэр дэвшүүлбэл манай аав дэмжинэ гэж би бодож байна. Таныг манай сургуулийн хамгийн сайн профессор гэж би түүнд хэлнэ.

Снег багш хүйтнээр инээмсэглэн ангийг тойруулан харах үедээ аз болоход тогоон дээрээ дотор нь муухайрсан мэт тонгойх Симус Финниганыг олж харсангүй.

- Гайхалтай нь яагаад эрлийзүүд чемодан саваа бэлтгэхгүй байнаа? Мөдхөн нэг нь үхнэ гэж таван галлеоноор мөрийцье. Харамсалтай нь Грэйнджер бус ... гэж Драког үргэлжлүүлтэл хонх жингэнэлээ.

Рон түүний зүг дайрсан авч үймээн шуугианаас болоод анд нараас нь өөр хэн ч түүнийг анзаарсангүй. Харри Дин хоёр Роны хоёр талаас нь зүүгджээ.

- Намайг тавь! Саваатай саваагүй би түүнийг нүцгэн гараараа дөнгөнө! гэж Рон мултрах санаатай хашгирна.

- Алив түргэлээрэй! Би та нарыг ургамал судлалын хичээлд чинь оруулж өгнө гэж Снег багш хэллээ.

Сурагчид цувран зогсоход адагт нь Харри Дин мултрах гэж зүтгэсээр байгаа Рон нар зогсов. Снегг багш сурагчдыг шилтгээнээс дагуулан гаргаж цэцэрлэг дундуур хүлэмж рүү аваачлаа. Тэгэхэд л Рон арайхийн суларчээ.

Ургамал судлалын хичээл дээр Жастин, Гермиона хоёр байхгүй байсан учраас хүүхдүүд сэтгэл санаагаар унасан харагдана.

Профессор Стебль тэдэнд гандаж муудсан абиссины алтан товчыг зулгаах үүрэг өгчээ. Харри тэвэр дүүрэн хуурай өвс авч яваад Эрни МакМиллантай хаз тулгарав. Тэрбээр Ханнатай хамт өвс зулгааж байсан аж. Энри гүнзгий санаа алдаад албан ёсны байдлаар:

- Чамайг хардаж байсныг уучлаарай, Харри. Чи Гермиона Грэйнджер өөд хэзээ ч дайрахгүй шүү дээ. Урьд ярьж байсан бүгдийнхээ төлөө хүлцэл өчье Одоо бид цөмөөрөө л адилхан. Гэхдээ ...

Түүнийг булцгар гараа сунгахад Харри чин сэтгэлээсээ атгажээ.

- Драко Малфой гэдэг энэ хижиг хичнээн додигор явааг хар даа! Би бүр үүнийг Слизериний үе залгамжлагч байх гэж бодох боллоо. Үнэн үү? гэж Эрни хатсан өвс хамах зуураа хэллээ.

- Бодож олсонд чинь баяр хүргэе гэж Эрнийг Харри шиг амархан уучлахааргүй байсан Рон бувтнан хэлэв.

- Харри чинийхээр бол энэ Малфой ингэсэн үү?

- Үгүй ээ! гэж Харри ер бусын ширүүнээр хэлжээ. Эрни, Ханна хоёр учрыг ололгүй түүнийг гайхан харна.

- Үгүй ер өө! Хараач! гэж Харри хэлээд Роны нурууг цэцэрлэгийн хайчлуураар түншээд авлаа. Тэднээс нэг метр орчмын зайд гурван том аалз ой чиглэн талбай дундуур гүйж явав.

- За-а. Гэхдээ бид одоо шуудхан мөрдөж чадахгүй нь ... гэж Рон баярлаж хөөрсөн царай гаргахыг хичээн хэллээ.

Эрни, Ханна хоёр тэдний яриаг сониучирхан чагнана. Харри маань зугтан яваа аалзнуудыг харсаар.

- Тэд хориотой ой руу явж байгаа бололтой ... Рон бүр урвайж гүйцжээ.

Ургамал судлалын хичээлийн дараа профессор Стебль сурагчдыг хар урлагаас хамгаалах хичээлд оруулахаар хүргэж өглөө. Рон, Харри хоёр ажиллах төлөвлөгөөгөө бусдад мэдэгдэлгүй хэлэлцэхийн тулд ангийхнаасаа хоцорчээ.

- Бидэнд ахиад л далдын хар нөмрөг маань хэрэг болох нь ээ. Хагрид ой руу Соёотыг авч явдаг байсан болохоор бид ч бас дагуулах болно. Нэг амьтан дэргэд байвал дээр гэж Харри хэлэв.

- Тэгье ээ. Гэхдээ ... Тэнд чинь ... Ойд гэнэтхэн махчин мангас гараад ирвэл яанаа? гэж Рон шидэт саваагаа тэмтрэн ярилаа.

Харри юу ч хэлсэнгүй. Андууд ангийн хамгийн арын суудалд суужээ.

- Тэнд сайн амьтад ч байдаг юм. Хүн морь, ганц эвэрт гээд л ... хэмээн Харри андынхаа сэтгэлийг засах санаатай хэлэв.

Рон хэзээ ч Хориотой ойд очиж үзээгүй билээ. Харри нэг удаа явж үзсэн болохоор тиймэрхүү явдал давтагдахгүй байх гэж битүүхэн найдаж байжээ.

... Алтан хонгиот Туг үс анги дотуур бараг нисэх шахан түүний хөөр хөгжөөнтэй төрх хүүхдүүдийн анхаарлыг татах аж. Бусад багш нар улам баргар дуугүй болсон ч Туг үс чалчаа яриа сайхан инээмсэглэлээ огт орхисонгүй.

- Би хүрээд ирлээ! Харуул хамгаалалт юунд хэрэгтэй юм бэ? гэж тэрбээр дуу алдана.

Хүүхдүүд дүнсгэр царайлан бие биеэ харсан ч огт дуугарсангүй. Аюул өнгөрсөн! Гэмт этгээд олдсон! гэж Туг үс сунжруулан хэлэх нь оюун ухааны хомсдолтой хүүхдүүдэд ярих мэт санагдана.

- Танд хэн ингэж хэлсэн юм бэ? гэж Дин Томас дуугаа өндөрсгөн асуув.

- Хонгор хүү минь, Хагридыг буруутай гэж зуун хувь итгээгүй бол ид шидтэний яамны сайд түүнийг хэзээ ч баривчлахгүй шүү дээ гэж Туг үс нэг дээр нэмэх нь нэг тэнцүү хоёр гэдгийг тайлбарлах лугаа хэллээ.

- Итгэлтэй байсан нь эргэлзээтэй байвал яана! гэж Рон Динээс чангаар хашгирав.

- Хагридыг баривчилсан тухай ноён Уизли танаас би арай илүү мэдэх байх гэж найднам гэж хэлэх Туг үсийн биеэ тоосон гэдэг нь хязгааргүй.

Рон цаашаа маргах гэсэн боловч ширээн доогуур Харрийг өшиглөхөд ухаарч яриагаа тасласан билээ.

- Бид тэнд байгаагүй бүү март гэж Харри шивнэжээ.

Гэхдээ Туг үсийн хоосон толгойлсон хөөр баясал, Хагридыг буруутай гэж эргэлзэлгүй итгэсэн явдал бүх муу юм дууссан гэдэг бодол нь Харрийн уурыг хүргэж

«Ороолонтой орооцолдсон нь» гэдэг зузаан номыг аваад хар урлагаас хамгаалах хичээлийн багш руу нүүлгэчихмээр санагджээ. Ингэхийн оронд тэрбээр: «Өнөө шөнө ой руу явцгаая» гэж бичээд Ронд өглөө.

Рон бичгийг уншаад шүлсээ арайхийн залгаж саяхан хүртэл Гермionaгийн сууж байсан суудал руу харав. Энэ нь түүний зоригийг бадраан тэрбээр зөвшөөрөн толгой дохижээ.

Зургаан цагаас хойш шилтгээн дотуур явах, зугаалах хориотой болохоор их танхим ямагт дүүрэн хүнтэй байна. Ярих юм бишгүй болохоор Гриффиндорынхон шөнө дөл болтол унтлагын өрөө рүүгээ тарж явалгүй сууцгаана.

Харри оройн хоолны дараа далдын хар нөмрөгөө чемоданаасаа гаргаж аваад хүүхдүүдийг тарахыг хүлээн оройжингоо дээр нь суужээ. Жорж Фред хоёртой алга болдог хэзрээр удаан тоглох зуур Жинни сонирхон үзэж байв. Тэрбээр Гермionaгийн суух дуртай сандалд суугаад тун ч уруу царайтай тэдний тоглохыг ажиглана. Рон, Харри хоёр тоглоомыг хурдхан дуусгахын тулд зориуд хожигдож байв. Тэгээд ч шөнө дунд өнгөрсөн болохоор Фред, Жорж, Жинни гурав унтахаар явцгаажээ.

Харри Рон хоёр унтлагын өрөөний хаалга дуугарахыг хүлээж байснаа далдын хар нөмрөгөө нөмрөөд бүдүүн хатагтайн манадаг завсраар гулсан гарлаа.

Ахиад л жижүүр багш нар дүүрэн зогсох шилтгээн дотуур явах амаргүй аян эхэлжээ. Эцсийн эцэст тэд ямар ч аюул осолгүй хонгилын танхимд хүрээд царсан хаалганы түгжээг чимээгүйхэн мулталж, юу ч дуугарахгүйг хичээн гадагш гарлаа. Орчин тойрныг сарны туяа гийгүүлнэ. Андууд сэтгэл амран амьсгал аваад нуга дундуур Хориотой ойн зүг явлаа.

Ой ойртох тусам Рон улам түгшиж байлаа.

- Бид ой руу орлоо гэж бодъё. Тэгтэл мөрдөх юм огт байхгүй бол яанаа.

Аалзнуудыг яг ой руу явсан гэдгийг бид хаанаас мэдэх билээ дээ. Тэд шилтгээнээс холдож явсан нь гарцаагүй хэдий ч ... гэж Рон ярина.

Гэхдээ түүний сэтгэл үймэрч байсан болохоор яриагаа таслажээ.

Хагридын оромжны харанхуй цонх уйтгартай харагдана. Харрийг үүд нээхэд Соёт баярлах гэж сүйд майд. Түүнийг чангаар хуцан шилтгээнд байгаа хүмүүсийг сэрээчих вий гэж айсандаа тэд зуухан дээр байсан цөцгийнний цавууг нохойд өгч шүдийг нь наалдуулжээ.

Харри далдын хар нөмрөгөө Хагридын ширээн дээр үлдээлээ. Харанхуй ойд түүний хэрэг байсангүй.

- Соёт минь зугаалъя! гэж Харри хэлээд хөлөө алгаджээ.

Чоноч нохой баярлаж хөөрсөндөө цовхчин байшингаас ухасхийн гараад ойн цоорхойгоор хурдлан нэгэн агч мод руу хөлөө өргөн сарив.

Харри шидэт саваагаа гаргаж ирээд «Люмос» гэж хэлтэл савааны үзүүрт зөрөг зам аалзны мөрийг ялгаж болохуйц бяцхан гэрэл гарлаа.

- Зүгээр л арга байна. Би өөрийнхийгөө асаая гэвч дэлбэрэх юм уу, эсвэл түүнээс ч муу юм болж магадгүйг чи мэдэх юм чинь ... гэж Рон хэлэв.

Харри Роны мөрнөөс татаад ногоо руу заалаа. Хоёр аалз шидэт савааны гэрлээс яаран зугтаж моддын өтгөн сүүдэрт орчихлоо.

- За яахав. Би явахад бэлэн байна гэж гарцаагүй байдалд орсон Рон санаа алдан хэлэв.

Анд нар эргэн тойрныг шиншлэн үндэс хожуулыг үнэрлэн явах Соёотыг дагуулан ой руу орлоо. Шидэт савааны гэрэлд ойн гүн рүү ар араасаа цувран явах аалзыг мөрдөх нь түвэггүй ажээ. Тэд юу ч ярилгүй хөл дор өвс шажигнах, навчис сэржигнэхээс өөр чимээг анхааран чагнасаар хориод хором явлаа. Төдхөн модод зөрөг замыг улам хаан, моддын орой тэнгэрийг халхлан ганцхан Харрийн шидэт саваа л гүн харанхуйд гялалзах цорын ганц гэрэл болж байв. Тэдний найман хөлтэй хөтөч нар замаас гарч байгааг андууд ажиглажээ.

Харри чиглэлийг тогтоох санаатай алхаагаа удаашруулсан ч өчүүхэн гэрлээс цааш харанхуйд юу ч үл үзэгдэнэ. Тэрбээр ойд ийм гүн орж үзээгүй юм.

Одоо яах вэ? Тэд Хагридтай хамт үүгээр явах үед ямар ч байсан замаас гарч болохгүй хэмээн ойн харуулын хэлж байсныг тэрбээр сайтар санаж байлаа. Гэтэл Хагрид одоо эндээс олон бээрийн тэртээ магадгүй Азкабаны шоронд сууж байгаа. Чухам тэр хүн аалзыг дагавал бүх юмын учир олдоно гэж тэдэнд ойлгогдохоор хэлсэн билээ.

Харрийн гарт ямар нэг нойтон юм хүрэхэд ар тийш үсрэн Роны хөлийг гишгэсэн боловч энэ нь ердөө л Соёотын хөлстэй хамар байжээ.

- Тэдний араас явах уу? гэж Харри аяархан асуулаа. Шидэт савааны гэрэл Роны нүдэнд тусаж харагдана.

- Явцгаая. Бид ийм хол дэмий яваагүй гэж Рон хэллээ.

Тэд одоо моддын хоорондуур сүлжин явах аалзнуудын сүүдрийг дагав. Явахад хэцүү байлаа. Харанхуйд бараг харагдахгүй хожуул, үндэс хөлд байнга тааралдана. Гэхдээ Харрийн гарт нохойн халуун амьсгал мэдрэгдэн түүнийг зоригжуулж байлаа. Шидэт савааныхаа гэрлийн тусламжтайгаар өтгөн өвсөн дотуур хаашаа ч юм яаран одох аалзнуудын мөрийг олохын тулд нэг бус удаа зогсох хэрэг гарчээ.

Бараг хагас цаг явсан агаад жанч нь юм л бол модны мөчир, бутны өргөсөнд тээглэн саад болно. Хэсэг хугацааны дараа хэдийгээр ой шугуй өтгөн хэвээр авч хэвгий толгодоор явж байгаагаа мэдэхтэй боллоо.

Соёот гэнэтхэн хуцахад чанга цуурайтна. Рон Харри хоёр санамсаргүй байсан тул цочжээ.

- Тэнд юу байна? гэж Рон Харрийн тохойноос чанга атгаж гүн харанхуй руу ширтжээ.

- Тэнд нэг юм хөдлөөд байна. Чимээг нь сонсоход том амьтан бололтой ...

Харри тун аяархан хэлэв.

Тэр хоёр чимээ чагналаа. Тэдний баруун талд нэвтэршгүй ойд зам гаргаж байгаа бололтой ямар нэгэн том амьтан мөчир хугачиж байв.

- Энэ юу вэ? Хөөе, тэнд хэн байнаа? гэж Рон чичирсэн хоолойгоор хашгирлаа.
- Чимээгүй! Тэр сонсчихно ... гэж Харри түүнд шивнэв.
- Сонсоно гэнээ? Соёотын хуцахыг аль хэдийн сонссон байлгүй! гээд Рон таг боллоо.

Харанхуйд юу ч үл үзэгдэнэ. Хүүхдүүд айсаар хүлээн зогсоцгооно. Нүргэлэх чимээ бүр ойрхон сонсогдсоноо нам гүм боллоо.

- Тэр юу хийгээд байнаа? гэж Харри асуув.
- Довтлох гэж байгаа байлгүй.
- Яваад өгсөн юм болов уу?
- М-мэдэхгүй ...

Энэхэн агшинд дэргэд нь хурц гэрэл гялалзлаа. Тэр хоёр алгаараа нүүрээ даржээ. Соёот улин зугтахыг завдсан ч өргөстэй бутанд тээглэхчээд улам чанга улилаа.

- Харри! Харри энэ чинь манай форд байна! гэж Рон баярласан дуугаар гэнэт хэлэв.
- Юу гэнээ?
- Хурдхан явцгаая!

Харри Роны араас итгэл муутайхан дагалаа. Андууд хальтарч бүдэрсээр хэдэн агшны дараа жижигхэн цоорхойд гарч иржээ.

Ноён Уизлийн машин цоорхойн яг голд сүлжилдсэн мөчрийн доохно зогсох агаад гэрэл нь нүд сохлом гялалзана. Гайхсан Роныг яаран дөхөхөд цэнхэр форд машин ч эзэнтэйгээ уулзаж байгаа том нохой мэт урдаас нь хөдөлжээ.

- Энд яг цагаа олж иржээ! Үүнийг хараач ... Ойд бүр зэрлэгшчихэж гэж Рон баясан хэлэв.

Машин зурагдаж шавар шавхай болжээ. Нэвтэршгүй ойгоор явахдаа тоймгүй зовлон үзсэн бололтой! Харин Соёот форд машинтай ойр дотно танилцахыг огт хүссэнгүй Харри руу наалдан, чичирсэн биеийг нь дулаан илчээрээ бүлээцүүлнэ. Харри бодлого болсноо шидэт саваагаа далд хийлээ.

- Чамайг бидэн рүү дайрах нь гэж бодлоо шүү! Чи хаана ирэх нь билээ! гэж Рон хэлээд машинаа эелдэгээр алгадна.

Харри нүдээ онийлгон аалзуудыг олоод үзчих санаатай гэрэлд харсан авч тэд бүгдээрээ хурц гэрлээс дайжин зугтсан байлаа.

- Бид тэдний мөрийг алдчихлаа. Мөрийг хурдхан олох хэрэгтэй! гэж Харри хэлэв.

Гэвч Рон хариу хэлсэнгүй. Тэрбээр хөшсөн мэт зогсох агаад харц нь Харрийн ард ойн дэвсгэрээс гурван метрт овойх нэг зүйл рүү ханджээ. Айсандаа түүний царай зэвхийрчээ.

Харри эргэж харж ч амжсангүй. Чангаар тас няс хийх чимээ гарснаа ямар нэг урт сахлаг юм түүнийг шүүрч аваад толгойг нь унжуулан дээш өргөхийг гэнэтхэн мэдэрчээ. Үхэтлээ айсан тэрбээр гар хөлөө савчин тонгочих зуур ахин нөгөө тас няс хийх чимээ гарч Роны хөл дээшээ гозосхийн өргөгдөж байхыг харжээ. Дараа нь Соёот цөхөрсөн байдалтай улиад ахин хэдхэн агшин өнгөрөхөд Харри тэднийг ойн гүн рүү авч явааг ойлголоо.

Толгойгоо доош санжигнуулан явахдаа түүнийг эзэмдсэн амьтан үсэрхэг зургаан хөлөөрөө алхалж хоёр хөлөөрөө түүнийг чанга зууран байгааг, дээр нь бас хоёр хазуур ам гялалзаж байхыг харжээ. Араас нь мөн л тийм амьтан Роныг авч явна.

Тэд бүр ойн гүн рүү явж байгаа нь эргэлзээгүй. Өөр нэг аварга амьтанд баригдсан Соёот суллагдах санаатай чангаар улихыг Харри сонссон ч өөрөө хашгирч чадахгүй байлаа. Түүний дуу хоолой ойн цоорхойд машинтай хамт хоцорсон юм байлгүй.

Энэхүү аймшигт амьтны саварт хэр удахаа Харри төсөөлөхгүй байв. Харанхуй жаахан сарниж аалзны хөл доорх навчис яг л амьд юм шиг бужигнан харагдана. Харри толгойгоо эргүүлэн харахад модгүй нүцгэн ойн цоорхойд байх агаад зүүдэнд ч оромгүй энэ явдлыг саран гэрэлтүүлэхэд түвэггүй ажээ.

Аалзнууд! Энэ бол ойн цоорхой руу тасралтгүй цувж байсан тэр жижигхэн амьтад биш ажээ. Бараг морины хэрийн биетэй найман нүд, сагсгар хар үстэй найман хөл

бүхий аварга аалзнууд! Харрийг авч явсан аалз шүүдэрт норсон толгод даган уруудсанаа аалзны шүлсээр нэхсэн торны яг голд байгаа бөмбөгөр мөнгөлөг үүр лүү явлаа. Олз хараад хазуур амаа тас нясхийлгэх сахлаг хөлтэй хамсаатнууд нь түүнийг дагалдана.

Аалз Харрийг тавихад хүү газарт дөрвөн хөллөн уналаа. Рон, Соёот хоёр ч хажууд нь унав. Соёот одоо улихаа болиод байрнаасаа хөдлөлгүй атиралдан байна. Рон ч бас тиймэрхүү харагдах бөгөөд амаа ангайж, нүдээ бүлтийлгэсэн байв.

Түүнийг авчирч хаясан аалз ямар нэг юм хэлэхийг Харри гэнэтхэн анзаарлаа. Гэхдээ юу гэдгийг хэлэхэд хэцүү. Эрүүгээ дэндүү чанга дуугаргах юм. Харри ямар ч байсан үл ойлгогдох үгийг ялаж сонсчээ.

- Арагог! Арагог! гэж аалз дуудна.

Аалзны бөмбөгөр үүрэн дотроос том зааны хэрийн биетэй аалз алгуурхан гарч ирлээ. Түүний бие хөлийн хар үсэнд буурал орж нүд нь муухай болсны дээр хазуур бүхий толгой нь сүү шиг цайрна. Тэр сохор аж.

- Юу болоод байна? гэж шинэ аалз эрүүгээ тачигнуулан сөөнгөтөв.
- Хүмүүс гэж Харрийг авчирсан аалз хариу хэллээ.
- Хагрид уу? гэж Арагог асуугаад улам ойртоход түүний цагаа буусан нүд тасралтгүй хөдлөх ажээ.
- Танихгүй хүмүүс ээ гэж Роныг авчирсан аалз хариулав.
- Тэднийг албал таарна. Би сайхан унтаж байсан юм сан ... гэж Арагог ууртай хэллээ.
- Бид Хагридын андууд гэж Харри хашгирав. Түүний зүрх хэнхдэгээ дэлбэлэх шахам оволзож хоолойд нь нэг юм тээглэжээ.

Ойн цоорхой даяар хазуур амны тачигнах дуулдана. Арагог дуугүй байлаа.

- Хагрид хэзээ ч нааш нь хүмүүсийг явуулдаггүй байсан гэж тэрбээр эргэлзэнгүй байртай алгуурхан хэлэв.
- Хагридад гай зовлон тохиолдсон юм. Тэгээд л бид ирлээ гэж Харри хүндээр амьсгаадан ярилаа.
- Гай зовлон гэнээ? Харин яах гэж та нарыг явуулсан юм? гэж хөгшин аалз асуухад Харри түүний эрүүний чимээг сонсоод түгшлээ.

Харри босох гэснээ болив. Хөл дээрээ зогсож чадахгүй байлгүй. Тэгээд тайван байхыг бүх чадлаараа хичээн газарт хэвтсэн хэвээрээ ярьж байв.

- Хагридыг ... нэг сурагч руу довтолсон гэж яамныхан бодоод байгаа юм. Тэд түүнийг Азкабаны шорон руу аваачсан.

Арагог хазуур амаа ууртай тачигнуулахад эргэн тойронд байгаа олон аалз түүнийг цуурай мэт давтлаа. Алга ташихтай адил байсан ч иймэрхүү алга таших чимээ Харрийг хэзээ ч ингэглээ айлгаж байгаагүй юм.

- Гэхдээ энэ чинь олон жилийн өмнө болсон явдал. Түүнээс хойш хичнээн ч хугацаа өнгөрөв дөө ... Тийм ээ би бүгдийг сайн санаж байна. Хагрид сургуулиа орхих хэрэгтэй болсон юм. Тэд намайг нууц өрөөнд цоожтой байдаг аюумшигт амьтан гэж бодсон билээ. Тэд Хагридыг үүд нээж намайг сулласан гэж бодоцгоодог байсан юм гэж Арагог гомдолтой хэллээ.
- Харин та ... та тэр өрөөнд байгаагүй юм уу? гэж асуух үед Харрийн нүүрэнд хүйтэн хөлс бурзайн урсана.

- Би юу? Би шилтгээнд төрөөгүй юм. Би алс холын орноос ирсэн. Намайг өндөг байхад нэг жуулчин Хагридад бэлэглэсэн билээ. Хагрид хариугүй жаахан хүүхэд байсан ч намайг асран халамжилж хонгилын өрөөнд нуугаад өөрийнхөө хоолны үлдэгдлээр тэжээж өсгөсөн юм. Хагрид миний дотны анд сайн хүн. Дараа нь хүмүүс намайг олоод цэл залуухан охины үхэлд буруутгасан билээ ... Хагрид тэгэхэд намайг аварсан. Түүнээс хойш би ойд амьдрах болж анд маань намайг эргэх боллоо. Надад бүр Мосаг гэргийг минь хүртэл олж өгсөн юм шүү. Манай гэр бүл хичнээн өнөр өтгөн болсныг харж байгаа биз дээ? Энэ бүхэн Хагридын ач гэж Арагог аалз хэлээд хазуураа тачигнуулна.

Харри эр зориггоо хөвчлөн байж

- Та хэзээ ч ... хэзээ ч хэнийг ч довтолж байгаагүй юу? гэв.

- Хэзээ ч үгүй. Би зөн совингоороо тэгж чадах байсан ч Хагридыг хүндэтгэдэг учраас хэзээ ч хүмүүст хор хүргэж байсангүй. Алагдсан охины биеийг жорлонгоос олсон бөгөөд би бол өөрийнхөө амьдардаг хонгилын өрөөнөөс өөр хаана ч очиж үзээгүй юм. Миний төрөл нам гүм, харанхуйг эрхэмлэдэг билээ гэж өвгөн аалз сөөнгө дуугаар ярина.

- Гэхдээ та охины хэн хөнөөснийг мэднэ биз дээ? Хэн ч байлаа гэсэн тэр чинь дахин эргэж ирээд хүмүүс рүү довтолох боллоо.

Уурсан тачигнах хазуурын чимээ олон хөлний дэвслэх шуугианд Харрийн үг дарагдаж асар том хар биеүд эргэн тойрон хөдлөнө.

- Түүнийг шилтгээнд байдаг муухай амьтан алсан юм. Энэ бол аалз бид үхэтлээ айдаг эртний чөтгөрийн үр удам. Түүнийг шилтгээн дотуур тэнэж явна гэж би мэдээд намайг суллаач хэмээн Хагридыг гуйж залбирснаа сайн санаж байна гэж Арагог өчив.

- Тэр ямархуу амьтан бэ? гэж Харри шаргуу шалгаалаа.

Хазуур амнууд аймшигтай тачигнаж айлган дэвслэх чимээ улам чангарч аварга биет аалзнууд бүр дөхөж ирэв.

- Бид энэ тухай хэзээ ч ярихгүй! Бид түүний нэрийг ч дурсдаггүй юм!

Хэдийгээр Хагрид надаас олон удаа гуйсан ч би түүнд энэ аймшигт амьтны нэрийг хэзээ ч хэлээгүй билээ гэж Арагог уурсан байлаа.

Хүрээлсэн аалзууд улам хумигдахуй Харри яриагаа үргэлжлүүлэх сонирхолгүй болов. Арагог ингэж удаан яриад бүр ядарсан бололтой. Тэгээд аалзны гэр лүүгээ алгуурхан ухарч эхлэлээ.

- Бид явдаг юм билүү? гэж Харри Арагог аалзнаас найдлага муутайхан асуув.

- Явна гэнээ? Тэгж бодохгүй л байна шүү ... гэж Арагог хяхтнана.

- Гэхдээ ... гэхдээ ...

- Миний үр хүүхдүүд намайг хэлсний дагуу Хагридыг хөнддөггүй байсан юм.

Гэхдээ шинэ зоог өөрөө залраад ирсэн үед би тэднийг хориглож чадахгүй л дээ. Хагридын анд минь үүрд баяртай.

Харри эргэн тойрноо харлаа. Хэдхэн метрийн зайд бүхэл бүтэн аалзны хороо тэднийг тонгойн харж зогсоод эрүү амаа тачигнуулан эв хавгүй толгой дээрх нүд нь эгнээ эгнээгээрээ гэрэлтэнэ. Харри гартаа зэвсэгтэй үхэхийн тулд босохыг завдтал ойд машины дохио хангинан дуугарч хурц гэрэл нүд сохлом гийгүүллээ.

Толгодын доод талд ноён Уизлийн машин дүнгэнэн иржээ. Чийдэн гэрэлтэж дохио чих дүлийрэм хангинаж аалзнууд тал тал тийшээ бут үсэрлээ. Зарим нь арагш ухасхийснээ нуруугаараа савж унаад хэмжээлшгүй урт хөлөө агаарт сарвалзуулна. Форд машин Рон Харри хоёрын өмнө хяхтнан зогсоод үүдээ нээлээ.

- Соёотыг аваарай гэж Харри хашгираад урд суудал руу үсрэв.

Рон чоноч нохойг гэдсээр нь тэврэн арагш чулуудлаа. Нохой өрөвдөлтэй гийнан хаалга тасхийн хаагдав. Рон хийн хөшүүргийг гишгэж амжаагүй байтал хөдөлгүүр өөрөө дүнгэнэн замаас зайлж амжаагүй аалзнуудыг дайран урагш ухасхийлээ. Бага зэрэг хажуулдан цоорхойгоос гарах үедээ ой шугуйг нэвтлэн зүтгэв. Машин мөчирт цонхоо шавхуурдуулан урагшилсаар нэг танихгүй замаа орлоо.

Харри Роныг харна. Роны ам ангайсан хэвээр авч бүлтийж байсан нүд нь хэвдээ оржээ.

- Бүх юм номоороо юу?

Рон хариу хэлэх ч тэнхэлгүй урдах замаа хөшин ширтэнэ.

Тэд таруу ойн замаар явахад Соёот урьдын адил арын суудалд гийнасан хэвээр. Тэгтэл аварга бүдүүн царс модыг шууд чиглэснээ мөчир зөчирийг нь хажуугийнхаа толиор хутга шиг зүслээ. Арван хором хэртэй чичирч шуугиж байтал модонд завсар гарч ахиад л тэнгэр цэлийн үзэгдэв.

Машин гэнэт зогсоход андууд эгээтэй л урд шилээ хага мөргөчихсөнгүй. Тэд Хориотой ойн цоорхойд ирсэн байлаа. Соёот савраараа урд шилийг маажин гарах гэж тэсч ядан тэмүүлнэ. Харрийг хаалга онгойлгов уу үгүй юу Соёот сум шиг үсрэн

гараад Хагридын байшингийн зүг сүүл хавчин хурдаллаа. Харри ч бас машинаас гарахад хормын дараа хүзүү нь хөшчихсөн Рон буугаад хөл гараа хөдөлгөж байв. Харри машины хамрыг талархан илбэхэд машин ой руу буцан нисэж төдхөн бараагүй боллоо.

Харри далдын хар нөмрөгөө авахаар байшинд ороход Соёот өөрийнхөө байдаг буланд хучлага дор чичрэн хэвтэж байв. Харри гэрээс гарахдаа хулуу ургасан талбай дээр Роны бүр уруу царайтай зогсож байхыг харжээ.

- Аалзыг дагаарай гэнэ шүү! Хагридыг үүний төлөө хэзээ ч уучлахгүй! Бид амьд үлдсэн маань л аз! гэж Рон ханцуйгаараа амаа арчин гомдолтой үглэнэ.

- Арагог өөрийнхөө андуудад муу юм хийхгүй гэж тэр бодсон байлгүй дээ.

Үүнд би эргэлзэхгүй байна гэж Харри татгалзан хэлэв.

- Хагрид маань солирсон байхаа! Тэрбээр элдэв амьтан харахад аймшигтай ч аюулгүй гэж үздэг юм байна! Энэ нь юунд хүргэж байгааг хар л даа! Азкабаны шоронд! Биднийг тийш явуулах ямар хэрэг байв аа? Бид тэнд очоод юу мэдсэн юм бэ? гэж хэлээд Рон оромжны ханыг нударгаараа балбан чичирч байлаа.

- Маш олон юм мэдсэн! Үгүй дээ гэхэд Харри хэзээ ч нууц өрөөг онгойлгоогүй гэдгийг. Хагрид буруугүй гэдгээ бидэнд хэлэх гэсэн юм байна. За яахав одоо хурдхан явахгүй бол үүр цайх нь гэж хэлээд Харри далдын хар нөмрөгөөрөө Роныг хучин зөөлөн түлхэв. Рон хариуд нь чанга тургижээ. Арагог аалзыг шилтгээний хонгилын өрөөнд өсгөнө гэдэг яавч жирийн санаа биш гэж түүнд бодогдсон юм байлгүй.

Шилтгээнд ойртсон хойноо Харри хөлөө харагдуулахгүйн тулд нөмрөгөө доошлуулан хяхтнан дуугардаг хаалгыг болгоомжтой онгойлголоо. Шилтгээнд байдаг өрөө рүүгээ явахдаа харуул хамгаалалтад гарсан хүмүүсийн дэргэдүүр амьсгал даран өнгөрнө.

Тэгж тэгж танхимд очиход ханан зуухны гал үнсэн дотроос өөрөө аслаа. Тэд далдын хар нөмрөгөө тайлаад дугуйрсан шатаар унтлагынхаа өрөө рүү өгслөө.

Рон хувцасаа ч тайлалгүй орондоо шургав.

Харин Харрийн нойр огт хүрэхгүй байгаа нь сонин. Тэрбээр орон дээрээ Арагогын хэлсэн үгийг цэгнэн сууна.

Тэгэхлээр ямар ч атугай шилтгээнд аймшигт амьтан байдаг л юм байна. Аймшигт амьтдынхаа дунд байхдаа шидтэнгүүдийн дунд Волдеморт ямар байдаг вэ, тийм л гэсэн үг. Аалзнууд түүний нэрийг хэлэхээсээ хүртэл айдаг аж. Рон тэр хоёр чухамхүү ямархүү амьтан байдгийг бас хүмүүсийг яаж чулуун хөшөө болгодгийг мэдэж чадаагүй нь л харамсалтай. Хагрид ч бас энэ тухай мэддэггүй юм байна.

Харри шилтгээний нарийхан цонхоор гийгүүлэх сарыг харсаар дэрээ дэрлэн хөлөө жийн хэвтлээ.

Одоо яавал дээр вэ? Одоохондоо мухардалд оржээ. Реддл өөр хүнийг барьсан юм байж. Тэгэхээр Слизериний залгамжлагч гэдэг урьдын адил оньсого хэвээр. Нууц өрөөг хэн онгойлгосон нь ойлгомжгүй юм. Тэр үед нээсэн хүн үү эсвэл өөр хүн юм болов уу? Хэнээсээ ч асуух вэ дээ? Харри Арагог аалзны ярьсныг тухайлан бодсоор хэвтлээ.

Тэгээд үүрэглэж эхэлтэл гэнэтхэн нэгэн бодол гялсхийн орж ирэв. Нойр нь ч хулжжээ. Энэ чинь л тааврын түлхүүр байж болох юм. Харри өндийн орон дээрээ суулаа.

- Рон! Хөөе Рон! гэж тэрбээр харанхуйд шивнэв. Рон зүүрмэглэн байснаа Соёотоос ч дутахгүй гиншлээ.

- Хөөе Рон, Тэр охин нас барахдаа ... Арагог аалз түүнийг жорлонгоос олсон гэж хэлсэн шүү дээ. Тэр чинь одоо болтол тэндээ байсаар байгаа юм биш биз? гэж Харри шивнэн хэлэв.

Рон сар луу уруу царайлан харсаар нүдээ арчиж байна. Үгүй ер ийм ч юм байх гэж!

- Харри чи түүнийг уйланхай Миртл гэж бодсон юм биш биз дээ?

БҮЛЭГ 16: НУУЦ ӨРӨӨ

- Биднийг хувиргах уусмал бэлтгэж байхад тэр чинь сүүлчийн бүхээгт дандаа бидний хажууд байсан. Бид түүнээс бүх зүйлийн тухай асуудаг байж л дээ. Харин одоо ... гэж маргааш өглөө нь Рон цай ууж суухдаа халаглана.

Аалзнуудыг олох амаргүй байлаа. Одоо болохоор Миртлийн хоргодох байранд хүрэх бүр ч хэцүү. Харуул хамгаалалтыг өнгөрч багш нарын соргог хараанаас удаан нуугдахгүй бол яриа хөөрөө болохгүйн дээр уйланхай Миртлийн жорлон Жастин, ноён Норрис муурын хэлмэгдсэн газраас ердөө л хоёрхон алхмын зайтай. Ингээд л андууд энэхүү шийдэж болохгүй юм шиг асуудалд толгойгоо эргүүлж гүйцжээ.

Гэтэл эхний хичээл дээр МакГонагалл багш тун ч таагүй мэдээ сонсголоо. Тэд энэ долоо хоногт анх удаа нөгөө гайтай өрөөний тухай мартсан юм. Ердөө долоо хоногийн дараа зургадугаар сарын нэгнээс шалгалт эхлэх болчихжээ.

- Шалгалт гэнээ? Биднээс шалгалт авах юм уу? гэж Симус Финниган сандрана. Харрийн ард ямар нэг юм түр няр хийлээ. Невилл Долгопупс шидэт саваагаа унагахдаа ширээний нэг хөлийг алга хийчихжээ. Профессор МакГонагалл саваагаараа дохиж ширээг зүгээр болгоод Симус руу эргэлээ.

- Сургууль одоо болтол хаагдаагүй болохоор та нарыг юм сураасай л гэсэн хэрэг. Шалгалт болдогоороо л болох учраас та нарыг сайн бэлтгэнэ гэж найдаж байна хэмээн тэрбээр ширүүн хэлжээ.

Сайн бэлтгэх! Харри шалгалтын тухай бодож ч чадахгүй байв. Анги даяараа шуугилдахад профессор МакГонагаллын царай төрх ширүүн боллоо.

- Профессор Дамблдор чадах чинээгээрээ дүрэм журмыг мөрдөх ёстой гэж хэлснийг би анхааруулмаар байна. Энэ бол жилийн турш мэдэж авсан юмыг чинь шалгана гэсэн үг.

Харри гэрийн шаахай болгон хувиргах ёстой хоёр цагаан молтогчинг гунигтай харна. Тэрбээр жилийн туршид юу сурсан билээ? Шалгалтан дээр юугаа хэлэх вэ? Рон Хориотой ой руу яаралтай очих тушаал авсан юм шиг уруу царайлан сууна.

- Ийм юмтай шалгалт өгнө гээд бодоод үз дээ гэж Рон хэлээд Харрид чичигнэн исгэрэх саваагаа харуулав.

Шалгалт эхлэхээс гурав хоногийн өмнө өглөөний цайны үеэр профессор

МакГонагалл бас дахин нэг юм зарлалаа.

- Би сайн мэдээ дуулгая гэж түүнийг хэлэхэд нам гүм байсан их танхимд хөөрөн хашгиралдах дуу хаджээ.

- Дамблдор захирал буцаж ирэх нь! гэж олон хүүхдүүд баярлана.

- Слизериний үе залгамжлагчийг барьчихжээ! гэж Когтевраны ширээний ард суугаа нэг охин хэллээ.

- Квиддичийн тэмцээн болох юм байна! гэж Вуд орилно.

- Одоо мандрагор ургаж гүйцээд хэрэглэж болохоор болсон гэж Стебль надад мэдэгдлээ. Хөших шившлэгэд өртсөн хэлмэгдэгсдийг өнөө орой бид амьдруулж чадах болно. Хэлмэгдэгсдийн нэг нь чухам хэн довтолсныг мэдэж байж болох юм гэдгийг та нарт сануулъя. Энэхүү аймаар жил гэмт этгээдийг барьснаар дуусах байх гэж их итгэж байна хэмээн хүүхдүүдийг чимээгүй болоход МакГонагалл багш үргэлжлүүлэн ярьжээ.

Хүүхдүүд хөгжилдөн шуугилдав. Харри тэсэлгүй Слизеринийхныг харлаа. Драко Малфой бусдын адил хөөрч баясахгүй ажээ. Харин Роны царай олон өдрийн туршид анх удаа инээмсэглэж харагдана.

- Бид Миртлийг байцаах шаардлагагүй ч байж болох юм! Гермиона бүх асуултанд хариулах байлгүй дээ. Тэр одоо яанаа! Гурван өдрийн дараа шалгалттай атал огт бэлтгээгүй байдаг! Хэрэв би л тэдний оронд байсан бол шалгалт дуустал сэхэхгүй байсан даа! гэж Харри хэллээ.

Жинни ойртож ирээд Ронтой зэрэгцэн суув. Тэрбээр сэтгэл догдолж хямарсан шинжтэй харагдана. Охин хуруугаа цайртал гараа чанга атгасан байхыг Харри анзаарчээ.

- Чи юу болоо вэ? гэж тавгандаа будаа хийх зуураа Рон асуув.

Хариуд нь Жинни тэдний ширээг уйтгартай айсан байртай харах аж. Түүний нүүр царай Харрид хэн нэгнийг санагдуулах авч чухам хэн гэдгийг нь санаж чадсангүй.

- Юу болоод байгаагаа яриач дээ гэж Рон амандаа юм чихэн асуув.

Жинни хэнтэй адилхан харагдаад байгааг Харри гэнэтхэн ухаарлаа. Тэрбээр сандалд суугаад яльгүй гайхан байгаа нь ганцхан өөрийнхөө мэдэж байгаа нууцыг хэлэх үү, байх уу гэж шийдэж ядах Доббитой яг адилхан байлаа.

- Би та нартай ярих хэрэгтэй байна гэж тэрбээр ичингүйрэн хэлээд Харрийг харахгүйг хичээнэ.

- Тэгээд яриач дээ гэж Харри түүнийг дэмжлээ. Гэвч Жинни ярих юмаа олохгүй мэт харагдана.

- Бид сонсож байна! гэж Рон тэсгэл алдан хэллээ.

Жинни амаа нээсэн ч нэг ч үг хэлж чадсангүй. Харри түүний зүг тонгойгоод зөвхөн

Рон тэр хоёрт дуулдахаар намуун дуугаар:

- Нууц өрөөний тухай ярих гэсэн юм уу? Ямар нэг юм хараа юу? Хэн нэг хүн хачин зан гаргаад байна уу? гэлээ.

Жинни гүнзгий санаа алдах үед ядарч туйлдсан царайтай Перси Уизли тэдэн рүү дөхөж ирэв.

- Чи юм идэв үү, Жинни? Тэгвэл би чиний оронд сууя. Өлсөж үхэх нь. Дөнгөж сая жижүүрээс буулаа.

Сууж байгаа сандлаар нь цахилгаан гүйсэн мэт Жинни ухасхийн босоод Персийг айсан маягтай хурдхан харснаа цааш одов. Перси ширээн дээрээс том аяга авлаа.

- Перси! Тэр чинь бидэнд маш чухал зүйл хэлэх байсан юм! гэж Рон уурлажээ. Цай балгах зуураа энэ үгийг сонссон Перси цацах шахлаа.

- Тэр юу хэлэх гэсэн юм бол? гэж ханиалган хэлэв.

- Би ямар нэг ер бусын юм харсан уу гэж асуухад тэр чинь ам нээх гэж байсан юм.

- Энэ чинь ... нууц өрөөтэй холбоотой байлгүй дээ гэж Перси таслан өгүүлэв. Рон гайхан хөмсөг өргөөд:

- Чи ямар нэг юм мэдэх үү? гэж асуулаа.

- Үгүй ээ, гэхдээ ... Гэхдээ нууцын тухай ярьсан юм чинь ... Жинни ... Би түүнтэй тааралдсан юм ... Саяхан ... намайг зүгээргүй байх үед тэр намайг харсан байхгүй юу. Чи элдэв юм бүү бодоорой. Би энэ тухай хэнд ч ярихгүй байхыг түүнээс хүссэн юм. Тэрбээр хэлсэн үгэндээ хүрсэн бололтой. Гэхдээ энэ бол дэмий хэрэг үнэн шүү ...

Персийг ийм их ичиж байхыг Харри хэзээ ч хараагүй билээ.

- Чи яасан юм бэ, Перси? Бидэнд нууцаа хэлчих, бид огт шоолохгүй ... гэж Рон инээмсэглэн хэллээ.

Гэвч Перси урьдын адил төлөв хэвээр байв.

- Харри, надад талх аваад өгөөч. Юм их идмээр санагдаад ...

Харри, Рон хоёрын тусламжгүйгээр маргааш гэхэд нууцыг илрүүлж болох юм гэдгийг ойлгоод юутай ч атугай боломж олдвол уйланхай Миртлгэй уулзаж ярихаар шийджээ. Аз болоход тийм боломж гарсан аж. Үдээс хойш Алтан хонгиот Туг үс тэднийг ид шидийн түүхийн хичээлд хүргэж өгөв.

Цаашдаа аюул байхгүй гэж өдөрт бараг зуун удаа давтан хэлэх Туг үс (энэ нь буруугаар эргэж ч болох талтай) жижүүр, харуул хамгаалалт гээд баахан түвэг удсан байна хэмээн үнэнээсээ итгэж байлаа. Түүний үс даахирч алтан өнгө нь алдагдаад ирэв. Шөнөжингөө дөрөвдүгээр давхарт жижүүрлэн зогссон болохоор тэр биз.

- Амилсан баримлуудын эхний хэлэх үг: «Энэ бол Хагрид байсан» гэх болно гэдгийг санаарай. Профессор МакГонагалл аюулгүйн энэ арга хэмжээг яагаад

өөрчлөхгүй байгааг үнэхээр гайхах юм гэж тэрбээр ангийхныг булан тойроход ярьжээ.

- Тийм ээ, тантай санал нэг байна гэж Харрийг хэлэхэд Рон гайхсандаа номоо унагаачихав.

- Баярлалаа Харри гэж Туг үс талархан хэлээд Пуффендуйхны урт цувааг өнгөрөөхийн тулд тэднийг зогсоожээ.

Тэгснээ:

- Шөнө болгон сэрэмжилж хичээлийн хоорондуур сурагчидтайгаа ингээд явж байна гэдэг тусгүй юм. Тэртэй тэргүй багш нарын ажил барагдахгүй байхад! Шал дэмий болгоомжлох юм гэж үглэнэ.

- Таны зөвөө, ноёнтон гэж Харрийг зөвшөөрөн толгой дохиход Рон түүний чухам яах гээд байгааг тааварлалаа.

- Энэ дэмий явдлаас яагаад одоо татгалзаж болдоггүй юм бэ? Одоо ердөө ганцхан хонгилоор өнгөрөх л үлдээд байна гэж Рон хэлэв.

- Уизли минь, би яагаад чиний зөвлөгөөг дагаж болохгүй билээ. Би дараагийнхаа хичээлд бэлтгэх хэрэгтэй байж гэж Туг үс хэллээ.

Тэгээд Туг үс яаран холдов.

- Хичээлд бэлтгэнэ гэнэ шүү! Үсээ буржийлгах гэж л яваа даа ... гэж Рон араас нь дурамжхан дуугарчээ.

Андууд маань халааснаасаа юм эрж байгаа дүр үзүүлэн ангийхнаасаа хоцроод уйланхай Миртлийн жорлон руу эргэн ухасхийлээ. Бүх юм одоохондоо яг номоороо болж байв.

- Поттер! Уизли! Та нар энд юу хийж байгаа юм бэ? гэх профессор МакГонагаллын ширүүн дуу тэднийг зогсоожээ.

- Бид энд ... Бид ... Бид явах гэж байсан юм ... гэж Рон түгдчив.

- Гермионаг эргэхээр гэж Харри анддаа туслалаа.

Рон, профессор МакГонагалл хоёр түүнийг тун ч гайхан харжээ.

- Бид түүнтэй уулзалгүй тун их удлаа гэж Харри юу ч болоогүй юм шиг ярих зуураа Роны хөлийг гишгэв. Тэгснээ цааш нь:

- Тэгээд эмнэлэг рүү сэмхэн очих гэсэн юм Мандрагор ургаад гүйцсэн ... бүх юм тайван боллоо ... гэж ярилаа.

Профессор МакГонагалл түүнийг хэсэг зуур анхааралтай харах үед Харри одоо бас л зэмлэх байх даа гэж бодов. Тэгтэл профессор МакГонагалл багш намуун тасалданги дуугаар:

- Тийм ээ, тэгэлгүй яахав ... та нарт хэцүү байгааг би мэдэж байна ... Поттер минь, хатагтай Грэйнджерийг эргэвэл эргэ л дээ. Би та нарын ирээгүй учрыг

профессор Бинст мэдэгдэмз. Хатагтай Помфрид намайг зөвшөөрсөн гэж хэлээрэй ... гээд түүний ширүүн нүдэнд нулимс мэлтрэхэд Харри гайхжээ.

Таагүй явдлаас гарч чадсандаа итгэж ядах Харри Рон хоёр булан тойрохдоо профессор МакГонагалл хамраа хавчин нусаа нийхийг сонсчээ.

- Үгүй ер! Үүнээс илүү сайхан арга бодож олохгүй дээ! гэж Рон догдлон хэллээ.

Андууд хурдан алхсаар эмнэлэгт ирж үүд тогшоод Гермионаг эргэхийг профессор

МакГонагалл зөвшөөрсөн гэж үүдний завсраар хатагтай Помфрид хэлэв. Хатагтай Помфри хэдийгээр дургүй байсан ч тэднийг оруулжээ.

- Хөшсөн хүнийг эргэх гэдэг чинь ямар утга учир байх вэ? дээ гэж тэрбээр үглэнэ.

Түүний үг үнэн гэдгийг андууд Гермионагийн хажууд суухдаа мэджээ. Гермионад амьдын тэмдэг огт үгүй бөгөөд тэдний ирснийг яаж мэдэх билээ. Бүх юм сайн сайхан болно гэж түүнд хэлэх түүний шүүгээтэй ярих хоёр ижил бүлгээ.

- Гермiona маань гэмт хэрэгтнийг харсан бол сайн байхсан даа. Хэрэв тэр шилтгээнээс зугтаасан бол хэн ч хэзээ ч мэдэхгүй шүү дээ ... гэж Рон хүү Гермionaгийн хөдөлгөөнгүй нүүрийг харан гунигтай хэлэв.

Хари Харри түүний царайг бус бүтээлэг дээрээ тавьсан баруун гарыг нь харж байлаа. Хуруугаа атган зангидсан байх агаад гараас нь нэг юм цухуйна. Харри тонгойгоод хэсэг цаас байгааг харжээ.

Хатагтай Помфри хаа нэгтээ ойр байгаа гэдэгт эргэлзээгүй болохоор цаасыг хар гэж

Ронд дуугүйхэн дохилоо.

- Гаргах гээд оролдоод үз гэж Рон тайван хэлээд Харрийг халхлахын тулд сандлаа хөдөлгөв. Тэгээд гэнэтхэн хүн ороод ирж магадгүй гэж бодсондоо үүд рүү хяламхийж байлаа.

Энэ нь бас яггүй ажил байжээ. Гермiona хуруугаа чанга атгасан болохоор Харри цаасыг урчихвий гэж айсандаа үзүүрээс нь татлаа. Татаж буцаан түлхэж, ахин татаж янз бүрээр оролдсоор хөшсөн гараас нь цаасыг авч чаджээ.

Энэ бол номын сангийн хуучин номоос урж авсан тасархай хуудас байлаа. Харри түүнийг яаран тэнийлгэв. Рон бас сониуч зандаа хөтлөгдөн түүний мөрөн дээгүүр өлийн уншлаа:

«... манай дэлхий дээр тааралдаж болох олон мангас, махчингуудаас Могойн хаан гэгддэг Василискаас өөр нууцлаг, үхлийн аюултай амьтан олдохгүй билээ. Энэхүү муухай амьтан аварга том биетэй байж болохын дээр түүний нас олон зуун жилээр хэмжигдэнэ. Тэрбээр бахын дарсан тахианы өндөгнөөс энэ хорвоод мэндэлжээ. Аймшигтай хортой соёотойгоос гадна хэрэв харц тулгарвал агшин зуур зовоож үхүүлдэг харцтай болохоор маш харгис хэрцгий аргаар хүмүүсийг хөнөөдөг юм.

Ялангуяа аалзнууд Василискаас тун их айдаг учраас аль блохоор хөндий байхыг боддог юм. Тэрбээр аалзнуудын заналт дайсан билээ. Харин Васлииск өөрөө тахианы дуунаас үхтлээ айдаг юм. Энэ дуу түүнд үхлийн аюултай ...».

Эдгээр мөрнүүд дор «Хоолой» гэж бичсэн байхыг Харри хараад Гермionaгийн бичиг гэж шууд таньжээ.

Ингэтэл харанхуйд гэрэл асах шиг андуудад санагджээ!

- Рон энэ мөн байна! Хариу нь энэ байна! Нууц өрөөний аймшигт амьтан бол аварга могой Василиск ажээ! Тэгээд л би ганцаархнаа дуу хоолойг сонсдог юм байна. Ганцхан би л могойн хэл ойлгодог шүү дээ гэж Харри амьсгал давхцан хэллээ.

Харри бусад орнуудыг харав.

- Василиск хүмүүсийг харцаараа алдаг юм байна. Гэхдээ одоохондоо хэнийг ч хөнөөнөөгүй байгаа. Хэн ч түүний нүд рүү эгцлэн хараагүй байж болох юм. Колин түүнийг гэрэл зургийн дурангийн нүхээр харсан болохоор Василиск зөвхөн хальсыг шатаагаад Колиныг хөнөөж чадалгүй чулуу болгочихсон юм байна. Жастин ... Жастин Василискийг бараг толгойгүй Никийн цаанаас нэвт харсан байлгүй! Василискийн бүх цэнэг Никэд оногдсон ч Ник хоёр дахь удаагаа үхэж чадахгүй юм чинь! Харин Гермiona, Когтевраны ахлагч хоёрын дэргэд толь байсан шүү дээ. Нууц өрөөний аймшигт амьтан бол Василиск гэж Гермiona багцаалж байсан хэрэг. Тэрбээр тааралдсан эхний хүнд толины тусламжтайгаар булангийн цаадахыг харъя гэж хэлсэн хэмээн мөрийцөхөд ч бэлэн байна. Ингээд л охин толь гаргаад ... юу болсныг чи мэдэж байгаа.

- ... Харин ноён Норрис муур? гэж сониучирхалдаа шатсан Рон асуув.

Харри тэрхүү Хэллоуиний баярын дурсгалт шөнө чухам юу болсныг эргэн санах гэж хичээн бодлогоширлоо.

- Ус ... Уйланхай Миртлийн жорлон усаар дүүрснийг санаж байна уу? Ноён Норрис муур усанд туссан дүрсийг харсан гэдэгт итгэлтэй байна ... гэж тэрбээр яаралгүй өгүүлнэ.

Тэгээд нөгөө хуудсыг улам анхааралтай, нарийн уншлаа.

- «... тахианы дуунаас үхтлээ айдаг юм. Энэ дуу түүнд үхлийн аюултай ...»

Гэтэл Хагридын бүх тахиаг хөнөөчихсөн байдаг! Энэ бол Слизериний үе залгамжлагчын ажил байж болох юм. Учир нь тэр л нөгөө амьтныг сулласан байж болох талтай. Бас цааш нь хараач «Ялангуяа аалзнууд Василискаас тун их айдаг ...». Бүгд яг тохирч байна!

Рон чихээ имэрснээ ахиад л:

- Гэхдээ энэ Василиск чинь шилтгээн дотуур яаж явдаг байнаа? Тийм том могой ... хэн нэг нь түүнийг харах ёстой доо ... гэлээ.

Харри хуудасны доод талд Гермionaгийн яаран бичсэн бичгийг үзүүлэв.

- Хоолой, хоолой ... Рон минь, Василиск шилтгээний хоолойнуудаар мөлхөж явдаг юм байна. Одоо л би ойлголоо. Тэр дуу хоолойг би чухам хана нэвт сонсодог байсан юм ...

Рон Харрийн гараас шүүрэн авлаа.

- Нууц өрөөний үүд! Үүд жорлонд байж болох юм биш үү? Тэр нь ... гэж Роныг сэтгэл догдлон хэлтэл:

- ... Уйланхай Миртлийн жорлон байж болох юм! гэж Харри яриаг дуусгав.

Андууд өөрсдийнхөө тааварт итгэж ядан гайхаж догдлон сууж байлаа. Харри сэтгэл амарсан байдалтай духаа арчаад:

- Тэгэхэлээр могойн хэлээр ярьдаг өөр хүн энэ сургуульд байгаа юм байна. Энэ л Слизериний үе залгамжлагч байж таарна. Тийм болохоор тэр л Василискийг захирч чадах юм гэлээ.

- Бид яах вэ? Шууд МакГонагалл багш руу очих уу? гэж Рон нүдээ гялалзуулан хэлэв.

- Тийм ээ, хурдхан багш нарын өрөө рүү явъя! Багш тэнд арван хормын дараа ирнэ. Одоохон хонх дуугарна гэж хэлээд Харри үсрэн бослоо.

Андууд доош гүйлээ. Тэд яг хичээлийн цагаар хонгилд хэн нэгэнтэй тааралдахгүй юмсан гэж бодож байв. Тэд айж сандарсан үгүй багш нарын хоосон өрөөнд орлоо. Энэ бол хар модон сандал тойруулж тавьсан тавилга бүхий том өрөө ажээ. Гэхдээ андууд маань хэт их догдолсон болохоороо суусангүй. Хонх дуугарахыг хүлээн өрөөн дотуур холхиж байв. Гэтэл завсарлах хонх дуугарсангүй.

Түүний оронд профессор МакГонагаллын чанга яригчаар хэлэх үг шилтгээн даяар хангиналаа.

- Бүх сурагчид унтлагынхаа өрөө рүү хурдан очих хэрэгтэй. Бүх багш нар багш нарын өрөөнд цугларцгаа. Аль болохоор хурдлаарай.

Харри Роныг эргэж харав.

- Ахиад л шинэ дайралт болж дээ?

- Одоо яах вэ? Унтлагын өрөө рүү явах уу?

- Үгүй ээ гэж Харри хэлээд эргэн тойрноо харав.

Түүний зүүн талд багш нарын жанч өлгөөтэй өндөр өлгүүр харагдана.

- Энд нуугдацгаая. Юу болсныг сонсоё. Тэд юу болсон тухайгаа ярих болно. Андууд жанчнуудын дунд орж нуугдлаа. Дээд давхарт олон арван хөлийн чимээ

гарах ажээ. Төдхөн багш нарын өрөөний үүд нээгдэн багш нар орж ирж байгааг тэд

жанчнуудын завсраар харлаа. Зарим нь цөхрөнгөө барж, зарим нь илэрхий айсан байв. Хамгийн сүүлд профессор МакГонагалл орж ирлээ.

- Энэ явдал ахин давтагдлаа. Аймшигт амьтан сурагч руу дайрсан байна. Энэ удаа түүнийг нууц өрөө рүү аваад явжээ гэж тэрбээр нам гүмийг эвдэн хэлэв.

Профессор Флитвик уулга алдлаа. Профессор Стебль алгаараа амаа даржээ. Снегг багш сандлын аравчийг байдгаараа атгасан харагдана. Тэрбээр:

- Яагаад ийм итгэлтэй байгаа юм бэ? гэж асуув.

- Слизериний үе залгамжлагч ханан дээр түрүүчийнхээ бичгийн доод талд бас дахин бичиг үлдээсэн байна. Бичиг нь: «ТҮҮНИЙ АРАГ ЯС ӨРӨӨНД ӨНӨ МӨНХӨД БАЙХ БОЛНО» гэжээ хэмээн МакГонагалл багш хэлээд царай нь цонхийжээ.

Профессор Флитвикийн нүдэнд нулимс цийлэгнэв.

- Энэ удаа хэн өртөв өө? гэж хатагтай Нугарагч дуу алдлаа. Түүний хөл гуйвагнан сандалд унажээ.

- Жинни Уизли.

Ард нь байсан Рон юу ч дуугаралгүй налан унахыг Харри мэдлээ.

- Маргааш хүүхдүүдийг гэр лүү нь явуулахаас. Хогвартс хаагдахын даваан дээр байна. Дамблдор ярихдаа ... гэж МакГонагалл багш алга хавсран өгүүлтэл багш нарын өрөөний үүд дахин чанга дуугаран нээгдлээ.

Дамблдор орж ирэх байх гэсэн өчүүхэн горьдлого Харрид төржээ. Гэтэл энэ хүн бол нөгөө л хөөр баяр гэрэлтсэн Туг үс байлаа.

- Хоцорсныг минь уучлаарай. Явах зуураа унтах юм! Ямар нэгэн чухал юм болоо юу?

Тэнд байгаа хүмүүс түүнийг үзэн ядаж дургүйцсэн байдалтай харж байхыг тэрбээр ажиглахгүй байгаа бололтой.

- Бидэнд хэрэгтэй хүн энэ байна! Яг энэ хүн. Туг үс минь сонсож бай. Аймшигт амьтан охиныг хулгайлсан байна. Түүнийг нууц өрөөндөө аваачжээ. Одоо таны оролцох цаг боллоо гэж Снегг багш урагш гаран хэлэв.

Туг үсийн царай цонхийлоо.

- Алтан Хонгиот минь үнэн хэрэгтээ өчигдөр орой та нууц өрөөний хаалга хаана байдгийг сайн мэднэ гэсэн биз дээ? гэж профессор Стебль ярианд оролцов.

- Би ... Тийм ээ ... Би гэж Туг үс бувтнана.

- Тэнд юу байдгийг би мэднэ гэж та бас хэлсэн шүү гэж Флитвик догдлон хэллээ.

- Би юу? Мэднэ гэсэн үү? Санахгүй байна ...

- Та гэмт хэрэгтэн өөрөөр хэлбэл Хагрид баригдсан болохоор ид шидийнхээ хүч чадлыг бидэнд үзүүлж чадсангүй гэж ярьж байсныг чинь би сайн санаж байна. эхлээд л ажиллах боломж олгосон бол ямар ч явдал сургуульд гарахгүй байсан гэж та бидэнд ярьж байсан даа гэж Снегг багш ярьж байв.

- Би ... Би үнэнийг хэлэхэд ... Та нар намайг буруу ойлгожээ ...

- Нэг үгээр хэлэхэд професоор Туг үс минь, бид энэхүү шударга бус үйлдлийг зогсоох хэрэгтэй байна. Та тэр амьтантай тулалдах хэрэгтэй. Өнөө орой бидний гар хуруу чөлөөтэй болох нь. Та ялалт байгуулж Хогвартсыг аймшигт амьтнаас салгах ёстой гэж профессор МакГонагалл эцэст нь хэллээ.

Туг үс аргаа барсан байдалд оржээ. Хөөрхий зайлуул! Өрөвдсөн хүн нэг ч алга. Тэрбээр агшин зуур хувхай цайн уруул нь чичрээд, нөгөө сайхан инээмсэглэл нь оргүй хийсэн одож өрөвдөлтэй ядруу амьтан болон хувирчээ.

- За сайн байна. Би ч ... явъя даа. Өрөөндөө очъё ... Бэлтгэх хэрэгтэй байна гэж тэрбээр түгдчин өгүүлэв.

- Ядахдаа ингэвэл зүгээр сэн. Туг үс одоо бидэнтэй орооцолдоод байхаа болино биз. Тэнхимийн эрхлэгчид болсон явдлын тухай хүүхдүүдэд дуулгах хэрэгтэй. Маргааш буухиа галт тэргээр бүгдийг гэрт нь хүргэж өгнө гэдгийг хэлээрэй. Бусад багш нар хүүхдүүдийг байрнаас гаргахгүй байвал зохино гэж профессор МакГонагалл гар занган хэллээ.

Багш нар дуугүй босоцгоон ар араасаа тарж одов.

Харрийн амьдралд үүнээс илүү муу өдөр тааралдаагүй байлгүй дээ. Тэрбээр Рон ихрүүдийн хамт Гриффиндорын өрөөний буланд юу ярихаа ч мэдэхгүй сууцгаана. Перси байсангүй. Тэрбээр аав ээждээ ууль илгээчихээд өрөөндөө орон түгжээд суучихжээ.

Нэг ч өдөр үүн шиг урт үргэлжилсэнгүй. Гриффиндорын өрөө хэзээ ч ийм дүүрэн, нам гүм байсангүй. Тэгээд бүрий болоход Фред Жорж хоёр ингэтлээ гашуудан сууж тэссэнгүй унтахаар явцгаалаа.

- Жинни ямар нэг юм мэдсэн хэрэг. Тэгээд л түүнийг довтолжээ. Персийн мангартах үүнд ямар ч хамаагүй. Жинни нууц өрөөний тухай ямар нэг юм мэдэж л дээ. Өөр шалтгаан байхгүй ... Манай гэр бүлд цэвэр цустай ид шидтэнгүүд байдаг юм чинь гэж Рон багш нарын өрөөнөөс гарснаасаа хойш анх удаа ам нээн хэлээд нүдэндээ мэлтэрсэн нулимсыг арчлаа.

Цусан улаан нар тэнгэрийн хаяанд жаргаж байхыг Харри харж зогсов. Сэтгэл санаа нь тун ч доройхон байлаа. Жаахан ч атугай юм хийж чаддаг болоосой! Жаахан ч атугай юм.

- Харри минь, Жинни ... мэдэж байна уу ... Жинни минь ... гэж Рон аяархан дуугарав.

Харри түүнийг уруу царайлан харлаа. Юу гэж хэлэх вэ? Жиннийг амьд байгаа гэх найдвар бараг алга.

- Туг үс рүү очицгооё. Тэр чинь нууц өрөөнд нэвтрэхийг зөвшөөрсөн. Нууц өрөө, Василиск гээд мэддэг бүхнийгээ түүнд ярья гэж Рон хэллээ.

Харри өөр олигтой юм болож олоогүй ч зүгээр байгаад байж болохгүй учраас татгалзсангүй. Андууд босоод үүд рүү явлаа. Гриффиндорын танхимд байгаа хүүхдүүд сэтгэл зовнин, Роныг өрөвдөж байсан болохоор хэн ч тэднийг зогсоох гэж оролдсонгүй. Рон Харри хоёр хөрөг бүхий завсраар саадгүй гарлаа.

Тэднийг Туг үсийн өрөө рүү бууж очиход харанхуй болж байв. Үүдний цаана шажиг шужиг түг түг хийх, яаран алхах чимээ гарах нь их ажил ундарч байгаа бололтой.

Харри үүд тогшиход дотор нь онгойсон байв. Хаалга яльгүй нээгдээд нарийн завсраар нь Туг үсийн нүд гялалзаж харагдлаа.

- Аа ... ноён Поттер ... ноён Уизли ... Би тун завгүй байна ... Та нар хурдхан юм бол ч яахав ... гэж Туг үс үүдээ яльгүй дэлгээд хэлжээ.

- Профессор оо, бидэнд чухал шинэ мэдээ байна. Энэ мэдээ танд тус болно гэж бодож байна ... гэж Харри завсраар хэллээ.

- -М-м-м-м ... За яахав ... Энэ бүхэн айгаад байх юм биш ... Би бүх юм ... ерөнхийдөө ... гайгүй ... гэх гэсэн юм гэж хэлэхдээ Туг үсийн царай хаалганы завсраар тун ч доройхон харагдав.

Тэрбээр үүдээ нээхэд андууд дотогш орлоо.

Өрөө бараг хоосон болжээ. Шалан дээр хоёр том чемодан хэвтэх агаад нэгэнд нь ногоон, цэнхэр, яагаан, хар өнгийн жанчнууд дүүрэн нөгөөд нь Туг үсийн номуудыг эмх замбараагүй чихжээ. Өчигдөрхөн хананаас нүд ирмэн байсан гэрэл зургууд одоо хайрцагт амар жимэр хэвтэнэ.

- Та нэг тийшээ явах гэж байна уу? гэж Рон асуулаа.

- Ээ-э-э ... тийм ээ, явах гэж байна. Түргэн дуудлага ... шаардлагатай ажил ...

Явах хэрэгтэй боллоо ... гэж Туг үс хэлээд хаалганд байсан бүхэл бүтэн биенийхээ хэмжээтэй зургийг ховх татан аваад хуйлж байв.

- Дүү маань яах билээ? гэж Рон хөмсөг зангидан хэллээ.

- Тийм ээ, тун ч азгүй явдал ... Надаас илүү гашуудах хүн байхгүй гэж Туг үс үглэх зуураа эгцлэн харж чадахгүй байлаа. Тэрбээр ширээний нүдийг татан гаргаж доторх зүйлүүдийг нь цүнхэнд хийв.

- Та чинь хар урлагаас хамгаалах хичээлийн багш! Одоо та бүхнийг хаяад эндээс явж болохгүй! Энд одоо хамгийн хүчтэй аймшигтай хар домьхон цуглаад байна! гэж Харри уулга алдлаа.

- Та нар бод л доо ... Би та нарт хэлэх ёстой ... Намайг энэ ажилд урих үед ийм юм болно гэж хэн ч мэдсэнгүй. Энэ бол миний хувьд үнэхээр санамсаргүй явдал ... гэж хэлээд Туг үс жанчнууд дээрээсээ баахан оймс овоолов.

- Та тэгээд зүгээр л явах гэж байна уу? Та номондоо бичсэн тэр олон ялалтын дараа юу? гэж Харри чихэндээ ч итгэхгүй асуужээ.

- Тийм ээ, ном бол ямар нэг байдлаар самууруулж болно шүү дээ гэж Туг үс төв байдлаар хэллээ.

- Гэхдээ та тэр номуудыг бичсэн шүү дээ! гэж Харри хашгирав.

- Залуу анд минь. Эрүүл саруул ухаанаар бодоод үз л дээ. Энэ бүх ялалтыг би бус өөр хүн байгуулсан гэж хүмүүс бодох юм бол ном маань тийм амжилттай борлогдохгүй байсан юм. Бүхэл бүтэн тосгоныг ороолонгуудаас аварсан хөгшин армяны тухай хэн унших юм бэ? Түүний зураг номын хавтсыг гутаах байлгүй! Түүний хувцас хунар гэж авах ч юмгүй! Харин үхэл уригч ирландын хий үзэгдлийг хөөсөн эмгэн чинь туулай шиг сэтэрхий уруултай байсан юм! Миний гадаад төрх бол амжилтын үндэс гэж хэлж болно ... гэж Туг үс эгцхэн зогсоод ярьжээ ...

Энэ бүхэн Харрид тун ч ойлгомжгүй байлаа.

- Энэ чинь юу болж байна? Бусад хүмүүсийн хийснийг та өөртөө авсан болж таарч байна уу?

- Харри минь, Харри минь! Энэ бүхэн санасантай адил амаргүй шүү. Энэ чинь тийм ч амар ажил биш. Энэ бүх шидтэнгүүдийг олж бүх юмыг тодорхой шалгах хэрэг гарна. Тэгээд мартуулах шившлэгээр мартуулна. Би ингэж төлөвлөсөн болохоор тэд энэхүү гавьяануудаа мартаж хэрэгтэй байлаа. Би өөрийнхөө мартуулах шившлэгээр үнэхээр бахархдаг юм даа! Тийм ээ, Харри минь би маш их ажил хийсэн! Номон дээр зурсан гарын үсэг гэрэл зураг бүгд биш ээ. Алдар хүндтэй больё гэвэл удаан шаргуу хөдөлмөрлөх хэрэгтэй гэж Туг үс толгой сэгсрэн яриу.

Туг үс чемоданаа тасхийтэл хаагаад түгжлээ.

- За бүгд болох шиг байна. Сүүлчийн шийдвэрлэх ажлаа хийх л үлдлээ гэж хэлээд эргэж харав.

Тэгээд шидэт саваагаа авч тэдний зүг хандан:

- Хөвгүүд минь их харамсалтай байна. Гэхдээ би мартуулах шившлэгээ хэрэглэхээс өөр арга алга. Тэгэхгүй бол та хоёр миний нууцыг дэлгэж чалчаад ганц ч ном зарагдахаа болино ... гэлээ.

Гэхдээ Харри юу болох гээд байгааг цагаа олж мэдсэн болохоор саваагаа бэлэн барьсан байжээ. Туг үсийг үгээ дуусгаж амжаагүй байтал тэрбээр:

- Экспеллиармус! гэж хашгирлаа.

Туг үс ар тийш шидэгдэх нь тэр. Чемоданаа алдаад шалан дээр ойчлоо. Шидэт саваа гараас нь мулт үсрэхэд Рон түүнийг шүүрч аваад нээлттэй цонхоор шидчихэв. Харри чемоданыг уурсан өшиглөлөө.

- Тэр үед энэ аргыг Снегг профессороор бидэнд дэмий л заалгаж дээ!

Туг үс шалан дээр атийн сууж байхад Харри саваагаа түүний зүг чиглүүлсэн байдлаар зогсоно.

- Та нар надаар яах гэсэн юм бэ? Нууц өрөө хаа байдгийг би мэдэхгүй. Би юу ч хэлж чадахгүй гэж хар урлагаас хамгаалах хичээлийн багш уйлагнан хэллээ.

- Танд аз таарчээ. Харин бид өрөө хаана байдгийг мэднэ. Тэнд ямар амьтан байгааг ч мэднэ гэж Харри түүнийг баярлуулан хэлээд саваагаа дохин профессорыг босголоо.

Тэд Туг үсийг өрөөнөөс нь дагуулан гарч ойрын шатаар уруудан үе залгамжлагчын бичиг ханан дээр гэрэлтэн харагдах харахнуй хонгилоор уйланхай Миртлийн оромж руу явжээ.

Туг үсийг түрүүлж яв гэлээ. Түүний жанчны хормой чичирч байгааг хараад Харрийн дургүй хүрч байв.

Миртл захын өрөөний усны саван дээр сууж байлаа.

- Энэ чинь чи юу? Яагаад дахин хүрээд ирэв ээ? гэж тэрбээр Харрийг хараад гайхан асуув.

- Чиний яаж үхсэнийг асуух гэсэн юм гэж Харри хэллээ.

Түүнд энэ асуултыг хэн ч тавьж байгаагүй бололтой агшин зуур өөрчлөгдөн зүс царай нь сайхан болжээ.

- Өө-өө! Үнэхээр аймшигтай! Би яг энэ бүхээгт нас барсан юм даа. Оливия Хронби миний нүдний шилийг шоолж инээдэг байсан болохоор энд нуугддаг байснаа одоо би санаж байна. Гомдмоор шоолдог байсан юм. Би үүдээ түгжээд уйлж байлаа. Тэгсэн чинь жорлонд хүмүүс орж ирээд ярилцахын сонссон юм. Өөр хэлээр ярилцаж байсан болохоор би ойлгосонгүй. Тэдний нэг нь хүүхэд байсан. Би үүдээ нээгээд түүнийг өөрийнхөө жорлонд ор гэж хэлсэн байхгүй юу. Тэгээд л энэ явдал болж би нас барсан юм даа гэж Миртл яриад царай нь туяарч байв.

- Гэхдээ яаж үхсэн юм бэ?

- Би өөрөө ч мэдэхгүй. Томоос том хоёр шар нүд байсныг санадаг юм. Миний бүх биеийг баглаад хааш нь ч юм аваачсан байлаа. Тэгээд ... тэгээд би дахин наашаа ирсэн билээ. Би Оливия Хронбид байнга үзэгдье гэж шийдсэн юм. Чи ойлгоно биз дээ ... Миний нүдний шилийг шоолоход би их харамсдаг байлаа л даа ... хэмээн Миртл үг бүрээ цэнэн яриад Харрийг учир битүүлэг харна.

Харри хэсэг зуур бодлогоширлоо.

- Чухам хаана тэр нүдийг харснаа зааж өгөхгүй юу?

- Тэнд л байхаа гэж Миртл хэлээд бүхээгний өмнө байгаа угаалтуурын зүг хайш яйшхан заажээ.

Харри, Рон хоёр угаалтуур руу очлоо. Туг үсийн нүдэнд аймшиг тодрон ард нь үлдлээ.

Эхлээд харахад ердийн л нэг угаалтуур аж. Тэд дотор гадна тал тэр ч байтугай шал руу орсон хоолойг хүртэл сайтар ажиглан үзлээ. Тэгтэл нэг зэс гоожуур дээр жижигхэн могой сараачин зурсан байхыг Харри ажиглажээ.

- Энэ гоожуур хэзээ ч ажиллаж байгаагүй юм гэж Харрийг гоожуур нээхээр оролдох үед Миртл баяртай нь аргаггүй хэлэв.

- Харри ямар нэг юм могойн хэлээр хэлээд үзээч гэж Рон сөөнгө дуугаар шивнэн гуйлаа.

- Гэхдээ би ... гэж Харри санамсаргүй байсандаа балмагдан хэлэв. Тэрбээр амьд могойтой ердөө л хоёрхон удаа ярьж үзсэн юм байна. Тэгээд өмнөө жинхэнэ могой байгаа гэж хүчлэн бодох зуураа могойн дүрсийг гайхан харж байлаа.

- Нээгээрэй гэж хэлээд Роны зүг асуусан байртай харав. Тэрбээр толгойгоо сэгсрээд:

- Үгүй ээ, энэ чинь могойн хэл биш байна гэлээ.

Харри дахин могойн дүрсийг хараад энэ бол амьд могой гэж бодохуй лааны сүүмэлзэх гэрэлд могой хөдлөх шиг санагджээ.

- Нээгээрэй! гэж Харри ахин хэллээ.

Энэ удаа түүний хэлсэн үгийг хэн ч сонссонгүй. Харрийн амнаас хачин исгэрэх чимээ гарахад гоожуур гэрэлтэн туяарснаа эргэлдэж эхэллээ. Ахиад хэдэн агшин өнгөрөхөд угаагуур доош сууснаа бүр харагдахгүй болж, бүдүүн хоолой тэднийг урих мэт онгойж байлаа. Чухам хаашаа юм бол?

Роны амьсгал давхцана. Харри бодлого болон нүүрээ алгаараа шувтрав. Ямар нэг юм шийдэх хэрэгтэй байлаа.

- За, би явлаа гэж тэрбээр эрсхэн хэлэв.

Явахгүй байж болохгүй шүү дээ. Энэ бол нууц өрөө рүү орох хаалга байлгүй. Хэрэв Жинни амьд байж магадгүй гэх хамгийн найдваргүй хамгийн дорой итгэл сүүмэлзсэн ч тар явах л байсан юм.

- Би чамтай явна гэж Рон хэллээ. Нам гүм болов.

- Би та нарт хэрэггүй бололтой. Би яг ингэх ... хэмээн Туг үс хулчгардуухан хэлээд хуучных шигээ инээмсэглэх аядав.

Түүнийг хаалганы бариулд хүрэх үед Харри Рон хоёр түүний зүг саваагаа чиглүүлээд:

- Түрүүлж явах эрх танд байгаа гэж Харри эрсхэн хэллээ.

Зэвсэггүй болж хувхай даасан Туг үс нөгөө нүх рүүгээ ойртож очив.

- Хүүхдүүд минь. Ингээд сайн юм болох уу даа? гэж үхмэл дуугаар цөхрөн асуужээ.

Харри саваагаараа ууц руу нь түлхлээ. Туг үс хөлөө хоолой руу оруулав.

- Би олигтой юм болно гэж бодохгүй байна ... гэж түүнийг ярьж эхэлмэгц Рон түүнийг түлхэж орхилоо. Шүдээ яралзуулдаг ганган эр маань гүн нүх рүү хийсэн оджээ.

Харри ч хүлээсэнгүй. Хоолойд болгоомжтой ороод ирмэгээс нь барьж байсан гараа тавьчихлаа.

Хоолой дотор ниснэ гэдэг эцэс төгсгөлгүй харанхуй эгц уулнаас гулсан уруудахтай адил аж. Салбарласан хоолойнууд хажуугаар нь жирэлзэн өнгөрч байсан ч мушгиралдсаар доош орох гол суваг шиг өргөн биш юм. Шилтгээн дор тун ч гүнзгий нүхэнд нисэж яваа гэдэгтээ Харри эргэлзсэнгүй. Араас нь Рон шуугин нисэх чимээ дуулдана.

Нислэг хэзээ нэгэн цагт дуусахад яаж унах бол гэж Харри түгшиж байлаа. Гэтэл хоолой тэгш өнцөгөөр тахирлан эгцэрснээ дуусах нь тэр. Харри шалхийх чимээ гарган хоолойноос суга үсрэн гараад босоо хүний хэртэй өндөр харанхуй чулуун хонгилын нойтон шалан дээр газарджээ. Бас шавар шавхай болж даавуу шиг хувхай цайсан Туг үс тэр хавьд унаад босож байлаа. Харрийг дөнгөж хажуу тийшээ болтол Рон ч хоолойгоос шидэгдэн гарав.

- Бид лав сургууль дор хэдэн бээрийн зайд байх шиг гэж Харри хэлэхэд харанхуй хонгил цуурайтах ажээ.

- Нууран дор ч байж болох юм гэж Рон хэлээд ханан дээр байгаа элс шаврыг тэмтэрч байв. Хонгилд тун ч харанхуй байлаа.

- Люмос гэж Харри шидэт саваандаа шивнэхэд үзүүрт нь бүдэг гэрэл гялалзан асав. Харри:

- Явцгаая гэж Рон, Туг үс хоёрыг дуудлаа.

Тэд цаашаа явган явцгаав. Нойтон шалаар алхах чимээ пал палхийн сонсогдоно. Савааны гэрэл харанхуйг нэвтлэхэд нойтон элс, шавар болсон хана л харагдана.

Шидэт савааны гэрэлд тэдний сүүдэр аймаар амьтан шиг сүүдэгнэх ажээ.

- Жаахан л чимээ гарвал нүдээ хурдхан аних хэрэгтэй гэдгийг санаарай хэмээн

Харри аяархан анхааруулав.

Гэвч хонгилд нам гүм байлаа. Гэтэл санамсаргүй байтал шажигнах чимээ гарчээ. Рон хархын гавал бололтой нэг юман дээр гишгичихсэн аж. Харри түүн рүү гэрлээ дөхүүлтэл шалаар дүүрэн жижиг амьтны яс тарсан байв. Жиннигээс л ийм яс үлдсэн байх вий гэсэн аймшигт бодлоо үлдэн хөөгөөд Харри цааш чулуун хонгилын харанхуй булан тойрон явлаа.

- Харри урд ямар нэг юм байна гэж Рон айсан дуугаар шивнэн хэлээд түүний мөрнөөс татжээ.

Тэд гэрэлд яльгүй бүүдийх харанхуйн зүг ширтэнэ. Харри өмнөө байгаа хонгилын дагуу хэвтэх том том цагаригийг ялган харжээ. Тэр цагариг огт хөдлөхгүй аж.

Харри дагалдан яваа хүмүүсээ эргэн харлаа.

- Аймшигт амьтан унтаж байгаа юм болов уу?

Туг үс байдаг чадлаараа нүүрээ дарна. Харри тэр хачин аймаар юмыг ахин харахад зүрх нь булгилан хэнхдэгээс нь гарах дөхнө.

Харри нүдээ бараг аниад саваагаа дээш өргөн алгуурхан урагшлав.

Аварга могойн хорт ногоон өнгө бүхий арьсанд туссан гэрэл ойх аж. Энэхүү арьсыг гуужуулан хаясан амьтан хорин метрийн урттай нь лав.

- Ой-ёо гэж Рон арайхийн дуу алдлаа.

Ард нь нэг юм унав. Андууд эргэн харахад Туг үс шалан дээр хөдөлгөөнгүй хэвтэж байлаа.

- Босоорой! гэж Харри хэлээд шидэт саваагаа түүний зүг чиглүүлэв. Туг үс өндийн босооноо гэнэтхэн Рон руу довтлон түүнийг унагаалаа.

Харри туслахаар ухасхийсэн авч оройтжээ. Профессор хүндээр амьсгаадан босох үед Роны шидэт саваа түүний гарт байлаа. Тэрбээр урьдынх шигээ яралзтал инээмсэглэх аж.

- Адал явдал дууслаа, хүү минь! Энэ сайхан могойн арьснаас хэсгийг аваад дээш явах юм шүү. Охиныг аврах ямар ч бололцоо алга, түүний эрэмдэглэгдсэн биеийг хараад та хоёрыг ухаан алдаж унасан гэж би сургууль даяар ярих болно. Ухаан бодолтойгоо салах ёс гүйцэтгэ! Одоо та нар өнгөрсөн явдлын тухай юу ч санахгүй! гэж тэрбээр уулга алдлаа.

Тэгээд шидэт туузаар ороосон нөгөө золгүй савааг дээш өргөөд:

- Март! гэлээ.

Роны айж байсан зүйл ёсоороо болж шидэт саваа гар бөмбөг шиг хүчтэйгээр тэсрэх нь тэр. Харри гараараа толгойгоо гараараа халхлаад гүйтэл могойн арьсан дээр

хальтирчээ. Хонгилын адараас том том чулуу унана. Нүд ирмэх зуур түүний өмнө чулуу овоорч Рон тэр хоёрыг тусгаарлажээ.

- Рон! Рон чи амьд уу? Рон оо! гэж Харри хашгирлаа.

- Би энд байна. Бүх юм зүгээр ээ. Энэ муухай амьтныг чангахан цохисон бололтой! гэх Роны дуу нурангийн нөгөө талаас сонсогдоно.

Бөглүүхэн цохих бас чангаар ёолох чимээ гарлаа. Рон Туг үс багшийгаа овоохон өшиглөсөн байлгүй дээ.

- Одоо яах вэ? Бид эндээс гарах хэрэгтэй. Зуун жил ухсан ч хамаагүй! гэж Рон хэлэхэд түүний цөхөрсөн дуу нурангийн цаанаас ч мэдрэгдэж байв.

Харри хонгилын адрьг харахад ан цав гарсан байлаа. Хоёрдугаар дамжаанд шидэт савааны тусламжтайгаар бул чулуу хөдөлгөхийг заагаагүй агаад одоо сурах цаг биш ээ. Хонгилыг бүр хаачихгүй л юмсан!

Нурангийн нөгөө талд ахиад цохих чангаар хашгирах чимээ гарчээ. Үнэт цаг хугацаа өнгөрсөөр. Жинни нууц өрөөнд олон цаг болсон байлаа. Одоо ганцхан юм үлдсэн гэдгийг Харри ойлгож байв.

- Намайг тэндээ хүлээгээрэй! Туг үстэй хамт хүлээж бай. Би ганцаараа явна.

Хэрэв цагийн дараа ирэхгүй бол ... гэж тэрбээр Ронд хашгиран хэлэхдээ бүх зүйлийг дэлгэе гэж бодсонгүй.

- Би хэдэн чулуу авч хаях гээд үзье. Чамайг буцаж ирэхэд ... хэрэг болох биз.

Чи тун болгоомжтой яваарай ... гэж Рон тайван байхыг ихэд хичээн хашгирлаа.

- Мөдхөн уулзацгаая гэж Харри итгэл төрүүлэхийг хичээн хэлээд аварга могойн арьсан дээгүүр гарч ганцаараа цааш явжээ.

Хөдөлгөж буй чулууны дуу холдон холдсоор сонсогдохоо болилоо. Хонгил байн байн тахирлах агаад Харрийн сэтгэл санаа хөвчирсэн байв. Тэрбээр хонгил хурдхан дуусаасай гэж хүсэх боловч юу хүлээж байгаа бол гэхээс айна. Ахиад нэг булан өнгөртөл Харрийн өмнө толгойгоо цогнойлгон орооцолдсон хоёр могойн сийлбэр бүхий гөлгөр хана харагдана. Могойн нүдний оронд том маргад эрдэнэ гялалзана.

Харри улам ойртлоо. Хоолой нь хатаж аргана. Одоо албан хүчээр амилуулах хэрэг алга. Тэртээ тэргүй могойн нүд гялалзаж байлаа. Одоо юу хийхээ Харри мэдэж байв. Түүнийг ханиалгахад ширтэн байсан маргад нүд улам ч тод гялалзжээ.

- Нээгээрэй! гэж Харри аяархан шивнэн хэллээ.

Хананд могойг тусгаарласан ангал гарч ханын тал хэсэг хажуу тийш алгуурхан хөдлөв.

Харри хөлөөсөө толгой хүртэл чичирсээр дотогш орлоо.

БҮЛЭГ 17: СЛИЗЕРИНИЙ ҮЕ ЗАЛГАМЖЛАГЧ

Тэрбээр бүдэг гэрэлтэй том өрөөний босгон дээр зогсож байв. Дээш цоройсон баганууд чулуун могойгоор ороогдсон байх агаад бүрэнхийд үл үзэгдэх адарт тулж бүдэг ногоовтор гэрэл бүхий орчинд урт хар сүүдрээ унагана.

Түүний зүрх догдлон булгилах ажээ. Харри нам гүмд чимээ чагнан зогслоо. Василиск баганын арын харанхуй буланд нуугдсан юм биш байгаа? Жинни хаана байна?

Тэрбээр шидэт саваагаа гаргаж аваад багануудын хоорондуур урагш явлаа. Алхах чимээ болгох сүүдэртсэн хананд цуурайтан ойно. Харри яльгүй хөдөлгөөн л ажвал нүдээ анихаар бэлтгэж онийсон аж. Чулуун могойнууд түүнийг хар нүдээрээ ажиглан байх шиг санагдана. Нэг бус удаа өмнө нь ямар нэг юм хөдлөх шиг санагджээ.

Арын ханын дэргэдэх сүүлчийн хос баганын ард таазанд тулсан өндөр баримал харагдана.

Харри өлийн харлаа. Шингэн урт сахалтай, сахал нь бараг чулуун жанчны хормойд хүрсэн эртний өвгөний баримал аж. Жанч дороос нь гөлгөр шаланд бөх бат гишгэсэн хоёр том саарал тавхай үзэгдэнэ. Тавхайн хооронд гал шаргал үстэй жижигхэн хар дүрс огт хөдөлгөөнгүй хэвтэж байлаа.

- Жинни, Жинни минь! Битгий үхээрэй! Үхэж л болохгүй шүү! гэж Харри шивнээд түүний зүг ухасхийн очиж дэргэд нь өвдөг сөхрөн суув.

Тэгээд шидэт саваагаа хажуу тийш чулуудаад Жиннийн мөрнөөс шүүрэн авч эргүүллээ. Түүний царай яг л гантиг шиг хүйтэн, цонхигор болсон агаад нүдээ анисныг нь харвал бүр хөшчихөөгүй бололтой. Хэрэв тийм бол ...

- Жинни минь сэргээрэй гэж Харри цөхрөнгөө баран шивнэж түүнийг сэгсэрч байлаа. Охины толгой амьгүй юм шиг хоёр тийшээ санжигнана.

- Тэр сэргэхгүй ээ гэх аяархан дуу гарав. Харри өвдөг дээрээ өндийснөө огцом эргэж харлаа.

Хар үстэй өндөр залуу ойролцоох баганыг налан тэднийг харж зогсоно.

Түүний биеийг харахад бүдэгхэн шилний цаанаас үзэгдэх мэт бүүдгэр балархай авч андуурах аргагүй байлаа.

- Том уу? Том Реддл уу?

Реддл Харрийг ширтсэн хэвээр толгой дохив.

- Түүнийг сэргэхгүй гэдэг чинь юу гэсэн үг вэ? Тэр чинь ... Тэр чинь ... гэж хэлэхдээ Харри хэмжээлшгүй уй гашууд автаж буйгаа мэдэрчээ.

- Одоохондоо амьд байгаа. Одоохондоо шүү гэж Реддл хэлэв.

Харри түүнийг эгцлэн ширтэнэ. Том Реддл Хогвартст тавин жилийн тэртээ суралцаж байсан боловч одоо энэхүү нууцлаг тайлбарлаж болшгүй ертөнцөд арван зургаан наснаас ах харагдахгүй ажээ.

- Чи хий үзэгдэл юм уу? гэж Харри эргэлзэн асуулаа.

- Би бол дурдатгал. Хагас зуун жил өдрийн тэмдэглэлд байлаа гэж Реддл тайван хариулав.

Тэрбээр тавхайны эрхий хурууг заалаа. Хурууны хажууд уйланхай Миртлийн өрөөнөөс тэдний олсон нөгөө жижигхэн хар тэмдэглэлийн дэвтэр шалан дээр хэвтэж байв. Харри түүнийг хараад агшин зуур гайхсан ч дараагийн ажилдаа шамдахгүй бол болохгүй байлаа.

- Том минь надад туслаач. Охиныг эндээс авч явъя. Василиск энд хаа нэгтээ байгаа. Чухам хаана байгааг мэдэхгүй ч дуртай үедээ гараад ирж болно шүү дээ. Надад туслаач дээ ... гэж Харри хэлээд Жиннийн толгойг дахин өргөлөө.

Реддл хөдөлсөнгүй. Харри мэрийн байж Жиннийг арайхийн өргөөд шидэт саваагаа авахаар сарвайв. Гэвч саваа байсангүй.

- Чи миний савааг хараагүй биз?

Тэрбээр дээш харахад Реддл урьдын адил түүнийг ажиглан зогсох агаад түүний цайвар хуруунд шидэт саваа нь эргэлдэн байна.

- Баярлалаа гэж Харри хэлээд саваагаа авахаар сарвайжээ.

Томас Реддл мушийн инээмсэглэнэ. Тэрбээр савааг залхуутайяа эргэлдүүлэн Харрийг харсан хэвээр.

- Чи аан гэж бай. Эндээс хурдхан явах хэрэгтэй байна. Хэрэв Василиск хүрээд ирвэл ... гэж Жиннийг өргөсөөр гар нь чилсэн Харри хэллээ.

- Хэрэв дуудахгүй бол тэр ирэхгүй ээ гэж Реддл хайнга маягаар ярина. Харри Жиннийг өргөж даахаа болиод шалан дээр тавилаа.

- Юу болоод байгааг хэлээч! Бас савааг минь буцааж өг л дөө. Тэр чинь надад мөдхөн хэрэг болно.

Реддлийн нүүр царайд басамжилсан инээд тодров.

- Энэ саваа чамд дахин хэрэг болохгүй ээ.
- Яагаад хэрэг болохгүй гэж? Реддлийн хамар яльгүй сартайжээ.
- Би энэ агшныг удаан хүлээсэн юм даа, Харри Поттер минь. Чамтай уулзах боломжийг хүлээж байлаа. Чамтай ярилцъя гэж бодож байсан юм.
- Том, бидэнд тийм боломж алга. Бид нууц өрөөнд байна. Өөр газарт л ярилцъя гэж Харри тэсвэр алдан хэллээ.
- Бид чухам энд ярилцах болно гэж Реддл нөгөө л инээдгээрээ инээмсэглэн хэлээд шидэт савааг нь халаасандаа шургуулав.

Харри түүнийг аргаа баран харна. Нэг л онцгүй юм болоод байлаа.

- Жиннид юу тохиолдсон юм бэ? гэж тэр алгуурхан асуув.
- Сонирхолтой л асуулт байна. Гэхдээ энэ чинь урт түүх. Одоо иймэрхүү байдалд орсон явдал бол өөрийнхөө зүрх сэтгэл, өчүүхэн нууцыг хэнд ч үл үзэгдэх танихгүй хүнд нээсэнтэй холбоотой юм гэж Реддл ууртайяа хариулав.
- Юу ч ойлгосонгүй! Юун тухай яриад байнаа?
- Өдрийн тэмдэглэл. Миний өдрийн тэмдэглэл. Бяцхан Жинни надад өөрийн өчүүхэн гомдол уйтгар гунигаа итгэн өдрийн тэмдэглэлд олон сар бичиж байсан юм. Ах нар нь түүнийг шоолдог хуучин жанч өмсөж хуучин ном үзэх хэрэг гардаг байж л дээ гэж Реддл тайлбарласнаа нүд нь гэнэтхэн гялалзаад:
- Алдарт агуу их Харри Поттерт тоогдох итгэл найдвар тун ч бага байж ... гэлээ.

Ярих зуураа Реддл Харригаас нүд огт салгахгүй ширтэх агаад нүдэнд нь хачирхалтай сувдаг шинж тодорно.

- Арван нэгэн настай охины гэнэхэн үгийг сонсоно гэдэг аймаар уйтгартай.

Гэхдээ би тэсвэртэй байсаан. Би хариу бичиж харууслаа илэрхийлэн эелдэг зөөлөн байсан юм. Жинни ч надад хайртай байлаа. «Хэн ч, хэзээ ч намайг чам шиг ойлгож байгаа юм, Том оо ... надад энэ өдрийн тэмдэглэл байгаа, би түүнд итгэж чадаж байгаадаа их баяртай байна ...» гэж бичдэг байсан юм.

Реддл арван зургаан настай хүүхдэд баймааргүй хүйтнээр инээв. Түүнийг инээхэд

Харрийн толгойтой үс арзайжээ.

- Хэрэв би шийдсэн л бол хэрэгтэй хүнээ татаж чаддаг юм даа, Харри минь.

Жинни надад сэтгэл гаргасан бөгөөд чухамхүү түүний сэтгэл надад хэрэгтэй байлаа. Би түүний айдас хүйдэс, хамгийн чухал нууцыг нь шингээн авч амьдруулагч хүчээр биеэ дүүргэн хүчтэй чийрэг болсон юм. Ингээд л жаахан хатагтай Уизлийг

дагуулахааргүй хүч чадалтай болсон билээ. Би маш их эрч хүчтэй болсон болохоороо түүнийгээ буцаан гаргаж бяцхан найз охиноо өөрийнхөө нууцаар тэжээдэг байлаа. Энэ бол миний сэтгэл зүрхний нууц ...

- Солиотой юм! гэж хэлээд Харрийн хоолой аргаж байв.

- Чи юу ч ойлгосонгүй юу, Харри Поттер оо? Жинни Уизли л өрөөг нээсэн юм шүү. Охин сургуулийн тахиаг хөнөөж, ханан дээр заналхийлсэн үг бичдэг байсан юм. Тэрбээр Слизериний могойд дөрвөн эрлийз, нөгөө сангасваагийн муурыг илгээсэн юм даа гэж Реддл сэмээрхэн хэлэв.

- Худлаа гэж Харри шивнэлээ.

- Үнээн. Эхлээд юу хийж байгаагаа мэддэггүй байсан л даа. Ямар сонирхолтой байсан гээч! Тэмдэглэлийнхээ дэвтэрт сүүлчийн удаа бод гэж бичсэнийг нь сонс л доо гэж Реддл цөхрөлгүй хэлээд Харрийн айж муруйсан царайг ажиглан харсаар уншиж гарлаа. Тэнд: «Хүндэт Том минь. Би ухаан алдаж байгаа юм шиг санагдах боллоо. Жанч маань тахианы өд болж гүйцжээ. Яагаад тэгснийг бүү мэд. Хүндэт Том минь, Хэллоуины баярын шөнө юу хийснээ би санаж чадахгүй юм. Тэр үед хэн нэг хүн муурыг довтлож, би өөрөө гэрэлтэгч будгаар будагдсан байлаа. Хүндэт Том минь, намайг цонхигор хачирхалтай болж байна гэж Перси байнга үглэх юм. Чамайг сэжиглээд байх шиг санагддаг боллоо ... Өнөөдөр дахиад л дайралт болсон ч би хаана байснаа бас л санасангүй. Том оо, би одоо яах вэ? Би солиорч байх шиг санагдах юм ... Би л бүх хүмүүсийг довтолсон юм шиг санагдаад байна!» гэж бичжээ.

Харри хумсаа алгандаа шигдэн ортол гараа чанга атгасан байв.

- Тэнэгхэн Жинни аажимдаа өөрийн анд нөхөр болсон тэмдэглэлийнхээ дэвтэрт эргэлзэж эхэлсэн юм. Гэхдээ ямар нэг юм сэжиглэж, дэвтрээсээ салахаар мэрийж байлаа. Энэ үед Харри чи тавцан дээр гарч ирсэн юм даа. Чи миний өдрийн тэмдэглэлийг олсон. Энэ чинь хувь заяаны бэлэг байлаа. Дэлхийн бүх хүмүүсийн дотроос чухамхүү миний уулзах гэж тэсэн ядан хүлээж байсан тэр хүн олоод авдаг байна шүү.

- Чи яагаад надтай уулзахыг тийм их хүссэн юм бэ? хэмээн Харри уурлан асуув. Тайван ярьж тэвчихгүй болжээ.

- Жинни чиний тухай олон юм надад мэдүүлсэн юм даа. Чиний үүх түүхийг гэж хэлээд Реддлийн харц Харрийн духан дээрх цахилгаан шиг сорви дээр туссанаа улам увайгүй байдалтай болжээ.

- Би чиний тухай улам илүү мэдэж, чамтай танилцах гэсэн юм ... Чиний итгэлийг олж авахын тулд Хагридыг илчилсэн «домогт» ялалтаа чамд үзүүлье гэж шийдсэн юм ...

- Хагрид бол миний анд нөхөр. Тэгэхээр чи түүнийг гүтгэсэн байж таарах нь ээ? Би чамайг зүгээр л андуурсан гэж бодсон юм ... гэж хэлэхдээ Харрийн хоолой чичирч байлаа.

Реддл ахиад л тачигнатал хөхрөв.

- Зөвхөн чиний үг л Хагридын эсрэг байсан юм. Гэхдээ өвгөн Армандо Диппетийн хувьд энэ чухам ямар байсныг бодоод үз дээ. Нэг талаас Том Реддл. Ядуухан авч авъяаслаг өнчин хүү, сургуулийн зоригтой ахлагч, гоц сурагч. Нөгөө талаас бүх юманд оролцож байдаг (долоо хоног бүр шуугиан тарина) бас вурдалахын зулзагыг орон доороо тэжээж, савдагтай тулалдахаар хориотой ой руу явдаг аварга биет Хагрид ... Гэхдээ бүх юм ёсоор болсонд би хүртэл гайхаж байснаа хүлээх ёстой. Хагрид бол Слизериний үе залгамжлагч байж болохгүй гэдгийг хэн нэг нь мэдэх л ёстой гэж би бодсон юм. Нууц

өрөөний тухай бүгдийг мэдэж нууц хаалгыг олоход би урт удаан таван жилээ үрсэн юм шүү дээ ...

- Хагридад толгой тархи буюу онцгой ид шидэт хүч байгаа юм шиг л!

Хагридыг буруугүй гэж ганцхан хувиргалын багш Дамблдор л бодож байсан байх. Зөвхөн тэр хүн Хагридыг сургуульд нь үлдээж ойн сахиул болгоё гэж Диппетийг ятгаж чадсан юм. Тийм ээ, Дамблдор тааварлаж байсан байх. Би бусад багш нарт таалагддаг шигээ түүнд таалагдаж байгаагүй билээ ...

- Дамблдор чамайг нэвт харж байсан гэдэгт эргэлзэхгүй байнаа гэж Харри хэлээд уурласандаа шүдээ тачигнуулан хавирч байлаа.

- Тийм ээ. Хагридыг хөөгдсөний дараа тэрбээр намайг жинхэнэ мөрдөж гарсан даа. Сургуульд байгаа үедээ нууц өрөөг дахин онгойлгох аюултай гэдгийг би ойлгож байлаа. Гэхдээ зүгээр орхичхоё гэж бодоогүй юм. Түүнийг эрж олоход зориулсан он жилүүдээ салхинд хийсгэхийг хүссэнгүй. Ингээд би намайг арван зургаан настай хэвээр нь хуудсандаа хадгалсаар байх өдрийн тэмдэглэлээ үлдээхээр шийдсэн юм. Тэгээд байдал азтайгаар эргэх үед би хэн нэгнийг өөрийнхөө замаар оруулж Салазар Слизериний их үйлийг дуусгаж чадах байлаа гэж Реддл ярив.

- Гэхдээ чи түүнийг дуусгаж чадсангүй. Одоохондоо хэн ч, тэр ч байтугай муур хүртэл үхээгүй байна. Одоо хоёр гурван цагийн дараа гэхэд мандрагорын ханд бэлэн болно. Тэгэхэд чиний хорлосон хүн амьтан дахин амьдрах юм гэж Харри дийлсэн байртай хэллээ.

Гэвч Реддл жаахан ч халирсангүй.

- Эрлийзүүдийг хөнөөх нь миний хувьд утгагүй явдал гэдгийг чамд хэлээгүй билүү? Олон сарын туршид миний шинэ бай бол чи л байлаа.

Харри түүнийг гайхан харлаа.

- Жиннийг өдрийн тэмдэглэлд дахин бичиж эхлэхэд намайг яаж уурласныг бодоод үз дээ. Тэрбээр өдрийнхөө тэмдэглэлийг чамд байхыг хараад айн чичирч байсныг ойлгож байгаа биз дээ? Хэрэв би түүний бүх нууцыг чамд илчилбэл юу болох билээ? Тахиаг хэн хөнөөгөөд байсныг чи мэдвэл бүр ч муу болно тийм үү? Тэгээд тэнэгхэн охин танай унтлагын өрөө эзгүй болохыг хүлээж байгаад тэмдэглэлийг хулгайлсан юм. Гэвч би юу хийхээ мэдэж байсан билээ. Слизериний үе залгамжлагчийн нууцыг тайлахад чи тун ойртсон гэдэг нь тодорхой боллоо. Чиний тухай Жиннийн мэдэгдсэн зүйлийн дотроос, чамайг юуны ч өмнө зогсохгүй гэдгийг би ойлгосон юм. Гэхдээ чиний анд дайралтанд өртсөн болохоор чи нууцыг нээж л таарна. Чамайг могойн хэл мэддэг гэдгийг сургуулийнхан чинь сонсоод хичнээн их шуугисныг Жинни тодорхой бичсэн л дээ. Товчхон хэлэхэд би Жиннийг ханан дээр хагацах үгээ бичээд өөрөө наашаа ирэх ёстойг итгүүлж чадсан юм. Тэгээд чамайг хүлээж байлаа. Охин энд ирээд орилж чарлаж харайн цовхчиж намайг аймшигтай залхаалаа. Гэхдээ түүнд амьдралын чадвар бага үлджээ. Учир нь охин хэтэрхий их хүч чадлаа өдрийн тэмдэглэлд, өөрөөр хэлбэл

надад шингээсэн юм. Үүний ачаар л би түүний хуудсыг орхиж чадлаа ... Би түүнтэй хамт наашаа орж ирсэн эхний агшинаас л чамайг ирэхийг хүлээж байна. Чамайг ирнэ гэж би мэдэж байсан юм аа. Харри Поттер минь, би чамаас олон юм асуумаар байна ...

- Юу асуух юм бэ? гэж Харри урьдын адил нударгаа зангидсан хэвээр асуулаа.

- Эхний асуулт. Онцгой ид шид эзэмшиж амжаагүй хүүхэд дэлхийн агуу их шидтэнг яаж дийлж чадав аа? Сорви төдийхнөөр чи яаж аврагдаж, лорд Волдеморт бүх хүч тамираа барсан юм бэ? гэж асуугаад Реддл инээмсэглэв.

Түүний шуналтай нүдэнд хачирхалтай улаан гал гэрэлтэнэ.

- Чи үүний юунд нь догдлоод байгаа юм бэ? Волдеморт чамаас нилээд сүүлд ... гэж Харри аяархан асуув.

- Волдеморт бол миний өнгөрсөн, одоо, ирээдүй юм гэж Реддл тогтуун хэллээ. Тэрбээр Харрийн шидэт савааг халааснаасаа гаргаж ирээд агаарт:

Том Нарвало Реддл

гэсэн гялалзсан үсэг бичив.

Тэгээд савааг ахин даллахад түүний нэрийн үсгүүд өөрчлөгдөн байраа сольж:

Лорд Волдеморт гэдэг үг боллоо.

- Одоо бүгд ойлгомжтой болоо биз дээ? Би Хогвартст байхдаа өөрийгөө тэгж нэрлэдэг байсан юм. Мэдээж дотныхоо андуудын дунд шүү дээ. Би өөрийнхөө магл аавынхаа ядуухан нэрээр үүрд дуудуулахыг хүсээгүй юм. Ээжийн талаар бодоход агуу их Салазар Слизериний цус судсаар минь гүйж байхад шүү!

Өөрийнхөө эхнэрийг ид шидтэн гэж мэдмэгцээ намайг төрөхөөс минь өмнө намайг хүүгээ биш гэж татгалзсан булай маглын нэрээр дуудуулна гэж үү? Мэдээж үгүй! Харри минь, ингээд л би өөртөө шинэ нэр бодож олсон юм. Би дэлхийн хамгийн агуу шидтэн болох учраас бүх шидтэнгүүд энэ нэрийг хэлэхээсээ ч айх өдөр ирнэ гэдэгт би итгэж байлаа!

Дөнгөж төрмөгцөө л өнчирч дараа нь Харрийн эцэг эхийг хөнөөхийн тулд өсөж өндийсөн Реддлийг Харри гайхан харна. Өөр бас олон хүнийг хорлох байсан байлгүй

... Эцсийн эцэст тэрбээр жигшил зэвүүцлээ арайхийн үлдэн хөөгөөд албын хүчээр:

- Тэгээд хамгийн агуу шидтэн болсонгүй шив дээ гэлээ.
- Болсонгүй гэнээ? гэж Реддл хэдэрлэв.
- Агуу их шидтэн болсонгүй ээ. Чамайг гомдоох харамсалтай ч дэлхийн хамгийн агуу шидтэн бол Альбус Дамблдор. Үүнийг бүгд мэднэ. Тийм ээ, чи өөрөө ид шидийн их хүчийг олж чадсан ч Хогвартсыг дийлэхэд хүрсэнгүй шүү дээ. Бүр сургуульд байхдаа л Дамблдор чамайг нэвт харж байжээ. Чи одоо болтол түүнээс айдаг. Тийм болохоор чи халз уулзаж чадахгүй гэж хэлэхдээ Харрийн амьсгал давхцаж байлаа.

Реддл инээмсэглэхээ болиод харцанд нь үзэн ядсан байдал тодорлоо.

- Дамблдорыг ердөө л миний дурсамж шилтгээнээс зайлуулж дөнгөсөн юм! гэж тэрбээр сөөнгө дуугаар хэлэв.
- Тэр чинь чиний бодсон шиг бүр явчихаагүй л дээ гэж Харри татгалзлаа.

Үүнийг үнэн гэж итгэхээсээ илүүтэй Реддлийг давах гэсэндээ ингэж таамгаар хэлжээ.

Реддл амаа ангайсан хэвээр хөшчихлөө.

Хаа нэгтэйгээс хөгжим сонсоно. Реддл хоосон өрөөг тойруулан харлаа. Хөгжим улам чангарсаар. Хөгжмийн чимээ зэвүүн, хахирган агаад Харри түүнийг сонсоход толгойтой үс нь босч, зүрх нь хэнхдэгэндээ багтахаа болих шиг санагдана. Хөгжмийн чичирхийлэх дууг Харри бүх биеэрээ мэдрэхээр хүчтэй болох үед ойролцоох багануудын оройгоос тал тал тийш оч цацарч байлаа. Тэгснээ хаанаас ирсэн нь үл мэдэгдэх хунгийн хэрийн биетэй улаан ягаан өнгийн шувуу сайхан дуу гаргасаар адар доогуур нисэж явав. Тэр шувуу тогосынх лугаа гялалзсан алтлаг урт сүүлтэй, ямар нэг хуучин хувцас алтан савартаа атгасан байлаа.

Агшин зуурын дараа шувуу Харри рүү ойртон нисэж ирээд авч явсан юмаа түүний хөлд унагаан, өөрөө жигүүрээ хумхин хүүгийн мөрөн дээр суув. Харри дээш хараад түүний хурц алтлаг хошуу, тас хар нүдийг олж үзлээ.

Шувуу дуугүй болов. Огт хөдөлгөөнгүй сууж байхад нь түүний дулаан илч Харрийн хацарт мэдрэгдэх ажээ. Шувуу Реддлийг тоомсоргүй харна.

- Галт шувуу! гэж Реддл гайхлаа.

- Фоукс уу? хэмээн Харри шивнээд алтан савраараа мөрийг нь хэрхэн зөөлөн атгаж байгааг Харри мэдрэв.

- Энэ юу вэ? Энэ чинь хуучин шидэт бүрх байна шүү дээ! гэж Реддл шалан дээр хэвтэх хэлбэр дүрсээ алдаж үнгэгдсэн хэсэг эсгийг хараад хэллээ.

Тиймээ, хуучин бүрх тэнд хэвтэж байлаа. Бохир далан долоон нөхөөс болсон малгай Харрийн хөл дор хэвтэнэ.

Реддл ахиад л муухай инээхэд олон арван Реддл нэгэн зэрэг инээсэн мэт чимээ гарч том өрөө тэр аяараа цуурайтаж байв.

- Дамблдор хамтран зүтгэгчдээ туслуулахаар ийм л юм илгээнэ дээ! Дууч шувуухай, хуучин бүрх! За Харри минь, зүрх зориг чинь нэмэгдэж байна уу? Аюулгүй гэж мэдрэгдэж байгаа биз?

Харри юм хэлсэнгүй. Үнэндээ ч Фоукс, шидэт бүрх хоёр юугаар туслах билээ дээ? Гэхдээ одоо цорын ганцаараа биш болохоор бас ч гэж зоригжиж байв. Одоо зөвхөн Реддлийн даажигнаж дуусахыг л хүлээх үлджээ.

- Ажил хэрэгтээ орёе доо, Харри. Чиний өнгөрсөн, миний ирээдүй үед бид нар хоёр ч удаа тааралдаж би чамайг хоёр удаа алж чадсангүй. Чи яаж амьд

үлдээд байнаа? Надад ярьж өгөөч. Аль болохоор тодорхой ярих тутам амьд байх хугацаа чинь төдий чинээ уртсах болно гэж Реддл ярив. Тэр инээмсэглэсэн хэвээр ажээ.

Харри аюул ослын байдлыг хурдхан цэгнэж үзлээ. Шидэт саваа нь Реддлын гарт байдаг. Харин Харрид Фоукс, шидэт бүрх хоёр байна. Энэ хоёр халз тулаанд хэрэг болохгүй. Муу л байна даа. За яахав. Гэхдээ Реддл энд удах тутам Жиннийн амьдралын хүч улам илүү барагдах юм. Харин Реддлийн бие улам бодитой харагдахуйц болж байлаа. Үнэхээр л Реддл тэр хоёрын хооронд тулаан болох ёстой бол хурдан тусмаа л сайн.

- Надтай тулалдахдаа чи яагаад сулраад байдгийг хэн ч мэдэхгүй. Би өөрөө өөрийгөө ч мэддэггүй юм чинь. Яагаад чи намайг алж чадахгүй байгаа тухай би нэг л юм мэднэ. Ээж маань намайг аврахын тулд амь насаа өгсөн юм. Миний шидэт ээж надаас үхлийг холдуулсан. Ноднин жил би чиний үнэн нүүр царайг харсан юм. Чи бол үнс нурам. Дөнгөж л амьд байна. Чиний хүч чадал өөрийн чинь эсрэг хандах болсон. Чи зугтааж байна. Чи бол хамгийн балиар амьтан гэж Харри уураа барьж ядсандаа чичрэн хэллээ.

Реддлийн царай байрагдсан ч хүчлэн мушийгаад:

- Эх чинь амь насаа өгсөн болохоор чи аврагдсан юм биз дээ ... Энэ бол ид шидийн эсрэг хэрэглэх хүчтэй зэвсэг. Гэхдээ чамд ер бусын зүйл байхгүй гэдгийг би

одоо харж байна. Чи бид хоёрын хооронд ижил төстэй зүйл байдаг нь хачирхалтай юм даа. Чи ч гэсэн үүнийг анзаарах ёстой байсан юм. Бид хоёулаа холимог цустай, хоёулаа өнчин, хоёуланг маань маглууд өсгөсөн. Зөвхөн чи бид хоёр их Слизеринээс хойш могойн хэлээр ярьдаг ч байж магадгүй. Зөвхөн азтай тохиолдол л чамайг надаас аварсан байж болох юм ... Миний мэдэх гэсэн юм энэ гэлээ.

Реддл одоохон шидэт саваагаа гаргана даа гэж Харри хүлээн зогслоо. Гэвч тэрбээр ахин даажинтай инээмсэглээд:

- Харри минь, би одоо жаахан тогломоор байна. Слизериний үе залгамжлагч хар лорд Волдеморт алдарт Харри Поттер, Дамблдорын хангасан сайн зэвсгийн эсрэг зогсож байна! гэлээ.

Тэрбээр Фоукс, шидэт малгай хоёрыг тохуурхан харснаа эргэж чулуун баримал руу очлоо. Реддл багануудын хооронд зогсож толгойгоо өргөөд адрын дор бүрэнхийд харлан буй Слизериний чулуун нүүр лүү харахыг ажаад Харри айн ширвээтэж байв. Тэгтэл Реддл амаан нээн исгэрэх мэт дуугарахад Харри:

- Хогвартсын дөрвөлийн хамгийн агуу Слизерин та надтай яриач! хэмээн хэлснийг нь ойлгожээ.

Харри хөшөөг сайтар харахын тулд ар тийш ухрав. Мөрөн дээр нь суусан Фоукс тонголзоно. Слизериний аварга нүүр хөдөлж эхлэлээ. Түүний чулуун ам хар нүх гарган нээгдэхийг Харри сайтар харсан аж. Аман дотор нь ямар нэг хөдөлснөө гадагш гулсан гарав.

Харри ар тийш ухарсаар хананд тулж мөргөлөө.

Тэрбээр нүдээ аньсан байжээ. Фоукс мөрөн дээрээс нь нисэхдээ хацрыг нь өдөөрөө шүргэхийг Харри мэдэрч байлаа. Харри: «Намайг бүү орхиоч!» гэж хашгирмаар байсан ч галт шувуу могойн хааныг яаж дөнгөх билээ дээ.

Ямар нэг хүчтэй юм шал доргиуллаа. Шалны хавтангууд чичрэн хөдлөхийг Харри мэдэрлээ. Юу болоод байгааг Харри мэдэрч байсан бөгөөд Слизериний амнаас гулсан гарах аймшигт могойг бараг харж байлаа. Реддл: «Түүнийг ал» гэж сийгүүлэн шивнэнэ.

Василиск Харрийн зүг хөдөлж байлаа. Хүнд бие нь чулуун шалан дээр шажигнан мурилзах нь түүнд сонсогдоно. Харри урьдын адил нүдээ аньсан хэвээр замаа сунгасан гараараа тэмтрэн хоёр тийш найган гүйлээ. Реддл хахаж цацан инээнэ.

Иймэрхүү байдлаар удаж болохгүй байлаа. Харри бүдрэн унахдаа чулуу мөргөчихжээ. Аманд нь цус амтагдана. Могой түүнд бараг метр хэртэй ойртон ирээд амьсгал нь түүнд мэдрэгдэж байв.

Тэгтэл чанх дээр нь чих дүлийрмээр шуугих чимээ гарснаа ямар нэг хүчтэй юм түүнийг хийсгэж нөгөө хана руу шидлээ. Хажууханд нь багана хүчтэй ороолгох чимээ гарах аж. Одоохон аймшигтай соёо биеэнд нь шигдэх байлгүй.

Харри шидэт саваа зэвсэггүйгээр эсэргүүцэж чадахгүй байлаа. Тэгээд нүдээ ялимгүй нээв.

Гялалзсан хорт ногоон өнгөтэй бүдүүнээрээ багана шиг биетэй аварга могой гурвалжин толгойгоо ийш тийш савлуулан сүүлэн дээрээ өндийжээ. Харри нүдээ анихад бэлэн хэвээр чичирч байсан ч аймшигт амьтныг чухам юу саатуулаад байгааг харлаа. Василикийн дээгүүр Фоукс эргэлдэх ажээ. Могой уурандаа сэлэм шиг нарийхан шүдээрээ түүнийг шүүрэн авахыг хичээнэ.

Фоукс дээшилж доошлох зуураа урт алтан хошуугаараа үл мэдэг хэдэн хөдөлгөөн хийхэд шалан дээр хар цус асгаран урслаа. Могой сүүлээрээ цохихдоо Харрийг шахахад нүдээ ч аниж амжаагүй байтал Василиск цааш эргэв. Харри түүний хоншоорыг эгцлэн харлаа. Могойн хоёр том шар нүдийг галт шувуу сохолсон ажээ. Шалан дээр цус садран урсаж, аймшигтай амьтан өвдсөндөө болоод ууртайяа сийгүүлэн исгэрэх ажээ.

- Чи шувууг орхиоч дээ! Одоохон орхи! Хүү ард чинь байна! Чи мэдэж байгаа шүү дээ! Түүнийг алаач! гэж Реддл галзуурсан мэт хашгирна.

Мэгдэж сандарсан ч үхлийн аюултай хэвээр байгаа сохорсон могой толгойгоо ганхуулсаар. Фоукс ахиад л аймаар дуу хадаан түүний дээгүүр эргэлдэх үедээ дайсныхаа сармай хоншоорыг хошуугаараа тоншино. Түүний тоншуулсан нүднээс цус садарсан хэвээрээ.

- Туслаарай! Туслаарай! Хэн нэг хүн, ямар нэг юм байвал туслаарай! гэж Харри тэсэлгүй шивнэн хэллээ.

Могой сүүлээрээ шалан дээгүүр ахиад л балбаж гарав. Харрийг үсэрч амжихад нэг зөөлөн юм нүүрэнд нь хүрлээ.

Василиск сүүлээрээ шидэт бүрхийг ороож аваад шууд Харрийн гар луу чулууджээ. Харри бүрх малгайнаас аврал эрэх мэт зууран авлаа. Малгайг толгой дээрээ амжиж тавиад шалан дээр хэвтэхэд Василикийн сүүл ахиад л дээгүүр нь ороолгон өнгөрөв.

«Туслаарай ... Надад туслаарай ...Туслаж хайрлаач!» гэж Харри бодож хэвтлээ. Малгай доорх нүдээ тас аньсан байлаа.

Хариу хэлэхийн оронд бүрх малгай үл үзэгдэх гарт хавчуулсан мэт агшжээ. Тэгтэл Харрийн толгойг ямар нэг хүнд юм нүднээс нь оч бутартал цохив. Харри бүрхээ тайлахаар шүүрэн автал түүний хуруунд нэгэн урт хүйтэн юм тэмтрэгджээ.

Малгай дор мөнгөөр өнгөлж, тагтааны өндөгний хэрийн эрдэнийн чулуу бариулд нь шигтгэсэн илд байлаа.

- Хүүг алаач! Шувууг март! Хүү ард чинь байна! Толгойгоо эргүүлбэл олно! Харри тулалдаанд бэлтгэн хөл дээрээ боссон байлаа. Василиск толгойгоо бөхийлгөн их биеэ цагариглуулаад багануудыг шүргэж Харри руу эргэв.

Хүү түүний онгорхой том ухархай, нарийхан гялалзсан хортой түүний илд шиг урт соёо цухуйсан том амыг харлаа ...

Василиск таамгаар үсрэв. Харри бултахад могойн толгой хана мөргөлөө. Ахайд үсрэхдээ салаа хэлээ Харрийн хавирганд хүргэх шахав. Харри хоёр гараараа илдээ өргөлөө.

Василиск ахин довтолсон авч ахиад л оновчтой болсонгүй. Харин Харри илдээ могойн тагнайд бариулыг нь хүртэл зоож аваад чадлаараа дарж байлаа.

Халуун цус Харрийн гарыг даган урсахад тохойноосоо дээш янгинан өвдөхийг мэдэрчээ. Хортой соёонуудын нэг нь түүний мөрөнд зоогдсон ч Василиск тэр дороо шалан дээр эвхрэлдэн унаж, соёо шүдээ хугалсан байлаа.

Харри хана даган мөлхөв. Хороо биед нь юүлж байгаа соёог гараараа шүүрэн суга татан авлаа. Гэвч оройтжээ. Гарт нь улайсмал төмөр хүргэсэн мэт шархны орчинд өвчин орлоо. Тэрбээр соёог авч хаяад, жанч нэвтлэн гоожиж байгаа өөрийнхөө цусыг харснаа нүд нь харанхуйлав. Бүдэг гэрэлтэй өрөө дайвалзан эргэлдэж эхэллээ ...

Тэгтэл нэгэн улаан юм нүдэнд нь үзэгдэн, дэргэд буух хөлийн чимээ түүнд сонсогджээ.

- Фоукс. Сайн байна, Фоукс минь гэж хэлээ арайхийн эвлүүлэн талархлаа.

Шувуу Харрийн гар дээрх цустай шарханд гоёмсог толгойгоо ойртуулав. Аллах чимээ цуурайтан, түүний өмнө хар сүүдэр гарч ирлээ.

- Харри Поттер үхэж байх шив. Үхсэн гэж хэлэхээр болжээ. Тэр ч байтугай

Дамблдорын шувуухай хүртэл мэдчихээд уйлж байна гэж Реддл хэлэв.

Харри нүдээ нээлээ. Фоуксын толгой агшин зуур үзэгдээд алга боллоо. Гэхдээ шувууны том сувдан нулимс гялтганасан өдийг нь даган бөмбөрөхийг хүү харж амжсан юм.

- Би чамтай хамт байж яаж үхэхийг чинь харъя. Яарах хэрэггүй. Чи бид хоёр хаашаа яарах билээ.

Харрийн толгой эргээд зүүрмэглэх аятай болжээ.

- Алдарт Харри Поттерийн газар дээрх зам дуусах нь энэ дээ. Үзэн ядаж бодлогогүйгээр тулаанд дуудсан хар Лорддоо ялагдаж, анд нөхөддөө хаягдаж нууц өрөөнд ганцаараа үлдэх шив. Одоохон чи өөрийн заваан эрлийз ээжтэйгээ хамт байх болно. Ээж чинь чамд арван хоёр жилийг худалдан авч өгсөн гэж бодсон хэдий ч үнэндээ бол зээлдсэн юм шүү дээ. Лорд Волдеморт өрөө шаардахад чи түүнийг төлж байна. Энэ бол шударга явдал гэдгийг чи ойлгох байлгүй гэж хэлэх Реддлийн дуу алсад сонсогдоно.

Хэрэв энэ үнэхээр үнэн юм бол тийм аймаар эд биш байна гэж Харри боджээ. Өвчин алгуурхан намдаж байлаа.

Үхэл биш юм болов уу? Өрөөний байдал тодорхой болж эхэллээ. Харри толгойгоо аяархан сэгсрэв. Гар дээр нь суусан Фоукс шувуу сувдан нулимсаараа шархыг угаана. Шарх хаана байнаа? Гар дээр ямар ч шарх байхгүй болжээ.

- Галт шувуу чи эндээс тонил! Одоохон зайл! гэж Реддл гэнэтхэн хашгирлаа. Харри толгойгоо өндийлгөв. Реддл галт шувуу руу шидэт савааг чиглүүлтэл нэг юм гар буу шиг тасхийн дуугараад галт шувуу алтлан улаан шуурганд эргэлдэн нислээ.

- Галт шувууны нулимс. Би түүний тухай мартсан байжээ. Гэхдээ энэ нь байдлыг өөрчлөхгүй л дээ. Би халз тулалдахыг илүүд үздэг юм. Зөвхөн чи бид хоёр. Чи бид хоёр л байх ёстой ... гэж Реддл Харрийн гарыг хараад бодлогошон хэллээ.

Реддл шидэт саваагаа өргөв.

Фоукс жигүүрээ хүчтэй дэвэн эсрэг этгээдийн дээгүүр шунгинан нисэхэд Харрийн өвөр дээр нэг юм унасан нь өдрийн тэмдэглэл ажээ!

Реддл, Харри хоёр хэсэг зуур дэвтрийг алмайран харав. Тэгснээ Харри огт эргэлзсэнгүй шалан дээр хэвтэх Василискийн соёог шүүрэн аваад өдрийн тэмдэглэлийн чанх голд шууд зоочихлоо.

Чөмгөнд хүрсэн чанга аймаар дуу хадаж өдрийн тэмдэглэлийн бэх Харрийн гарыг даган урсаж, шалан дээр асгарна. Реддл атиганан, мурчигнан, тийчлэн гаслаж байснаа ... алга болчихлоо. Харрийн шидэт саваа хүйтэн шалан дээр торхийн унаад нам гүм болов. Тог тог тог гэхээс өөр чимээгүй байлаа. Энэ бол өдрийн тэмдэглэлээс урсан дуслах бэхний чимээ юм.

Василискийн хор дэвтрийг цоортол түлжээ.

Харри хүчлэн байж чичрэхээ болилоо. «Нисдэг дарь» хэрэглэж олон бээр туулсан мэт толгой нь эргэжээ. Харри яаралгүй хөдлөн бүрх малгай, шидэт саваагаа авч нуун, ихээхэн хүч гаргаж байж Василискийн амнаас гялалзсан илдээ сугалж дөнгөв.

Өрөөний нөгөө үзүүрт сулхан гинших дуулдана. Жинни яльгүй хөдлөхөд Харри түүний зүг ухасхийн очлоо. Жинни ахин өндийн суусан байв. Үхээд хэвтэж буй аварга биет могой, цусанд нэвтэрсэн жанчтай Харри, хар өдрийн тэмдэглэлийг гайхширан харна. Охин гүнзгий санаа алдахад нүүрний дээгүүр нь нулимс асгарлаа.

- Харри ... Харри би чамд өглөөний цайны үеэр бүх юмыг ярих гэсэн авч Перси байгаад чадаагүй юм. Энэ бол би байсан юм, Харри. Гэхдээ би үнэндээ ингэе гэж бодоогүй ээ ... Реддл намайг илбэдэн захирч байсан юм ... Харин чи ... энэ араатныг яаж хөнөөсөн юм бэ? Реддл хаана байна? Миний санаж байгаа сүүлчийн юм бол тэр тэмдэглэлийн дэвтрээс гарч ирээд ...

- Бүх юм зүгээр, Жинни минь гээд Харри өдрийн тэмдэглэлд могойн шүднээс үлдсэн цоорхойг үзүүлснээ:

- Харав уу? Реддл зүйл дууссан. Реддл ч, аварга могой ч зүйл дууссан. Эндээс явцгаая гээд Харри түүнийг босоход нь тусаллаа.

- Намайг одоо хөөх байлгүй. Би Биллийг сургуульд орсноос хойш Хогвартст элсэхийг хичнээн их хүслээ. Гэтэл одоо хөөгдөх болж байдаг. Аав ээж минь юу гэх бол гэж хэлээд Жинни уйлна.

Фоукс өрөөний үүдний дэргэд элин халин тэднийг хүлээж байв. Харри Жиннийг урагш түлхээд тэд үхсэн могойн цагаригласан биен дээгүүр гарч, бүдэгхэн цуурайтах чимээ сонсон явсаар ахин хонгилд гарч ирлээ. Тэдний ард чулуун хаалга зөөлхөн хяхтнан хаагдав.

Хэдэн хормын дараа тэр чулуу хөдлөх чимээ олж сонслоо.

- Рон! Жинни амьд! Энд надтай хамт байна! гэж Харри алхаагаа хурдасган хашгирав.

Рон хариуд нь ямар нэг юм хэлсэн бөгөөд булан тойроход түүний тэсэж ядсан царай харагдлаа. Тэрбээр нурангийг зайчлан овоо том нүх гаргаж амжжээ.

- Жинни! гэж хэлээд Рон дүүгээ түрүүлж авахаар гараа цухуйлгав. Тэгээд:

- Чи минь амьд байна! Нүдэндээ итгэхгүй нь! Юу болсон бэ? гэж хэлээд түүнийг тэврэх гэсэн авч Жинни уйлсаар хөндийрчээ.

- Чи л зүгээр бол болох нь тэр, Жинни минь! Бүх аймшиг ард хоцорлоо гээд

Харри баяртай инээлээ.

Жиннийн араас Фоукс нүхээр нисэн гарав.

- Энэ юун шувуу вэ? Хаанаас гараад ирэв ээ?

- Энэ бол Дамблдорын шувуу гэж Харри хэлээд нүхээр шургаж байлаа.

- Чи хаанаас энэ сайхан илдийг авсан юм бэ? гээд Рон андынхаа гарт гялалзах илдийг гайхан харна.

- Бүгдийг яринаа. Одоо эндээс хурдхан гарцгаая! гэж Харри хэлэв.

- Жаахан ч гэсэн ярь л даа ...

- Одоо болохгүй ээ. Туг үс хаана байгаа вэ? гэж Харри яриаг таслав.

Нууц өрөөг хэн нээсэн гэдгийг ялангуяа Жиннийг хажууд байхад Ронд дэлгэрэнгүй ярихыг Харри хүссэнгүй.

- Тэнд байгаа. Түүний ажил явдал бүтэл муутай. Очоод үзнээ гэж Рон гарах зүг рүү гар занган хэллээ.

Өргөн жигүүрээ дэвэн харанхуйд алтан туяа цацруулах Фоуксын араас явсаар хоолойн үзүүрт ирэхэд Алтан хонгиот Туг үс тэнд томоотой нь аргагүй суучихсан амандаа ямар нэг юм үглэж байв.

- Түүний ухаан самуурчихсан. Түүнийг мартуулах шившлэг эргэн цохидог мод шиг өөрт нь туссан юм. Өөрийгөө болон биднийг хэн гэдгийг, хаана байгаагаа огт мэдэхгүй байгаа. Бид зүгээр. Харин тэр өөрөө өөртөө аюултай. Би түүнийг явж, үүдний дэргэд биднийг хүлээж бай гэж хэлсэн юм хэмээн Рон тайлбарлав.

Туг үс тэднийг баярласан байдалтай харснаа:

- Сайн уу! Хачирхалтай газар юм, тийм ээ? Та нар энд суудаг юм уу? гэв.

- Үгүй ээ гэж Рон хэлээд Харрийг харан хөмсгөө зангидлаа. Харри дээш одсон хоолойны хар нүхийг тонгойн харав.

- Эндээс яаж явахыг чи бодсон уу? гэж Роноос асуулаа.

Рон толгой сэгсрэв. Фоукс Харри руу нисэж ирээд жигүүрээ шуугиулан дэвнэ. Түүний нүд харанхуйд очтон гялалзаж, сүүлний нь урт алтан өд сэрчигнэнэ. Харри түүнийг хараад ямар нэг юм бодож олохыг хичээлээ.

Рон учрыг сайтар ололгүй, чихнийхээ ард маажсанаа:

- Шувуу чамайг өөрөөсөө зуур гээд байх шиг байна. Гэхдээ чи хүнддэх байх аа ... гэлээ.

- Фоукс бол онцгой шувуу. Бид бие биеэсээ сайтар барих хэрэгтэй. Жинни чи Роны гараас барь. Профессор Туг үс та ...

- Профессор гэж та шүү гэж Рон түүнд хэллээ.

- Жиннийн гараас барь.

Харри илд, шидэт бүрхээ бүсэндээ хавчуулахад Рон түүний жанчнаас зуурлаа. Харри гараа дээш сунган Фоуксын гайхмаар халуун сүүлний өдийг сайтар атгажээ.

Тэрбээр ер бусын хөнгөн болсноо мэдэрсэн тэр агшинд тэд усны хоолой даган дээш шуугин нисэж байлаа. Дор нь дүүжлэгдэн байгаа Туг үс: «Гайхалтай! Бахархмаар юм! Жинхэнэ ид шид энэ дээ!» хэмээн уулга алдахыг Харри сонсчээ. Агаарын хүйтэн урсгал Харрийн үсийг хийсгэн, нүдэнд нь алтлаг туяа үзэгдэнэ. Тэд нисэн байгаадаа баярлан хөөрч амжаагүй шахам байтал нислэг дуусаж дөрвүүлээ уйланхай Миртлийн жорлонгийн чийглэг шалан дээр унажээ. Туг үсийг бүрхээ засаж тавих зуур хоолой руу орох нүхийг нууж байсан угаалтуур хөдлөн байрандаа буцаж ороод бүх юм урьдынхаараа боллоо.

Мирт нүдэндээ ч итгэхгүй байв.

- Чи амьд байх шив ... гэж тэрбээр урам хугарсан янзтай бувтнажээ.
- Гомдох хэрэггүй гэж хэлээд Харри нүднийхээ шилэнд наалдсан цус, шороог арчиж байв.
- Мэдээж, гомдохгүй ээ ... Би зүгээр л чамайг үхчихвэл жорлонгоо хуваах хэрэг гарах нь гэж бодож байлаа ... Тэгвэл би их баярлах байсан даа! гэж Миртл хэлээд, ичингүйрэн туяарч байв.
- Үгүй ер өө! гэж Рон жорлонгоос хоосон, харанхуй хонгил руу гарсан хойноо гайхсанаа:
- Миртл чамд дурласан юм шиг байна! Гэхдээ жинлүүрийн таваг чам руу хазайжээ, Жинни минь! гэлээ.

Жиннигийн нүүрэн дээгүүр урьдын адил нулимс асгарна. Рон түүнийг түгшин харснаа Харри руу эргээд:

- Одоо хаачих вэ? гэлээ.

Харри Фоуксын зүг толгой дохив. Шувуу эргэн тойрноо алтлаг туяагаар гийгүүлэн урагш нисэх аж. Тэд түүний араас явсаар хормын дараа профессор МакГонагаллын өрөөний үүдэнд зогсож байв. Харри үүдийг тогшин түлхлээ.

БҮЛЭГ 18: ДОББИЙН ХҮРТСЭН ШАГНАЛ

Газар доогуур тэнүүчилсэн Харри, Рон, Жинни, Туг үс дөрөв толгойноосоо хөлөө хүртэл норчихсон бас Харри цусан толбо болчихсон өрөөнд ороход тэнд байсан бүх хүмүүс гайхан дуугаа хурааснаа гэнэтхэн нам гүмийг эвдэн:

- Жинни! гэж хашгирах дуу гарлаа.

Задгай зуухны өмнө уйлан сууж байсан хатагтай Уизли охиноо хараад ухасхийхэд араас нь ноён Уизли босож хоёулаа охин руугаа очлоо.

Гэвч Харри тэднийг харсангүй. Ханан зуухны дэргэд профессор Дамблдор инээмсэглэн зогсох агаад дэргэд нь профессор МакГонагалл зүрхээ даран, хүндээр амьсгаадан байгаа харагдана. Галт шувуу Харрийн чихний хажуугаар далавчаа сэржигнүүлэн нисэж өнгөрөн Дамблдорын мөрөн дээр суухад хатагтай Уизли Рон тэр хоёрыг ээлжлэн чангаар тэвэрлээ.

- Та нар түүнийг аварчээ! Аварсан байна! Яаж ингэж чадав аа?

- Бид бүгдээрээ л үүнийг мэдмээр байна гэж профессор МакГонагалл хэлэхдээ дуу нь урьдынхаасаа зөөлөрсөн байв.

Хатагтай Уизли Харрийг тавихад тэрбээр хэсэг зуур эргэлзсэнээ ширээ рүү очоод шидэт бүрх, эрдэнийн чулуугаар чимэглэсэн илд, Реддлийн өдрийн тэмдэглэлийн өрөвдөлтэй хэсгийг гаргаж тавилаа.

Тэгээд болсон явдлыг ярьж өгчээ. Нам гүм ахуйд тэрбээр биегүй дуу хоолой сонссон тухай, үүнийг аварга могойн дуу гэж ганцхан Гермiona мэдсэн тухай, тэр могой шилтгээний зузаан ханан доторх хоолойгоор мөлхдөг байсан тухай, Рон тэр хоёр аалзнуудыг мөрдөн ойд очиход Арагог аалз сүүлчийн хохирогч хаана үхсэн талаар ярьсан тухай, энэ хохирогч нь уйланхай Миртл байж болох юм гэж таасан тухай, нууц өрөөнд орох хаалга өөр хаана ч биш түүний жорлонд байгааг мэдсэн тухайгаа арван таван хором хэртэй ярилаа.

Харри бодол санаагаа төвлөрүүлэхээр дуугүй болов.

- Гайхалтай! Та нар чинь сургуулийн олон дүрэм журмыг зөрчин орох үүдийг олсон юм байж. Харин тэндээс яаж амьд гарч ирэв ээ, Поттер? гэж МакГонагалл багш сониуч зангаа дийлэлгүй асуулаа.

Фоукс шувуу цагтаа хэрхэн амжиж ирсэн шидэт бүрх түүнийг хэрхэн илдээр зэвсэглэсэн тухай Харри яльгүй сөөнгө хоолойгоор ярьж байснаа гэнэтхэн түгдрэв. Тэрбээр Реддлийн өдрийн тэмдэглэлийн тухай дурсахгүй байхыг хичээнэ. Жиннийг харахад охин ээждээ наалдан хоёр алхамын цаана зогсох агаад нулимс нь тасралтгүй урсаж байв.

«Хэрэв түүнийг үнэхээр хөөчихвөл яанаа? Реддлийн өдрийн тэмдэглэл үүрд дуугүй болсон. Түүнийг ид шидийн аргаар шилтгээнд болсон аймшигт явдлыг охиноор үйлдүүлэхэд хүргэсэн гэж нотлох гээд үз л дээ!» хэмээн Харри цөхрөн боджээ.

Харри дэмжлэг олох санаатай Дамблдор багшийг харахад тэрбээр үл ажиглагдам инээмсэглэх нүдний шилэнд нь задгай зуухны гал гялалзаж үзэгдэнэ.

- Би нэг юм мэдмээр байна. Лорд Волдеморт Жиннийг чухам яаж илбэдэж чадсан юм бол? Надад байгаа мэдээгээр бол тэр Албанийн ойд нуугдаж байх ёстойсон гэж захирал намуухан асуулаа.

Харрийн сэтгэл баяр хөөрөөр дүүрч зүрх нь амарчээ.

- Юу гэнээ? Хэцүү нэрт ... Жиннийг илбэдсэн юм уу? Гэхдээ Жинни ... тэр чинь ... тэр чинь ... гэж ноён Уизли гайхан дуу алдав.

- Бүх юманд өдрийн тэмдэглэл буруутай. Реддл арван зургаан настай байхдаа түүнийг хөтөлж байжээ гээд Харри өдрийн тэмдэглэлийг авч Дамблдор багшид үзүүллээ.

Дамблдор багш Харригаас тэмдэглэлийн дэвтрийг аваад норж гэмтсэн хуудсан дээр нь урт махир хамраа унжуулан сонирхон үзэж байв.

- Гайхмаар юм. Реддл бол Хогвартсын хамгийн авъяаслаг сурагчдын нэг байсан юм гэж тэрбээр аяархан хэллээ.

Дамблдор багш учраа олохоо байсан Уизли авхай, ноён Уизли руу хандан:

- Лорд Волдемортыг дээр үед Том Реддл гэдэг байсныг цөөн хүн мэднэ. Би түүнийг тавин жилийн тэртээ энд сургаж байсан юм. Тэр хүү сургуулиа төгсөөд хамгийн аюултай шидтэн, илбэчингүүдтэй арцалдан алс хязгаарт алга болсон доо. Хар домын нууцад улам гүн нэвтэрсэн юм. Тэрбээр өөрийгөө тоо тоомшгүй удаа өөрчилсөн болохоор Волдеморт нэртэй болоод гарч ирэхэд нь хэн ч танихааргүй байсан билээ. Харгис ширүүн хар Лорд нэгэн цагт сургуулийн ахлагч байсан ухаалаг, сайн хүү хоёрын хооронд адил төстэй юм алга байлаа гэж ярив.

- Гэхдээ манай Жинни түүнтэй яаж холбогдсон байх вэ? гэж ноён Уизли гайхан асуулаа.

- Түүний ... түүний өдрийн тэмдэглэл. Би өдрийн тэмдэглэлд нь юм бичихэд тэр хариулдаг байсан юм ... Энэ жилийн туршид гэж Жинни уйлагнан хэлэв.

Ноён Уизли гайхаж гүйцжээ.

- Жинни минь! Чи яаж чадав аа! Би чамд дандаа хэлдэггүйсэн биш билүү? Хэн нэг хүн, ямар нэг юм сайхан ойлгосон мэт дүр үзүүлж болох шүү дээ! Огт танихгүй хүний урхинд орно гэж байх уу даа! Яагаад надад ч юм уу! ээждээ өдрийн

тэмдэглэлийг үзүүлээгүй юм бэ? Ийм сэжигтэй юм байхад шүү! Энэ маань хар шидэд автаж гүйцжээ!

- Би мэдээгүй юм. Өдрийн тэмдэглэл ээжийн худалдан авсан сурах бичгүүдийн нэгэн дотор байсан юм. Хэн нэг хүн түүнийг номон дотор хийгээд мартаж дээ гэж би бодсон юм ... гэж Жинни цурхиран уйлна.

- Жинни Уизли авхайг одоохон эмнэлэгт аваачих хэрэгтэй. Түүнд хэтэрхий хүнд сорилт тулгарчээ. Шийтгэх барих тухай ямар ч яриа байж болохгүй. Үүнээс хамаагүй ах шидтэнгүүд Волдемортод хууртагдсан байдаг юм гэж Дамблдор ярианд оролцон хэлэв.

Тэрбээр үүд рүү том том алхаж очоод онгойлгосноо:

- Жинни нойр авах бас аяга халуун шоколад уух хэрэгтэй. Надад л лав ингэвэл хүч тамир орох нь илүү байдаг юм гээд охины зүг нүдээ нөхөрсөгөөр ирмэснээ:

- Хатагтай Помфри унтаагүй байгаа. Яг одоо мандрагорын шүүс тараана.

Василиск могойд хорлогдогсод агшин зуур өөрчлөгдөнө гэж итгэлтэй хэлж чадах байна гэлээ.

- Тэгэхлээр Гермiona мөдхөн зүгээр болох нь ээ! хэмээн Рон баясав.

- Бүх муу юм ард хоцорсон гэж Дамблдор багш толгой дохин хэллээ. Хатагтай Уизли Жиннийг түшсээр өрөөнөөс гарахад яагаад ч учраа олж чадахгүй байгаа ноён Уизли араас нь гэлдрэв.

- Минерва минь, энэ явдлыг тэмдэглэж сайхан найрлана байгаа. Та яваад тогооч нартай ярилцахгүй юу? гэж Дамблдор багш инээмсэглэн хэллээ.

- Бололгүй яахав гэж профессор МакГонагалл толгой дохиод:

- Намайг байхгүйд та Поттер Уизли хоёртой учраа олохоор шийдээ шив дээ?

гэж үүдний дэргэдээс асуулаа.

- Яг үнэн гэж Дамблдор зөвшөөрөв.

Түүнийг явахад Харри, Рон хоёр Дамблдорыг түгшин харлаа. Учраа олно гэдэг чинь юу гэсэн үг вэ? Үгүй л баймаар ... гэхдээ шийтгэх юм болов уу даа?

- Хэрэв та нарыг дүрэм зөрчих юм бол хоёуланг чинь сургуулиас хөөх болно гэж байсан шиг санагдах юм гэж захирал ярьж эхэллээ.

Рон айсандаа нүдээ бүлтийлгэв.

- Харин энэ явдал заримдаа хэлсэн үгнээсээ буцах хэрэгтэй болдгийг батлаж байна. Та хоёр сургуульдаа байгуулсан гавъяаныхаа төлөө онцгой шагнал хүртэх

болно. Тэгээд ... за байз ... хүн тус бүрт хоёр зуун оноо гээд Дамблдор багш инээмсэглэжээ.

Роны царай Валентины өдрөөр Туг үсэд өгсөн цэцэг шиг улайв.

- Гэхдээ энд байгаа хүмүүсийн нэг нь яагаад таг дуугүй байгаад байгаа билээ.

Түүнийг энэ аюултай ажилд хэрхэн оролцсон талаар сонсвол сонирхолтой

байх сан. Яагаад ийм их даруухан байнаа, Туг үс минь? гэж Дамблдор багш түүнээс асуулаа.

Туг үсийн тухай таг мартчихсан Харри давхийн цочжээ! Харин Туг үс тэнэгдүү маягтай инээмсэглэсэн хэвээр буланд зогсоно.

Дамблдорын үгийг сонсоод тэрбээр чухам хэнд хэлж байгааг мэдэх санаатай эргэн тойрноо харах аж.

- Профессор Туг үс ... гэж Харрийг ярихаар завдахад:

- Би профессор гэж үү? Үгүй ерөө! Гэтэл би өөрийгөө мангуу амьтан гэж л бодоод байдаг ... гэж Туг үс яльгүй гайхасхийн хэллээ.

- Бидэн рүү мартуулах шившлэг илгээх гэсэн чинь саваа нь буцаагаад өөрийг нь шившчихсэн юм гэж Рон өгүүлэв.

- М-м-м. Өөрийнхөө зэвсэгт өртсөн юм биз дээ? гээд Дамблдор толгойгоо сэгсрэхэд түүний урт мөнгөн сахал чичирч байлаа.

- Зэвсэг гэнээ? Надад зэвсэг байхгүй. Харин энэ хүүд бий. Маш сайхан илд.

Танд түр хэрэглүүлэх байлгүй гэж Туг үс хэлээд Харрийг заана.

- Рон минь, профессор Туг үсийг эмнэлэгт хүргээд өг дөө. Би Харрид бас хэдэн үг хэлэх хэрэгтэй байна гэж Дамблдор багш Ронд хэлэв.

Туг үс үүд рүү итгэл муутай гэлдэрлээ. Рон явах зуураа захирал, Харри хоёрыг сониучирхан хараад Туг үсийн тохойноос дэмжин хонгилд гарчээ.

Дамблдор багш өрөөн дундуур явж задгай зуух руу очоод нэгэн сандалд сууснаа:

- Суу, Харри гэлээ. Харри сэтгэл догдлон суув. Дамблдор сахлаа илбээд:

- Юуны өмнө би чамд талархал илэрхийлэх ёстой. Чи тэр дор жинхэнэ эр зориг гаргажээ. Тэгээгүй бол Фоукс чам руу очихгүй байсан гэж хэлэхдээ нүд нь гялалзаж байлаа.

Тэрбээр өвөр дээрээ жигүүрээ хөдөлгөн суух галт шувууны өдийг илбээд:

- Тэгэхлээр чи тэнд Том Реддлтэй учирчээ. Чи л түүний сонирхлыг илүү их татсан юм байж дээ ... гэж бодлогошрон хэлэв.

Гэтэл Харрийн санаа сэтгэлийг зовоож байсан зүйл гэнэтхэн зад үсрэн:

- Профессор оо ... Реддл намайг өөртэйгөө адилхан гэсэн ... Хачин адилхан гэсэн шүү ... гэлээ.

- Тэгж хэлсэн үү? Харин чи юу гэж бодож байна? хэмээн хэлэхдээ Дамблдор багш өтгөн буурал хөмсгөн доорх нүдээрээ Харрийг анхааралтай ширтжээ.

- Огт төсгүй гэж бодож байна! Би Гриффиндорт сурдаг шүү дээ ... гэж Харри хэтэрхий чанга хэллээ.

Тэрбээр дуугүй болсноо сэтгэлд нь бас л эргэлзээ төрж:

- Профессор оо, намайг Слизеринд орвол илүү сайн юм гэж шидэт бүрх хэлсэн юм аа. Намайг могойн хэлээр ярьж чаддаг болохоор ихэнх хүүхдүүд Слизериний үе залгамжлагч гэж үздэг гэлээ.

- Салазар Слизериний үлдсэн цорын ганц удам могойн хэлээр ярьдаг учраас л чи могойн хэлээр ярьдаг юм даа, Харри. Хэрэв би андуураагүй бол чамайг сорвиор шагнасан шөнөө тэрбээр өөрийнхөө хүч чадлын нэгээхэн хэсгийг чамд санамсаргүй шингээчихсэн юм. Уул нь ингэе гэж бодоогүй гэдэгт итгэлтэй байна гэж Дамблдор шивнэн хэлэв.

- Волдеморт надад ... өөрийнхөө хэсгийг шингээсэн байх нь ээ? гэж хэлэхдээ

Харри аянганд ниргүүлсэн мэт харагдана.

- Тийм л болж таарч байна.

- Тэгэхээр би Слизеринд байх ёстой ажээ. Шидэт бүрх надад шингээсэн хэсгийг мэдээд ... гэж Харри аргаа баран хэлээд Дамблдор багшийг харахад:

- ... Гриффиндорт хуваарилсан гэж Дамблдор тайвшруулан хэллээ. Тэгснээ:

- Харри минь ийм байна л даа. Салазар Слизерин өөрийн хайртай сурагчиддаа байдаг овсгоотой, шийдвэртэй, нуух юу байхав бас сургуулийн дүрэм журмыг хайхардаг чанаруудыг нь өндөр үнэлдэг байсан юм. Энэ олон чанар чамд бүгд бий. Бас могойн хэл мэддэг ховорхон авъяас байна. Гэхдээ шидэт бүрх чамайг Гриффиндорт хуваарилсан байдаг. Яагаад гэдгийг мэдэх үү? Бодоод үз дээ! ... гэлээ.

- Яагаад гэвэл намайг Слизеринд бүү хуваарилаач гэж гуйсан учраас л ... гэж

Харри сэтгэл зовнин өгүүлэв.

- Яг үнэн. Чухам үүнд л чиний Том Реддлээс ялгарах чанар байгаа юм. Хүн гэдэг чинь зан араншингийн чанар биш өөрийн нь сонголт байдаг юм шүү дээ гээд Дамблдор дахин инээмсэглэлээ.

Харри сонссон зүйлдээ итгэж ядан хөдөлгөөнгүй суусаар.

- Чи Гриффиндорт тохиолдлоор ороогүй гэдэгт чинь өөр баталгаа хэрэгтэй байгаа бол энд юу гэж бичсэнийг унш даа. Дамблдор багш професоор МакГонагаллын ширээ рүү очоод цус болсон мөнгөн сэлмийг авч Харрид сунгав. Харри учрыг нь ололгүй илдийг эргүүлж харав. Илдний эрдэнийн шигтгээ галын гэрэлд гялалзана. Бариул дор Годрик Гриффиндор гэдэг нэр шигтгээстэй байгааг уншлаа.

- Энэхүү илдийг шидэт бүрхнээс зөвхөн жинхэнэ Гриффиндорын хүн л гарган авч чадна гэдгийг мэдэж ав, Харри.

Хоёулаа хэсэг дуугүй суулаа.

- Одоо чамд юу хэрэгтэй вэ гэхээр хоол унд, амралт хоёр. Өрөөндөө очиж гар нүүрээ угаагаад баярын ширээнд суу. Харин би Азкабан руу захидал бичнэ. Ойн харуулаа гаргах хэрэгтэй. Далимд нь бас «Өдөр тутмын зөнч» сонинд

захидал бичье гээд ширээний дээд нүдийг татан бэх гаргаж ирснээ үзгээ хутгаар хурцлаад:

- Одоо бидэнд хар домын урлагаас хамгаалах шинэ багш хэрэгтэй байна. Энэ хичээлийн багш нар манайд удаан тогтохгүй юм даа ... гэлээ.

Харри босож үүд рүү очоод хаалгыг нээхээр бариулд хүртэл хаалга гэнэтхэн тасхийн нээгдээд хана цохиж буцаж ойв.

Босгон дээр галзуурсандаа нүүр нь муруйсан Люциус Малфой зогсож байлаа. Ард нь бүх биеэ ороолтоор ороосон Добби атийн хүлээнэ.

- Оройн мэнд, Люциус минь гэж Дамблдор эелдэгээр мэндлэв.

Малфой Харрийг унагах шахан зүтгэсээр ширээнд ойртлоо. Айж сандарсандаа Добби араас нь шурдхийн оров.

- Ингэхэд та буцаад ирсэн юм байна. Ивээн тэтгэх зөвлөл таныг зайлуулсан боловч та зөвлөлийн шийдвэрийг дагасангүй шив дээ. Хогвартст буцаад ирэх боломжтой гэж тооцсон байх нь гэж Малфой хэлээд хүйтэн харцаар Дамблдорыг нэвт шувт сүлбэнэ. Дамблдор урилгагүй зочинг тайван яльгүй инээмсэглэж харснаа:

- Ивээн тэтгэх зөвлөлийн танаас бусад арван нэгэн гишүүд бүгд надад хандсан гэдгийг танд яаран дуулгамаар байна, Люциус минь. Амаргүй ч гэсэн ил тод яриа болсон доо. Ээлжит хохирогч нь Артур Уизлийн охин байсныг мэдмэгцээ зөвлөл намайг яаран буцаахаар шийдсэн юм. Байдал иймэрхүү байхад надаас илүү захирал олдохгүй гэж бүгд бодсон бололтой байсан даа. Бас хачирхалтай зүйл ч бий. Зөвлөлийн зарим гишүүд гэр бүлд нь ч хор учруулж мэдэх шившлэгээс айгаад намайг зайлуулах бичигт зөвшөөрөл өгсөн гэж байгаа гэв.

Тэртээ тэргүй цонхигор царайтай ноён Малфой улам зэвхийрч, нүд нь бүр онийжээ.

- Тэгээд та довтолгооныг зогсоож чадаа юу? Гэмт этгээдийг бариа юу? гэж тохуурхан асуув.

- Тийм ээ гэж Дамблдор бас л инээмсэглэн хэллээ.

- Тэр чинь хэн юм бэ?

- Нөгөө л харгис хар Лорд. Харин энэ удаа өөр хүнээр дамжин довтолж байсан аж. Энэ өдрийн тэмдэглэлийн тусламжтайгаар. Дамблдор багш ноён Малфойг сорьсон янзтай харснаа голдоо том нүх бүхий хар дэвтрийг түүнд сарвайлаа.

Энэ үед Харри гэрийн үйлчлэгчийг харж байжээ. Добби өдрийн тэмдэглэлийг харснаа гэнэтхэн хачин болчихлоо. Том ногоон нүдээ бүлтийлгэн өдрийн тэмдэглэл рүү, дараа нь ноён Малфой руу зааж Харрид харуулаад нударга зангидан толгойгоо балбаж гарав.

- Мэдлээ гэж ноён Малфой аялгуулан хэлэхдээ Доббийг яаж байгааг харсангүй.

- Ухаалаг төлөвлөгөө шүү. Хэрэв Харри ... гэж хэлэхдээ Дамблдор багш

Малфойн нүдийг анхааралтай харах агаад дуу хоолой нь огт өөрчлөгдсөнгүй. Малфой хүүг түргэн зуур нэвт шувт ширтлээ. Захирал үргэлжлүүлэн:

- ... Бас түүний анд Рон хоёр энэ дэвтрийг олоогүй бол би бүх юманд Жинни Уизлийг буруутай гэж үзэх байлаа. Өөрийнхөө хүсэл зоригоос гадуур хийсэн гэж хэн ч, хэзээ ч нотлож чадахгүй шүү ... гэлээ.

Ноён Малфой дуугүй зогсоно. Түүний нүүр баг шиг болжээ.

- Одоо ямар үр дагаварт хүргэснийг бодоод үз дээ. Уизлийнх бол шидтэний ертөнц дээрх хамгийн нэртэй, цэвэр цустай гэр бүлийн нэг. Артур Уизли болохоор Маглуудыг хамгаалах хууль зохиосон хүний нэг. Гэтэл түүний охин холимог цустай хүүхдүүдийг хөнөөгөөд байдаг. Түүнд болон тэр хуулинд юу болохыг бодоод үз дээ! Өдрийн тэмдэглэлийг олж уншаад дараа нь тэмдэглэл байхгүй болсон явдал том амжилт.

- Тийм ээ, том амжилт гэж Малфой хүчлэн хэллээ.

Түүний ард уяатай юм шиг зогсох Добби өдрийн тэмдэглэл, эзэн хоёр ээлжлэн харснаа толгойгоо балбаж байв.

Тэгтэл Харрийн санаанд нэг юм гялсхийн орлоо. Түүнийг ойлгосон янзтай толгой дохиход Добби булан руу ухран, өөрийгөө шалгахаар шийдсэн бололтой чихээ мушгиж гарлаа.

- Ноён Малфой, энэ өдрийн тэмдэглэл Жиннид яаж очсоныг та мэдэхгүй юу? гэж Харри түүний зүг ойртон асуув.

- Тэр заваан амьтан хаанаас авсныг би яаж мэдэх юм! Гэвч Харрийг өнөөдөр юу ч айлгаж чадахааргүй байв.

- Тийм ээ, энэ дэвтрийг та «Флориш, Блоттс» дэлгүүрт байхдаа түүнд шургуулчихсан юм. Та тэгэхдээ түүний тогооноос хувиргалын сурах бичиг аваад дараа нь буцааж хийснийг би санаж байна. Тийм учраас л энэ дэвтэр сурах бичиг дотор байсан юм аа.

- Та маргах уу?

Малфой хувхайрсан хуруунуудаа нэг базаж, нэг тавина.

- Нотлох гээд үз л дээ гэж тэрбээр сийгүүлэн хэлэв.

- Үүнийг хэн ч нотлож чадахгүй гэж Дамблдор багш хэлээд Харрийг харан инээмсэглэж:

- Ядахдаа Том Реддл өдрийн тэмдэглэлийн хуудаснаас алга болчихсон. Гэхдээ л Люциус минь танд урьдчилан анхааруулъя. Волдемортын эд юмсыг баруун солгойгүй бүү тараагаад бай. Нэг юм нь буруу гараар орох аваас энэ ажил таных гэдгийг Артур Уизли нотлож чадна. Үүнд эргэлзэхгүй байна гэлээ. Люциус Малфой хэсэг зуур хөдлөлгүй зогссоноо шидэт саваагаа авах гэсэн

бололтой баруун гар нь татгасхийхийг Харри харжээ. Гэхдээ байдлыг ойлгоод гэрийн үйлчлэгч рүүгээ хандан:

- Явъя, Добби! гэлээ.

Тэрбээр үүдийг түлхэж онгойлгоод гэрийн үйлчлэгч араас нь дуулгавартай дагасан авч эзэн нь түүнийг өрөөнөөс өшиглөн гаргав. Добби өвдсөндөө гаслан, хонгилын үзүүр хүртэл гасласаар байлаа. Хөөрхийд яаж туслах вэ? гэж Харри хөмсөг зангидан бодов. Тэгтэл арга олджээ.

- Профессор Дамблдор гуай, өдрийн тэмдэглэлийг ноён Малфойд буцаан өгч болох уу? Тэгье л дээ! гэж яаран гуйлаа.

- Болно, Харри. Харин цайллагатайгаа бүү мартаарай гэж Дамблдор багш хэлжээ.

Харри өдрийн тэмдэглэлийг шүүрэн аваад өрөөнөөс гүйхээрээ гарлаа. Булангийн цаана Доббийн орилох сонсогдоно. Төлөвлөсөн зүйл нь гэнэтхэн бүтэхгүй болбол яанаа гэж айсан Харри хөлөө яаран шаахайнаасаа сугалаад, норж заварсан оймсоо тайлж аван өдрийн тэмдэглэлийн гадуур углаад тэдний араас хүнгүй хонгилоор хурдаллаа.

Тэднийг шатны тавцан дээр байхад гүйцэж очингуутаа амьсгаадан байж:

- Ноён Малфой, үүнийгээ буцааж ав ... гэж хэлээд оймсоо Малфойн гарт шургуулчихав.

- Бас юу вэ? ...

Малфой өдрийн тэмдэглэлээс оймсыг мулталж аваад хажуу тийш шидэхдээ Харрийг тун ч ууртай харж байлаа.

- Чи ч эцэг эх шигээ муугаар дуусах юм байна даа. Ойрын үед шүү. Тэд бас л тэнэг байсан болохоороо бусдын хэрэгт хуруу дүрдэг байсан юм. Явъя Добби. Явъя гэж танд хэлж байна шүү! гэж ууртай аядуухан дуугаар заналхийлжээ.

Гэвч Добби хөшсөн юм шиг зогсоно. Тэрбээр шидсэн заваан оймсыг унаагүй байхад нь барьж аваад үнэт эрдэнэс олсон юм шиг шимтэй харж:

- Эзэн Доббид оймс өглөө. Эзэн Доббид үүнийг өгчээ ... хэмээн гайхшран хэлэв.

- Юу гэнээ? Чи тэнд юу гэж бувтнаад байнаа? гэж ноён Малфой уурслаа.

- Добби оймсыг хүлээн авлаа. Эзэн шидсэн, Добби барьсан, Добби ... Добби чөлөөтэй болсон гэж гэрийн үйлчлэгч аз жаргалдаа итгэж ядан шивнэх ажээ.

Ноён Малфой гэрийн үйлчлэгчээ харснаа Харри руу довтлон:

- Чи л миний зарцыг авчихлаа! гэв.

Гэтэл Добби: Одоо чи Харри Поттерт хор хүргэж чадахгүй хэмээн хашгирлаа. Нэг юм түжигнэснээ ноён Малфой ар тийш огло үсэрчээ.

Тэрбээр нэг дор гурав дөрөв бөмбөрөн шатаар доош унаснаа талбай дээр нэг бөөрөнхий юм болон унав. Уурласандаа улаан хүрэн болсон Малфой үсрэн босоод шидэт саваагаа гаргасан авч Добби түүнийг урт нарийхан хуруугаараа зангаад:

- Одоохон яв. Чи Харри Поттерт хүрэх ёсгүй. Чи одоо явах болно гэж тушаалаа.

Люциус Майфой ч үгэнд нь оржээ. Тэрбээр мань хоёрыг ууртай үзэн ядсан харцаар хараад жанчаа нөмрөн талбайгаас гарч хонгил руу одлоо.

- Харри Поттер Доббийг чөлөөллөө! Харри Поттер Доббийг чөлөөллөө хэмээн гэрийн үйлчлэгч Харрийг баясан харах зуураа чанга дуугаар орилно. Түүнийд дүгэрэг нүд ойрын цонхоор тусах сарны гэрэлд гялалзаж байлаа.

- Би үүнээс илүү юм хийж чадсангүй. Гэхдээ Добби чи миний амь насыг хэзээ ч урьдчилан аврахгүй гэдгээ надад амла гэж Харри инээмсэглэн хэлэв.

Гэрийн үйлчлэгчийн муруй нүүр царайд сайхан инээмсэглэл тодорлоо. Тэрбээр чичирсэн гараараа түүний оймсыг өмсөж байхыг Харри харж байснаа гэнэтхэн нэг юм санаад:

- Надад нэг асуулт байна ... Надад учрах гээд байгаа аюул хэцүү нэрттэй ямар ч холбоогүй гэж чи тэгэхэд хэлсэн биз дээ? Гэтэл юу болов? гэлээ.

- Энэ чинь түлхүүр байсан юм аа, ноёнтоон. Добби танд сануулсан. Дээр үед хар Лордыг зүгээр л нэрээр нь хэлдэг байсан юм. Харин шинэ нэртэй болсноос нь хойш энэ нэрийг хэлэхээ байсан ойлгов уу? гэж Добби тов тодорхой зүйлийг тайлбарлаж байгаа мэт нүдээ улам том болгож хэлэв.

- Ойлголоо гэж Харри итгэл муутайхан хэлээд:

- За, би явахаас даа. Дор баяр тэмдэглэж байгаа ... Бас Гермiona мөдхөн сэрнэ ... гэлээ.

Добби нарийхан гараараа Харрийг чанга тэврээд:

- Харри Поттер Доббийн бодож байснаас хавьгүй агуу юм. Баяртай, Харри Поттер гэж асгартал уйлан хэлжээ.

Тэгээд баярын буудлага шиг нүргэлсэн чимээ гарснаа Добби алга боллоо.

Харри Хогвартст байхдаа олон баярт оролцсон хэдий ч үүнтэй адил байхыг хэзээ ч харсангүй. Бүгд л гоёлын хувцасаа өмсөөд хичнээн их баяр баясгалан авчирсан гээч! Гермiona түүнийг: «Чи ялсаан, Харри!» гэж баярлан хашгирч угтсан бол Жастин ширээний араас үсрэн босоод түүнийг сэжиглэж байсандаа эцэс төгсгөлгүй уучлал гуйж гарыг нь дугтарч байлаа. Харин дөрөв хагас гэхэд Хагрид гэнэтхэн хүрч ирсэнээ Харри, Рон хоёрыг хамраараа таваг мөргөтөл шахуу чангаар мөрийг нь алгадав. Түүний дараа профессор МакГонагалл энэхүү баярт үйл явдлыг тохиолдуулан захирлын зөвлөлөөс шалгалтыг хойшлуулах боломжтой гэж үзсэнийг дурьдаад («Ямар харамсалтай вэ!») гэж Гермiona халаглажээ. Харри Рон хоёрыг авсан дөрвөн зуун оноо энэ жил Гриффиндорынхон сургуулийн цомыг дахин нэг

жил хадгалах боломжийг хангалаа хэмээн нэмж хэлжээ. Тэгтэл Дамблдор захирал босоод харамсалтай нь хар хүчнээс хамгаалах хичээлийн багш цаашид багшлахгүй, оюун ухаанаа эмчлүүлэхээр явж байгааг дуулгахад хүүхдүүд хашгиралдан хэд хэдэн профессор ч дэмжиж харагдав.

- Харамсалтай л байна. Надад дөнгөж таалагдаж эхлэсэн юм сан ... гэж жимсний чанамалтай бялуу үмхэх зуураа Рон бувтнана.

Харри амьдралдаа хэзээ ч ийм жаргалтай байж үзсэнгүй. Зуны хичээлийн сүүлийн өдрүүдэд халуун нартай байлаа. Хогвартс буцаад хэвийн байдалдаа оржээ. Гэхдээ яльгүй зүйл өөрчлөгдсөн байв. Хамгаалах урлагийн хичээлийг хойшлуулж («Хамгаалах хичээлийн дадлагын ажил их юм чинь дээ» гэж Рон Гермionaг тайтгаруулж байлаа), ивээн тэтгэх зөвлөлөөс Люциус Малфойг хөөжээ. Харин Драко маань Хогвартсыг өөрийн эзэмшил мэт дүртэй явдгаа больсон байна. Түүний дүр төрх ямагт гомдолтой, баргар харагдах ажгуу. Харин Жинни баяр хөөрөөр гэрэлтэж явдаг байлаа. Явах цаг хурдан, бүр дэндүү хурдан болчихлоо. Манай анд Харри, Рон, Гермiona, Фред, Жорж, Жинни нар Хогвартс Лондонгийн буухиа галт тэргэнд суудлаа эзэлжээ. Амралт эхэлэхд хэдхэн цаг үлдсэн учраас сурагчид ид шид үзүүлж

болох боломжоо ашиглан дуртай зүйлээ хийцгээж байлаа. Алга болдог хөзрөөр наадан, ихэр хоёр үлдсэн сүүлчийн цаасан бууг буудуулж, шившлэгийн тусламжтайгаар бие биеэ зэвсэггүй болгоцгооно. Харри үүнийг маш сайн хийж байв.

Кингс-Кросс буудалд бараг хүрсэн хойноо Харри нэг зүйлийг гэнэтхэн саналаа.

- Перси ямар нэг юм хийгээд дараа нь ичиж зовохдоо хэнд ч бүү хэлээрэй гэж чамд хэлснийг санаж байна уу, Жинни? Энэ юу байсан юм бэ?

- Саналгүй яахав. Перси найз охинтой болсон байхгүй юу гээд Жинни хи, хи инээлээ.

Номын ард зогсож байсан Фред баахан юм Жоржын толгой дээрээс унагаад:

- Юу гэнээ? гэв.

Когтевраны ахлагч Пенелопа Кристалл. Тэр чинь зунжингаа түүнд захидал бичсэн юм. Тэд сургууль дотор нууцаар уулздаг байхгүй юу. Би нэг удаа хоосон ангид гүйгээд орсон чинь тэр хоёр үнсэлцэж байсан юм. Дараа нь тэр охин руу довтлоход

... ойлгож байна уу ... Перси бүр учраа олохоо больчихсон. Та нар түүнийг дооглохгүй биз дээ? хэмээн Жинни түгшин асуулаа.

- Би юу? Тэгэхгүй ээ гэж Фред царай нь туяаран хэлжээ.

- Тэгэлгүй яахав, дооглохгүй гэж Жорж дэмжлээ. Буухиа галт тэрэг хурдаа саан зогслоо.

Харри үзэг, хэсэг цаас гаргаж ирээд Рон, Гермiona хоёрт хандан:

- Энэ Дурслийн утасны дугаар гэж хэлээд хоёр дахин бичсэнээ дундуур нь ижил хуваагаад тэр хоёрт өгч:

- Өнгөрсөн зун би утас яаж ашигладгийг аавд чинь зааж өгсөн. Аав чинь чамд хэлээд өгнө. Над руу утасдаарай. Хоёр сар ганцхан Дадлитай ярина гэдэг байж болшгүй хэрэг! гэж Ронд хэлэв.

- Ямар баатарлаг үйл бүтээснээ нагац ах, эгчдээ яриач. Тэд чамаар бахархах болно гэж шидэт хаалтны өмнө очих үедээ Гермiona хэлжээ.

- Бахархах гэнээ? Тэд бүр харамсах байлгүй! Зээ нь тэр олон удаа үхлийн ирмэг дээр очсон мөртөө амьд үлдсэн байдаг! Тэд бахардаж үхэх байлгүй гэж айж байна! Андууд энэ удаа магл, шидтэн гэдэг хоёр ертөнцийг тусгаарлагч саадыг элдэв саад бэрхшээлгүйгээр нэвтэрч чадлаа.